БУРХАН
БАГШИЙН
СУРГААЛ



НОМЫН ХҮРД

Номын хүрд нь "Дхарма-чакра" хэмээх санскрит үгний орчуулга юм. Ямагт эргэж байдаг тэрэгний дугуй лугаа адил Номын хүрд нь дөрвөн зүг найман зовхист эцэс төгсгөлгүй түгэн дэлгэрч буй Бурхан багшийн сургаал номын бэлэг тэмдэг билээ. Хүрдний найман хэгээс Бурхны шашны хамгийн чухал хэмээн сахиж мөрдөх ёстой хутагтын найман мөрийг төлөөлдөг. Хутагтын найман мөр нь үнэн үзэл, үнэн бодол, үнэн хэл, үнэн явдал, үнэн ахуй, үнэн хичээл зүтгэл, үнэн ухаарал, үнэн бясалгал зэрэг юм. Эрт дээр үед буюу Бурхан багшийн баримал, дүрүүдийг бүтээдэг болохоос өмнө Номын хүрдэнд мөргөдөг байжээ. Харин одоо Номын хүрдийг Бурханы шашны бэлэг тэмдэг хэмээн үзэж хэрэглэдэг.

©1996, 2017 Зохиогчийн эрх, хэвлэх эрхийг Бүккё дэндо кёкай эдэлнэ

Энэ номын аль ч хэсгийг бидний зөвшөөрөлгүй хэвлэж болно. Гагцхүү Токио дахь Бүккё дэндо кёкайг дурьдаж, хэвлэж нийтэлснийхээ нэг хувийг бидэнд илгээхийг хүсч байна.

БҮККЁ ДЭНДО КЁКАЙ
(Бурханы шашныг сурталчлах нийгэмлэг)
108-0014 Япон улс, Токио, Минато-ку,
Шиба 4-чомэ 3-14
Утас: (03) 3455-5851
Fax: (03) 3798-2758
E-mail:bdk@bdk.or.jp http://www.bdk.or.jp

Thirteenth revised edition, 2017

"Косайдо" Ко., лтд. хэвлэв.
Токио, Японулс

Бурхан багшийн оюун ухаан далай тэнгис лүгээ адил зах хязгааргүй, зүрх сэтгэл нь асар нигүүлсэнгүй, энэрэхийн дээд биелэл бүлгээ. Бурхан багш тодорхой хэлбэргүй боловч Тэрбээр Өөрийгөө асар нарийн хэлбэр дүрсээр илэрхийлж, нигүүлсэнгүй сэтгэлдээ амьтан бүгдийг багтаан, хүмүүст чин сэтгэлээсээ номлол сургаалаа хайрлах бүлгээ.

Энэ номд 2500 гаруй жилийн турш улс түмний 5000 илүү боть бүхий ариун судрт тэмдэглэсэн Бурхан багшийн бүхий л сургаалын мөн чанарыг сорчлон эмхтгэсэн юм.

Эл номд буй Бурхан багшийн айлдсан сургаал нь ахуйн болон оюуны амьдралын аливаа ээдрээтэй асуудалд утга төгс хариу өгнө.

ДАРМАБАДА БУЮУ "НОМЫН БАДАГ" ЗОХИОЛ

Өшөө хорсолыг өшөө хорсолоор тайлж болохгүй. Зөвхөн уучлан сэтгэлдээ багтааваас тайлж болно. Энэ бол хувирашгүй үнэн. (5)

Өөрийн мунхаг хэмээн зовох хүн буй. Энэ хүн бол мунхаг хүн биш. Харин өөрийгөө мэдэхгүйгээр мэргэн хэмээгч хүн бол мунхагийн дотор мунхаг хүн. (63)

Дайн байлдаанд хэдэн мянган дайсныг дархаас илүү, өөрийгөө ялан дийлэх нь хамгийн дайчин болно. (103)

Үлгэрлэвэл зуун наслах насан хутагийг олсон ч бурханы сургаалтай эс уулзсан бол, бурханы сургаалтай уулзсан хүний нэгэн өдөрт ч хүрэхгүй юм. (115)

Эрдэнэт хүний биеийг олж төрөх хэцүү, үхэх цаг нь ирэхэд үхэхгүй байх хэцүү, ариун үнэнийг олж сонсох хэцүү, бурхан багшийг олж харах хэцүү. (118)

Элдэв муу муухайг тэвчин, олон арвин буян үйлдэж, сэтгэлээ ариусгах нь бурхадын сургааль болно. (183)

Эцэгт ч, хүүд ч хамгаалалт гэж үгүй. Үхэлт ойртсон нэгнийг цусан төрөл нь ч хамгаалж чадахгүй. (288)

ГАРЧИГ

БУРХАН БАГШ

I. бөлөг. Бурхан Шагжамуни 2

I. Бурхан багшийн амьдрал 2

II. Сүүлчийн номлол 10

II. бөлөг. Мөнхийн Бурхан 15

I. Бурханы нигүүлсэнгүй сэтгэл, өргөсөн тангараг 15

II. Бурханы аврал, түүний тусын мутар 19

III. Мөнхийн Бурхан 23

III. бөлөг. Бурхан багшийн дүрүүд, түүний бодь чанарууд 26

I. Бурхан багшийн гурван дүр 26

II. Бурхан багш буй болох нь 30

III. Бурхан багшийн бодь чанар 33

НОМ

I. бөлөг. Учир шалтгаан 42

I. Дөрвөн үнэн 42

II. Гайхамшигт хэлхээ холбоо 45

III. Харилцаа холбоо 46

II. бөлөг. Сэтгэл санаа болон эд юмсын үнэн байдал .. 50

I. Юм бүхэн хувирч өөрчлөгдөх тул байнгын мөн чанаргүй 50

II. Сэтгэл санаа 53

III. Эд юмын үнэн байдал 56

IV. Дундад зам мөр 61

III. бөлөг. Гэгээрэхийн үр 70
I. Ариун нандин сэтгэл.. 70
II. Нууц эрдэнэ 76
III. Аливаа дасахын хүлээснээс ангид байх............. 81
IV. бөлөг. Нисваанис 87
I. Сэтгэлийн бузар.. 87
II. Хүний зан араншин.. 94
III. Хүний амьдрал 96
IV. Хүний бодит амьдрал..102
V. бөлөг. Бурхан багшийн аврал 110
I. Бурхан багшийн тангараг 110
II. Жаргалын орон 118

БОДЬ МӨРИЙН ЗЭРЭГ

I. бөлөг. Гэгээрэх зам 124
I. Сэтгэл санаагаа ариусгах....................................124
II. Буян үйлдэх..131
III. Бурхан багшийн сургаалыг эртний
Домогт өгүүлсэн нь 143
II. бөлөг. Бодь мөрийн зэргийг олох арга зам...............161
I. Үнэний эрэл 161
II. Гэгээрэх янз янзын зам мөр....................................175
III. Сүсэг бишрэлийн зам..189
IV. Ариун шударга үг 197

АХАН ДҮҮСИЙН ХОЛБОО

I. бөлөг. Ахан дүүсийн холбооны үүрэг 208
I. Хуврагийн амьдрал 208
II. Сүсэгтний зам мөр 213
III. Амьдралын чиг баримтлал 226
II. бөлөг. Бурхан багшийн жаргалын орныг бүтээх нь 239
I. Эвтэй хуврагууд 239
II. Бурхан багшийн ертөнц 248
III. Бурхан багшийн ертөнцийн үндэс суурь 253

Номзүй 261

Хавсралт

I. Бурханы шашны товч түүх 274
II. Бурхан багшийн сургаал уламжилж ирсэн түүх 285
III. "Бурхан багшийн сургаал" хэмээх эл ном түүх 289
IV. Сэдвийн заалт 292
V. Самгарьд үгсийн тайлбар 301

Бурханы шашныг сурталчлах "Бурхан багшийн сургаал" Нийгэмлэгийн тухай....................308

БУРХАН БАГШ

I БӨЛӨГ

БУРХАН ШАГЖАМУНИ

I

Бурхан багшийн амьдрал

1. Himалайн уулсын урд хормойг ороон урсах Рохини голын эрэг дээр оршигч, Шагжа омгийн улсын нийслэл Капилавасту балгаст Суддодана Гаутама буюу Ариун идээт хаан бээр амьдарч байжээ. Тэрбээр шулуун шударга, цэцэн мэргэн хэмээн алдаршиж, айлдсан болгоныг нь үг дуугүй дагах ард түмнийхээ хайр хүндэтгэлийг хүлээжээ.

Хааны хатныг Маяа хэмээнэ. Тэрбээр мөнөөхи Шагжа омгийнхны үүсгэж буй болгосон хөрш зэргэлдээ орших нэгэн улс гүрний эзэн хааны нагац ахын охин буюу эзэн хааны үеэл ДҮҮ байжээ.

Хаан, хатан хоёр гэрлэснээс янагш хорь гаруй жил улирсан ч, тэдэнд үр заясангүй. Нэгэнтээ хааны хатан цагаан заан баруун сугаар хэвлийд нь орж бие давхар болов хэмээн сонин зүүд зүүдлэв. Эзэн хаан болон ордныхон, мөн ард түмэн нь хоног өдрийг хуруу даран тоолж, мэндлэх хүүхдийг тэсэн ядан хүлээжээ. Бие хөнгөрөх цаг болоход хааны хатан ард түмнийхээ ёс заншлыг дагаж, төрсөн гэртээ амаржихаар явлаа. Зам зуураа Лумбини цэцэрлэгт алжаал тайлахаар түр саатжээ.

Ээлтэйхэн хаврын урин дулаан цаг тул эргэн тойрон үзэсгэлэнт сайхан ашока мод цэцэглэж байлаа. Хааны хатан цэцгээ дэлгэсэн модны мөчир таслах санаатай баруун гараа сунгатал хүү нь мэндлэв. Хатан, хүү хоёрыг ерөөн адислаж, эргэн тойрон дуу хуур эгшиглэн найрсав. Энэ бол 4 дүгээр сарын 8-ны өдөр байлаа.

Баярлаж хөөрсөн хаан, хүүдээ Сиддарта буюу "Хамаг тусыг бүтээгч" Артасиди хөвгүүн хэмээх утга бүхий нэр хайрлав.

2. Гэвч хаан баяр цэнгэлийн эцэст уй гашуу амсаж, хатан Маяа нь ертөнцийн мөнх бусыг үзүүлэв. Хатны охин дүү Махапражапати хан хүүг асран бойжуулах болсон аж.

Тэр хавиас холгүй орших нэгэн ууланд Асита хэмээх мэргэн даянч амьдарч байв. Хааны ордныг тйрон гэрэл гэгээ сацрахыг тэрбээр хараад залран ирэхэд саяхан мэндэлсэн хан хүүг түүнд үзүүлжээ. "Том болоод хэрэв ордондо үлдвэл аугаа их хаан болж бүх ертөнцийг нэгтгэнэ, Харин ордноо орхиж даяан хийж, үнэнийг ухаарвал энэ ертөнцийг аврах заяатай Бурхан болно" гэж Асита өгүүлэв.

Хаан, мэргэн даянчийн үгийг сонсоод эхлээд их баярласан ч, он жил улирах тусам хүү нь ордныг

орхиж даянч болж магадгүй гэсэн бодол сэтгэл зүрхий нь зовоож эхлэв.

Хан хүү долоон настайдаа ном судар үзэж, цэргийн эрдэмд суралцаж эхлэв. Хаврын нэгэн өдөр тэрбээр хаан эцэгтэйгээ хамт тосгонд очихоор явжээ. Тариачин газар хагалж буйг ажиж байснаа, анжис нь газрын хэвлийг ярахад гарч ирсэн өтийг шувуу тоншиж идэхийг харчихжээ. Тэрбээр саяхан үзсэн харсандаа гайхаж: "Ямар муухай юм бэ! Амьд нь амьдыгаа идэж байх юм!" хэмээн уулга алдаж модны сүүдэрт саатан сууж, гүн бодолд автав.

Хар нялхаараа эхийгээ алдсан, сая болохоор амьд нь амьдыгаа идэхийг харсан хан хүү амьдралын эмгэнэл гунигийг эрт ухааран таньж, эмзэг өрөвчхөн сэтгэлд нь гүн шарх суужээ. Энэ шарх сорви зулзган модны шарх цаг хугацаа улирах тусам улам ихсэх адил, харсандаа гайхаж: "Ямар муухай юм бэ! бодол төрүүлдэг болов.

Хүүгийнх нь зан ааш хувирч буйг анзаарсан хаан эцэг нь мэргэн даянчийн хэлснийг санаж сандрав. Хаан бээр хүүгээ хөгжөөн баясгахын тулд болол-цоотой бүхнээ хийжээ. 19 нас хүрмэгц нь хүүдээ Яшодхара нэртэй бөл дүүг нь эхнэр болгон авч өгчээ. Яшодхара бол хан хүүгийн эхийн төрсөн ах, Девадаха цайзанд суудаг Супрабуддха хааны охин байлаа.

3. Хан хүү арван жилийн турш найр наадам, баяр цэнгэлд умбаж Хавар, Намар, Бороонь орднууддаа ээлжлэн амьдарч байлаа. Гэвч тэрбээр цаг үргэлж гүн бодолд автаж, амьдралын үнэнийг ухаарахыг эрмэлзэж байв.

"Ордны баян тансаг, цатгалан чинээлэг амьдрал, хүмүүсийг баясгах миний эрүүл саруул бие, залуу шндан нас ямар утга учиртай юм бэ? Хүмүүс өвчинд баригдаж, эцэст нь амьсгал хураах аж. Хэн ч үхлээс мултарч чадахгүй. Залуу нас, эрүүл саруул бие, амьдралын утга учир юунд оршино вэ?

Хүн амьдарч байна гэдэг ямар нэг юмыг эрж байна гэсэн үг. Гэтэл нэг хэсэг нь бурууг, нөгөө хэсэг нь зөвийг хайна. Бурууг эрж хайгчид хэн бэ гэвэл өтлөх, өвдөх, үхэх заяатай мөртлөө мөнхийн омголон залуу нас, мөнх амьдралыг хүсэгчид билээ.

Зөвийг эрэгч хэн бэ гэвэл энэ бүхнийг төөрөгдөл хэмээн ухаарч, өтлөх, өвдөх, үхэх зэрэг амьдралын эрээн бараан бүхнээс эрхэм дээд зүйлийг эрэн хайгч юм. Би тэр бурууг л хүсч, бурууг эрэн хайж байна даа".

4. Олон жилийн турш ийнхүү хүнд хүчир бодолд автан, зүрх сэтгэл нь хатуу ширүүн тэмцлийн талбар болов. 29 нас хүрэхэд нь Рахула хэмээх нэртэй цорын

ганц хүү мэндэлж, хан хүү ордноо орхин явахаар шийдэв. Чандаха хэмээх хөтөчөө дагуулаад Кантхака хэмээх хайртай агтандаа мордож ордноо орхин, энэ ертөнцтэй холбоогоо таслаж, нямба хийж суулаа.

Тэгтэл нэгэн рагшис түүнийг сорьж хэлсэн нь: "Чи ордондоо буцаж очоод хүлээсэн нь дээр. Удахгүй энэ ертөнц тэр аяараа чинийх болно". Хан хүү хашгирсан нь: "Рагшис чи эндээс тонил! Энэ ертөнцийн юуг ч би үл хүснэ". Түүнийг хөөн тонилгосныхоо дараахан хүүү лам болж, бадар барьж өмнө зүг оджээ.

Эхлээд хан хүү мэргэн даянч Багавад бараалхаж түүний хатуу хориг дэглэм бүхий амьдралтай танилцав. Дараа нь Арада Калама, Удрака Рамапутрад бараалхаж бэрх хэцүү хатамжлалыг нь үзэж, тэдэнтэй адилхан даяан хийхийг оролджээ. Удалгүй ийм замаар эс гэгээрэхийг ухаарч, Магада улсад очжээ. Тэнд Гайя хотын дэргэдүүр урсдаг Ниранзана мөрний эрэгт нэгэн аглаг ойд очиж, биеэ зовоосон хатуухан сорилтыг эхэлжээ.

5. Өөрийнхөө бие бялдрыг хүнд ширүүн зовоон тарчлааж байлаа. Хожим нь түүний дурсан айлдсанаар, урьд өмнө нь үзэгдээгүй бэрх аргаар махбодоо зовоосон аж. Түүний өгүүлснээр, "Урьд өмнө нэг ч даянч өөрийгөө тэгэж хатуу ширүүн

зовоож байгаагүй, одоо ч өөрийгөө тэгэж зовоож буй хүн байхгүй, ирээдүйд энэ ертөнцөөс халин одсон хэн боловч түүнээс илүү хатуу ширүүнээр өөрийгөө зовоож тарчлаахгүй" ажээ.

Ингэж өөрийгөө зовоосон ч хан хүү эрж хайснаа, хүсэж хүлээснээ эс олов. Тэрбээр 6 жилийн турш эр биеэ зовоосон энэхүү хатамжлалаа үл харамсан зогсоож, мөрний усанд угаал үйлдэн, Сужата хэмээх залуухан бүсгүйн гараас сүүтэй будаа авч хүртээд, ядарч сульдсан биеэ анагааж эхэлсэн байна.

Ойд түүнтэй цуг хатамжилсан таван даянч, хан хүү сорилтыг давсангүй хэмээн сэтгэж, ганцааранг нь орхин өөр газар руу нүүн дүрвэжээ.

Хан хүү гав ганцаараа хоцорч модны сүүдэрт суугаад хэзээ л бол хэзээ үхэхээс буцахгүй, гүн бясалгалд автав. Тэрбээр сэтгэл шулуудан: "Миний цус хатвал хатаг. Миний мах ялзарвал ялзраг. Миний яс өмхөрвөл өмхрөг. Эндээс би хаашаа ч хөдлөхгүй" гэжээ.

Санаа сэтгэлд нь хэцүүхэн, ээдрээтэй тэмцэл эхэлжээ. Түгшүүртэй болоод зовлонтой бодлууд санаа сэтгэлийг нь үймүүлж, элдэв зүйлийн хий үзэгдлүүд цааш нааш үсчин, тэр нь илүү аймшигтай гэж хэлэхийн аргагүй жигшмээр дүрс сэтгэлд нь нэг нэгээсээ өрсөн ургана. Энэ бүхэн рагшисын явуулга

байлаа. Хан хүү эдгээр явуулгатай тэмцэж, нэгийг нь ч зүгээр орхилгүй, дор нь нам дарж, хумхын тоос болгож байлаа. Энэ бол жирийн нэг тэмцэл бус, цус нөж урсаж, амьд махыг яснаас нь салган хуулж, яс хугарч байсан болохоор сэхэхийн төлөө тэмцэл байсан юм.

Гэвч энэ тэмцэл дуусч, тэнгэрт үүрийн цолмон гийж, шинэ өдөр эхэлснийг тунхаглан зарлахад хан хүүгийн сэтгэл санаа гэрэлтэн гялалзаж, тэрбээр гэгээрч Бурхан багш болов. Энэ баяр баясгалант үйл явдал хан хүүгийн 35 насан дээр арванхоёрдугаар сарын 8-ны өглөө тохиосон юм.

6. Энэ мөчөөс эхлэн хан хүү Бурхан багш Ялж төгс нөгчсөн, түүнчлэн ирсэн, Сайваар ажирсан, Амарлингуй оршигч, бүхнийг айлдагч, Чадагчийн эрхт, Шагжагийн арслан зэрэг олон нэртэй болсон бүлгээ.

Юуны түрүүн Шагжамуни зургаан жилийн турш цугтаа хатамжлан зовж байсан, эдүгээ Варанасийн Мригадавад амьдарч буй таван даянч дээр очиж шашиндаа оруулжээ. Эхлээд тэд цэрвэн зугтаж байснаа сургаал айлдахы нь сонсож түүнд бүрэн итгэл найдвараа өгч, анхны шавь нар нь болов. Тэрбээр Ражагрихад байхдаа эзэн хаан Бимбасараг шашиндаа оруулжээ. Шагжамуни түүний ордонд заларч орон даяар ариун сургаалаа айлдаж эхлэв.

Хүмүүс цангахдаа ус, өлсөхдөө хоол хүсдэг лүгээ адил түүн рүү тэмүүлэн цувж байлаа. Эндээс гол шавь Шарибудари, Модгальяана нарыг олж, мөн хоёр мянга гаруй хүн түүнд шавь оржээ.

7. Шагжамуни 45 жилийн турш сургаалаа айлдаж 80 нас сүүдэр зооглов. Ражагрихаас Шравасти орох замдаа Вайсали хэмээх газар бие алжааж, гурван сарын дараа Нирванд орно гэдгээ хэлжээ. Тэгээд помлол сургаалаа айлдаж явсаар Пава хэмээх газар очиж, тэнд Чунда дархны барьсан хоолыг амсаад овчин нь үгдрэв. Өвчин зовлонд шаналж, улам ядарч сульдсан ч тэрбээр цаашаа Кусинагара руу явжээ.

Тэрбээр Кусинагара балгасын захад сала хэмээх ойд очиж, хоёр өндөр модны хоорондох газар хэвтэв. Газар дээр ийн хэвтэж байхдаа ч шавь нартаа сургаал айлдсаар байлаа. Чингээд агуу их сургаал номлогч Бүрханы үүргээ бүрэн гүйцэд биелүүлж дуусаад алгуурхан Нирванд оров.

8. Шагжамуни Нирван дүрийг үзүүлсний дараа Кусинагара балгасын иргэд гүн их уй гашууд автжээ. Бурханы хайртай шавь Анандын айлдсанаар тэд, багшийнхаа шарилыг ариун галд өргөв.

Ажатасатра хаан, мөн Энэтхэгийн 7 хаан Шагжамунийн чандраас хүртээхийг хүссэнд Кусинагара балгасынхан татгалзаж, чингээд дайн дэгдэв. Гэвч Дрона мэргэний зөвлөсний дагуу Бурхан багшийн чандрыг найман улсын дунд хуваасан аж. Шагжамунийн чандраас өөр олон улс, хүмүүс ч хүртжээ. Бурханы ариун шарилыг тэд нүдний цөцгий мэт хайрлан хамгаалдаг болов. Түүнийг хадгалж байхын тулд бурханы шашны арван сүм босгосон аж.

II
СҮҮЛЧИЙН НОМЛОЛ

1. Кусинагарагийн ойролцоо сала хэмээх ойд Шагжамуни сүүлчийн удаа сургаалаа айлдсан аж.

Тэрбээр шавь нартаа хандаж номлосон нь: Та нар өөрсдөө бусдын төлөө ассан гэрэл болцгоо! Та нар өөрсдөө өөрсдийнхөө түшиг тулгуур болж, хэнд ч бүү найдаж бай! Миний сургаал та нарт гэрэл гэгээ, түшиг тулгуурын аль аль нь болог! Бусад сургаал, номыг түшиж тулахаас цээрлэ!

Бохир биеэ хараад бохирыг нь ухаарч, хэзээ ч гоё чамин хувцас бүү хүсч бай! Баяр цэнгэл, зовлон

зүдгүүрийн аль аль нь зовлонгийн шалтгаан гэдгийг үхаарч, цэнгэл жаргалд автахыг цээрлэ! Сэтгэл санаагаа шинжээд тэнд өөрийн чинь "Би" бээр байхгүйг ойлгож, сэтгэлийн хөдөлгөөндөө бүү хуурт! Тэр цагт та нар зовлон зүдгүүрээс үүрд ангижирна. Намайг энэ ертөнцөөс халин одсоны дараа ч гэсэн та нар, миний сургаалыг үнэн зөв даган мөрдөж чадвал, жинхэнэ үнэнч шавь нар минь болно.

2. Миний номлосон бүх сургаалыг цаг ямагт санаж яв, тэдгээрийн тухай үргэлж бодож бай, утга учрыг нь онохыг хичээ, ямар ч үед тэдгээрээс бүү татгалз. Хэрэв миний сургаалыг үнэн зөв дагавал та нар жинхэнэ жаргалыг амсана.

Миний сургаалын хамгийн гол нь санаа сэтгэлээ удирдаж чаддаг болоход оршино. Өөрийнхөө хүслийг хазаарлан номхотгож, өөрийгөө ялж сурах хэрэгтэй. Биеэ зөв авч явж, зөв үйл хийж, сэтгэл санаагаа ариун байлгаж, хэлсэн үгэндээ эзэн болох ёстой. Шунал хүслээсээ татгалзаж, уур хилэнгээ номхтгож, нүглээс зайлж, амьдрал мөнх бусыг үргэлж санавал зохино.

Зүрх сэтгэлд чинь хүсэл шунал, нүгэл хилэнц орогновол, түүнийг ялах хэрэгтэй. Зүрх сэтгэлдээ бүү захирагд, харин зүрх сэтгэлийнхээ эзэн болох

хэрэгтэй.

Зүрх сэтгэл нь хүнийг бурхан ч болгоно, буг ч болгоно. Төөрөлдсө хүн шулам, гэгээрсэн хүн бурхан болно. Санаа сэтгэлээ ариун байлгаж, буяны замаасаа бүү хазай.

3. Миний сургаалыг дагаж бие биетэйгээ энх амгалан, эвтэй найртай амьдарцгаа, нэг нэгнийгээ хүндэлж бай, хоорондоо бүү хэрэлдэж маргалд. Ус, сүү лүгээ адил бие биентэйгээ зохицож бай, ус, тос лугаа адил нэг нэгийгээ бүү түлх.

Миний сургаалыг хамтдаа дагаж мөрд, сурч ухаар, хамтдаа төгс төгөлдөр болж, нэг нэгэндээ тусалж, буяны зам мөрийн баяр баясгалангаа хуваалцаж бай. Хэрэггүй юмыг эс шохоорхож, ашиггүй юманд цагаа бүү зарцуул, гэгээрэн гийхийн цэцэг, буяны зам мөрийн үр жимснээс хүртэж яв.

Би бээр, та нарт өгч буй сургаалаа гэгээрснээр ухаарсан юм. Та нар энэ сургаалыг баримталж, хатуу мөрдөх хэрэгтэй.

Миний сургаалыг дагахгүй бол миний дэргэд байсан ч намайг олж харахгүй. Харин сургаалыг минь дагавал надаас асар хол байсан ч үргэлж цуг байна.

4. Шавь нар минь, удахгүй миний цаг болох гэж

байна. Та нараасаа салах цаг ойртлоо. Гэвч та нар гуньж гутарч үл болно. Амьдрал мөнх бус, энэ ертөнцөд төрсөн хэн боловч үхнэ. Би бээр үхэхэд миний бие модон тэрэг лүгээ адил өмхөрч алга болно. Ингэж хүний оршин тогтох мөнх бус гэдгийг дахин батална.

Бүү гуньж гутарцгаа. Ертөнцөд ганц ч мөнх юм үгүйг ухаарч, хүний оршин тогтнохын утга учрыг оножь мэдэцгээ. Хувирч өөрчлөгддөг бүхнийг үл хувиргахыг бүү хүс. Энэ хүсэл хэзээ ч бүтэж биелэхгүй.

Энэ ертөнцийн тачаал шуналын шулам хэзээд бэлэн байдаг бөгөөд сонор сэрэмж чинь сулармагц та нарыг эзэмдэж эрхэндээ оруулна. Хэрэв гэрт чинь хорт могой үүрлэвэл, тэр амьтныг хөөж гаргахаас нааш амар амгалан нойрсож чадахгүй шүү дээ.

Ертөнцийн тачаал шуналын шулмыг хөөж зайлуулах хэрэгтэй. Ертөнцийн хүсэл шуналын могойг хөөн гаргах хэрэгтэй. Сэтгэл санаагаа та нар сонор соргог хамгаалах ёстой.

5. Шавь нар минь, миний цаг ирлээ. Гэвч энэ бол миний бие махбодын үхэл гэдгийг бүү мартаарай. Хүн биеийг эцэг эхээсээ олдог, олсон биеэ хоол хүнсээр торддог учир, тэр нь эмгэгт хялбархан өртөж, шарх сорви авах нь ч түргэн, эцэстээ эвдэрч нурах л

хувь тавилантай юм.

Бурханы мөн чанар бие махбодод нь бус, гэгээрэхэд нь оршино. Бие махбод эвдэрч нурна, гэтэл гэгээрэл нь Номын үнэн болон үйл хэрэг нь мөнх орших байдаг. Бие махбодыг минь харж буй хүн бус, харин сургаал номыг минь ухаарч буй хүн л намайг олж үзнэ.

Амьсгал хураасны минь дараа миний орхиж үлдээсэн ном та нарын багш болно. Та нар түүнийг хайрлан хадгалж, тэгснээр надад үнэнч зүтгэх ёстой.

Шавь нар минь, амьдралынхаа сүүлчийн 45 жилд би бээр айлдах ёстой болгоноо айлдсан, хийх ёстой бүхнээ хийсэн. Одоо та нарт үзүүлээгүй нууц надад байхгүй. Миний дотор ч тэр, миний гадна ч тэр хаана ч байхгүй. Би Номлох бүхнээ номлосон.

Шавь нар минь, миний цаг ирлээ. Би бээр Нирванд орлоо. Энэ бол миний сүүлчийн номлол юм.

II БӨЛӨГ

МӨНХИЙН БУРХАН

I

БУРХАНЫ НИГҮҮЛСЭНГҮЙ СЭТГЭЛ, ӨРГӨСӨН ТАНГАРАГ

1. Бурханы амин сүнс бол Дээд зэргийн нигүүлсэнгүй, дээд ээргийн энэрэнгүй сэтгэл билээ. Дээд зэргийн нигүүлсэнгүй сэтгэл нь ямар ч үнэ цэнээр хамаагүй бүх хүнийг аврах гэсэн Бурхан багшийн хүслэн юм. Дээд зэргийн энэрэнгүй сэтгэл нь хүмүүстэй хамт өвдөж зовох, тэдэнтэй хамт зовлон зүдгүүрийг туулах гэсэн Бурхан багшийн хүслэн юм.

Элбэрэлт эх лүгээ адил Бурхан багшийн сэтгэл нь хэнийг ч гэсэн цаг үргэлж анхааран хамгаалж, хооллож, аюултай мөч тулгарахад авардаг юм. Бурхан багш хүмүүсийг хэзээ ч үл орхино. Тэрбээр хүмүүс зовоход өөрөө адилхан зовж, хүмүүс баярлаж баясахад Өөрөө адилхан баясах бүлгээ.

Бурхан багш хүмүүст Дээд зэргийн нигүүлсэнгүй сэтгэлээр ханддаг. Хүмүүс энэхүү Дээд зэргийн нигүүлсэнгүй сэтгэлийг мэдэрч түүнд сүсэглэн биширч эхэлдэг юм. Сүсэг бишрэл нь гэгээрэх замд хөтөлнө. Үлгэрлэвээс эх хүн үрээ хайрлах сэтгэлээр эх болсныгоо мэддэгтэй энэ нь агаар нэгэн буй. Эхийн хайр ивээлээр үр нь ч гэсэн тав тухтай, бүлээн

дулаан амгалан тайван өсч бойжино.

Гэвч хүмүүс Бурхан багшийн энэ амин сэтгэлийг үл ухаарах бүлгээ. Тиймээс ч хорвоогийн тачаал шуналд олзлогдон, шаналал зовлонд автаж, төөрөлдөн тарчилна. Нүгэлт үйлийн үрээ даахгүй зовж, төөрөгдлийн нэг уулнаас нөгөө ууланд хэсүүчилнэ.

2. Бурхан багшийн нигүүлсэнгүй, энэрэнгүй сэтгэл зөвхөн энэ ертөнцийн амьдралаар үл хязгаарлагдана. Энэ чанар нь мөнхийн бөгөөд аливаа хил хязгаарт үл баригдана.Нигүүлсэнгүй, энэрэнгүй сэтгэл нь хүмүүс энэ ертөнцөд мэндэлж, төөрөлдөн зовж, шаналан тарчилсаар амьсгал хураадаг болсон цагаас эхлээд оршиж байсан юм.

Бурхан багш хүмүүсийн ертөнцөд тэдний хамгийн ойр дотно дүрийг олон төрж, тэднийг аврахын тулд бололцоотой бүхнийг хийдэг.

Бурхан багш Шагжа овгийн хааны гэрт хан хүүгийн дүрийг олон мэндэлж, хожим нь ордноо орхин явж, Өөрийн биеийг хатамжлан зовоож, дараа нь гэгээрч, ард түмэнд сургаалаа номлож, эцэст нь амьсгал хурааж, ингэснээр үхлийн мөн чанарыг хүмүүст үзүүлсэн юм.

Хүмүүсийн төөрөгдөл зах хязгааргүй, Бурхан багшийн ариун үйл хэрэг ч эцэс төгсгөлгүй бүлгээ.

Хүмүүсийн нүгэл хилэнцэд хил хязгаар үгүй бол, Бурхан багшийн нигүүлсэнгүй, энэрэнгүй сэтгэлд бас хил хязгаар үгүй.

Учир иймээс гэгээрэх зам мөрд орохдоо Бурхан багш дөрвөн их тангараг өргөжээ. Нэгдүгээрт, бүх хүнийг аварна. Хоёрдугаарт, бүх төөрөгдлийг устгана, Гуравдугаарт, бүх ном сургаалыг үзэж судална. Дөрөвдүгээрт, заавал гэгээрнэ Энэхүү дөрвөн их тангарагыг өргөж Бурхан багш Өөрийн гэгээрэх замыг эхэлжээ. Замын эхэнд энэ дөрвөн тангарагыг өргөсний учир нь Бурхан багшийн сэтгэл бол Дээд зэргийн нигүүлсэнгүй, энэрэнгүй, хүмүүсийг өрөвдөн хайрлаж, аврахын элгэн халуун хүслэн гэдэгт л оршино.

3. Юуны түрүүн Бурхан багш төгс төгөлдөр чанарыг эзэмшихийн тулд бусад амьтны амь хороохын нүглээс салж, хүмүүст урт удаан наслахын ерөөл айлджээ.

Бурхан багш хулгай хийх нүглээс салж, хүмүүс хүссэн бүхнээ хүртэж байхын ерөөл дэвшүүлжээ.

Бурхан багш бие махбодын шунал тачаалаас ангижирч, хүмүүс нэг нэгэндээ нүгэл хүсэхийг тэвчиж, цангах, өлсөхийн зовлонгоос ангижрахын ерөөл айлджээ.

Бурхан багш төгс төгөлдөр болохын тулд худал хэлэхийн нүгэлээс салж, зөвхөн үнэнийг хэлдэг хүмүүсийн санаа сэтгэлийн амгалан тайван байдлыг ухаарах ерөөлийг айлджээ.

Бурхан багш хов живийн нүглээс ангижирч, хүмүүс нэг нэгтэйгээ найртай, эв түнжинтэй амьдарч, зөв зам мөрийг хамтран хайж олохын ерөөл айлджээ.

Бурхан багш муу үг хэлэх нүглээс салж, хүмүүсийн санаа сэтгэл байнга энх амгалан, амар тайван байж, түгшүүрт үл автахын ерөөл айлджээ.

Тэрбээр дэмий чалчих дутагдлаас салж, хүмүүс нэг нэгэндээ анхаарал халамж тавьж байхын ерөөл айлджээ.

Бурхан багш төгс төгөлдөр чанар эзэмшихийн тулд хармын сэтгэлээс салж, хүмүүс өглөгч байхын ерөөл айлджээ.

Тэрбээр үзэн ядах сэтгэлээс ангижирч, хүмүүс бие биедээ энэрэнгүй хандаж байхын ерөөл айлджээ.

Бурхан багш харанхуй мунхагаас ангижирч, хүмүүс учир шалтгааны хуулий үл ойшоон төөрөлдөхгүй байхын ерөөл айлджээ.

Иймээс ч Бурхан багшийн нигүүлсэнгүй, энэрэнгүй сэтгэл бүгдэд зориулагдсан юм. Бурхан багш бүгдэд гагцхүү жаргалыг хүсэн ерөөдөг билээ. Бурхан багш эцэг эхийн хайраар хүн төрөлхтнийг энэрэн хайрлаж, төөрөгдлийн далайг эсэн мэнд даван туулах ерөөл айлддаг юм.

II
БУРХАНЫ АВРАЛ, ТҮҮНИЙ ТУСЫН МУТАР

1. Гэгээрлийн эрэг дээр зогсч буй Бурхан багшийн дуу хоолой төөрөгдлийн далайд живж байгаа хүмүүсийн сонорт хүрдэггүй. Тиймээс Бурхан багш Өөрийн биеэр төөрөгдлийн далайд орж, хүмүүст туслахын тулд мутраа сунгасан юм.

Нэгэн сургамжит домогт өгүүлснээр, эрт урьд цагт баян хүн амьдарч байжээ. Нэг удаа гэрт нь гал гарчээ. Тэрбээр ажил хэргээр яваад эзгүй байсан тул буцаж ирээд галд автсан гэрээ үзжээ. Баян хүн галд автсан байшин дотор тоглож байсан хүүхдүүдээ дуудахад цаадуул нь гал гарсныг анзааралгүй тоглосоор байлаа.

Эцэг нь хүүхдүүддээ хандаж хашгирсан нь: “Хүүхдүүдээ амиа аварцгаа! Наад байшингаасаа шалавхан гарцгаа!" гэхэд хүүхдүүд нь сонссонгүй.

Айж сандарсан эцэг дахин хашгирсан нь: “ Хүүхдүүдээ би хөөрхөн тоглоом авчирлаа. Май, гарч ирээд авцгаа". Тоглоомын тухай сонссон хүүхдүүд шатаж буй байшингаас гүйн гарч аврагджээ.

Бидний амьдрал шатаж буй байшин лугаа адил билээ. Гэвч хүмүүс байшин нь галд автсаныг эс анзааран, амь насаа алдах гэж буйгаа мэдэлгүй шатаж буй байшиндаа амьдарч байдаг. Иймээс Бурхан багш Дээд зэргийн нигүүлсэнгүй сэтгэлийг үзүүлж, хүмүүсийг аврахын тулд бололцоотой бүхнийг байнга хийдэг юм.

2. Өөр нэгэн сургамжтай домогт өгүүлснээр, эрт цагт нэгэн баян хүний ганц хүү, эцгийн гэрийг орхин хорвоо ертөнцөөр хэрэн хэсч яваад золгүй явдалтай учирч ядуу хоосны туйлыг үзжээ.

Эцэг нь орон гэрээ орхиж, тэнэмэл хүүгийнхээ эрэлд гарчээ. Тэрбээр хүүгээ газар сайгүй хайгаад хаанаас ч олсонгүй.

Чингээд олон арван жил өнгөрөв. Ядуурч хоосорсон хүү нь баян чинээлэг эцгийнхээ сууж байсан хотод санамсаргүй очжээ.

Хүүгээ таньсан аав нь баярласандаа дэвхцэж, түүний араас зарцаа илгээв. Гэвч хүү хэлүүлсэнд нь

үл итгэв. Хууртаж мэхлүүлэхээс айсан хүү нь аав дээрээ очсонгүй.

Чингээд эцэг нь зарцаа дахин илгээж сайн хөлс төлье, манайд ирж ажиллаач хэмээн хэлүүлжээ. Хүү нь энэ мэхэнд гэнэдэн зөвшөөрч аавынхаа гэрт зарц болов.

Баян эцэг нь гэртээ ажиллаж буйгаа үл анзаарах хүүдээ улам бүр хариуцлагатай ажил даалгаж, нэгэнтээ үнэт баялгаа хадгалсан агуулахын түлхүүр өгчээ. Тэгсэн ч хүү нь эцгийнхээ гэрт ажиллаж буйгаа ухаарсангүй.

Хүү нь дуулгавартай бөгөөд хөдөлмөрч болсонд эцэг нь учиргүй баярлаж байлаа. Тэрбээр удалгүй амьсгал хураах цаг ирэхийг мэдэж, нэг өдөр төрөл төрөгсөд, найз нөхөд, ойр дотныхноо дуудан цуглууж хэлсэн нь: "Энэ хүү минии төрсөн үр юм. Олон жилийн турш эрж хайсан хүү минь юм. Энэ мөчөөс эхлэн хураасан бүх эд баялаг минь түүнд шилжин очно" гэв.

Үүнийг сонссон хүү гайхаш алдаж: "Би бээр эцгээ олоод зогссонгүй, санаандгүй энэ бүх баялгийн эзэн болдог байж" гэв.

Энэ сургаал — домогт баян хүн нь бурхан

багшийг, төөрсөн хүү нь нийт хүмүүсийг төлөөлж байгаа юм. Эцгийн хайр нь цорын ганц хүүдээ хандсан лугаа адил бурхан багшийн нигүүлсэнгүй, энэрэнгүй сэтгэл нь энэ газар дэлхий дээрх бүх хүнд хандана. Бурхан багш хүн бүрийг хүү шигээ бодон сургаж, гэгээрэхийн баялгийг өгч баян болгодог юм.

3. Бүх хүмүүсийг хүү шигээ хайрладаг Бурхан багшийн Дээд зэргийн энэрэнгүй сэтгэл бүгдэд ижил оногдох боловч, хүн бүрийн зан араншин өөр байх лугаа адил тэднийг аврах арга зам ч өөр буй. Зүйрлэвэл, бороо нь бүх өвс ногоо, мод цэцгийг ижилхэн усалдаг боловч өвс ногоо, мод цэцэг бүр түүнээс өөрийн хувийг янз янзаар хүртэх бүлгээ.

4. Эцэг эх хичнээн ч олон үр хүүхэдтэй байсан, цугааранд нь адил тэгш, ойр дотно ханддаг. Тэдний дундаас нэг нь өвдөж зовбол түүнийг бусдаас илүү хайрлах бүлгээ.

Үүн лүгээ адил Бурхан багшийн дээд зэргийн энэрэнгүй сэтгэл бүгдэд ижилхэн хүрэх боловч, Хүнд хүчир нүгэл үйлдэж, мунхгаасаа болж зовж шаналж буйг нь Тэрбээр илүү хайрлаж,илүү энэрдэг юм.

Нар зүүнээс мандахдаа харанхуйг сарниаж, газар дээр буй бүхэнд гэрлээ тэгшхэн хүртээж тэтгэх адил Бурхан багш хүмүүсийн дунд орж нүглийг арилган,

буяныг дээдлэн үржүүлж оюун ухааны гэрлийг түгээж, мунхгийн харанхуйг арилгаж, хүмүүсийг гэгээрэх зам мөрд хөтөлдөг юм.

Бурхан багш бол халамжит эцэг, нигүүлсэнгүй эх юм. Бурхан багш нигүүлсэнгүй, энэрэнгүй сэтгэлийн үүднээс энэ дэлхийн бүх хүний сайн сайхны тулд хүчин зүтгэдэг юм.

Бурхан багшийн энэрэнгүй, нигүүлсэнгүй сэтгэл үгүйгээр хүмүүс яагаад ч аврагдаж чадахгүй. Хүмүүс цугаараа Бурхан багшийн хүүхэд тул өөрсдийг нь аврахаар сунгасан Бурхан багшийн мутарт мөргөх хэрэгтэй.

III
МӨНХИЙН БУРХАН

1. Бурхан багш хан хүү болж мэндэлсэн, дараа нь даянч болохоор ордноо орхин явсан, чингээд гэгээрсэн гэж хүмүүс боддог. Гэтэл үнэн хэрэг дээрээ Бурхан багш энэ ертөнцөд хэзээ ч байж байдаг. Түүнд эхлэл ч үгүй, төгсгөл ч үгүй.

Мөнх орших Бурхан багш хүн бүрийг сайн мэдэх бөгөөд хүмүүсийг бололцоотой бүх аргаар авардаг.

Бурхан багшийн номлодог мөнхийн номд худал

Хуурмаг зүйл үгүй. Бурхан багш энэ ертөндөд буй бүх юмсыг яг байгаагаар нь мэддэг, мэддэгээ ч хүмүүст зааж номлодог.

Ертөнцийн бүх юмсыг яг байгаагаар нь танин мэдэх хэцүү. Учир юун гэвэл энэ ертөнцөд зөв мэт санагдаж буй юм нь үнэн хэрэг дээрээ буруу байдаг. Харин буруу мэт санагдсан нь зөв байдаг. Мунхаг хүмүүс энэ ертөнцийг ухаж ойлгож чадахгүй.

Гагцхүү Бурхан багш л бүх юмыг байгаагаар нь ухаарч чадна. Учир иймээс Тэрбээр энэ зөв, тэр буруу гэж хэлдэггүй, энэ сайн, тэр муу гэж ярьдаггүй, харин байгаагаар нь яг оножхэлдэг.

Бурхан багш сургах нь: “Бүх хүн зан ааш,үйл хэрэг, сүсэг бишрэлийнхээ дагуу буян хийх ёстой".

2. Бурхан багш гагцхүү үгээр бус үйл хэргээрээ зааж сургана. Хэдийгээр Бурхан багшийн амьдрал эхлэл үгүй, төгсгөл үгүй боловч Тэрбээр тачаал шуналдаа автан амьдарч буй хүмүүсийн нүдийг нээж өгөхийн тулд, Өөрийн үхлээр хүний мөнх бусыг харуулахын тулд үхдэг.

Үлгэрлэвэл манайд олон хүүхэдтэй нэг оточ буй. Нэгэнтээ тэрбээр хөрш гүрэн рүү явжээ. Түүний эзгүйд хүү нь хор ууж, бие нь мууджээ. Хол газраас эргэж ирсэн оточ айн сандарч тэдэнд эм тан өгөв.

Эвдрээгүй хөөрхөн ааштай хүүхдүүд нь өгсөн эмийг ууж эдгэхэд, зан чанар эвдэрсэн нь эм уухаас татгалзжээ.

Хүүхдээ эмчлэхийн тулд оточ эцэг заль хэрэглэхээр шийдэж, тэдэнд хэлсэн нь: "Би урт удаан аян замд гарах боллоо. Нас сүүдэр өндөр тул хэзээ амьсгал хураахаа мэдэхгүй. Хэрэв намайг ҮХСЭН гэж дуулвал миний үлдээсэн эмийг ууж эдгээрэй". Чингээд тэрбээр холын аянд дахин гарчээ. Тэрбээр зарцаа замаасаа буцааж өөрийгөө таалал төгссөн гэж хүүхдүүддээ хэлүүлжээ.

Үүнийг дуулсан хүүхдүүд нь гүн их уй гашууд автаж: "Эцэг маань нас барлаа. Одоо биднийг өмгөөлж хамгаалах хүнгүй болов" хэмээн уйлалдав. Уй гашууд автаж, гуньж гутарсан хүүхдүүд эцгийнхээ захиасыг санаж үлдээсэн эмийг нь ууж цугаараа эдгэрчээ.

Оточ эцгийн худал хэлснийг буруушааж болох уу? Бурхан багш энэ оточ лугаа адил бүлгээ. Хүслийн хүлээсэнд баригдаж сохорсон хүмүүсийг аврахын тулд Тэрбээр энэ ертөнцөд төрөх, үхэх хоёулаа буйг хүмүүст үзүүлсэн юм.

III БӨЛӨГ

БУРХАН БАГШИЙН ДҮРҮҮД, ТҮҮНИЙ БОДЬ ЧАНАРУУД

I

БУРХАН БАГШИЙН ГУРВАН ДҮР

1. Бурхан багшийг ямар нэгэн дүр, хэлбэрээс хайж олохыг эрмэлзэх хэрэггүй. Дүр, хэлбэрийн аль нь ч жинхэнэ Бурхан багш биш. Жинхэнэ Бурхан багш бол гэгээрлээс өөр юу ч биш. Гэгээрсэн хүн л жинхэнэ Бурхан багшийг олж харна.

Хэрэв хэн нэгэн нь Бурхан багшийн гайхамшигтай сайхан дүр зургийг үзчихээд Бурхан багшийг харлаа гэвэл энэ нь мунхаг нүдний гэм юм. Бурхан багшийн жинхэнэ дүр хэнд ч харагдахгүй. Ямар ч өнгө будгаар Бурхан багшийг дүрсэлж, ямар ч үг, найруулгаар Бурхан багшийн дүрийг тодорхойлж болохгүй.

Дүр төрхтэй л бол тэр нь Бурхан багш биш юм. Бурхан багш дүр төрхгүй. Үүний сацуу Бурхан багш гайхамшигтай сайхан бүх дүрээр илэрнэ.

Бурхан багш өөрийгөө ямар ч хэлбэрээр илэрхийлсэн, түүнээс үл шалтгаалан, хэн нэгэн нь Бурхан багшийг ноттой олж үзвэл энэ нь тэрбээр Бурхан багшийг харах чадвартай боллоо гэсэн үг ээ!

2. Бурхан багшийн бие цогцос нь гэгээрэл буюу эвдэрч нурахыг мэдэх мөнхийн бүтээл туурвил юм.

Энэ бол хоол хүнсээр тэжээгддэг бие махбод бус, харин тэр чигээрээ оюун ухаан бүхий мөнхийн цогцос юм. Тэр цогцос айх эмээх, өвдөж зовохын алийг ч үл мэднэ. Тэр цогцос мөнхийн хувиршгүй чанартай.

Тиймээс Бурхан багш хэзээ ч үл эвдэрнэ. Гэгээрэл мөхөөгүй цагт Бурхан багш үл мөхнө. Гэгээрэл нь хүмүүсийг сэхээрүүлэгч Бурхан багшийн ертөнцийг буй болгогч оюун ухааны гэрэл гэгээ маягаар илэрнэ.

Эл ҮНЭНИЙГ таньж мэдсэн хүн Бурхан багшийн хүү юм уу, охин нь болж, Бурхан багшаас сургаалыг нь хүртэж, тууштай даган мөрдөж, хойч үедээ уламжлуулан өвлүүлж чадна. Бурхан багшийн хүч чадлаас илүү гайхамшиг үгүй.

3. Бурхан багш гурван цогцостой. Нэг нь Дхармакая буюу Бурхан багшийн жинхэнэ мөн чанар юм. Хоёр дахь нь Самбхогакая буюу Бурхан багшийн дотоод нөөц хүч юм. Гурав дахь нь Нирманакая буюу Бурхан багшийн илрэх хэлбэр юм.

Дхармакая бол Ном өөрөө мөн. Ном нь үнэн болон үнэнийг оновж гэгээрсэн оюун ухаан хоёрын нэгдэн нийлэхийн нэр юм.

Ном бол Бурхан багш өөрөө мөн. Бурхан багш тодорхой өнгө, хэлбэргүй болохоор Тэрбээр хаанаас ч ирдэггүй, хаашаа ч явдаггүй. Хаанаас ч ирдэггүй хаашаа ч явдаггүй учир Тэрбээр хаа сайгүй оршино. Зах хязгааргүй тэнгэр огторгуй лугаа адил Тэрбээр бүхний болон бүгдийн дээр оршино.

Бурхан багш байдаг гэж хүмүүс боддогоос Бурхан багш буй юм бус. Бурхан багшийг мартдагаас Бурхан багш алга болдог юм биш. Тэрбээр хүмүүс баярлаж баясахад ирдэг, залхуурч лазагнахад явдаг ч юм биш. Бурхан багш, хүмүүс юу бодож, мэдэрдэгээс үл шалтгаалан энд тэнд, хаа сайгүй оршино.

Бурхан багшийн бие цогцос бүх сав шимийн ертөнцийг дүүргэн, хаа сайгүй оршино. Хүмүүс түүний тухай юу ч бодсон Бурхан багшийн цогцос мөнхийн чанартай юм.

4. Самбхогакая бол тодорхой хэлбэргүй Дхармакая Бурханы илрэл юм. Зовж зүдэрсэн олон амьтныг аврахын тулд Тэрбээр ямар нэгэн дүр төрхөнд хувилан тэдний дунд буй болж, тэдний төлөө залбирч, махбодоо хатамжлан тарчлааж, Өөрийн

ариун нэрийг нэрлэж, хүмүүсийг аврал өөд дагуулан явдаг.

Энэхүү Бурханы мөн чанар Дээд зэргийн нигүүлсэнгүй сэтгэлд оршино. Тэрбээр хүмүүсийг бололцоотой бүх аргаар аварна. Тэрбээр бүхнийг шатаагч гал лугаа адил ертөнцийн тачаал шуналын түлээ модыг шатааж дуусгана. Тэрбээр тоос арилгагч салхи лугаа адил төөрөгдлийн тоосыг сарниан замхруулна.

Нирманакая бол өмнө нь хэнбугай байгаагаас шалтгаалан тохирсон дүрийг олж хүмүүсийг аврахаар бууж ирдэг Бурхан юм. Тэрбээр энэ ертөнцөд мэндэлж, ертөнцийн амьдралыг огоорон орхиж гэгээрдэг юм. Тэрбээр бололцоотой бүх аргаар хүмүүсийг зөв замд нь оруулахын тулд номлон сургаж, тэдэнд өвчин зовлон, үхэл хагацлыг үзүүлэн сэрэмжилдэг.

Бурхан багшийн язгуур бие цогцос нь Дхармакая юм. Гэвч хүмүүс олон янзын зан араншинтай тул, Тэрбээр олон дүр төрхөд хувилж тодордог. Хэдийгээр Бурхан багшийг эрж хайж буй хүмүүс санаа сэтгэл, биеэ авч явах онцлог, авьяас чадвараасаа шалтгаалан Бурхан багшийн олон дүрийг үзэж хардаг боловч Бурхан багш тэдэнд нэг л үнэнийг номлодог.

Бурхан багшийн бие цогцос гурван өөр цогцост хуваагддаг ч ганцхан зорилгод хүрэхийн тулд чингэдэг юм. Эл зорилго хүмүүсийг аврахад оршино.

Бурхан багшийн эцэс төгсгөлгүй мөнхийн бие цогцос нь хорвоо ертөнцөд, хаа сайгүй буй болдог ч, Бурхан багш бие махбодгүй учир энэ цогцос Бурхан багш бус юм. Бурхан багшийн бие цогцос нь гэгээрэл юм, энэ ертөнцөд гэгээрэл бүхнийг дүүргэнэ. Бурхан багш үнэнийг ухаарсан хүний өмнө заавал буй болдог.

II
БУРХАН БАГШ БУЙ БОЛОХ НЬ

1. Бурхан багш энэ ертөнцөд тодрох нь ховор. Одоогоор энэ ертөнцөд Бурхан багш нэгэнт гэгээрч, Номоо номлож, эргэлзлийн тор, шунал хүслийн үндсийг таслаж, нүглийн нүх уурхайг хаан таглаж байна. Тэрбээр энэ ертөнцөд ямар ч саад бэрхшээлгүй, эрх чөлөөтэй явж байна. Бурхан багшийг хүндэтгэн бишрч, энэрэн хайрлахаас илүү дээд буян үгүй.

Бурхан багш Номоо номлож, хүмүүст жинхэнэ зол жаргал хайрлахын тулд хорвоод мэндэлдэг. Бурхан багш зовж шаналсан олон амьтныг гаргуунд нь орхиж чадахгүй учраас зовлонгоор дүүрсэн энэ

Бурхан ертөнцөд өөрөө залардаг.

Үнэн байдаггүй, худал хуурмаг явдал ноёрхдог энэ замлинд хүмүүс хүслийнхээ эргүүлэгт живж, бие бялдар, зан суртахууны хувьд ялзардаг. Энд амьдрал нүд ирмэх зуур өнгөрөх тул Ном номлоход бэрх байдаг. Гагцхүү хүмүүст Дээд зэргийн энэрэнгүй сэтгэлээр ханддаг болоод Бурхан багш эдгээр хэцүү бүхнийг давдаг юм.

2. Бурхан багш энэ ертөнцөд Хүн бүхний хамгийн ойр дотны анд нөхөр юм. Тэрбээр хорвоогийн шунал тачаалын хүнд ачаан дор зовж зүдэрсэн хэн нэгнийг олж харвал, хүнд ачааг нь Өөрийн нуруунд үүрнэ.

Бурхан бол энэ ертөнцийн жинхэнэ багш юм. Тэрбээр төөрөлдөн зовсон мунхаг хүнийг олж харвал оюун ухааны гэрлээр нүдний гэмийг нь арилгаж харанхуй мунхгийг нь сарниана.

Тугал эхээсээ нэг ч алхам холдохгүйн адил Бурхан багшийн сургаалыг таньж мэдсэн хүн Түүнээс холдож үл чадна. Учир нь түүний сургаалыг сонсох нь хэзээд баяр баясгалан төрүүлнэ.

3. Сар шингэхэд хүмүүс сар далд орлоо, сар мандахад сар гараад ирлээ гэлцдэг. Гэтэл тэнгэр огторгуйд сар үргэлж оршиж буй бөгөөд хэзээ ч далд

орж, ил гарч ирдэггүй. Үүнтэй Бурхан багш агаар нэгэн буй. Бурхан багш мөнх оршдог. Тэрбээр төрдөг ч үгүй, үхдэг ч үгүй. Тэрбээр зөвхөн хүмүүсийн нүдийг нээж, үнэнийг үзүүлэхийн тулд төрж, үхдэг.

Хүмүүс хавирган сар, тэргэл сар гэж ярьдаг. Үнэн хэрэг дээрээ сар ихсэх ч үгүй, багасах ч үгүй, үргэлж тэргэл хэвээр л буй. Үүнтэй Бурхан багш агаар нэгэн буй. эрбээр үл төрж, үл үхнэ. Хүмүүс л Түүнийг төрж, үхэж байна гэж бодмуй.

Сар бүхнийг, бүгдийг гэрэлтүүлнэ. Хот, тосгон, уулс, ус, гол мөрөн, ваар сав, навчисын үзүүрт чичрэх шүүдрийн дусал гээд л бүгдийг гийгүүлнэ. Хүн сартай шөнө явж байхад сар араас нь үргэлж дагана. Саран авхай үл хувирна, гэвч өөр рүү нь харж буй хүнээс шалтгаалан хүн бүрт өөр өөр харагдана. Үүнтэй Бурхан багш агаар нэгэн буй. Тэрбээр хүмүүсийн араас үргэлж дагаж тэдний өмнө янз бүрийн дүр төрхөөр тодорно. Гэвч Бурхан багш мөнх оршиж, Тэрбээр үл хувирч өөрчлөгдөнө.

4. Бурхан энэ ертөнцөд учир шалтгааны улмаас буй болж, алга болдог.Хүмүүсийг аврах нөхцөл бүрдэхэд Тэрбээр энэ дэлхийд буй болно. Бүрдсэн нөхцөл арилахад Тэрбээр энэ дэлхийгээс халин одно.

Хэдийгээр Бурхан багш аливаа дүрийг

олохдоо төрж, үхдэг боловч үнэн хэрэгтээ Тэрбээр үл мэндэлж, үл үхнэ. Үүнийг ухаарч, Бурхан багшийн төрөх, үхэх хийгээд орчин тойрон байнга хувиран өөрчлөгдөж буйг харан гайхах, гуньж гутрахыг болих хэрэгтэй. Харин гэгээрч дээд зэргийн оюун ухааныг олвол зохино.

Бурхан багш бие махбодгүй, харин гэгээрэхийн биелэл юм. Бие махбод болбоос хоосон сав лугаа адил.Хэрэв энэ савыг гэгээрлээр дүүргэвэл Бурхан багш болно Бие махбодыг Бурхан багш хэмээн сэтгэж, Түүний бие махбодын үхэлд уйтгарлан гашуудсан хүн жинхэнэ Бурхан багшийг олж харж үл чадна.

Үнэн хэрэгтээ юмс хоосон чанартай, тэдгээрийн хооронд өчүүхэн бээр ялгаа үгүй. Юмс төрөх, эвдрэх, ирэх, одох, буян нүглээс үл шалтгаалан оршино.

Юмсын ялгаа зөрөө нь тэдгээрийг харж буй хүмүүсийн буруу санаанаас үүднэ. Үүнтэй Бурхан багшийн дүр агаар нэгэн буй. Жинхэнэ Бурхан багш хэзээ ч буй болж, хэзээ ч үгүй болохгүй.

III
БУРХАН БАГШИЙН БОДЬ ЧАНАР

1. Бурхан багш дараах таван бодь чанартай учир түүнийг бүгд хүндэлдэг. Үүнд: биеэ зөв авч явах

чадвар, суут үзэл бодол, суут оюун ухаан, суут номлох чадвар, хүмүүсийг зөв замд оруулах суут чадвар багтана.

Түүнээс гадна Бурхан багш дараах найман чадвартай.Үүнд: нэгдүгээрт, Тэрбээр хүнд зол жаргал, сайн сайхныг авчирдаг. Хоёрдугаарт, Бурхан багшийн сургаал энэ ертөнцөд ашиг тус болдог. Гуравдугаарт, Тэрбээр нүгэл, буян, үнэн, худлын тухай зөв зүйтэй сургадаг. Дөрөвдүгээрт, Тэрбээр зөв зам мөрийн тухай зааж сургаад, хүмүүсийг гэгээрэлд залж авчирдаг. Тавдугаарт, Тэрбээр бүх хүнийг нэг л замаар дагуулан явдаг. Зургадугаарт, Бурхан багш биеэ тоох, онгирч сагсуурахыг үл мэднэ. Долдугаарт, Тэрбээр хэлсэн үгэндээ эзэн болж, юу хэлсэн яг түүндээ хүрдэг. Наймдугаарт, Тэрбээр өргөсөн тангараг, хүртсэн сахилаа заавал баримталж биелүүлдэг.

Бурхан багш бясалгалаар дамжин энх амгалан, амар тайван байдлыг олж, бүгдэд тэнцүүхэн энэрэнгүй бөгөөд нигүүлсэнгүй сэтгэлээр ханддаг. Тэрбээр атгаг сэтгэлээс бүрэн ангижирч, санаа сэтгэлээ муу муухайгаас чөлөөлж, зөвхөн ариун цагаан сэтгэлтэй хүний хүртэх тийм жаргал цэнгэлд хүрдэг.

2. Бурхан багш бол бүх хүний эцэг нь ч, эх нь ч

мөн. Мэндэлснээс нь хойш 16 сарын турш хүүхэдтэйгээ нялхын хэлээр нь ойлголцож, дараа нь том хүмүүсийн хэл зааж сургаж эхэлдэг эцэг эх лүгээ адил.

Бурхан багш хүмүүсийн ярьдаг хэлээр сургаалаа айлдаж, хүмүүсийн өмнө буй болохдоо тэдний таних дүрийг олж тодрон тэд нарыг амар амгалан, тайван ертөнцөд залж аваачдаг.

Бурхан багш сургаалаа нэг хэлээр номлох атал бүх хүн өөрийнхөөрөө ойлгож, Бурхан багш зөвхөн өөрт нь хандаж байна хэмээн боддог бүлгээ.

Бурхан багшийн сэтгэл санааг төөрөлдөгсөд үл ойлгоно, түүний үгээр илэрхийлэх аргагүй, гагцхүү сургаал домгоор тайлбарлаж болно.

Хэдийгээр Ганга мөрнийг яст мэлхий, загас жараахай, заан болон бусад ан амьтан бохирдуулж байдаг боловч ус нь цаг ямагт цэвэр цэнгэг байдаг. Үүнтэй Бурхан багш агаар нэгэн буй. Өөр шашин шүтлэгийн загас жараахай, яст мэлхий сүрэг сүргээрээ явж ус ундааг бохирдуулж булингартуулсан ч Бурхан багшийн Ном цэвэр цэнгэг, намуун тогтуун хэвээр үлдэнэ.

3. Бурхан багшийн оюун ухаан бүх үнэнийг мэднэ.

Бурхан багш аливаа туйлширлаас зайлсхийж ямагт дундад зам мөрийг баримталдаг юм. Аливаа бичиг үсэг, хэлээс хол давсан байдаг учир Тэрбээр хорвоогийн бүх хүний бодол санааг тод томруун уншиж нэгээхэн агшинд оюун ухаандаа орчлонт ертөнцийг бүхэлд нь багтаадаг.

Зах хязгааргүй тэнгис далайн усанд бүх од мичид багтан тусдагтай адил Бурхан багшийн оюун ухааны далайд бүх хүмүүсийн бодол санаа, бүх юмс нэгэн зэрэг тусмуй. Тиймээс Бурхан багшийг Бүхнийг мэдэгч хэмээдэг.

Бурхан багшийн оюун ухаан, хүмүүсийн санаа сэтгэлийн цангааг тайлж, тэдэнд гэрэл гэгээ хайрлаж, амьдралын утга учрыг номлож, цэцэглэн дэгжих болон мөхөн сүйрэх, учир шалтгаан болон үр дагаврын үнэнийг нээн харуулна. Гагцхүү Бурхан багшийн оюун ухааны дэмээр хүмүүс энэ хорвоог танин мэднэ.

4. Бурхан багш хүмүүсийн өмнө гагцхүү Бурхан багшийн дүрээр буй болдоггүй. Заримдаа Тэрбээр шулам, эмэгтэй хүн, бурхан, эзэн хаан, сайдын дүрээр ч тодордог. Тэрбээр янхан эм, мөрийтэй тоглогчийн гэрт ч залардаг.

Халдварт өвчин тархсан цагт Бурхан багш эмч

болж, бүгдэд эм тан тарааж, сургаал номоо хайрлана. Дайн дажин дэгдсэн цагт хүмүүсийг зовлон сүйрлээс аварч зайлуулахын тулд тэдэнд гэгээн сургаалаа айлддаг. Тэрбээр ганцхан үзлээ хатуу чанд баримтлах хүнд энэ ертөнцөд мөнхийн тогтонги юм үгүйг сургана. Тэрбээр биеэ тоож, амиа хичээсэн хүнд төлөв даруу байх, бусдын төлөө бие сэтгэлээ үл хайрлахыг номлоно. Тэрбээр энэ ертөнцийн зугаа цэнгэлд хууртсан хүнд хорвоогийн зовлон зүдүүр, аюул сүйрлийг үзүүлж харуулна.

Амьдралын аливаа тохиолдолд илрэх Бурхан багшийн бүх үйл хэрэг Дхармакая (Бурхан багшийн үнэмлэхүй мөн чанар)-гаас үүдэн гардаг. Бурхан багшийн эцэс төгсгөлгүй амьдрал, авралын эцэс төгсгөлгүй гэрэл гэгээ нь мөн адил Дхармакаягаас гарна.

5. Энэ ертөнцийн амьдрал шатаж буй байшинд байгаа мэт амар тайван бус. Хүмүүс мунхагийн харанхуйд автаж, хэрэлдэн уралцаж, атаа жөтөөнд өртөж, нэг нэгэндээ тунин гомдож, ертөнцийн шунал тачаал амьдралыг нь хиртээж хордуулна. Нялх хүүхдэд эх нь хэрэгтэйн адил хүмүүст Бурхан багшийн энэрэнгүй, нигүүлсэнгүй сэтгэл үгүйлэгдэнэ.

Бурхан багш ариун явдалтай бүхнээс хамгийн ариун явдалтай нь болой. Тэрбээр энэ орчлонгийн

эцэг нь юм. Тиймээс бүх хүн түүний үр хүүхэд юм. Тэд гагцхүү зугаа цэнгэл хөөцөлдөж, аюул сүйрлийг урьдчилан харах оюун ухаангүй юм. Энэ хорвоо зовлон зүдүүрээр дүүрэн, энд үргэлж өтлөж өвгөрөх, өвдөж зовох, үхэх мөхөхийн гал сүүмэлзэж байдаг юм.

Харин Бурхан багш төөрөгдөл бүхий, галд автсан ертөнцийн гадна, чимээ аниргүй ойд буй бөгөөд түүний айлдах нь:

"Энэ бол миний ертөнц, энд амьдарч буй хүмүүс цугаараа миний үр хүүхэд юм. Гагцхүү би тэднийг эцэс төгсгөлгүй зовлон зүдүүрээс аварч чадна".

Бурхан багш бол үнэхээр Номын агуу их хаан мөн. Тэрбээр сургаалаа хүссэнээрээ номлож чадна. Бурхан багш хүмүүсийг амарлингуй болгож, тэдэнд зол жаргал авчрахын тулд энэ ертөнцөд заларсан юм. Тэрбээр хүмүүсийг зовлон зүдүүрээс аврахын тулд Номоо номлодог. Гэвч хүмүүс хүсэл шуналаасаа болж түүний хэлснийг үл сонсож, түүнд анхаарлаа үл хандуулдаг юм.

Харин энэ сургаалыг сонсоод баярлаж баяссан хүмүүс шинэ ертөнцөд очиж тэндээс төөрөгдлийн мананд эргэж унахгүй. Бурхан багшийн хэлснээр "Миний сургаалыг зөвхөн түүнд сүсэглэн итгэсэн

Хүмүүс хүлээн авч чадна. Гагцхүү Бурхан багшид сүсэглэн итгэснээр энэ сургаалыг ойлгохоос бус ухаанаар эс ойлгоно". Иймээс Бурхан багшийн сургаалыг анхааралтайяа сонсож, чанд мөрдвөөс зохино.

HOM

I БӨЛӨГ

УЧИР ШАЛТГААН

I

ДӨРВӨН ҮНЭН

1. Энэхүү хүний ертөнц зовлон зүдүүрээр дүүрэн. Амьдрах нь зовлон, өтлөх нь зовлон, өвдөх нь зовлон, үхэх нь зовлон. Дургүй хүргэх хүнтэй учрах нь зовлон, хайртай хүнээсээ хагацах нь зовлон. Хүссэндээ хүрэхгүй бол мөн адил зовлон. Аливаа юманд дасах нь зовлон. Энэ бол зовлонгийн үнэн юм.

Ахуй орчлонгийн зовлон зүдүүр, хүний санаа сэтгэлд цөмрөн ордог тачаал шуналаас үүддэг нь эргэлзээгүй. Ертөнцийн тачаалын үндэс шунал нь асар хүчтэй хүслэнгээс ургана.Энэхүү шунал амьдралд учиргүй дассанаас үүднэ. Нүд харж, чих сонсож буй бүхнийг хүн хүсч эхэлдэг. Тэр ч бүү хэл, үхэхийг ч хүсэх нь буй. Энэ бол зовлонгийн учир шалтгааны үнэн юм.

Хэрэв ертөнцийн тачаал шуналын бүх үндэс язгуурыг устгаж, дасаж дадсанаасаа салж ангижирвал зовлон арилна. Энэ бол зовлонг дарж устгахын үнэн мөн.

Зовлонгоос салахын тулд найман зөв зам мөрийг хөөх хэрэгтэй. Эдгээр нь зөв үзэл, зөв бодол, Зөв үг,

зөв үйл, зөв амьдрах, зөв тэмүүлэх, зөв санаж дурсах, ухаан санаагаа зөв төвлөрүүлэх болой.Энэхүү цангааг тайлагч найман мөрийг зөв замын үнэн хэмээнэ.

Энэ ертөнц зовлонгоор дүүрэн тул эдгээр үнэнийг гүн гүнзгий ухаарвaас зохино. Зовлон зүдүүрээс хагацахын тулд хорвоогийн тачаал шуналаас салах хэрэгтэй. Шунал тачаалаас ангид байдалд зөвхөн гэгээрснээр хүрч болно. Гэхдээ энэхүү наймтын замыг л дагавал гэгээрнэ.

2. Номыг дагасан хүн энэхүү дөрвөн ариун үнэнийг ухаарах ёстой. Эдгээрийг ухаараагүй нь харанхуйд удтал төөрнө. Эдгээр ариун үнэнийг ухаарсан хүнийг гэгээрсэн гэж дуудна.

Бурхан багшийн сургаалыг дагахыг хүссэн хэн бүхэн хүч чадлаа шавхан энэ дөрвөн ариун үнэнийг зөв ухаарвaас зохино. Ямар ч цаг үед аливаа ариун явдалтан үнэхээр ариун сэтгэл юутай бол эдгээр үнэнийг ухаарч, бусдад номлоно.

Хүн эдгээр дөрвөн ариун үнэнийг ухаармагц анх удаа хүсэл шуналаас ангижирч, хүмүүстэй маргалдахаа больж, бусдын амь насанд халдах, хулгай хийх, буруугаар хурьцах, хуурч мэхлэх, хараaж загнах, бялдуучлах, атаархах, уурлаж

Уцаарлахыг орхиж, оршихын мөнх бусыг ямагт санаж, зөв замаас хазайж хэлтийхгүй болно.

3. Номыг дагавал харанхуй өрөөнд бамбар асааж орсон хүнтэй адил буюу. Түнэр харанхуй сарнин замхарч эргэн тойрон гэрэл гэгээ түгнэ.

Хэрэв Номыг дагаж буй хүн дээрх дөрвөн үнэнийг ухаарвал, мунхагийн харанхуйг арилгагч оюун ухааны зулыг олно.

Бурхан багш зөвхөн энэ дөрвөн үнэнийг зааж, хүмүүсийг зааж сургадаг.Түүний сургаалыг зөв хүлээн авсан хүн эдгээр үнэний ачаар энэхүү мөнх бус ертөнцөд гэгээрч, өөрөө бусад хүмүүсийг хамгаалж, тэдний түшиг тулгуур болно.

Учир нь эдгээр үнэнийг ухаарснаар ертөнцийн шунал тачаалын эх булаг болсон харанхуй мунхгийг арилгана.

Эдгээр дөрвөн үнэнийг ачаар Бурхан багшийн шавь нар бүх ном сургаалыг эзэмшиж, ертөнцийн бүх үнэнийг ухаарагч оюун ухаан болон бодь чанаруудыг олно. Тэд, Бурхан багшиин сургаалыг хэнд ч чөлөөтэй зааж номлодог болно.

II
ГАЙХАМШИГТ ХЭЛХЭЭ ХОЛБОО

1. Хүмүүсийн зовлон зүдүүрт өөрийн учир шалтгаан буйн адил, зөв замыг дагаваас гэгээрэх нь лавтайн адил, энэ хорвоогийн юмс нөхцөл байдал бүрэлдэхийн үр дагавар юм. Нөхцөл бүрэлдэхэд энэ орчлонд бүх юм буй болж, нөхцөл бүрэлдэхэд бүх юм арилна.

Бороо орох, салхи үлээх, цэцэг навч дэлгэрэх, навч унах энэ бүхэн нөхцөл бүрэлдэхэд л болж буй. Хүн эцэг эхийн хоорондын холбооноос мэндэлдэг. Хоол хүнс түүний биеийг тэнхрүүлж, мэдлэг туршлага санаа сэтгэлийг нь хөгжүүлдэг.

Тиймээс бие, сэтгэл хоёр нь нөхцөл бүрэлдсэний ачаар оршин тогтнож, нөхцөл бүрэлдэхэд өөрчлөгдөнө.

Утсыг хооронд нь хэлхэхэд тор буй болохтой адил энэ ертөнцийн бүх юм өвөр зуураа хэлхээ холбоотой.

Торны нэг зангилаа дангаараа оршин тогтнож чадна гэж бодсон хүн ихээхэн алдаж буй хэрэг.

Торны зангилаа бусадтайгаа холбогдож, сая тор болно. Зангилаа бүхэн бусад зангилааны нэг хэсэг юм.

2. Нөхцөл бүрэлдэж цаг нь ирэхэд цэцэг цэцэглэдэг, нөхцөл бүрэлдэхэд унаж хатдаг. Өөрсдийн дураар цэцэглэж, дураараа унаж хатах нь үгүй.

Цэцэг навч цаг нь болж нөхцөл бүрэлдэхэд цэцэглэж, мөн нөхцөл бүрэлдэхэд унаж хатах учир энэ ертөнцөд тогтонги зүйл байхгүй. Энэ дэлхийд юм бүхэн хувирч өөрчлөгдөнө. Юунаас ч үл шалтгаалан, үл өөрчлөгдөх зүйл гэж хорвоод үгүй.

Цаг нь болж, нөхцөл бүрэлдэхэд бүх юм төрж, цаг нь болж, нөхцөл бүрэлдэхэд унаж хатах нь хөдөлшгүй үнэн юм. Бүх юм өөрчлөгдөн хувирч, байснаараа эс байх нь энэ ертөнцийн цорын ганц хувиршгүй үнэн юм. Гагцхүү энэ үнэн хэзээ ч үл өөрчлөгдөнө.

III
ХАРИЛЦАА ХОЛБОО

1. Хүний санаа бодлын зовнил, уйтгар гуниг, зовлон зүдүүр сэтгэлийн хөдөлгөөнд оршино.

Хүн нь эд баялаг, алдар гавьяа, нэр төр, тав тух, зугаа цэнгэлд дадаж, өөрөө өөртөө ч бас дассан байдаг. Үүнээс болж зовлон зүдүүр тасардаггүй.

Энэ ертөнцөд хэзээний аюул сүйрэл оршиж байдаг. Хүн аюул сүйрлээс гадна өтлөх, өвдөх, үхэхээс ч зайлж чадахгүй учир зовлон зүдүүр, уйтгар гунигт автдаг билээ.

Дадаж дасах амархан учраас зовлон зүдүүр, уйтгар гуниг буй болдог. Хэрэв дадаж дасах нь алга болвол зовлон зүдүүр, уйтгар гуниг мөн ул мөргүй алга болно.

Хүний дасаж дадах сэтгэлийн уг язгуурт нь мунхаг хийгээд хомхой сэтгэлийн харанхуй ноёлож байдаг.

Мунхагийн харанхуй хэмээх нь хүмүүс энэ ертөнцөд бүх юм хувирч өөрчлөгдөхийг эс ухааран, юмс үзэгдлийн учир шалтгааны нарийн холбоог олж хараагүйг хэлнэ. Ховдог хомхой сэтгэл хэмээх нь олдохгүй юмыг хүсэх, энэ хүслээсээ үл татгалзах хүмүүсийн чанар юм.

Эд юмсын хооронд өчүүхэн бээр ялгал үгүй, гэвч хүмүүс тэдгээрийг ялгаж салгадаг. Үүний шалтгаан нь мунхаг хийгээд шунахай сэтгэлд оршино. Сайн, муу юмс гэж үгүй атал хүмүүс юмсыг сайн, муу хэмээн хуваадаг. Энэ нь мунхаг хийгээд хомхой сэтгэлээс үүднэ.

Муу санаа бодол хүмүүсийн сэтгэлд байнга үүсч, тэд мунхаг учир юмсын мөн чанарыг олж харалгүй өөрөө өөртөө дасаж буруу үйл хийдэг. Тиймээс ч төөрөлддөг юм.

Хүмүүс өөрийн үйлийн цэцэрлэгт санаа сэтгэлийнхээ үрийг цацаж, мунхаг харанхуйн хөрсөөр хучиж, ховдог хомхой сэтгэлийн бороогоор чийглэж, амиа хичээх сэтгэлийн усаар усалж, буруу ташаа үзэл бодлын ургацыг ургуулж, чингээд төөрөлддөг юм.

2. Учир иймд, хүний сэтгэл нь уйтгар гуниг, зовлон зүдүүр, түгшүүр хямрал бүхий төөрөгдлийн ертөнцийг өөрөө буй болгодог.

Төөрөгдлийн ертөнц нь санаа сэтгэлийн буй болгосон төсөөлөл, таамаглалын хий орчлон юм. Гэгээрлийн ертөнцийг ч мөн адил санаа сэтгэл буй болгоно.

3. Энэ ертөнцөд гурван буруу үзэл бодол байдаг. Тэдгээрийг баримталваас хорвоогийн бүх юмыг үгүйсгэнэ. Нэгдүгээр үзэл санааг үлгэрлэвэл, хүмүүс энэ дэлхийд өөрсөдтэй нь тохиолдож буй аливаа хэрэг явдлыг заяа төөргийн дагуу болж буй гэж нотолно. Хоёрдугаар үзэл санаа нь хүмүүс энэ бүхэн бурханаас л шалтгаалсан гэдэг. Гуравдугаар үзэл

санаа нь хүмүүс энэ дэлхийд болж буй аливаа үйл хэрэг учир шалтгааны ямар ч холбоогүй гэж ярьдаг.

Хэрэв бүх юмыг хувь тавиланд даатгавал энэ ертөнцийн сайн муу бүх явдал хувь тавилан л болно. Зол жаргал, золгүй явдал ч ялгаагүй, нөгөө л хувь тавилан болж, энэ хорвоод хувь тавилангаас өөр юу ч эс үлдэнэ.

Улмаар хүмүүс өөдөлж сайжрахад найдахаа больж, хөдөлмөрлөхийг орхиж, дэлхийд дэвшил хөгжил үгүй болно.

Энэ ертөнцөд бурхан ганцаараа бүхнийг хийдэг хэмээх удаах үзэл, юмсын хооронд учир шалтгааны холбоо үгүй хэмээх дараагийн үзэл аль алиных нь тухайд мөн адил няцааж болно. Хэрэв хүмүүс эдгээр үзлийг дагавал мууг үйлдэхээс татгалзах, сайныг үйлдэхийг эрмэлзэхээ болино. Учир иймээс тэгэхийн тулд хүч чадлаа дайчлах утга алдагдана.

Эл учир энэ гурван үзэл гурвуулаа буруу юм. Цаг нь болж, нөхцөл бүрэлдэхэд бүх юм буй болж, цаг нь болж нөхцөл бүрэлдэхэд бүх юм мөхөж сөнөнө.

II БӨЛӨГ

СЭТГЭЛ САНАА БОЛОН ЭД ЮМСЫН ҮНЭН БАЙДАЛ

I

ЮМ БҮХЭН ХУВИРЧ ӨӨРЧЛӨГДӨХ ТУЛ БАЙНГЫН МӨН ЧАНАРГҮЙ

1. Цаг болж, нөхцөл бүрэлдсэний улмаас санаа сэтгэл, махбодийн аль аль нь үүсэх учир бие нь өөрийн мөн чанаргүй билээ. Бие бээр нөхцөл нь бүрэлдэхэд буй болсон тул мөнхийн чанартай бус юм.

Хэрэв бие махбод өөрийн мөн чанартай байсан бол өөрөө ямар байхыг хүснэ, яг тийм болж чадна.

Эзэн хаан, хаант улсдаа хүссэн бүхнээ хийж чадна. Тэрбээр хүссэн цагтаа залхааж, эсвэл шагнана. Гэвч тэрбээр өөрийн махан биеийг эзэгнэн захирч чаддаггүй. Хэдийгээр эс хүссэн ч бие нь өвдөж зовооно. Хэдийгээр эс хүссэн ч бие нь өтөлж өвгөрнө.

Үүнтэй нэгэн адил санаа сэтгэл өөрийн мөн чанаргүй. Цаг нь ирж, нөхцөл бүрэлдэхэд, санаа сэтгэл буй болох тул хувирамтгай чанартай.

Хэрэв санаа сэтгэл мөн чанартай бол хүссэнээ хийж, хүсээгүйгээ үл хийхсэн. Гэтэл үнэн хэрэгтээ өөрөө эс хүссэн ч атгаг муу санаа бодлыг төрүүлж,

хэдийгээр үл хүссэн ч буянаас холдоно.

2. Бие махбод байнга орших чанартай юу, эсвэл үргэлж хувирах чанартай юу хэмээвээс хэн ч гэсэн үргэлж хувирдаг гэж хариулах нь дамжиггүй.

Хувирамтгай чанар зовлон зүдүүр үү, эсвэл баяр баясгалан уу хэмээвээс, энэ хорвоод төрсөн л бол заавал өтөлж, өвдөж, үхдэг гэдгийг ухаарсан хэн бүхэн зовлон зүдүүр гэж л хариулах болов уу.

Тийм болохоор эдгээр байнгын бус цаг хугацаа улирахад хувиран өөрчлөгдөх юм зовлон зүдүүр мөн бөгөөд тэдгээр нь мөн чанартай хэмээн үзэх нь алдаа юм.

Санаа сэтгэл ч гэсэн хувирамтгай билээ. Санаа сэтгэл бол зовлон зүдүүр бөгөөд өөрийн мөн чанаргүй юм.

Тийм учраас бидний бие махбод болон санаа сэтгэлийг тойрч буй юм бүхэн "Би", "Миний" хэмээх ухагдахуунтай өчүүхэн бээр ч холбоогүй юм.

Гагцхүү мунхаг сэтгэл энэ бүхнийг "Өөрийн" хэмээн тооцож, хагацахгүйг бодно.

Цаг нь болж, нөхцөл бүрэлдэхэд бие болон түүнийг

хүрээлэгч бүхэн буй болдог учраас тэр нь хувирч өөрчлөгдөн, хэзээ ч байнга, тогтонги байдаггүй.

Санаа сэтгэл урсаж буй ус, дүрэлзэж буй дөл лүгээ адил үргэлж хувирч өөрчлөгдөнө. Тэрбээр байрандаа тогтож эс чадах сармагчин лугаа адил байнгын хөдөлгөөн дунд оршдог билээ. Тэрбээр өчүүхэн төдий ч амар тайван байж үл чадна.

Ухаант хүн үүнийг таньж мэдээд бие махбод, санаа сэтгэлдээ дасаж дадахаас татгалзах хэрэгтэй. Аливаа хүн бие, сэтгэлдээ дасаж баригдахаа боливол гэгээрнэ.

3. Энэ ертөнцөд хэн ч өөрчилж үл чадах таван зүйл буй. Үүнд: нэгдүгээрт, өтлөх хууль байхад үл өтлөх, хоёрдугаарт, өвдөх жам байхад үл өвдөх, гуравдугаарт, үхэх жам байхад үл үхэх, дөрөвдүгээрт, эвдэрч өмхрөх жам байхад үл мөхөх, тавдугаарт, шавхагдаж дуусах жам байхад үл шавхагдах эдгээр болно.

Энгийн хүмүүс эдгээр зайлшгүй жамтай тулгармагцаа зовж шаналж эхэлдэг. Харин Бурхан багшийн сургаалыг ухаарсан хүн тохиолдох ёстой жамаас зайлах аргагүйг мэдэж иймэрхүү тэнэг зовлон зүдүүрээс чөлөөтэй байдаг.

Энэ ертөнцөд өөр дөрвөн үнэн буй. Нэгдүгээрт, амьд бүхэн мунхагийн харанхуйгаас төрж буй болдог. Хоёрдугаарт, хүссэн бүхэн хувирамтгай чанартай тул зовлон зүдүүр авчирч, үргэлж өөрчлөгдөн хувирна. Гуравдугаарт, оршиж буй юм бүхэн байнгын чанаргүй, бүгд зовлон зүдүүр мөн бөгөөд үргэлж хувирч өөрчлөгдөж байдаг. Дөрөвдүгээрт, "Би" бээр, "Миний" бээр аль аль нь үгүй.

Бүх юм хувирч өөрчлөгдөнө, аливаа юм өөрийн “БИ”- гүй гэдэг нь энэ ертөнцөд Бурхан багш мэндэлсэн эсэхээс үл шалтгаалах хөдөлшгүй үнэн мөн. Бурхан багш энэ үнэнийг танин ухаарч, хүмүүст түүнийг номлож эхэлсэн байна .

II
СЭТГЭЛ САНАА

1. Төөрөгдөх, гэгээрэхийн аль аль нь санаа сэтгэлээс ургаж, аливаа юм санаа сэтгэлийн үйлдлээс үүднэ. Ид шид бүхий илбэчний ханцуйнаас янз янзын юм гарч ирэхтэй адил санаа сэтгэлээс бүх юм урган гарна.

Санаа сэтгэл хувирч хөдлөх нь эцэс төгсгөлгүй, нөөц бололцоо нь зах хязгааргүй. Тухайлбал, бузартсан сэтгэл эргэн тойрондоо бузартсан ертөнцийг бий болгож, ариун сэтгэл ариун ертөнцийг бий болгоно.

Гадаад ертөнц санаа сэтгэлээс шалтгаалан зүйл бүрээр хувиран өөрчлөгдөж болно.

Зураач хүн зураг бүтээдэг шиг санаа сэтгэл гадаад ертөнцийг бүтээдэг. Бурхан багшийн буй болгосон ертөнц ариухан бөгөөд элдэв шунал тачаалаас чөлөөтэй буюу. Харин хүний буй болгосон ертөнц бузартсан байх агаад шунал тачаалаар дүүрэн бүлгээ.

Сайн зураач лугаа адил санаа сэтгэл янз бүрийн ертөнцийг бүтээдэг. Энэ ертөнцөд санаа сэтгэлийн буй болгож чадахгүй тийм юм үгүй. Бурхан багш ч гэсэн мөн адил ийм чадвартай. Тиймээс ч хорвоо ертөнцийг бүтээхийн тухайд бол санаа сэтгэл, Бурхан багш, хүмүүсийн хооронд өчүүхэн бээр ялгал үгүй.

Бурхан багш, энэ ертөнцөд санаа сэтгэл, юм бүхнийг буй болгосныг зөв ухаардаг. Үүнийг зөв ойлгосон хүн жинхэнэ Бурхан багшийг олж харна.

2. Гэвч санаа сэтгэл цаг үргэлж айн эмээж, гунин гашуудаж, догдолж байдаг. Болоод өнгөрснөөс айна, болох гэж байгаагаас айна. Учир нь санаа сэтгэлд мунхагийн харанхуй, ертөнцөд дасал дадал болсон сэтгэлийн хүлээс оршино.

Чухамхүү ийм мунхаг болоод шунахай санаа сэтгэлээс төөрөгдлийн ертөнц үүднэ. Ертөнцийн төөрөгдлийн бүхий л учир шалтгаан эцсийн эцэст санаа сэтгэлд л оршино.

Төрөх, үхэхийн аль нь ч санаа сэтгэлээс үүдэх тул амьдрал, үхлийн тухай буруу ташаа төсөөлөл буй болгодог санаа сэтгэл мөхвөл түүнтэй хамт буруу ташаа төсөөлөл ч замхарна.

Төөрөгдлийн ертөнц санаа сэтгэлээс ургана. Төөрөлдсөн сэтгэлийн нүдээр орчлонг харах учир энэ хорвоо төөрөгдөл, буруу ташаа ойлголтоор дүүрэн байдаг. Төөрөгдлийн ертөнц санаа сэтгэлээс эс хамааран бие дааж тогтнож чадахгүйг ухаарвал бузраас салж, гэгээрнэ. Улмаар санаа сэтгэл энэ ертөнцийг удирдаж, дагуулан чиглүүлнэ. Хэрэв санаа сэтгэл төөрөлдөж байвал хорвоо ертөнц адилхан төөрөлддөг.

3. Ертөнцийн юм бүхнийг санаа сэтгэл буй болгож, удирдана. Ертөнцийн бүх юм санаа сэтгэл л юм. Муу юм хэлдэг, хийдэг, сэтгэл нь бузартсан хүнийг зовлон зүдүүр салахгүй дагаж байдгийг зүйрлэвэл шар үхрийн араас үхэр тэрэг үргэлж дагахтай адил бүлгээ.

Хүн сайн санаа өвөрлөж, сайныг үйлдэж, хэлж

явбал түүнийг баяр баясгалан дагах бөгөөд үлгэрлэвээс сүүдэр нь эзнээ дагахтай адил юм. Энэ ертөнцөд муу үйл хийж буй хүн түүнээсээ болон зовж зүдэрч, хойд төрөлдөө шийтгэл хүлээж, бүр ч их тарчилж зовно.

Сайныг үйлдэж буй хүн энэ ертөнцөд түүнийхээ ачаар баярлан баясч, хойд төрөлдөө үр шимий нь хүртэж улам их цэнгэж жаргана.

Санаа сэтгэл будагнавал, зам мөр тэгш хийгээд дардан бус болж хүмүүс бүдчин бүдэрнэ. Санаа сэтгэл ариун байвал зам мөр үргэлж тэгш дардан байна.

Ариун тунгалаг бие, сэтгэлтэй хүн шулмын тавьсан хавх зангууг тас татаж, Бурхан багшийн оронд очно. Сэтгэл санаа тайван хүн амар амгаланг олж, өдөр, шөнөгүй санаа сэтгэлээ төгс төгөлдөр болгодог.

III
ЭД ЮМСЫН ҮНЭН БАЙДАЛ

1. Энэ ертөнцөд юм бүхэн цаг нь болж, нөхцөл бүрэлдэхэд бүтэх учир эд юмсын хооронд өчүүхэн бээр ялгал үгүй. Гэвч хүмүүс тэдгээрийг хоорондоо ялгаатай хэмээнэ. Үүнд тэдний ухвар мөчид бодол санаа оршино.

Тэнгэрт баруун хязгаар, зүүн хязгаар аль нь ч байхгүй бүлгээ. Гэвч хүмүүс түүнийг баруун, зүүн хэмээн хуваах тийм байх ёстой юм шиг бодно.

Тоо нэгээс эхлэн хязгааргүйд хүрдэг. Эдгээр нь цөм бүхэл тоонууд юм. Тоонд ялгаа үгүй, их тоо, бага тоо гэж байхгүй. Харин хүмүүс л өөрсдийн амрыг бодож ялгаж, салгаж байхын тулд тоог их, бага хэмээн хувааж ангилдаг.

Ер нь амьдрах, үхэх үйл явцын аль нь ч байхгүй бүлгээ. Гэвч хүмүүс өөрсдөө амьдрах, үхэхийг ялган үздэг. Үүнтэй адил аливаа үйл хэргийг сайн гэж хэлж болохгүй, муу ч гэж хэлж болохгүй. Гэвч хүмүүс үйл хэргийг саин, муу хэмээн ялгана. Энэ бол хүний ухвар мөчид бодол.

Бурхан багш юмс хоорондоо ялгаатай гэж үздэггүй. Тэрбээр энэ ертөнцийг тэнгэрт хөвж буй үүл, зүүд зэрэглээ мэтээр үзэж, санаа сэтгэлийн хүсч буй, үл хүсч буй юм бүхэн хоосон буюу мөн чанаргүй болохыг сайн мэддэг билээ. Тэрбээр санаа сэтгэлийн аливаа хүсэл шуналаас чөлөөтэй юм.

2. Санаа сэтгэл тав тухтай, сайн сайхан амьдрахыг хүсэх тул хүмүүс хорвоогийн бүх юманд дасаж дотно болдог. Тэд эд баялаг, өмч хөрөнгө, алдар гавьяа, амьдрал юунд дасаж дотносдог.

Хүмүүс байгаа хийгээд байхгүй юманд, буян, нүгэл, зөв, буруу, ер бүх юманд дасдаг учраас төөрөлдөн зовж зүдэрдэг.

Эрт урьд цагт нэг хүн амьдарч байжээ. Нэгэнтээ тэрбээр холын аянд гарч том гол мөрөнд тулж иржээ. Тэрбээр бодсон нь: "Энэ талын эрэг дээр аюултай, цаад талын эрэг дээр аюулгүй юм байна". Тэрбээр сал хийж мөрнийг эсэн мэнд гаталж, цаад талын эрэг дээр гарчээ. Аюулгүй эрэгт гарсныхаа дараа тэрбээр эрэгцүүлсэн нь: "Энэ сал намайг эрэг дээр эсэн мэнд гаргаж их тус боллоо. Тиймээс би энэ салыг хаялгүй цааш үүрээд авч явна".

Энэ хүн салыг үүрч авч явсан нь зөв үү? Үгүй ээ, буруу.

Энэ сургаал домог юу өгүүлнэ вэ гэвэл, "Зөв зүйтэй юманд хүртэл дасаж болохгүй, харин түүнээс татгалзах хэрэгтэй. Буруу ташаа юмны тухайд бол ярих ч хэрэггүй. Шууд л татгалзвал таарна".

3. Энэ орчлонд биднийг тойрон хүрээлж буй юм бүхэн хаанаас ч урган гарч ирэхгүй, хаашаа ч шингэж алга болохгүй, төрөхгүй, эвдэрч үхэхгүй, тийм учраас юуг ч олж, баттай эзэмшиж болдоггүй, юуг ч алдаж болдоггүй юм .

Бурхан багш сургасан нь: "Энэ ертөнцөд бүх юм "бий", "байхгүй" хэмээх ойлголтоос чөлөөтэй юм Тийм учраас эд юмс байна, байхгүй гэж алиныг нь ч хэлж үл болно. Тэдгээр юмс үл төрж, үл мөхдөг". Энэ нь ертөнцөд бүх юм цаг нь болж, нөхцөл бүрэлдэхэд бүтэж, өөрийн гэсэн мөн чанаргүй тул тэдгээрийг оршиж буй хэмээн нотолж болохгүй. Тэдгээр нь цаг нь болж, нөхцөл бүрэлдэхэд бүтэж, үнэхээр оршиж буй тул бас огт байхгүй гэж хэлж болохгүй.

Хэрэв эд юмсыг олж харчихаад тэдгээрт ээнэгшиж дасвал энэ нь санаа сэтгэлийн төөрөгдөл болно. Хэрэв эд юмсыг олж харчихаад тэдгээрт дотносон дасахгүй бол санаа сэтгэлд хүсэл шунал үл төрнө. Гэгээрэх нь энэхүү үнэнийг ухан ойлгож, сэтгэл санааны хүсэл шуналаас ангижирна гэсэн үг юм.

Орчлон хорвоо үнэхээр зүүд зэрэглээ мэт, үнэт эрдэнэ мөн адил хий үзэгдэл шиг юм. Бүх юм зурмал зураг дээр байгаатай адил. Хэдийгээр бид зураг дээр дээд, доод хэсэгт нь зурсан байхыг харах боловч, үнэн хэрэг дээрээ тэр бүхнийг нэг л хавтгай дэвсгэр дээр зурсан шүү дээ. Орчлон хорвоогийн бүх юм халуунд халсан агаар лугаа адил зэрэглээ болой.

4. Хэмжиж тодорхойлшгүй, нөхцөл нь бүрэлдэхэд

бүтэж буй болсон бүхнийг мөнх оршино гэж итгэх нь буруу үзэл бөгөөд түүнийг "Мөнх оршихын онол" гэнэ. Нөгөө талаар, энэ бүхэн замхарч алга болно хэмээх нь мөн буруу үзэл бөгөөд түүнийг "Үл оршихын онол" хэмээнэ.

Энэ бүх мөнхийн амьдрал ба үхэл, орших ба үл оршихын томьёолол нь эд юмсын үнэн зөв байдал бус юм. Хүн тэдгээрт дасаж ээнэгшсэн учир түүнд ингэж санагдаж буй билээ. Хэрэг дээрээ хорвоо ертөнцийн юм бүхэн нь дасаж дотноссон эсэхээс үл шалтгаалан оршиж байдаг.

Энэ ертөнцөд юм бүхэн цаг нь болж, нөхцөл бүрэлдэхэд буй болох тул бүгд хувирч өөрчлөгдөнө. Эд юмс мөн чанаргүй учир мөнхийн хийгээд байнгын орших чанартай байж чадахгүй. Эд юмс үргэлж хувирах тул хий үзэгдэл, халуунд халсан агаар зэрэглээтэн үзэгдэх мэт билээ. Үүний хажуугаар тэдгээр нь үнэн чанартай. Тэдгээр нь мөнхийн хувирамтгай чанартай юм.

Гол мөрөн хүнд гол мөрөн гэж л харагдана. Гэтэл усыг гал хэмээн үздэг өлсгөлөн сүнс буюу бирдийн нүдэнд гол мөрөн хэмээн харагдахгүй. Тиймээс бирдийн хувьд гол ус "байхгүй байна", хүний тухайд "байна" гэж нотолж болохгүй.

Үүнтэй адил юуны ч тухай "Байна", "Байхгүй" хэмээж болохгүй. Учир нь бүх юм хий үзэгдэл билээ.

Түүгээр ч зогсохгүй энэхүү хий үзэгдэл бүхий ертөнцөөс өөр бодит ертөнц, мөнхийн ертөнц аль аль нь үгүй учир энэ орчлонг харьцангуй, цаг зуурын холбоо хэмээж бас болохгүй. Мөн энэ ертөнц бодит чанартай хэмээж үл болно.

Хүмүүс, алдаа дутагдлын учир шалтгаан энэ ертөнцөд оршино хэмээн боддог. Гэтэл энэ ертөнц хий үзэгдэл юм бол хүний сэтгэлд хүслийг төрүүлж чадахгүй, түүнээс болж хүн алдаа мадаг гаргах ёсгүй. Хүмүүс энэ үнэнийг эс мэдэж, эл ертөнцийг харьцангуй, эсвэл цаг зуурын, үгүй бол бодит хэмээн үздэгээс тэнэг алдаа гаргана.

Ухаантан хүн энэ үнэнийг ойлгож, хий үзэгдлийг хий үзэгдэл хэмээн үзэж, эл алдааг гаргадаггүй.

IV
ДУНДАД ЗАМ МӨР

1. Бурхан багшийн сургаалыг дагаж буй хэн бүхэн амьдралын хоёр туйлаас зайлсхийх ёстой. Нэгдүгээрт, бузар булай хүсэлдээ автаж түүнийгээ хангах гэж хөөцөлдөхөөс сэргийл. Хоёрдугаарт, бие

махбод, санаа сэтгэлээ элдвээр сорьж, тарчлаан зовоож, хэт хатуу амьдралыг дээдлэхээс болгоомжил.

Амьдралын энэ хоёр туйлаас зайлж, билгийн нүдээ нээж, оюун ухааныг хөгжүүлж, гэгээрүүлдэг амьдралын дундад замыг баримтлах хэрэгтэй.

Дундад зам гэж юун буй. Энэ бол зөв зүйтэй найман мөрийн нэр юм. Үүнд: зөв үзэл, зөв бодол, зөв үгс, зөв үйлс, зөв амьдрах, зөв эрмэлзлэл, зөв дурсахуй, зөв төвлөрөхүй эдгээр болно.

Энэ хорвоод цаг нь болж, нөхцөл бүрэлдэхэд бүх юм бүтэж эвдэрдэг бөгөөд эд юмс оршиж байна, үл оршиж байна хэмээн алиныг нь ч нотолж үл болно. Нэг хэсэг тэнэг хүн эд юмс оршиж байна гэдэг, нөгөө хэсэг нь үл оршиж байна гэдэг. Харин зөв ухаарсан хүмүүс энэ бүхэн оршиж буй бус, үл оршиж буй бус хэмээдэг. Энэ нь чухамхүү эд юмсыг үнэн зөвөөр үзэх дундад үзэл юм.

2. Томоохон гуалин мод их мөрөнд хөвж явна хэмээн бодогтун. Хэрэв энэ гуалин баруун, зүүн эргийн алинд ч эс ойртвол, их мөрний тэхий дунд эс живбэл, усны хаялга түүнийг эрэг дээр эс гаргаж хаявал, хүн түүнийг эс барьж тогтоовол, эргүүлгэнд эс орвол, дотроосоо эс өмхөрвөл, хөвсөөр яваад

эцэст нь далай тэнгист хүрнэ.

Бурхан багшийн сургаалыг дагагч хэн ч гэсэн энэхүү гуалин лугаа адил дотоод, гадаад тал, орших, үл орших, зөв, буруугийн аль алинд эс дасаж, төөрөгдлөөс ангижиран ухаан санаагаа гагцхүү гэгээрэхийн тухай бодолд эс автуулж, харин гол мөрний яг тэхий дундуур нь хөвж явах ёстой. Энэ бол чухамхүү эд юмсыг үзэх дундад үзэл, амьдрах дундад арга юм.

Бурхан багшийн сургаалыг дагаж буй хүн бүхэн амьдралдаа хоёр туйлаас зайлсхийж, дундыг баримтлавал зохино.

Аливаа юманд ижилдэн дасч үл болно, орчлон хорвоод бүх юм үл эвдэрдэг, тодорхой шинж чанаргүй хэмээн мэдэх ёстой. Тэр ч байтугай өөрийнхөө сайн үйлд ч дасаж болохгүй.

Эс ижилдэн дасах нь аливаа юмнаас эс чаргууцалдах, аливаа юманд эс ээнэгшин дасахын нэр юм. Бурхан багшийн сургаалыг баримтлагч хүн үхлээс үл айж, амьдрахыг эс гуйдаг. Тэрбээр янз бүрийн үзэл санааг эс дагадаг.

Хүн аливаа юманд ижилдэн дасмагцаа төөрөлдөж эхэлдэг. Тиймээс гэгээрэхийн зам мөрийг

баримтлан явж буй хүн юунд ч ижилдэн дасаж үл болно, аливаа юмнаас чаргууцалдаж үл болно, юуг ч хэт сониучирхан шохоорхож үл болно, юун дээр ч саатан зогсож үл болно.

3. Гэгээрэх нь илрэх тодорхой хэлбэргүй, өнгөгүй билээ. Тиймээс гэгээрэхэд гэгээрч буй юм үгүй .

Төөрөгдөх нь буй учраас л гэгээрэх нь байдаг, хэрэв төөрөгдөл үгүй болвол, гэгээрэл мөн адил алга болно. Төөрөгдөл үгүй бол гэгээрэл байхгүй, гэгээрэл үгүй бол төөрөгдөл байхгүй.

Тиймээс гэгээрэл буй нь нэг ёсны саад бэрхшээл юм. Харанхуй буй учраас гэрэл гэгээ гарах ёстой. Хэрэв харанхуй үгүй бол гэрэл гэгээ гарах ч хэрэггүй. Тэгсэн цагт гэрэл гэгээ ч үгүй , гэрэлтүүлэх зүйл ч үгүй болно.

Бурхан багшийн сургаалыг үнэхээр дагаж буй хэн ч гэсэн гэгээрчихээд түүндээ саатан зогсдоггүй. Учир нь гэгээрэл буй хэмээх нь төөрөгдөл билээ.

Тийм байдалд хүрвээс бүх юм төөрөгдөл мөн учраас гэгээрэл, бүгд харанхуй мөн учраас гэрэл гэгээ болно. Хорвоогийн хүсэл шунал бүхэн өөр юу ч бус, гагцхүү гэгээрэл болон хувиртал гэгээрэх хэрэгтэй юм.

4. Аливаа эд юмс хоорондоо ижил тэнцүү, тэдгээрийн хооронд ялгаа үгүй. Энэ ухагдахуун нь Шунъята буюу хоосон чанар юм. Аливаа эд юмс өөрийн мөн чанаргүй, тэд эс бүтэж, эс эвдэрдэг. Тэдгээрийг үгээр дүрслэн тодорхойлох аргагүй юм. Тиймээс тэдгээр нь хов хоосон билээ.

Гэгээрэх нь илрэх тодорхой хэлбэргүй, өнгөгүй юм. Тиймээс гэгээрэхэд гэгээрч буй юм үгүй.

Энэ хорвоод бүх юмс хоорондоо харилцан холбоотой, нэг нэгнээсээ шалтгаалан оршдог. Тэдгээр нь бусдаас үл шалтгаалан өөрсдөө орших чадахгүй.

Энэ нь гэрэл сүүдэр, урт богино, хар цагаан хоёр лугаа адил юм. Эд юмс өөрсдөө, бие даан оршиж үл чадна. Тэдгээр нь мөн чанаргүй юм.

Түүгээр ч зогсохгүй, төөрөгдөл үгүй бол гэгээрэл үгүй, гэгээрэл үгүй бол төөрөгдөл үгүй билээ. Энэ хоёр нь нэг нэгтэйгээ ҮЛ зөрчилдөх тул, эд юмс эсрэг тэсрэг чанаргүй билээ.

5. Хүмүүн бид эд юмс бүтэж, эвдэрч байна хэмээн боддог. Үнэн хэрэг дээрээ эд юмс эс бүтнэ, тийм болохоор эс эвдэрнэ.

Юмсын мөн чанарыг таних билгийн нүдтэй болсон хүн эд юмс үл бүтэж, үл эвдэрдэгийг мэдээд, үнэнийг сэхээрч, эдгээр нь тус тусдаа ялгаатай ойлголт бишийг ухаарна.

Хүн "би" байдаг хэмээн итгэдэг тул "миний" гэдэгтэй зууралддаг. Гэтэл үнэн хэрэг дээрээ "би" бээр үгүй учраас "миний" бээр мөн адил үгүй юм. Хүн "би", "миний" аль нь ч үгүйг мэдээд үнэнийг таньж, эдгээр нь өөр, өөр ялгаатай ойлголт биш болохыг мэддэг.

Ариун, бузар хоёр буй гэж үздэгээс хүн бүх юмыг ариун, бузар хэмээн хуваана. Гэтэл хэрэг дээрээ ариун, бузрын аль нь ч үгүй, тэдгээр нь хүний сэтгэлээс үүдсэн буруу ташаа төсөөлөл юм.

Хүн нүгэл, буян буй хэмээн бодож, бүхнийг нүгэл, буян хэмээн хуваадаг. Гэтэл дан ганц буян, дан ганц нүгэл гэж байхгүй. Гэгээрэх замыг дагаж буй хүн үнэнийг ухаарч буян, нүгэл нь ялгаатай бус гэдгийг ойлгоно.

Хүн гай зовлонгоос айж, зол жаргалыг хүснэ. Гэтэл гэгээрсэн оюунаар тунгаавал хүн гай зовлон бол чухамхүү зол жаргал мөнийг ухаарна. Хүн үнэнийг ухаарахдаа бие сэтгэлийг эзэмдэж, эрх чөлөөг боогдуулсан төөрөгдөл ч үгүй, мөн жинхэнэ

эрх чөлөө гэдэг ч үгүй хэмээн ойлгоно.

Тиймээс "Орших", "Үл орших", "Төөрөлдөх", "Гэгээрэх", "Чухал", "Чухал бус", "Зөв", "Буруу" хэмээн ярьдаг ч хэрэг дээрээ хоёр эсрэг тэсрэг ойлголт буй бус. Тэдгээрийн үнэн байдлыг үгээр илэрхийлэн дүрслэх, үзүүлж харуулах, ухаарч мэдэх бололцоо байхгүй. Харин үгс болон санаа сэтгэлийнхээ төсөөллийн эрхшээлээс гарах хэрэгтэй. Хүмүүс үг хийгээд төсөөллийн эрхшээлээс ангижирсан цагтаа жинхэнэ хоосныг оножи ухаарна.

6. Үлгэрлэвэл лянхуа цэцэг цэмцгэр тал, өндөр ууланд бус, харин булингартсан намагт ургадаг билээ. Үүнтэй адил төөрөгдөл дунд хүн гэгээрч, буруу ташаа үзэл бодол, төөрөгдлөөс Бурхан болохын үр үндэслэдэг бүлгээ.

Элдвийн аюул саадыг давж, далайн ёроолд хүрч баймааж сая үнэт эрдэнэсийг түүхтэй адил төөрөгдлийн булингарт далайн ёроолд шумбаж баймааж гэгээрэхийн үнэт эрдэнэсийг олно. Хүний өөртөө дассан сэтгэл нь уул нуруу адил агуу том боловч, хэрэв Бурхан багшийн сургаалыг дагахаар сэтгэл шулуудвал ямар ч байсан гэгээрнэ.

Эрт урьд цагт мэргэд шовх шовх үзүүртэй хадан дээр гараад эс шархтаж, дүрэлзэн асч буй галд ороод

эс түлэгдэж, эс үхэж үрэгддэг байсантай адил, харин ч үргэлж цовоо сэргэлэн байсны адил, Бурхан багшийн сургаалыг дагаж буй хүн нэр төр, алдар гавьяаны шовх шовх хад асган дээр гарсан ч, үзэн ядах сэтгэлийн галд орсон ч гэгээрлийн ариухан салхи сэвэлзэхийг мэдэрнэ.

7. Бурхан багшийн сургаалыг дагасан хүн үнэнийг ухаарч, эсрэг тэсрэг ухагдахуун нь өөр өөр бус, угтаа нэг л мөн чанартайг ойлгоно. Эсрэг тэсрэг ойлголтоос нэгийг нь салгаж, түүнийгээ эс тавин зууралдваас тэр ухагдахуун нь буян буюу зөв үзэл байсан ч алдаа болно.

Хорвоо ертөнцөд бүх юм өөрчлөгдөн хувирна гэсэн үзэл санааг хатуу баримталбал энэ нь мөн алдаа болно. Ертөнцөд юу ч хувиран өөрчлөгдөхгүй гэсэн үзлийг чанд дагавал энэ нь бүр ч том алдаа болно. Хэрэв "би" бээр буй хэмээн хатуу итгэвэл алдаа болж, хүн зовлонгоосоо салж чадахгүй. Хэрэв "би" бээр буй бус хэмээн чанга итгэвэл энэ нь бас алдаа болж, тийм хүн Бурхан багшийн сургаалыг дагах утга учиргүй болно.

Энэ ертөнцөд бүх юм зовлон зүдүүр хэмээн хөдөлшгүй итгэвэл энэ нь алдаа болно. Энэ ертөнцөд бүх юм баяр баясгалан хэмээн хөдөлшгүй итгэвэл энэ нь бас алдаа болно. Бурхан багшийн сургаал

дундад замыг зааж, аливаа туйлшралаас зайлсхийхэд сургадаг.

III БӨЛӨГ

ГЭГЭЭРЭХИЙН ҮР

I

АРИУН НАНДИН СЭТГЭЛ

1. Орчлон хорвоод янз янзын хүмүүс байдаг. Санаа сэтгэл нь манантаж эхэлсэн, санаа сэтгэл нь бүр манантчихсан хүмүүс аль аль нь буй. Ухаантай хүмүүс буй, тэнэг хүмүүс ч буй.

Сайхан сэтгэлтэй хүмүүс, атгаг санаатай хүмүүс ч буй. Нэг хэсгийг нь зааж сургахад амархан, нөгөөг нь хэцүү байдаг.

Хүмүүсийг өнгө өнгийн лянхуа цэцэгтэй үлгэрлэж болно. Тэднийг тогтмол усанд ургадаг цэнхэр, улаан, шар, цагаан олон өнгийн лянхуатай зүйрлэж болно. Тэдгээр нь цугаараа усанд ургадаг хэдий ч нэг хэсэг нь усан доор, нөгөө нь усны гадаргуу дээр, гурав дахь нь уснаас дээш, усанд хүрэлгүй ургадаг билээ.

Түүнээс гадна хүмүүс хүйсээрээ ялгагдана. Эмэгтэй, эрэгтэй хүмүүс буй. Гэвч бүх хүмүүсийн мөн чанар адилхан юм. Бурхан багшийн сургаалыг дагасан эрэгтэй хүн гэгээрч болохтой адил, сэтгэл юугаа ариусган төгс төгөлдөр болгож буй эмэгтэй хүн ч гэгээрнэ.

Зааныг унаж сурахад итгэл, эрүүл мэнд, хичээл зүтгэл, шулуун шударга зан, саруул ухаан хэрэгтэй. Бурхан багшийг дагаж гэгээрэхийн тулд эдгээр таван чанар мөн шаардагдана. Дээрх таван чанар буй бол бурхан багшийн сургаалыг эзэмшихэд цаг хугацаа их шаардагдахгүй. Учир нь бүх хүн гэгээрэх мөн чанартай төрсөн билээ.

2. Гэгээрэх явцдаа Бурхан багшийг хүн нүдээрээ харж, түүнд зүрх сэтгэлээрээ сүсэглэн итгэнэ. Гэвч Бурханыг олж харах өнөө нүд, түүнд сүсэглэн итгэх өнөө зүрх сэтгэл эдүгээ хүнийг амьдрал, үхлийн ертөнцөд хөтлөн явж байна.

Дээрэмчдийг бут цохихын тулд эзэн хаан юуны түрүүнд тэдний үүр хаа байгааг олж мэдэх ёстой. Үүнтэй адил төөрөгдлийг устгахын тулд түүний нүд, зүрх сэтгэл нь хаана буйг олж мэдэх хэрэгтэй.

Хүн тасалгаанд нүдээ нээхдээ юуны өмнө тэнд буй эд юмсыг олж хардаг. Дараа нь цонхоор харж, цонхны цаана буй юмыг үздэг. Тасалгаанд буйг олж хараагүй мөртлөө цонхны цаадахыг олж харна гэж үгүй.

Хэрэв бие махбод дотор санаа сэтгэл оршдогсон бол тэрбээр эхлээд бие доторхийг сайн харах байсан билээ. Гэтэл хэрэг дээрээ хүн бие махбодынхоо

гаднахыг л сайн мэддэг бөгөөд бие махбод дотроо юу байдгийг бараг мэдэхгүй.

Хэрэв санаа сэтгэл бие махбодынхоо гадна байсан бол тэдгээр нь тусдаа орших байсан агаад санаа сэтгэл нь бие махбодын мэддэгийг мэдэхгүй, бие махбод нь санаа сэтгэлийнхээ мэддэгийг мэдэхгүй байхсан. Үнэн хэрэгтээ санаа сэтгэлийнхээ мэддэгийг бие махбод мэдэрч, бие махбодынхоо мэдэрдэгийг санаа сэтгэл нь мэддэг. Тиймээс санаа сэтгэл нь бие махбодын гадна байдаг хэмээж үл болно. Тийн аваас санаа сэтгэлийн мөн чанар хаана оршдог вэ?

3. Тэргүүлшгүй цагийн чанадаас эхлээд бүх хүн өөрсдийнхөө үйлийн үрээр холбогдож, хоёр зүйлийг мэддэггүй учраас төөрөлдөж байдаг.

Нэгдүгээрт, хүмүүс төрөх, үхэхийг үзэж хардаг төөрөлдсөн сэтгэлээ өөрсдийн мөн чанар гэж үздэг. Хоёрдугаарт, гэгээрэхийн мөн чанар болсон ариун цагаан сэтгэл нь төөрөлдсөн сэтгэлийнхээ сүүдэрт нуугдаж, өөрсдийнх нь дотор оршдогийг үл мэднэ.

Хүн гараа зангидаж нударгаа дээш өргөхөд түүний нүд харж, сэтгэл мэдэж авдаг. Гэвч энэ сэтгэл бол жинхэнэ сэтгэл биш.

Элдвийг санаархаж буй санаа сэтгэл хүслээс ургана. Энэ сэтгэл нь өөрийнхөө ашиг хонжоог л урьтал болгоно. Энэхүү санаа сэтгэл цаг нь болж, нөхцөл бүрэлдсэний улмаас хөөрөн дэвэрч үргэлж хувирч байдаг, жинхэнэ мөн чанаргүй билээ. Хүн өөрөө санаа сэтгэлээ мөн чанартай гэж итгэснээс төөрөгдөл үүснэ.

Хүн гараа атгахаа больж, хуруугаа тэнийлгэхэд санаа сэтгэл нь хуруунууд тэнийснийг мэднэ. Ингэхэд юу хөдөлгөөнд орно вэ? Гар уу? Санаа сэтгэл үү? Эсвэл аль нь ч биш үү?

Гар хөдөлж байвал санаа сэтгэл мөн хөдөлж байгаа билээ. Эсвэл санаа сэтгэлийн хөдөлгөөн гарт шилжиж байгаа юм. Гэвч хөдөлж буй санаа сэтгэл нь гүн гүнзгий оршдог бус, гүехэн өнгөц оршдог сэтгэл юм.

4. Бүх хүн ариун тунгалаг жинхэнэ санаа сэтгэлтэй билээ. Тэр сэтгэл нь гадаад нөхцөлөөс шалтгаалан буй болдог төөрөгдлийн тоосонд хучаастай байдаг. Гэвч төөрөгдөж буй санаа сэтгэл гол бус, хоёрдогч чанартай юм.

Хэдийгээр үүлс сарыг хэсэг зуур хаадаг ч, түүнийг бохиртуулж хиртүүлэхгүй, байрнаас нь ч хөдөлгөхгүй.

Тиймээс хүн мөн чанараа салхинд боссон бөөн тоосон үүл лүгээ адил төөрөлдсөн санаа сэтгэл мөн хэмээн бодож болохгүй.

Хүн үл хөдлөгч, үл бузартсан, жинхэнэ санаа сэтгэлээ түргэн олж, өөрийнхөө мөн чанарт эргэн орох ёстой. Хүн хувиран өөрчлөгдөх, төөрөлдсөн сэтгэлийнхээ эрхэнд байдаг тул, эд юмыг буруугаар үзэж, тиймээс ч төөрөгдлийн далайд зүг чигээ олохгүй самуурдаг.

Үргэлж хувиран өөрчлөгдөгч гадаад шалтгаан, хүсэл шуналын улмаас хүний санаа сэтгэл төөрөлдөн бузартдаг билээ.

Мөнхийн үл хөдлөх, үл эвдрэх, гадаад шалтгаанд үл автах санаа сэтгэл бол хүний мөн чанар, гол санаа сэтгэл нь юм.

Буудалласан хүн буцахад дэн буудал нь алга болохгүйтэй адил, гадаад нөхцөл шалтгааны улмаас буй болж, алга болж, элдвийг санаархаж байдаг сэтгэл үгүй боллоо гээд хүн алга болохгүй. Гадаад нөхцөл байдлаас болж өөрчлөгдөх санаа бол хүний сэтгэлийн мөн чанар бус юм.

5. Уужим танхим байна гэж бодъё. Нар мандах үед танхим гэрэлтэж, нар жаргахад харанхуй болно.

Гэрэл гэгээг нартай, харанхуйг шөнөтэй холбож болно. Гэвч бид гэрэл, харанхуйг танин мэдэхэд тус болдог хүчийг юутай ч холбож үл чадна. Гагцхүү санаа сэтгэлийн мөн чанартай холбохоос өөр аргагүй юм.

Нар мандаж, бид гэрэл гэгээг олж харах нь санаа сэтгэл хоромхон зуур илэрч байгаа хэрэг. Нар жаргаж, харанхуйг олж харах нь бас санаа сэтгэл хоромхон зуур илэрч байгаа хэрэг. Гэтэл харанхуй мэтийн гадаад нөхцөл шалтгаан нь гэрэл, харанхуйг ялгадаг бидний сэтгэлийг дуудан гаргаж ирдэг. Гэвч энэ нь санаа сэтгэлийн түр зуурын илрэл бөгөөд санаа сэтгэл өөрөө бус, түүний мөн чанар бус билээ. Гэрэл, харанхуйг ялгагч хүчний эх булаг бол санаа сэтгэлийн мөн чанар юм.

Гадаад нөхцөл шалтгааны улмаас буй болж, бас алга болох буян нүглийн ойлголт хийгээд хайрлах, үзэн ядах сэтгэл нь хүний сэтгэлд хуримтлагдсан хир бузраас үүдэн буй санаа сэтгэлийн түр зуурын илрэл юм.

Хэдийгээр хорвоогийн хүсэл шуналын тоосонд дарагдсан ч хиртэж, бузартаагүй үнэхээр ариун тунгалаг санаа сэтгэл байдаг.

Бөөрөнхий саванд буй ус бөөрөнхий, дөрвөлжин

саванд буй ус дөрвөлжин санагдана. Гэвч ус мөн чанартаа бөөрөнхий ч бус, дөрвөлжин ч бус. Хүмүүс үүнийг мартаж усыг гагцхүү хэлбэрээр нь дүгнэдэг. Хүмүүс буян, нүгэл, хайрлах, үл хайрлах, орших, үл орших зэрэг ухагдахууны хүлээсэнд баригдаж гадаад хэлбэрийг хөөцөлдөн зовж зүдэрдэг.

Хэрэв гадаад нөхцөл шалтгаанаас ангижран салж, өөрийн жинхэнэ чөлөөт мөн чанарыг олвол, бие махбод, санаа сэтгэл ямар ч хүлээсэнд авталгүй, бүрэн эрх чөлөөгөө олно.

II
НУУЦ ЭРДЭНЭ

1. Ариун тунгалаг, жинхэнэ санаа сэтгэл бол зүйрлэн хэлбэл Бурхан багшийн мөн чанар буюу Бурхан багшийн үр юм.

Бид томруулдаг шил авч нарны олон сая, живаа туяаг нэгэн багц болгон зулын голд тусгахад ямар учраас асдаг вэ? Хаанаас гал гарч ирдэг вэ? Нар, томруулдаг шил хоёр нэг нэгнээсээ алс хол учир нэг бие болон нэгдээгүй гэлээ ч нарны туяа нь томруулдаг шилийн тусламжтайгаар зулын голыг асаасанд хэн ч үл эргэлзэнэ. Гэтэл нарны туяа зулын гол дээр туслаа ч, хэрэв тэр нь үл асах чанартай бол

асгахгүйсэн билээ.

Хэрэв Бурхан багшийг төрүүлдэг Бурхан багшийн мөн чанарын зулын голд Түүний оюун гал нь хүн-зулын голыг асааж, Бурхан багшийн мөн чанарыг нээгч итгэл бишрэлийн гал болон бадран дүрэлзэнэ.

Бурхан багш өөрийн оюун ухааны томруулагч шилийг ертөнцөд тусгадаг тул энэ ертөнцөд итгэл бишрэлийн гал дүрэлзэн асдаг.

2. Хэдийгээр бүх хүн төрөлхөөсөө гэгээрэх үрийг өөртөө агуулдаг ч, хүмүүс хорвоогийн шунал тачаалын тоосны үүл мананд төөрч, сайн, муу хэмээх ойлголтын эрхшээлд автаж бачимддаг билээ.

Хүмүүс төрөлхөөсөө гэгээрэх санаа сэтгэлийг агуулдаг мөртлөө яагаад буруу ташаа төсөөлөл буй болгож, Бурхан багшийн гэрэл гэгээнээс зайлж, төөрөгдлийн ертөнцөд хэрэн хэснэ вэ?

Эрт урьд цагт нэг хүн өглөө эрт босч, өөрийгөө толинд харж, нүүр царай, толгойгүй болсноо үзээд сандарчээ. Гэвч түүний нүүр царай, толгой нь алга болоогүй, тэрбээр толио буруу харуулж, өөрийгөө ар талд нь харж тийнхүү эндүүрчээ.

Хүсэн хичээвч гэгээрч чадахгүй нь гээд зовж шаналах бол тэнэг явдал юм. Ингэх шаардлагагүй. Гэгээрэлд төөрөгдөл байхгүй, гэвч хүн эцэс төгсгөлгүй цаг хугацааны турш гадаад тоосонд дарагдахдаа, төсөөлөл таамаглалын ертөнцөд амьдарч, улмаар өөртөө төөрөгдлийн ертөнцийг бүтээн буй болгожээ.

Тиймээс хүн төсөөллийн ертөнцөө орхиж чадвал, төвөггүй гэгээрч, гэгээрлээс өөр төсөөллийн ертөнц байхгүйг ухаарна. Гэвч гэгээрсэн хүний хувьд төсөөллийн ертөнц нэгэнт алга болж, тэрбээр юунд ч гэгээрэх хэрэггүйг ухаарах нь юу юунаас илүү гайхалтай.

3. Бурхан багшийн энэхүү мөн чанар үүрд мөнх оршдог. Ертөнцөд хүн, амьтны төрхийг олж төрсөн ч, эсвэл бирд буюу өлсгөлөн сүнс болж төрөөд зовж зүдэрсэн ч, тамд унасан ч гэсэн Бурхан багшийн мөн чанар мөнх оршино.

Бузартсан бие махбод, хорвоогийн шунал тачаалын хир буртаг бүхий ёроолд унавч Бурхан багшийн мөн чанар нь гэрэл гэгээ цацраасан хэвээр байна.

4. Эрт урьд цагт нэгэн хүн найзындаа очихоор явжээ.

Тэрбээр дарс ууж согтоод, найзындаа унтжээ. Түүнийг нойрсож ахуй үед найзад нь яаралтай ажил гарч аянд оджээ. Гэвч явахынхаа өмнө найзыгаа бодож, дээлийнх нь заханд эрдэнэ нууж оёсон аж.

Түүнийг мэдээгүй нөхөр нь унтаж босоод олон орноор хэрэн хэсч, идэх хоол, уух усгүй явж байлаа. Чингээд найзтайгаа тааралдахад цаадах нь дээлийнхээ заханд буй эрдэнийг хэрэглэ хэмээжээ. Энэхүү домог үлгэр лүгээ адил Бурхан багшийн мөн чанарын эрдэнэ бол хүсэл шунал, уур уцаар зэрэг хорвоогийн тачаалын дээлийн заханд нууц далд буй бөгөөд хэзээ ч өнгө алддаггүй билээ.

Энэ ертөнцөд Бурхан багшийн оюун ухаангүй төрсөн нэгээхэн бээр ч хүн байхгүй. Тиймээс Бурхан багш харцаараа хүмүүсийг цоо ширтэхдээ: " Бүх хүн Бурхан багшийн оюун ухаан, бодь чанаруудыг өөртөө агуулдаг нь юутай сайхан бэ!" гэж баясан баярладаг.

Гэвч хүмүүс мунхагийн харанхуйд автаж, эд юмсыг ёсоор нь эс харж, өөрт нь Бурхан багшийн мөн чанар буйг эс үзэх учир Бурхан багш хүмүүсийг сургаж, тэднийг төсөөллийн ертөнцөөс ангижруулж, тэд төрөлхөөсөө Бурхан багшаас өчүүхэн бээр ялгал үгүй хэмээн ойлгуулдаг.

5. Энд бидний ярьж буй Бурхан багш бол Бурхан

багш болсон хүн юм. Ирээдүйд бүх хүн мөн адил Бурхан багш болно, өөр хэн ч болохгүй.

Хэдийгээр тэд Бурхан багш болох ёстой ч, одоохондоо болоогүй байгаа билээ. Хэрэв хэн нэг нь Бурхан багшийн сургаалыг ухаарч таньсан гэж бодвол их л алдаж байгаа хэрэг.

Хэдийгээр бүх хүнд Бурхан багшийн мөн чанар буй боловч хүн Бурхан багшийн сургаалыг ухаартал тэр чанар нь үл илэрнэ. Тэр чанар үл илэрнэ гэдэг нь Бурхан багшийн сургаалыг тэр ХҮН ухаараагүй гэсэн үг.

6. Эрт урьд цагт нэгэн хаан амьдарч байжээ. Тэрбээр сохор хүмүүсийг дуудан цуглуулж, цугааранд нь нэгэн зааныг барьж үзэхийг тушааж, дараа нь хүн бүрээс зааныг хэрхэн төсөөлж байгааг лавлажээ. Зааны соёог барьж үзсэн сохор хүн хэлэхдээ, заан томоос том лууван лугаа адил гэжээ. Чихийг нь барьж үзсэн хүн, заан дэвүүр лүгээ адил хэмээжээ. Хушуугий нь оролдсон хүн өчихдөө, заан томоохон нүдүүр лүгээ адил хэмээжээ. Хөлийг нь оролдсон хүн, заан том гуалин мод лугаа адил гэжээ. Сүүлийг нь барьж үзсэн хүн, заан нь олстой адилхан гэжээ.

Нэг ч сохор хүн зааны тухай зөв төсөөлөл олж

аваагүй аж.

Үүнтэй адил хүнийг оролдож үзээд, биений нь зарим хэсгийг тодорхойлж болох ч, түүний мөн чанарын тухай буюу Бурхан багшийн мөн чанарын тухай зөв, оновчтой хэлэхэд туйлын хэцүү.

Хүн үхэхэд эс алдагдах, хорвоогийн шунал тачаалд өнгөө үл алдах, мөнх оршдог Бурхан багшийн мөн чанарыг гагцхүү Бурхан багш, Түүний сургаалын хүчээр л олж болно.

III
АЛИВАА ДАСАХЫН ХҮЛЭЭСНЭЭС АНГИД БАЙХ

1. Хүн бүр Бурханы мөн чанартай. Үүнийг зарим хүн бусад сургаалд номлодог "Би"-тэй эндүүрнэ. Үүгээрээ тэд асар их алдаж байгаа юм.

"Би" нь дасаж дадахтай холбоотой, гэтэл гэгээрсэн хүн бол "би"-гээсээ, дасал болсон юмнаасаа ангижрах ёстой. Бурхан багшийн мөн чанар бол олох ёстой эрдэнэ лүгээ адил. Тэр нь "би"-тэй адил боловч "би", "миний" гэж ярихдаа бидний ойлгож байдаг тэр "би" бус юм.

Өөрийнх нь "би" буй гэж боддог хүн, үл орших

буйг оршиж буй хэмээн эндүүрснээрээ алдаж байна. Бурхан багшийн мөн чанар байхгүй гэж үздэг хүн оршиж буйг үл оршиж буй хэмээн эндүүрч байгаа юм.

Үлгэрлэвэл, манай хүүхэд өвджээ гэж бодъё. Эмчид үзүүлвээс эм өгөөд, хүүхдийн бие нь эмийг шингээтэл сүү өгч болохгүй гэжээ.

Эх нь хүүхэд хөхөө үлгэхээс сэргийлж, товчийг нь гашуун тосоор тосолжээ. Хүүхдийн бие эмийг бүрмөсөн шингээсний дараа эх нь хөхөө угааж үрээ хөхүүлжээ. Хүүхдээ хайрласны учир л ингэсэн ажгуу.

Энэхүү домогт гарч буй эхтэй адил хүмүүсийн алдааг засаж, өөрийн "би"-д дасаж дадахаас нь ангижруулахын тулд Бурхан багш "би" бээр байхгүй хэмээн сургасан аж. Харин Тэрбээр хүмүүсийн алдааг зассаныхаа дараа Бурхан багшийн мөн чанар буй хэмээн номлож эхэлсэн юм.

"Би" хэмээх нь төөрөгдөлд хүргэдэг бол, Бурхан багшийн мөн чанар гэгээрэлд хүргэнэ.

Гэрт нь дүүрэн алт бүхий авдар буйг мэдээгүй ядуу хоосон эмэгтэйг өрөвдөж, түүнд авдрыг нь ухаж авч өгсөн хүн лүгээ адил Бурхан багш, хүний доторхи Бурхан багшийн мөн чанарыг нээж,

хүмүүст харуулна.

2. Тэгвэл хүмүүс Бурхан багшийн мөн чанартай мөртлөө яагаад дээд, доод зиндааны, баян, ядуу хэмээн хуваагдана вэ? Тэд яагаад амьтны аминд халдаж, нэг нэгнийгээ хууран мэхэлж, бусад буруу үйл хэргийг үйлддэг юм бэ?

Ордны нэгэн хүч тэнхээтэй эр байжээ. Нэгэнтээ тэрбээр магнайгаа гоёж зүүсэн эрдэнийн чулуун шигтгээгээ авалгүй барилджээ. Тэрбээр духаараа хүчтэй мөргөхөд эрднийн шигтгээ хамрын хянганы арьсан доогуур гүнзгий шигдэн орж, хөндүүр болгожээ. Хүчтэн эр эрдэнийн шигтгээгээ гээчихсэн хэмээн бодож, эмчид бараалхаж, өвдөж буй газраа эмчлүүлэхийг хүсчээ. Эмч түүнийг хараад л эрдэнийн шигтгээ арьсан доор нь гүнзгий шигдэн орсноос болж өвдсөнийг нь ойлгов. Тэгээд эрдэнийн чулуун шигтгээг чимхэн гаргаж хүчтэнд харуулжээ.

Үүнтэй адил хүмүүст буй Бурхан багшийн мөн чанар хорвоогийн элдэв шунал тачаалын зузаан тоосон дор буй учраас өөрсдөө үл анзаардаг. Мөн чанараа олж харах нүдийг нь сайн багш нээж өгдөг.

Тиймээс хүмүүс Бурхан багшийн мөн чанартай боловч, шунал, уур хилэн, мунхаг сэтгэлээсээ болж бурханы чанар өөрт нь буй тухай санаанд нь ч

багтдаггүй юм. Өөрсдийн үйлдсэн үйл, үйлийн үр нь тэднийг төөрөгдлийн эрхэнд оруулдаг. Гэвч Бурхан багшийн мөн чанар алдагдахгүй бөгөөд эвдрэхгүй. Төөрөгдөл нь арилмагц тэр нь тодоос тод гялалзах өнгөт од лугаа адил гэрэлтэнэ.

Үлгэр домгийн хүчтэн, эмчийн ачаар эрдэнийн шигтгээгээ олсон лугаа адил хүмүүс Бурхан багшийн гэрэл гэгээний ачаар өөртөө буй Бурхан багшийн мөн чанарыг олдог.

3. Хэдийгээр хар, цагаан, хүрэн зэрэг олон зүсмийн үхэр байвч, цугаараа ижилхэн цав цагаан сүүтэй. Үүнтэй адил хүмүүс өөр өөр нөхцөлд амьдарч, төрөл бүрийн аргаар аж төрж, үйлийнхээ хариуд янз янзын үйлийн үрийг амсдаг ч тэд цугаараа ижилхэн Бурхан багшийн мөн чанартай юм.

Үлгэрлэвэл, Һималайн ууланд үнэт эмийн ургамал байдаг боловч, өтгөн өвс ширэнгэний гүнд нь ургадаг тул хүмүүс олж үл чадна. Эрт урьд цагт нэгэн мэргэн хүн эмийн ургамлыг үнэрээр нь олж, модоор сав үйлдэж, эм тангаа дотор нь хийжээ. Гэвч түүнийг нас барсны дараа эм танг нь ууланд мартсанаас модон саван дотроо муудан ялзарч савнаасаа асгарчээ. Эмийн амт нь ч өөр болсон байлаа.

Энэхүү домогт гардаг лугаа адил Бурхан багшийн мөн чанар нь хорвоогийн шунал тачаалын өтгөн өвс ширэнгэн дунд гүн гүнзгий нуугдаж байдаг бөгөөд хүмүүс түүнийг олоход хэцүү юм. Гэвч энэ удаа Бурхан багш өвс ширэнгийг ярж, түүнийг хүмүүст үзүүлэв. Бурхан багшийн мөн чанар үргэлж чихэр бурам лугаа адил амттай байдаг боловч, хорвоогийн шунал тачаалын улмаас хүмүүст өөр өөр амттай санагддаг учир хүмүүс янз анзаар амьдардаг.

4. Бурхан багшийн мөн чанар эрдэнийн чулуу алмаз лугаа адил хатуу учраас эвдрэхгүй. Элс юм уу, эсвэл чулууг цоолж нүх гаргаж болох авч, алмаз чулууг цоолж нүх гаргаж үл болно.

Хэдийгээр хүний бие махбод, сэтгэл санааг эвдэж болох боловч Бурхан багшийн мөн чанарыг эвдэж үл болно.

Бурхан багшийн мөн чанар бол хүний хамгийн сайн шинж чанар юм. Хүмүүс эрэгтэй хүн, эмэгтэйчүүдээс илүү, эмэгтэй хүн эрэгтэй хүнээс доор гэж үздэг билээ. Харин Бурхан багшийн сургаалын дагуу эрэгтэй, эмэгтэй хүний хооронд өчүүхэн бээр ялгаа байхгүй юм. Энэхүү сургаал Бурхан багшийн мөн чанарыг үнэлж хүндэлдэг байхыг зааж сургана.

Хэрэв бохир алтыг хайлуулан хольцыг авбал

шижир нь тунана. Хэрэв хүний сэтгэлийн бохир алтыг хайлуулж, хорвоогийн шунал тачаал хэмээх хольцыг ялгавал, аливаа хүний дотор Бурхан багшийн мөн чанар ижилхэн тунаран тодорно.

IV БӨЛӨГ

НИСВААНИС

I

СЭТГЭЛИЙН БУЗАР

1. Хүний сэтгэлд буй Бурхан багшийн мөн чанарыг ухааны болон зүрх сэтгэлийн хэмээх хоёр шунал тачаал хучсан байдаг.

Ертөнцийн бүх шунал тачаалыг энэхүү хоёр төрөлд хуваана. Үүсэх шалтгаан нь мунхаг харанхуй болон шунахай сэтгэл юм.

Харанхуй болон ховдог хомхой сэтгэл бүх шунал тачаалыг өдөөнө. Эдгээр нь ямар ч шунал тачаалын эх ундарга болой.

Харанхуй гэдэг нь мунхаг ухаан хийгээд үнэнийг үл ойлгох байдал юм. Ховдог хомхой сэтгэл бол хүсэд шунал, амьдралд дасал болохын эх ундарга юм. Энэ бол нүдээр харж, чихээр сонсч буй бүхнээ эзэгнэх хүслэн юм. Энэ бол үхлийн хүслэн болж өсч ургадаг хүслэн билээ.

Харанхуй хийгээд ховдог хомхой сэтгэлээс эгээрэл хүсэл, уур уцаар, мунхаг ухаан, буруу тайлбар, гомдол, атаархал, худал хуурмаг, бялдууч зан, ихэмсэг зан, бусдыг үл тоомсорлох, хөнгөн

Хийсвэр загнах зэрэг хорвоогийн шунал тачаал төрнө.

2. Хүн өөрт нь таалагдсан юмыг олж хараад хүслээ хангах буруу бодолд автахад шунал үүснэ. Хүн өөртөө үл таалагдах юмыг олж харахдаа эрхэндээ оруулах гэсэн буруу бодолд автахад уур хилэн үүснэ. Хүн харанхуйгаасаа болж юу хийх ёстой, юу хийх ёсгүйгээ үл мэдэх нь мунхаг явдал юм. Буруу сургаалын нөлөөн дор буруу бодох нь буруу тайлбарлахад хүргэнэ.

Хүсэл шунал, уур хилэн, мунхаг харанхуй гурвыг энэхүү ертөнцийн гурван гал хэмээдэг. Бүх хүслээ дураар нь тавьж ухаан бодлоо хазаарлах чадваргүй болсон хүний хүслийн гал нь шатаадаг. Амьд амьтныг хөнөөж, уурын мунхагт автсан хүнийг хилэнгийн гал нь шатаадаг. Бурхан багшийн сургаалыг мэдэхгүй, төөрөлдөж яваа хүнийг мунхагийн гал хуйхалдаг.

Үнэхээр энэ орчлонд янз янзын гал асч буй билээ. Хүсэл шунал, уур хилэн, мунхаг ухааны гал, амьдрах, өтлөх, өвдөх, үхэхийн гал, санаа сэтгэл шаналж, уйтгарлан гуних, зовж зүдрэх, тарчлахын олон гал асч байна. Ертөнцийн шунал тачаалын хорт гал зөвхөн төөрч будилсан хүмүүсийг хуйхлаад зогсохгүй, бас бусдыг зовоож, бие, хэл, сэтгэлээр нүгэл үйлдэхэд хүргэдэг. Үүгээр ч

зогсохгүй энэ галд түлэгдсэнээс үүдсэн идээ бээр нь бусад хүмүүст халдварлаж, тэднийг муу үйлийн замд хөтлөн оруулна.

3. Шунал хүсэл нь хангалуун байх гэсэн сэтгэлээс, уур хилэн нь сэтгэл хангалуун бишээс, мунхаг харанхуй нь муу муухай санаанаас үүднэ. Хэдийгээр шунал хүсэл нь сүйдтэй том нүгэд биш боловч, түүнээс ангижирна гэдэг амаргүй. Хэдийгээр уур хилэн нь их нүгэд боловч, түүнээс ангижирах нь хэцүү биш. Мунхаг харанхуй бол том нүгэл, түүнээс ангижрах нь амаргүй.

Тиймээс хүмүүс өөртөө таалагдаж буй юмыг үзэх, сонсох үедээ зөв бодож сэтгэх, тааламжгүй зүйлийг үзвэл тэвчихийг дээдэлж ямагт зөв бодох, ингэснээрээ муу гурван галыг унтраах ёстой. Хүмүүс зөв, ариун тунгалаг, өгөөмөр сайхан сэтгэлтэй болвол хорвоогийн шунал тачаал тэдэнд үгүй болно.

4. Шунал хүсэл, уур хилэн, мунхаг харанхуй нь өвчтөн халуурах лугаа адил билээ Ямар ч саруулхан, гоё тансаг өрөөнд хэнбугай ч хэвтэж байсан, халуунтай л бол дэмийрч, нойр муутай хононо.

Хорвоогийн эдгээр шунал тачаалаас ангижирсан

хүн хөхөө өвлийн хүйтэн шөнө, газар унаж дэрийн хөлдсөн навчисын дээр ч гэсэн тайван тухтай нойрсоно. Зуны бүгчим шөнө, тав тух муутай, бачуухан өрөөнд ч сайхан унтана.

Ертөнцийн энэхүү гурван шунал тачаал эл хорвоогиин уй гуниг, зовлон зүдүүриин гол шалтгаан билээ. Энэ уйтгар гуниг, зовлон зүдүүрийг гагцхүү сонор сэрэмж, сэтгэл санааны төвлөрөл, оюун ухаан л таслан зогсооно. Сонор сэрэмж нь шунал хүслийн, санаа сэтгэлийн зөв төвлөрөл нь уур уцаарын, оюун ухаан нь харанхуй мунхгийн бузрыг арилгана.

5. Хүний хүсэл аливаа хязгаарыг үл мэднэ. Зүйрлэвэл, энэ нь давстай ус уугаад, цангаа тайлж чадахгүй байгаа хүнтэй адил бүлгээ. Тэрбээр хичнээн их ус уулаа ч, цангаагаа тайлж чадахгүй, улам ангана.

Хүн хүслээ хангахаар тэмүүлэвч сэтгэл нь улам бүр үл ханаж, уурлаж уцаарлаж эхэлнэ.

Хүн хүслээ хангаж чадахгүй. Тэрбээр хүслээ биелүүлж чаддаггүй учир зовж зүдэрдэг. Тэрбээр хүсэл нь биелэхгүй болохоор галзуурах шахдаг.

Хүмүүс ховдог хомхой сэтгэлээсээ болж нэг нэгтэйгээ маргалдаж, хоорондоо дайтна. Ховдог

хомхой сэтгэлдээ автаж урдахаа харахаа больсон хаад ноёд, сайд язгууртан, эцэг хөвгүүд, ах дүү, анд нөхөд хоорондоо тэрсэлдэн дайтаж, нэгийгээ алж хяддаг.

Шунаг сувьдаг сэтгэлээсээ болж хүн зөв замаасаа урваж, хулгай хийж, худал хэлж, буруу хурьцаж эхэлдэг. Зарим үед гэмт хэрэг үйлдэж байгаад баригдан шийтгэгдэж, зовж тарчилдаг.

Түүнээс гадна сувьдаг шунахай сэтгэлээсээ болж бие, хэл, сэтгэлээр нүгэл үйлдэнэ. ХҮН Энэ ертөнцөд зовж, үхсэнийхээ дараа нөгөө ертөнцөд очихдоо харанхуй тамын элдэв зовлонг эдэлдэг.

6. Сувьдаг шунахай сэтгэл бол ертөнцийн хамгийн хэцүү шунал тачаал бөгөөд бусад нь түүний эрхэнд байдаг.

Хомхой сэтгэл нь хорвоогийн шунал тачаал соёолж ургадаг чийгтэй хөрс лүгээ адил юм. Энэхүү ховдог сэтгэл нь хорвоогийн элдэв шунал тачаалыг төрүүлнэ. Сувьдаг шунахай сэтгэл бол буяныг залгидаг шулмас юм. Хомхой сэтгэл ямар ч буяныг үгүй болгоно.

Ховдог хомхой сэтгэл бол цэцгийн сүүдэрт нуугдаж буй хорт могой лугаа адил бөгөөд хүслийн

цэцэгт хуруу хүрсэн болгоныг хөнөөх амой. Ховдог хомхой сэтгэл бол мод ороож ургадаг хорт ургамал бөгөөд хүний сэтгэлийг ороож, буяных нь шим шүүсийг сордог юм. Ховдог хомхой сэтгэл бол шуламын шидсэн талх, түүнийг авсан хүн нүглийн замаар ордог.

Хэрэв өлсгөлөн нохойд цус түрхсэн хоосон булуу хаяж өгвөл шуналтай нь аргагүй түүнийг мэрэх боловч дэмий л цуцаж, зовж зүдэрнэ.

Хэрчим махны төлөө зэрлэг амьтад нэг нэгэнтэйгээ уралцдаг. Асаасан бамбар бариад салхи сөрөн явж буй мунхаг хүн бамбарынхаа галд шатна. Зэрлэг амьтад, мунхаг хүмүүс сувьдаг шунахай сэтгэлээсээ болж өөрсдийгөө зовоож эсвэл шатаадаг.

7. Хорт сум гаднаас эрчлэн нисч ирвэл түүнээс хамгаалж болно, хэрэв дотроос эрчлэн нисч ирвэл хамгаалж үл болно. Шунал хүсэл, уур хилэн, харанхуй мунхаг, ихэмсэг зан энэ дөрвийг элдэв өвчин халдаадаг хорт дөрвөн сумтай зүйрлэж болно.

Сэтгэлд шунал хүсэл, уур уцаар, мунхаг ухаан үүрлэсэн цагт хүн худал ярьж, илүү дутуу чалчиж, хараал хэлж, хоёр нүүр гаргаж, амьтан алж, хулгай хийж, буруу хурьцах бүлгээ.

Сэтгэлээр үйлдэх гурав хэл амаар үйлдэх дөрөв, биеэр үйлдэх гурван нүглийг арван хар нүгэл гэнэ.

Хэрэв хүн санаатай худал хэлж эхэлвэл ямар ч муу үйл үйлдэнэ. Буруу хэрэг хийж буй учир худлаа ярихаас өөр аргагүй болдог. Худлаа ярьдаг учраас нүгэл үйлдэхдээ ичиж зовохыг мэдэхгүй.

Ховдоглох, шунаж хүсэх, айж эмээх, уурлаж уцаарлах нь цугаараа мунхаг ухаанаас үүднэ. Мөн гай гамшиг, аюул зовлон ч мунхаг ухаанаас урган гардаг. Энэ ертөнцөд мунхаг ухаан элдэв халдварын эх булаг мөн.

8. Хүн хорвоогийн шунал тачаалд автаж муу үйл үйлдэнэ. Муу муухай үйлсээсээ зовж шаналдаг. Хорвоогийн шунал тачаал, муу үйл, зовлон зүдүүр нь эцэсгүй эргэлдэж байдаг гурван хүрд юм.

Эдгээр хүрдний эргэлт нь эхлэл, төгсгөлгүй юм. Хүн энэ хүрээнээс гарч үл чадна. Энэ хүрээнд эргэлдэж, дахин дахин төрж, энэ ертөнцөөс өөр ертөнцөд шилжин очиж, тэндээсээ гурав дахь ертөнцөд шилжиж, ийнхүү дуусашгүй олон төрлийг олно.

Энэхүү мөнхийн эргэлдэх хүрээнд хүний үхсэн

болгоных нь дараа шатаасан ясыг нь цуглуулбал Сүмбэр уулнаас өндөр болно. Энэ цаг хугацаанд ээжээсээ хөхсөн сүүг цуглуулбал сүн далайгаас илүү болно.

II
ХҮНИЙ ЗАН АРАНШИН

1. Хүний зан чанарыг таних хэцүү. Үлгэрлэвэл, хаагуур нь ч орохын аргагүй битүү ургасан зэгс лүгээ адил билээ. Хүнийхийг бодвол зэрлэг амьтны зан чанарыг танихад хялбар юм. Зан чанарынх нь хувьд хүмүүсийг дөрвөн зэрэгт хувааж болно.

Нэгдүгээрт, зовж шаналж буй хүмүүс багтана. Тэд буруу сургаалыг дагаж бие бялдраа зовоож тарчлаадаг.

Хоёрдугаарт, бусдыг зовоож буй хүмүүс орно. Тэд, амьд амьтныг алж талах, хулгай хийх зэрэг олон

муу үйлийг үйлддэг.

Гуравдугаарт, өөрсдөө зовж, бусдыг зовоодог хүмүүс багтана.

Дөрөвдүгээрт, өөрөө үл зовж, бусдыг үл зовоодог хүмүүс багтана. Тэд энх тайван, амар амгалан байдалд, аливаа хүсэл шуналаас ангид амьдарна. Бурхан багшийн сургаалын дагуу тэд амьтан үл алж, сайн үйлс бүтээнэ.

2. Түүнээс гадна энэ ертөнцөд гурван төрлийн хүмүүс буй. Чулуун дээр сийлсэн бичиг лүгээ адил, элсэн дээр зурсан бичиг лүгээ адил, усан дээр бичсэн бичиг лүгээ адил хүмүүс болой.

Чулуун дээр сийлсэн бичиг лүгээ адил хүмүүс уурлаж уцаарлах нь олонтаа, тэр нь удаан үргэлжилж, чулуун дээр сийлсэн бичиг лүгээ адил мөд арилахгүй.

Элсэн дээр зурсан бичээс лүгээ адил хүмүүс уурлаж уцаарлах нь их боловч уур хилэн нь түргэн арилж, зүйрлэвээс элсэн дээрх бичээс лүгээ адил замхармуй.

Усан дээр бичсэн бичээс лүгээ адил хүмүүс усан дээр бичмэгц урсан арилах бичээс лүгээ адил; тэд

бусдыг муучилдаггүй, муу муухай юмны тухай сонсоод хэрэгсдэггүй бөгөөд санаа сэтгэлд нь ямагт энх тайван, амар амгалан ноёрхож байдаг.

Мөн өөр гурван зүйлийн хүмүүс буй. Эхнийх нь ааш зан эгэл жирийн, сэтгэл хөдөлж үймрэх нь амархан, хөнгөмсөгдүү, ямагт хувирамтгай, удаах нь зан чанарын хувьд амаргүй, дуу шуу цөөнтэй, төлөв даруу, маш болгоомжтой, сэтгэлээ барьж хүслээ удирдаж чадах бүлгээ. Түүний удаах нь бүр ч амаргүй, тэд хорвоогийн шунал тачаалаа үндсээр нь дарж устгасан байдаг.

Энэ ертөнцөд олон янзын хүн буй тул, хүн болгоны зан чанарыг ойлгож танихад бэрх хэцүү, гагцхүү Бурхан багш тэдний зан чанарыг ойлгож, хүн болгоныг түүнийх нь дагуу сургаж чадна.

III
ХҮНИЙ АМЬДРАЛ

1. Нэгэн хүний амьдралын тухай сургаал домогт өгүүлснээр, тэрбээр завинд сууж голын урсгал даган хөвж явахад эрэг дээр буй өөр хүн түүнд хандан хашгирсан нь: “Урсгал дагаж баяр баясгалантай уруудаж байна уу. Гэхдээ чи сайн бод. Урсгал дагавал өндөр өндөр давалгаа, эргүүлэг бий, матар,

догшин шуламууд бтхий ёроолгүй ус бий. Тэнд чи

Энэ домогт урсаж буй гол ус нь зугаа цэнгэлд автсаар өнгөрөх амьдралыг төлөөлнө. "Урсгал дагаж баяр баясгалантай" уруудах гэдэг нь өөртөө дасахын нэр юм. "Өндөр өндөр давалгаа" нь уур уцаар, зовлон зүдүүр, "Эргүүлэг" нь зугаа цэнгэл юм. "Матар, догшин шуламууд бүхий ёроолгүй ус" нь нүгэл үйлдэж доройтохыг төлөөлнө. "Эрэг дээр буй хүн" нь Бурхан багш юм.

Өөр нэг домог үлгэр сонсоно уу. Нэг хүн гэмт хэрэг үйлдчихээд зугтжээ. Араас нь хүмүүс нэхэн элдэж, гүйцэж очоод тал талаас нь бүсэлж, ухран зугтах замгүй болгов. Хавханд орсон лугаа адил болсон тэр хүн дэргэд нь ашиглахаа больсон худаг буйг гэнэт олж харжээ. Худгийн хашлагаас ороонго мод доошоо унжиж байлаа. Тэрбээр ороонго модоор доошоо бууж эхлэв. Тэгтэл худагны ёроолд хорт могой өөрийг нь бууж ирэхийг хүлээж буйг харсан аж. Тэрбээр доошоо буухаа больж ороонго модны тэг дунд гацчихав. Удалгүй гар нь чилжээ Хажуугаар нь тас хар, цав цагаан хоёр хулгана ороонго модыг мэрж эхлэв.

Хулгана ороонго модыг мэрж дуусмагц тэр хүн доошоо унаж, могойн идэш болно. Тэрбээр толгойгоо дээш өргөтөл зөгийний үүрнээс ам руу нь

амтат балны хэдэн дусал унав. Тэрбээр балыг амталж аюулд орсноо ч умартав.

Энэхүү домог үлгэрт "Нэг" гэдэг нь эл ертөнцөд эхлээд төрдөг, дараа нь үхдэг хүний ганцаардлыг илэрхийлж байгаа юм. "Араас нь хүмүүс нэхэн элдэх", "Хорт могой" хэмээх нь янз янзын хүслийн эх булаг болсон бие юм. "Ашиглахаа больсон худагт ургасан оroонго" нь хүний амьдрал гэсэн үг билээ. "Хар, цагаан хоёр хулгана" хэмээх нь цаг хугацаа юм. "Амтат зөгийн балны дусал" бол зугаа цэнгэл юм.

2. Дахин нэг домог үлгэрийг сонсмуу. Хаан хайрцганд дөрвөн хорт могой хийж, асарч байхыг нэг хүнд тушааж, сануулсан нь: "Хэрэв ганцхан ч болов могойны уурыг хүргэвэл толгойгүй болно гэж мэдээрэй". Нөгөө хүн энэ тушаалаас үнхэлцгээ хагартал айж могойтой хайрцгийг хаяж зугтаав. Үүнийг мэдсэн хаан бариулахаар араас нь таван зарцаа явуулжээ. Тэд зугтсан хүнийг мэхлэн хаанд авчрахыг төлөвлөсөн ч, цаадах нь мэхэнд оролгүй улам цааш зугтааж, нэг тосгонд хүрээд тэнд орогнох байр хайж эхлэв.

Гэтэл тэнгэрээс нэгэн дуу дуулдаж, энэ тосгонд хэн ч үл амьдрах бөгөөд өнөө шөнө зургаан дээрэмчин ирнэ гэв. Айж сандарсан хүн цааш зугатав. Замд нь хүчтэй урсгал бүхий гол тааралджээ.

Гатлахад хэцүү байсан ч, энэ талын эрэг дээр үлдвэл аюултайг мэдэрсэн хүн сал зангидаж, арайчүү цаад эрэг дээр нь гарч анх удаа аюулгүй газар ирснээ мэдрэв.

Энэ домог үлгэрт "Хорт дөрвөн могой хийсэн хайрцаг" нь газар, ус, гал, салхи хэмээх дөрвөн махбодоос бүрдсэн хүний биеийг төлөөлнө. Энэхүү бие хүслийн эх булаг, санаа сэтгэлийн дайсан мөн билээ. Тиймээс тэр хүн ийм биенээс зугатахаар шийдсэн аж. "Таван зарц зугтсан хүнийг мэхлэхээр шийдсэн" гэдэг нь хүний бие, түүний сэтгэлийг бүрдүүлсэн таван махбодын нэр юм.

"Орогнох байр" нь хүний зургаан мэдрэхүй, "Зургаан дээрэмчин" бол зургаан, мэдрэхүйн тусагдахуун билээ. Мэдрэхүйн эрхтнүүд аюул авчирдагийг ухаарсан хүн улам цаашаа зугтахад зам хаасан "Түргэн урсгалтай гол" бол хорвоогийн шунал тачаалд автсан амьдрал буюу.

Бурхан багшийн сургаалын салыг зангидсан хүн хорвоогийн шунал тачаалын аймшигтай, гүн гүнзгий голыг гэтэлж, цаад эрэгт гарч амар тайван, энх амгалан байдлыг олсон аж.

3. Энэ хорвоод эх нь хүүхдээ, хүүхэд нь эхээ аварч чадахгүй гурван тохиолдол буй. Эдгээр нь их

түймэр, их үер, их дээрэм болой. Гэвч ийм тохиолдолд хүртэл заримдаа эх, үрс бие биедээ тус болж чадна.

Харин эх нь үрдээ, үр нь эхдээ яагаад ч тусалж чадахгүй өөр гурван тохиолдол байдаг. Үүнд өтлөх, өвдөх, үхэхээс, айх энэ гурван тохиолдол орно.

Эх нь өтөлж буйг харсан хүүхэд өөрийн биеэр өтөлж буй эхээ орлож чадах уу? Өвдөж буй хүүхдийнхээ дэргэд уйлж суугаа эх нь өөрийн биеэр өвдсөн хүүхдээ орлож чадах уу? Хүүхэд нь, эсвэл эх нь үхэж байхад хэдийгээр энэ хоёр эх, үрийн холбоотой ч гэсэн хэрхэн өөрийн биеэр нэг нь нөгөөгөө орлон нөхөж чадах билээ. Эх үрс бие биедээ хязгааргүй хайртай ч эдгээр тохиолдолд нэгэндээ яагаад ч тус болж чадахгүй.

4. Энэ ертөнцөд олон муу үйл үйлдсэн хорон санаат хүн үхсэнийхээ дараа тамд унахад Тамын эзэн Эрлэг хаан түүнээс: "Чи хүний ертөнцөд байхдаа гурван сахиулсан тэнгэртэй учирсан уу?" гэхэд: "Үгүй ээ, би сахиулсан тэнгэртэй учраагүй" гэв.

"Тэгвэл чи таяг тулж бөгтийсөн, арай ядан хөлөө зөөсөн хөгшчүүлтэй уулзаж байсан уу?" хэмээв. "Тийм ээ, би тийм олон өвгөнтэй учирч байсан" гэв. "Чи тэдгээр сахиулсан тэнгэртэй учирсан ч тэдэнтэй адил өтлөхөө эс ойлгож, сайн үйл яаран бүтээхийг

бодсонгүй. Тиймээс одоо ийм шийтгэлийг хүлээж байгаа юм" гэв.

"Чи хэвтэрт орсон, харахад нүд дальдирмаар турж сульдсан өвчтэй хүмүүстэй учирч явсан уу?". "Би тийм өвчтөнтэй олон удаа таарч байсан". "Чи өвдөж" буй сахиулсан тэнгэртэй учрахдаа өөрийг чинь бас өвчин ороохыг ойлгосонгүй. Тиймээс тамд унасан байна".

"Чи дэргэдээ үхэж буй хүмүүсийг харсан уу?" "Би үхэж буй хүмүүстэй олонтаа таарсан". "Амьд бүхэнд үхлийг сануулагч сахиулсан тэнгэртэй учирсан боловч чи, хэзээ нэгэн цагт өөрөө үхэхээ эс ухаарч, сайн үйл бүтээхийг бодсонгүй. Тиймээс ч ийм шийтгэл амсаж байгаа юм. Хийсэн үйлийнхээ үрийг өөрийн биеэр амсах ёстой".

5. Нэгэн баян хүний бэр Кисаготами ганц бяцхан хүүгээ алджээ. Зовлон гасланд нэрвэгдсэн залуухан эхийн ухаан санаа элий балай болжээ. Тэрбээр хүүгийнхээ хөрсөн цогцсыг элгэндээ нааж, хайртай хүүгий нь эдгээж чадах хүнийг олохоор явжээ.

Таарaлдсан хүмүүс зовлонг нь хуваалцах боловч нэг нь ч тусалж эс чадна. Ялж төгс нөгчсөн багшийн нэг шавь нь эмэгтэйг өрөвдөж Жетаванад буй багш дээрээ очихыг зөвлөсөн аж. Залуухан эх

хүүгээ тэвэрсээр Бүхнийг айлдагч багш руу яарчээ.

Хамгийг мэдэгч багш, эмэгтэй рүү анхааралтайяа ширтэн хараад хэлсэн нь: "Эмэгтэй минь, хүүхдийг чинь эмчилж эдгээхийн тулд намуу цэцгийн үр хэрэгтэй. Хотод очоод хүнээс 4-5 ширхэг үр гуйгаад ир. Гэхдээ нэг ч хүн нь талийгаач болоогүй тийм айлаас авсан намуу цэцгийн үр байх ёстой" гэв.

Уй гашууд автаж, ухаан санаа нь балартсан эх намуу цэцгийн үр олж авчрахаар хот руу явжээ. Тэрбээр намуу цэцгийг амархан олсон боловч, нэг ч хүнээ алдаагүй айл өрхийг олсонгүй. Эмэгтэй өөрт нь хэрэгтэй намуу цэцгийн үрийг олж чадалгүй, Бурхан багш дээр буцаж очжээ. Амарлингуй оршигч багш амар амгалан байдалд, дуу чимээ үл гарган суухыг хараад эмэгтэй сая Түүний үгийг утгыг ойлгожээ. Тэрбээр нойроос сэрсэн юм шиг болж, ухаан санаа нь эрүүл саруул болов. Чингээд хүүхдийнхээ хүйтэн цогцсыг оршуулж, Чадагчийн эрхт багш дээр эргэж ирээд Түүнд шавь оржээ.

IV
ХҮНИЙ БОДИТ АМЬДРАЛ

1. Энэ дэлхийд амьдарч буй хүмүүс нэг нэгийгээ хайхардаггүй, нэг нэгийгээ хайрладаггүй билээ. Тэд

өчүүхэн юмнаас хэрэлдэж, нүгэл хилэнц зовлон зүдүүр дунд амьдарч, амьдрал нь тэр чигээрээ гай гамшиг, зовлон зүдүүрийн битүү тойрог болном.

Тэд байр суурь, эд баялгаасаа үл шалтгаалан зөвхөн мөнгөний тухай бодож зовж шаналнa. Нэг хэсэг нь мөнгөгүй болоод зовно. Нөгөө хэсэг нь мөнгөтэй болоод зовно. Тэд, гагцхүү хүслээ хангахыг л бодож, нэг хором ч амар тайван байж чаддаггүй.

Баян хүмүүс тариалангийн талбайтай бол түүнийхээ төлөө, байшинтай бол бас түүнийхээ төлөө санаа зовно. Тэд өөрт нь буй, дасаж дадсан бүх юмныхаа төлөө санаа зовж байдаг. Гай тохиолдож, саад бэрхшээл учрах, эсвэл эд баялаг нь түймэрт шатахад зовон шаналж, түүгээр ч зогсохгүй амиа хорлох гэнэ. Тэр ч бүү хэл тэд үхлийн замд ганц ганцаараа одож, тэднийг хэн ч үл дагалдана.

Ядуу нь юу ч үгүй хоосноосоо болж зовж зүдэрдэг. Тэд байшин сав, тариалангийн талбайтай болохыг хүснэ. Тэд хүслийн галд шатаж, бие сэтгэлээрээ ядарч сульдана. Үүнээс болж тэд олдсон амьдралаа бүрэн гүйцэд эдэлж чадалгүй цагаасаа өмнө амьсгал хураана. Тэдэнд энэ хорвоогийн бүх юм дайсагнах шиг санагддаг бүлгээ. Үхлийн урт замд тэд мөн л нэг нэгээрээ оддог.

2. Энэ ертөнцөд таван нүгэл буй. Нэгдүгээрт, хүн болоод газар дээр мөлхөгч амьтан хүртэл бие биедээ байнга дайсагнаж байдаг. Хүчтэй чадалтай нь сул доройгоо шахан хавчиж, сул дорой нь хүчтэй чадалтайгаа хууран мэхэлнэ. Тэд хоорондоо дайсагналцаж, нэг нэгийгээ үргэлж гомдоож, доромжилж байдаг.

Хоёрдугаарт, эцэг эх, үр хүүхэд, ах дүү нар, эхнэр нөхөр, төрөл төрөгсөд, ойр дотны хүмүүс өөрийн гэсэн амьдралын зарчимгүй, хатуу чанд дүрэм журамгүй байдаг. Тэд гагцхүү амиа бодож, хүслээ хангахыг хичээнэ. Тэдэнд өөрийн үнэн үгүй. Тэд бие биенээ хууран мэхэлж, үг үйл хоёр нь үргэлж зөрнө.

Гуравдугаарт, бүх амьтан атгаг муу санаа өвөрлөж, шунал тачаалд автдаг. Эрэгтэй, эмэгтэйчүүдийн аль нь ч ноогдсон үүргээ биелүүлдэггүй. Учир иймээс хоорондоо дайсагнаж, хэсэг бүлэг болон хуваагдаж, хорт үйл үйлддэг.

Дөрөвдүгээрт, хэн ч сайн үйл бүтээхийг эрмэлздэггүй. Бие биеэ муу уруу татаж, муу үйл үйлдэж, худал ярьж, дэмий чалчиж, бусдыг муучилж, хоёр нүүр гаргаж, нэг нэгийгээ доромжилно. Бие биесээ үл хүндлэх тул, хүн бүр өөрийгөө энэ хорвоогийн хамгийн чухал хүн хэмээн үзэж, өрөөлийг доромжилсондоо огтхон ч ичиж

гэмшихгүй.

Тавдугаарт, бүх хүн залхуу хойрго зантай, сайн үйл бүтээхийг үл мэднэ. Тэд баярлаж талархахыг мэдэхгүй, үүргээ ухамсарлахгүй. Гагцхүү өөрийн хүсэлд хөтлөгдөж, бусдад гай тарьж, эцсийн эцэст хүнд гэмт хэрэг үйлдэнэ.

3. Хүмүүс бие биенээ хүндэтгэж , нэг нэгэндээ тус болох ёстой. Гэтэл тэгэхийн оронд хувийн өчүүхэн ашиг сонирхлоо дээдэлж, биесийг үзэн ядна. Ингэхдээ бяцхан маргаан нь яваандаа томоохон хэрүүл дэгдээж, гүн их нуугдмал хонзон, гомдож өших сэтгэл төрүүлдгийг үл мэднэ.

Хэдийгээр энэ ертөнцөд дайсагнах нь хоёр талд хоёуланд нь хор хүргэх боловч шууд сүйрэлд авчирдаггүй. Гэвч тэр нь сэтгэлийг хордуулж, хүнийг уур уцаартай болгож, сэтгэл санааг нь хувирган өөрчилдөг. Иймээс хүмүүс дахин дахин төрж, бие биеэ доромжилж, гүжирдэн гүтгэж, өвөр зуураа дайсагналцсаар байгаа юм.

Энэхүү ховдог хомхой сэтгэл, шунал тачаалын ертөнцөд хүн ганцаараа төрж, ганцаараа үхдэг. Үйлийн үрийг нь ирээдүйд өөр хэн ч бус, өөрөө л үүрэх ёстой болдог.

Буян, нүгэлийн хариу өөр өөр буй. Буян үйлдсэн хүн зол жаргалыг олдог бол, нүглийн хариуд гай гамшиг ирдэг. Энэ бол хөдөлшгүй үнэн юм. Гэхдээ хүн бүр үйлдсэн үйлийнхээ хариуг заавал өөрөө амсана.

4. Хүсэл шунал, дадал заншил, зовлон зүдүүрээр бат бэх холбогдсон хүмүүс цаг хугацаа улиран өнгөрөхөд улам цөхөрч зовно. Тэд гүн гүнзгий цөхрөлд автаж, ховдог хомхой сэтгэлээ хангахыг хичээж, уур омогтой болж, эрүүл ухаанд багтамгүй юм үйлдэж, хэрэлдэж, зөв зам мөрийг үл олж, цагаасаа өмнө үхэж, байнга шаналж зовохоос өөр аргагүй болдог.

Хүмүүсийн иймэрхүү амьдрал байгалийн хуулинд ч тэр, газар, тэнгэрийн хуулинд ч тэр үл нийцнэ. Ийм амьдрал гай гамшиг л авчирч, хүмүүс энэ ертөнц болон хойт насандаа ч заавал зовж зүдэрнэ.

Үнэхээр энэ хорвоод бүх юм урсан улирч, түргэн өөрчлөгдөж, тогтвортой, найдлагатай юу ч байхгүй бүлгээ. Ийм нөхцөлд байгаа хэрнээ бүгд л зугаа цэнгэл хөөцөлдөх нь ихэд гунигтай юм.

5. Энэ бол ертөнцийн үнэн дүр зураг юм. Энэ ертөнцөд хүмүүс зовлон дунд төрж, сайн үйлсийн тухай өчүүхэн бээр үл мэдэж, гагцхүү нүгэл үйлдэнэ.

Тиймээс хорвоогийн жам ёсны дагуу улам их зовлон эдэлнэ.

Хүмүүс гагцхүү хувиа хичээж бусдад үл тусална. Тэд хүслийнхээ хүлээсийг сул задгай тавьж, шунал тачаалын галыг бадрааж, зовж зүдэрч, хариуд нь улам их тарчлан шаналдаг.

Цэцэглэж дэгжих нь удаан үл үргэлжилж, нүд ирмэх зуур улиран одно. Энэ ертөнцөд зугаа цэнгэл мөн адил дорхноо арилан өнгөрнө.

6. Тиймээс хүн хорвоогийн явдлаас салж, эрүүл саруул байгаа дээрээ зөв замд орж, мөнхийн амьдралыг хүсэх хэрэгтэй. Зөв зам мөрөөс өөр илүү аятай, тааламжтай юм буй гэж үү?

Гэвч хүмүүсийн сайн үйлийн ачаар буян хураадаг, зөв үйл хэрэг зөв зам мөрд хөтөлж авчирдагт үл итгэнэ. Тэд, хүн үхсэнийхээ дараа дахин төрөхийг ч үл мэднэ. Бусдад туслах бол жаргал гэдэгт тэд үл итгэнэ. Тэд буян, нүгэлтэй холбоотой юунд ч үл итгэнэ.

Хүмүүс алдаж, зөв сургаал, сайн үйл юу болохыг үл мэднэ. Тэдний санаа сэтгэлд харанхуй ноёрхож, үйл хэрэг нь бүтэх, эс бүтэх болон зол жаргал тохиолдох, золгүй явдал учрахын хууль журмыг үл

мэднэ. Тэд гагцхүү уйлж унжиж, энэ амьдралдаа гуньж гутарна

Ертөнцөд мөнхийн юм үгүй, бүх юм улиран урсаж, хувиран өөрчлөгдөж байдаг. Үүнээс болж хүмүүс уйтгарлан гуньж, зовж зүдрэхээс өөр юу ч мэдэхгүй. Зөв сургаалыг үл сонсож, гүн гүнзгий бодож бясалгадаггүй. Тэд амархан олддогоор нь гагцхүү зугаа цэнгэл эргүүлнэ. Тэдний эд баялагтай болох эрмэлзэл, шунал тачаалд нь эцэс төгсгөл, зах хязгаар үгүй.

7. Аль дивангараас эхлэн хүмүүс төөрөгдлийн ертөнцөд амьдарч, мөнхийн түгшүүрт оршиж, хязгааргүй их зүдэрдэг. Энэ төөрөгдөл эдүгээ үргэлжилсэн хэвээрээ юм. Харин одоо тэд Бурхан багшийн сургаалыг мэдэх, Түүнд итгэх боломжтой болсон нь юутай сайхан бэ.

Тэд гүн гүнзгий бодлогоширч, нүглээс холдож, буяныг сонгож, Бурхан багшийн сургаалыг дагах ёстой.

Аз болоход одоо цугаараа Бурхан багшийн сургаалыг танин мэдэх бололцоотой учир Түүнд сүсэглэж, Бурхан багшийн ертөнцөд мэндлэхийг хүсч байх ёстой. Бурхан багшийн сургаалтай танилцсаны дараа бусдад уруу татагдаж, хорвоогийн

шунал тачаалын эрхэнд орж, нүгэл үйлдэхийг тэвчих хэрэгтэй. Зөвхөн өөртөө авралыг хүсч болохгүй, харин энэ сургаалыг түгээн дэлгэрүүлж, бусад хүмүүст ч авралыг ерөөх хэрэгтэй.

V БӨЛӨГ

БУРХАН БАГШИЙН АВРАЛ

I

БУРХАН БАГШИЙН ТАНГАРАГ

1. Хүмүүст хорвоогийн шунал тачаалаас салж ангижрах туйлаас хэцүү. Эрт дээр үеэс тэд муу үйл үйлдэж, төөрөлдөж буй билээ. Тиймээс ч тэд Бурхан багшийн мөн чанартай боловч, түүнийгээ илрүүлэн гаргаж үл чадна.

Хүний зан чанарыг сайн мэддэг Бурхан багш аль дивангарын үеэс бодьсад болохоор шийдэж, Дээд зэргийн энэрэнгүй, нигүүлсэнгүй сэтгэлийг үзүүлэн хүмүүсийг айж эмээх, зовж зүдрэхээс ангижруулж эхэлсэн юм. Үүний тулд Тэрбээр олон тангараг өргөж, өөрт нь ямар ч хүнд сорил тохиолдсон бололцоотой бүхнийг хийхээ андгайлж:

а) Хэдийгээр би Бурхан багш болох боловч, миний ертөнцөд төрж буй хүмүүс Бурханы хутгийг олж чадахгүй буюу гэгээрэхгүй бол би өөрөө гэгээрэхгүй;

б) Хэдийгээр би Бурхан багш болох боловч, миний гэрэл гэгээ хязгаарлагдмал, ертөнцийн өнцөг булан бүрт хүрэхгүй бол би өөрөө гэгээрэхгүй;

в) Хэдийгээр би Бурхан багш болох боловч, миний амьдрал хязгаарлагдмал, тодорхой он жилд багтахаар байвал би өөрөө гэгээрэхгүй;

г) Хэдийгээр би Бурхан багш болох боловч, ертөнцийн бүх арван зүгийн орны бурхад миний нэрийг магтан дуулж алдаршуулахгүй бол би өөрөө гэгээрэхгүй;

д) Хэдийгээр би Бурхан багш болох боловч, ертөнцийн бүх арван зүгийн орны хүмүүс миний сургаалд гүн гүнзгий итгэн сүсэглэж, миний ертөнцөд мэндлэхийг хүсч, миний нэрийг амандаа арав давтавч тэгж чадахгүй бол би өөрөө гэгээрэхгүй;

е) Хэдийгээр би Бурхан багш болох боловч, миний сургаалыг дагахаар шийдсэн ертөнцийн бүх арван зүгийн орны хүмүүс олон буяныг үйлдэж миний ертөнцөд мэндлэхийг чин сэтгэлээсээ хүсээд үхэхэд нь, би агуу их бодьсад нарын хамт тэдний өмнө тодрон гарч ирэхгүй бол өөрөө гэгээрэхгүй.

ж) Хэдийгээр би Бурхан багш болох боловч, ертөнцийн бүх арван зүгийн орны хүмүүс миний тухай танин мэдээд, миний ертөнцийн тухай мөрөөдөж, тэнд мэндлэхийг чин зүрхнээсээ хүсэн буяны үрийг таривч тэгж чадахгүй байвал би өөрөө гэгээрэхгүй;

з) Хэдийгээр би Бурхан багш болох боловч, миний ертөнцөд төрөл олсон хэн ч гэсэн Бурхан багш болж бусад хүмүүсийг сургаж, тэднийиг гэгээрэл, Их нигүүлсэнгүй сэтгэлийн буян руу залж чадахгүй бол би өөрөө гэгээрэхгүй;

и) Хэдийгээр би Бурхан багш болох боловч, миний гэрэл гэгээ гийсэн ертөнцийн бүх арван зүгийн орны хүмүүс бие сэтгэлээрээ эс тайвширч, энэ ертөнцөд бусдаас илүү болохын хүслээр бадрахгүй бол би өөрөө гэгээрэхгүй;

к) Хэдийгээр би Бурхан багш болох боловч, ертөнцийн бүх арван зүгийн орны хүмүүс намайг таньж мэдээд амьдрал, үхлийн тухай нарийн үнэнийг эс ухаарч, гүн их оюун ухааныг эс олвол би өөрөө гэгээрэхгүй.

Би эдгээр тангаргыг өргөж байна. Хэрэв миний энэ бүх хүсэл эс биелвээс би өөрөө гэгээрэхгүй. Би бээр шавхагдашгүй гэрэл гэгээний эх булаг болж, бүх орныг гийгүүлэн гэрэлтүүлж хүмүүсийг төөрөгдлөөс ангижруулж, хүмүүст сургаалын санг нээж, газар сайгүй буяныг үйлдэх болно.

2. Бурхан багш эдгээр тангаргыг өргөөд, урт удаан хугацаанд хязгааргүй их буяныг үйлдэж Өөрийн Ариун цагаан ертөнцийг бүтээж, аль дивангарт

Бурхан багш болоод, одоо Өөрийн сургаалыг Өөрийн Ариун гэгээн оронд заан номлож байна.

Энэхүү ариун цагаан ертөнцөд цэвэр ариун, амар амгалан байдал ноёрхож байдаг юм. Энд төөрөгдөл үгүй, гагцхүү гэгээрэхийн баяр баясгалан буй. Хувцас хунар, хоол хүнс, аливаа гоо сайхан юмс энэхүү ертөнцийн оршин суугчдын хүслээр буй болдог. Ариухан салхи намуухан сэвэлзэж, эрдэнэсийн моддыг үл мэдэг ганхуулахад гэгээн сургаалыг номлогч дуу хоолой агаар мандлыг дүүргэж, сонсож буй бүгдийн сэтгэлийг ариутгана.

Энэ ертөнцөд өнгө бүрийн тансаг анхилуун үнэртэй лянхуа цэцэглэж байдаг. Цэцэг болгон өөр өөрийн гэрэл гэгээг сацруулах хязгааргүй олон дэлбээтэй юм. Гэрэл болгон Бурхан багшийн оюун ухааныг номлож, анирхан сонсогч бүгдийг энх тайван, амар амгалан бүхий Бурхан багшийн зам мөрөөр зална.

3. Бүх арван зүгийн орны Бурхан багш нар энэхүү Бурхан багшийн буяныг магтан дуулна.

Энэхүү Бурхан багшийг мэдсэн хэн боловч Түүнд баяр баясгалантайгаар итгэвэл Түүний ертөнцөд мэндэлнэ.

Энэхүү Бурхан багшийн ертөнцөд очсон хэн боловч мөнх насыг олж, бусад хүмүүсийг аврахын хүслээр бадарч, энэхүү ариун үйл хэрэгт өөрийгөө буй чигээр нь зориулмуй.

Тэд ийм хүслээр шатан бадарч, дасаж дадсанаасаа ангижиран, ХҮНИЙ оршихын мөнх бусыг танин мэднэ. Тэд зөвхөн өөртөө бус, бусдад тустай үйлийг эхэлж, бусдын итгэл найдвар, зовлон зүдүүрийг хуваалцана. Тэд хорвоогийн амьдралын аливаа хүлээс, дадал заншлаас чөлөөтэй буюу.

Тэд энэхүү ертөнц зовлон зүдүүрээр дүүрнийг мэдэх бүлгээ. Тэд Бурхан багшийн энэрэнгүй, нигүүлсэнгүй сэтгэл эцэс төгсгөлгүй, зах хязгааргүйг сайн мэднэ. Тэдний санаа сэтгэлд аливаа дадал заншил байхгүй. Тэд өөрийгөө бусдаас, бусдыг өөрөөсөө өчүүхэн бээр үл ялгадаг. Тэд төгс эрх чөлөөтэй билээ. Тэд хаашаа л бол хаашаа явж, урагшаа ч тэр, арагшаа ч тэр хөдөлж чадах боловч Бурхан багшийн энэрэнгүй, нигүүлсэнгүй сэтгэлийг хүртэх ёстой хүмүүсийн хамт үлдэх нь дээр гэж үздэг.

Тиймээс Бурхан багшийг таньж мэдсэн хэн боловч Бурхан багшийн алдрыг ганц удаа ч гэсэн баяр баясгалантайгаар давтвал Бурхан багшийн ерөөлийг хүртэнэ. Бүх хүн Бурхан багшийн сургаалыг анхааралтайяа сонсч, амьдрах, үхэхийн ертөнцийг бүхэлд нь залгисан гал руу Тэрбээр дахин

дагуулан явж буй мэт санагдсан ч Түүнийг дагах хэрэгтэй.

Хэрэв Хүмүүс үнэхээр гэгээрэхийг хүсвэл Бурхан багшийн тусыг гуйх хэрэгтэй.

Бурхан багшийн туслалцаагүйгээр жирийн хүн гэгээрч чадахгүй.

4. Одоо ч Бурхан багш биднээс тун холгүй байгаа юм. Хэдийгээр Түүний ертөнц асар хол оршивч, Бурхан багш Өөрөө түүний тухай бодож буй бүх хүний сэтгэлд амьдарч байдаг.

Хэрэв сэтгэлд оршиж буй энэ Бурхан багшийн дүрийг төсөөлвөл Тэрбээр тоолж баршгүй алтан гэрэл туяагаа тал тал тийшээ түгээж, 84 мянган дүр төрхийг үзүүлнэ. Дүр, төрх бүр мянган туяаг цацруулна. Туяа бүр Бурхан багшийн тухай хэн бодно, түүнийг гэрэлтүүлж, хэзээ ч үл орхих билээ.

Бурхан багшийг харж буй хүн Түүний сэтгэлийг үзнэ. Түүний сэтгэл нь дээд зэргийн энэрэнгүй болой. Тэрбээр Өөрт нь итгэж сүсэглэсэн бүхнийг авраад зогсохгүй, мөн Өөрийнх нь энэрэнгүй сэтгэлийг үл мэдэх, эсвэл Өөрийг нь мартсан хүмүүсийг ч аварна.

Бурхан багш Өөрт нь итгэн сүсэглэдэг хүнд Өөртэйгээ нийлэн нэгдэх бололцоо олгоно.Түүний тухай үргэлж бодвол Тэрбээр Өөрөөрөө аливаа юмыг

дүүргэж чадах тул хүн болгоны сэтгэлд нэвтрэн орно.

Тиймээс хүн Бурхан багшийн тухай бодоход, санаа сэтгэл нь Бурхан багшийн тод томруун дүр төрхийг олж, улмаар өөрөө Бурхан багш болно.

Сүсэг бишрэл сайтай, зөв шударга явдалтай хүний сэтгэл нь Бурхан багшийн сэтгэл юм.

5. Бурхан багш олон дүр төрхтэй. Тэрбээр хэний ч өмнө тухайн хүн авьяас чадварынхаа дагуу Бурхан багшийг ухааран ойлгохтой нь дүйж тохирох дүрээр тодорно. Бурхан багш ертөнцийг тэр чигээр нь Өөрөөрөө дүүргэж, Тэрбээр эцэс төгсгөлгүй, зах хязгааргүй чанартай болой. Тэрбээр хүний ухаанд танигдашгүй бүлгээ. Бурхан багшийг сансар огторгуй, байгаль дэлхий, хүн болгоны аль алинаас нь олж харж болно.

Бурхан багшийн нэр алдрыг давтсан хүн бүхэн Түүнийг олж харж чадна. Тэрбээр уг хүндээр заавал хоёр бодьсадыг дагуулан ирнэ.

Бурхан багш бүхий л ертөнцөд орших боловч Түүнд итгэж сүсэглэдэг хүн л түүнийг олж харна.

Бурхан багшийн харьцангуй нэгэн дүртэй учирсан ч хүн зол жаргалыг олно. Тиймээс жинхэнэ Бурхан багштай учирвал улам их, үнэхээр хэмжээ

хязгааргүй жаргалыг олно.

6. Энэ Бурхан багшийн сэтгэл нь гагцхүү Дээд зэргийн энэрэнгүй нигүүлсэл, оюун ухаан учраас Бурхан багш ямар ч хүнийг аварна.

Хүн мунхгаасаа болж хүнд хэцүү гэмт хэрэг үйлдэж, санаа сэтгэлдээ ховдог хомхой, уур уцаарыг үржүүлж, атгаг муу санааг өвөрлөж, худал ярьж, илүү дутуу чалчиж, хараал урсгаж, хоёр нүүр гаргаж, амьтан алж, хулгай хийж, худалд автаж, өөрөөр хэлбэл арван хар нүглийг үйлдэж байдаг бөгөөд муу үйлээсээ болж ирээдүйд үүрд зовж зүдрэх ялыг авдаг.

Хүнийг амьсгал хураах байхад сайн найз нь ирж хэлэх нь: "Өмнө чинь чамайг зовлон зүдүүр хүлээж байна. Одоо чи Бурхан багшийн тухай бодож ч чадахгүй байна. Тэгвэл чи ядахдаа Түүний нэрийг давт".

Хэрэв хүн сэтгэл санаагаа төвлөрүүлж Бурхан багшийн нэр алдрыг хэдэнтээ хэлбэл, давтах болгонд нэгэн томоохон нүгэл нь цайрч, улмаар эцэс төгсгөлгүй төөрөн хэсүүчлэхийн ертөнцөөс авраг дана.

Хэрэв хүн Бурхан багшийн нэрийг давтвал нүгэл нь арилж эцэс төгсгөлгүй төөрөн хэсүүчлэхийн ертөнцөөс аврагдана. Хэрэв тэрбээр чин сэтгэлээсээ залбирвал бүр ч амархан бүтнэ.

Үнэхээр Бурхан багшид мөргөн залбирч буй хүн цагаан лянхуа адил сайхан бүлгээ. Энэрэнгүй сэтгэл, оюун ухаан хэмээх хоёр бодьсад, тэр хүнд газарчилж зөв зам мөрөөр залж, Бурхан багшийн ертөнцөд авчирна.

Тиймээс бүх хүн "Наму-Амида бицу" буюу "Аминдава нэрт Цаглашгүй гэрэлт бурханд мөргөмүй" гэсэн үгсийг цээжлэх ёстой юм. Эдгээрийг тогтоох нь Бурхан багшийн нэрийг цээжилнэ гэсэн үг.

II
ЖАРГАЛЫН ОРОН

1. Бурхан багш үнэхээр оршиж Номоо номлож буй. Түүний ертөнцөд амьдарч буй хүмүүс зовж зүдрэхийг үл мэдэж, өдөр хоногийг жаргал цэнгэл дунд өнгөрөөнө. Тиймээс ч энэ ертөнцийг энхжингийн орон гэдэг.

Энэ ертөнцөд эрдэнийн чулуугаар бүтээсэн долоон нуур байдаг. Нуурын ус цэвэр тунгалаг. Нуурын ёроол алтан элсээр хучаастай. Нуурын усны мандал дээр том том лянхуа цэцэг ургана. Цэнхэр өнгийн лянхуа цэцэг цэнхэр гэрэл, шар өнгийн лянхуа цэцэг шар гэрэл, улаан өнгийн лянхуа цэцэг улаан гэрэл, цагаан өнгийн лянхуа цэцэг цагаан гэрэл тус тус цацраана. Тэдгээр нь эргэн тойрон ариун

тунгалаг, тансаг сайхан үнэр түгээнэ.

Нуурын дэргэд тус тусдаа алт, мөнгө, индранил, болороор бүтсэн дөрвөн ордон байдаг. Тэдгээр ордны нуурын эрэг рүү буусан шатыг гантигаар бүтээжээ. Зарим газар нуурын эрэг дээр эрдэнийн чулуун шигтгээ хэлхэж оёсон хөшгөөр хучаатай, гоё чамин хийцтэй хашаа хашлага босгосон үзэгдэнэ. Тэдгээрийн хооронд газар сайгүй тансаг сайхан үнэртэй мод, цэцэг ургана.

Дээд тэнгэрээс гайхамшигтай сайхан хөгжмийн эгшиг сонсдож, газар дэлхий алтан гэрлээр гэрэлтэнэ. Хоногт зургаан удаа тэнгэрээс цэцэг унана. Хүмүүс эдгээр цэцгийг түүж ваaранд суулгаж, бусад бурхан багшийн ертөнцөд аваачиж, түм түмэн бурхан багш нарт өргөл болгоно.

2. Энхжингийн орны цэцэрлэгт хун, тогос, тоть, хөхөө зэрэг шувууд яруу сайхан хоолойгоор уянгалуулан зогсолтгүй дуулна. Тэд сайн үйл, буян тэргүүтнийг магтан дуулж, Бурхан багшийн сургаалыг номлоно.

Хүмүүс яруу сайхан хоолойгоор уянгалуулан дуулах шувуудыг сонсоод Бурхан багшид сүсэглэн, сургаал юуг нь бясалгаж, энх амгалан, эв найрын төлөө залбиран мөргөнө. Эдгээр дууг сонсч буй хэн боловч Бурхан багшийн дуулал хэмээн болгоож,

Бурхан багшид сүсэглэх нь улам батжиж, шинэ шинэ баяр баясгаланд автаж, бусад ертөнцөд амьдардаг Бурхан багшийн сургаалыг дагагчидтай сайн буяны бүх ерөөлөө улам улам батжуулна.

Ариухан салхи намуухан сэвэлзэж эрдэнэсийн моддыг үл мэдэг ганхуулж, гэрэл гэгээ цацруулсан олон хонхыг хөндөхөд, тэдгээр хонх тус тусдаа нэг нэг эгшиглэнт ая тоглож эхэлнэ.

Хүмүүс түүнийг сонсоод Бурхан багшид залбиран мөргөж, сургаал юуг нь бодон бясалгаж, амар амгалан, эв найртай амьдралын төлөө мөргөн залбирч эхэлнэ. Бурхан багшийн ертөнц ийм бодь чанар, урьд өмнө үзэгдээгүй гоо үзэсгэлэнгээр дүүрэн юм.

3. Яагаад энэ ертөнцийн Бурхан багшийг зах хязгааргүй гэрэл гэгээ, эцэс төгсгөлгүй амьдралын Бурхан багш хэмээн алдаршуулна вэ? Учир нь Бурхан багшийн гэрэл гэгээг хэмжиж үл болно. Тэрбээр хорвоогийн арван зүгийн бүх орныг гийгүүлэн буй ч, гэрэл гэгээ нь шавхагдаж үл дуусна. Түүний амьдрал эцэс төгсгөлгүй. Тиймээс Түүнийг ийнхүү нэрлэн алдаршуулдаг.

Энэхүү ертөнцөд мэндэлсэн бүхэн эргээд төөрөгдлийн ертөнцөд үл очно. Тэднийг ч гэсэн тоолж баршгүй.

Бурхан багшийн гэгээ гэрлээр гийсэн мөн адил тоо томшгүй олон хүн шинэ амьдралд сэрж мэндэлдэг.

Хэрэв хүн ертөнцөөс одох цаг ирэхэд Бурхан багшийн нэр алдрыг бүтэн нэг өдөр юм уу, эсвэл долоо хоногийн турш дуудан алдаршуулвал Бурхан багш олон ариун явдалтнаа дагуулан түүний өмнө тодорно. Тийм хүний сүнс заавал Бурхан багшийн ертөнцөд мэндэлнэ.

Хэрэв хүн Бурхан багшийг таньж мэдээд Түүний сургаалд итгэн сүсэглэвээс л тэрбээр Бурхан багш нарын ивээл дор, оройн дээд гэгээрэлд хүрнэ.

БОДЬ МӨРИЙН ЗЭРЭГ

I БӨЛӨГ

ГЭГЭЭРЭХ ЗАМ

I

СЭТГЭЛ САНААГАА АРИУСГАХ

1. Хүн, төөрөгдөл зовлон зүдүүрийн эх булаг болсон хорвоогийн шунал тачаалын эрхшээлд оршмой. Тэдгээрийн эрхшээлээс ангижрах таван арга буй.

Нэгдүгээрт, эд юмсыг үнэн зөв харах, учир шалтгааны хуулийг ухааран мэдэх явдал болой. Бүх зовлон зүдүүрийн эх булаг нь сэтгэлийг эзэмдэх хорвоогийн шунал тачаал мөнийг мэдэж, түүнийг устгаж арилгавал зовлон зүдүүрээс сая ангижирна.

Хүн эд юмыг буруу үзэж харах тул, өөрийнхөө "Би"-г оршдог хэмээн бодож, учир шалтгааны хуулийг үл хэрэгсэнэ. Иим буруу ташаа ухаарал, шунал тачаалын шалтгаан болж, хүн төөрөлдөж, зовж зүдэрнэ.

Хоёрдугаарт, хүслээ хазаарласнаар хорвоогийн шунал тачаалыг номхотгоно. Нүд, чих, хамар, хэл, бие хийгээд бодол санааны нөлөөгөөр үүсдэг хүслийг эрүүл ухаанаар дарж шунал тачаалын үндсийг тас цавчих хэрэгтэй.

Гуравдугаарт, эд юмсыг хэрэглэхдээ, тэдгээрийг хэрхэн ашиглах тухай зөв ойлгож төсөөлөх учиртай. Өөрийнхөө зугаа цэнгэлийг л бодож хувцас хунар өмсөж, хоол унд идэж ууж болохгүй. Хувцас хунар бол нүцгэн биеийг бусдын нүднээс далдлах, халуун, хүйтнээс хамгаалах зориулалттай. Хоол хүнс нь Бурхан багшийн сургаалыг дагаж буй хүний бие махбодыг тэжээхэд зориулагдана. Эд юмсад хүн ингэж зөв хандвал шунал тачаал санаа сэтгэлд нь буй болохгүй.

Дөрөвдүгээрт, бүх юманд тэвчээр хэрэгтэй. Халах хөрөх, өлсөх цангахыг тэвчиж, доромжлол, гүтгэлгийг хүлцэж чадвал хүнийг шатаадаг шунал тачаалын гал үл асна.

Тавдугаарт, аюулт дур сонирхлоос холхон байвал зохино. Ухаантай хүн эмнэг морь, эсвэл галзуу нохойд үл ойртох адил, осолтой газраас холхон байж, муу нөхдөөс зайлсхийх ёстой. Тэгвэл шунал тачаалын дөл бөхнө.

2. Ертөнцөд таван хүсэл буй. Тэдгээр нь, хүний нүд аятайхан хэлбэр галбирыг олж харах, чих аятайхан ая дууг сонсох, хамар аятайхан анхилууныг үнэрлэх, аятайхан амтнаас арааны шүлс асгарах, гар аятайхан юмыг мэдрэхэд буй болно.

Олон хүн биеийн эдгээр хүсэлд автаж, хожмын үр дагаврыг үл бодон зугаа цэнгэлд умбадаг. Тэд ойн буга гөрөөчний зангуунд өртөх лүгээ адил шуламын эрхэнд орох бүлгээ. Үнэхээр эдгээр таван хүсэл нь хавх, зангуу лугаа адил юм. Хүн тэдгээрт баригдмагц сэтгэлд нь шунал тачаал төрж, зовж зүдэрч эхэлнэ. Эдгээр хүслээс болж гай гамшигтай тулгарвал, хавхнаасаа мултрах аргыг эрэх хэрэггэй.

3. Хавхнаас гарах нэг бус арга буй. Тухайлбал, могой, матар, шувуу, нохой, үнэг, сармагчин буюу зан авирааараа эвлэрэх аргагүй зургаан амьтныг барьж, бат бэх уяагаар холбон, хоёр үзүүрийг нь зангидаж тавъя.

Зургаан амьтан өөр өөрийн төрөлх чанартаа хөтлөгдөн үүр үүр рүүгээ зүтгэнэ. Могой уул толгод руу, матар ус руу, шувуу тэнгэр рүү, нохой тосгон руу, үнэг эзгүй тал руу, сармагчин ой мод руу тэмүүлнэ. Амьтан бүр өөрийн зүг рүү зүтгэж, тэднээс хамгийн чадалтай нь дийлж, бусдыгаа үүр рүүгээ чирэн одно.

Үүнтэй адил хүн нүд харж, чих сонсож, хамар үнэрлэж, хэл амталж, арьс мэдэрч, сэтгэл хүсч буй юмныхаа эрхшээлд орно. Эдгээрээс хамгийн хүчтэй нь дийлж, хүн тэр хүслийн эрхшээлд бүрэн автана.

Хэрэв нөгөө зургаан амьтныг тус тусад нь газарт лав суулгасан баганаас чанга уявал эхлээд амьтан бүхэн өөрийн үүр рүү тэмүүлнэ. Удалгүй ядран сульдаж тус тусын баганын дэргэд хэвтэнэ.

Үүнтэй адил санаа сэтгэлээ барьж, удирдаж чадвал, бусад таван хүсэл нь хүний сэтгэлийг уруу татаж дийлэхгүй. Сэтгэлээ захирч чадсан хүн өнөөдөр, маргаашийн алинд ч зол жаргалтай амьдарна.

4. Хүмүүс хүслийн галд шатаж, алдар нэрийн хойноос хөөцөлдөнө. Тэд, асаахад уугин шатсаар алга болдог гүгэл лүгээ адил бүлгээ. Хэрэв Бурхан багшийн сургаалыг мартан нэр алдар, гавъяа шагналын хойноос хөөцөлдвөл хүний бие махбод үхэх мөхөхийн аюулд унаж, санаа сэтгэл гэмшин зовж шаналнa.

Нэр алдар, эд баялаг, гоё чамин юмны хойноос хөөцөлдөж буй хүн зөгийн бал түрхсэн хурц иртэй илдийг долоож буй хүүхэдтэй адил юм. Амтат балыг долоож байгаад хэлээ зүсч болзошгүй.

Хүсэлдээ автаж, ханахыг үл мэдэх хүн нь асаасан бамбарыг салхины эсрэг барьж яваа этгээдтэй адил юм. Тэрбээр өөрийн гар, бие юүгээ түлж шатаана.

Шунаж хүсэх, үзэн ядах, мунхаг харанхуйн гурван хоронд идэгдсэн өөрийн сэтгэлд итгэж үл болно. Мөн сэтгэлээ дур зоргоор нь сул тавьж үл болно. Санаа сэтгэлээ хазаарлан барьж, хүсэл шуналдаа автахгүй байхыг хичээвээс зохино.

5. Гэгээрэхийг хүсч буй хүн хүслийн галаас зайлсхийх ёстой. Хуурай өвс үүрч яваа хүн талын түймрээс зугатахтай адил, гэгээрэхийг тэмүүлж буй хүн хүслийн галаас хол байх учиртай.

Хурц гоё өнгийн юм харчихаад санаа сэтгэл нь шохоорхохоос сэрэмжилж нүдээ ухан авч хаяхыг хүсэх хүн тэнэг. Энд хамгийн гол нь сэтгэл юм. Сэтгэлээ засаж чадвал түүнд захирагддаг нүдний гэм арилна. Бурхан багшийн сургаалыг дагахад хэцүү. Гэвч гэгээрэхийг хүсэх сэтгэлгүй амьдрах бүр ч хэцүү. Гэгээрлийг хүсдэггүй хүн энэ ертөнцөд төрөөд өтлөх, өвдөх, үхэхийн эцэс төгсгөлгүй зовлонд унана.

Бурхан багшийн сургаалыг дагагч хүн гүн гүнзгий шавар шавхай дундуур зоон дээрээ хүнд ачаа үүрээд гэлдэрч буй үхрээс үлгэр авах хэрэгтэй. Тэр үхэр зогсохыг мэдэхгүй урагшаа зүтгэнэ. Гагцхүү шавар шавхай өнгөрсний дараа саатаж амардаг. Хүслийн шавар шавхай бүр хэцүү ч, гэгээрэх зам мөрийг зөв сэтгэлтэй дагавал түүнийг туулсны

дараа зовлон зүдүүр дуусч, хөнгөрч амарна.

6. Гэгээрэх зам мөрийг дагаж яваа хүн амиа бодсон бардам зангаасаа салж, Бурхан багшийн сургаалын гэрэл гэгээг олох хэрэгтэй. Ямар ч үнэт эрдэнийг энэхүү буянтай зүйрлэх аргагүй.

Хүний бие бялдар эрүүл энх байж, гэр орон нь цэцэглэн хөгжиж, энх төвшин, амар амгаланг олохын тулд юуны өмнө сэтгэлээ хатамжилж, залж сурах хэрэгтэй. Хэрэв хүн сэтгэлээ залж чадаад Бурхан багшийн сургаалыг үзэхдээ баярлаж баясдаг болвол, өөрөө мэдэлгүй буяныг хураана.

Үнэт эрдэнэ газраас гарч, буян нь сайн үйлээс төрж, оюун ухааныг амар тайван, ариун тунгалаг сэтгэлээс олно. Зах хязгааргүй тал лугаа адил, төөрөгдөл дүүрэн амьдралыг эсэн мэнд даван туулахын тулд зам мөрөө оюуны гэрлээр гийгүүлэн, өөрийгөө буянаар хамгаалахыг хичээсүгэй.

Бурхан багш шунал хүсэл, үзэн ядах сэтгэл, харанхуй мунхгийн гурван хороос салахыг номлоно. Энэ бол зөв сургаал юм. Түүнийг дагасан хэн боловч сайн сайхан, зол жаргалтай аж төрнө.

7. Хүний сэтгэл, бодол санаагаа даган үргэлж хувирна. Шунал хүслийн тухай бодмогц, шунал хүсэл

буй болно. Үзэн ядахын тухай бодмогц, үзэн ядах сэтгэл буй болно. Өшөө хонзонгийн тухай бодмогц, өшөө хонзон буй болдог

Намар ургац хураах цаг ойртоход малчин билчиж буй үхрээ хурааж, хашаанд нь оруулдаг. Тэрбээр үхэр нь ургацыг гишгичиж, түүнийг хурааж буй хүмүүсийн уур хилэнг хүргэж, зодуулж нүдүүлэх вий хэмээн болгоомжилсных билээ. Үүнтэй адил үйлээс болж гай гамшиг үүдэхийг харсан хүн сэтгэлээ хорьж, атгаг муу бодол санаанаас хагацах хэрэгтэй юм. Шунал хүсэл, үзэн ядах сэтгэл, өшөө хонзонг устгаад, үл хүсэж шунах, үл үзэн ядах, үл өшиж хонзогнохыг хичээх хэрэгтэй. Хавар хээр талд шинэхэн өвс ногоо соёолоход үхэрчин үхрээ бэлчээрт гаргана. Гэвч тэрбээр хариулгаа үл орхино.

Үүнтэй адил хүн ямагт санаа бодлоо хянаж, залж чиглүүлэх ёстой.

8. Нэгэнтээ Ялж төгс нөгчсөн багш Каусамби балгаст морилов. Түүнд хорон санаа агуулсан хүн, тус хотод амьдарч байжээ. Тэрбээр муу хүмүүсийг хахуулдаж энэ балгаст Амарлингуй оршигч багшийн тухай олиггүй цуу тараажээ. Хамгийг мэдэгч багшийн шавь нар балгасаар бадар барин явж гуйлга гуйхад тэдэнд юу ч өгөлгүй, урьдаас нь элдэв муухай үг хэлээр доромжилжээ.

Тэгээд Ананда, Бүхнийг айлдагч багшдаа хандаж: "Энэ балгаст үлдэх дэмий байна. Энэнээс дээр өөр балгаст очъё" гэв. Түүнчлэн ирсэн багш хариуд нь: "Ананда, дараагийн балгаст бидэнтэй мөн л ингэж харьцвал яана?" гэсэнд Ананда: "Тэгвэл түүний дараагийн балгаст очъё" хэмээв.

Бурхан багш. "Үгүй ээ, Ананда, иймэрхүү маягаар биднийг ямар ч балгаст уггаж магадгүй. Тэгвэл үргэлж нэг балгасаас нөгөө рүү явна. Миний бодоход биднийг доромжилж байвал тэвчиж, бүр чингэхээ больтол нь тэвчих хэрэгтэй. Харин үүнийхээ дараа өөр балгас руу явж болно. Ананда, чи сонсож бай. Бурхан багш хожих болон алдах, гүжирдүүлж гүтгүүлэх болон нэр алдар олох, магтаал болон доромжлол, зовж зүдрэх болон баярлаж баясах зэрэг найман ойлголтоос хол хөндий байдаг юм. Энэ бүхэн тун удахгүй улиран өнгөрнө" гэв.

II
БУЯН ҮЙЛДЭХ

1. Гэгээрэхэд тэмүүлсэн хүн бие, хэл, сэтгэлээр үйлдэж буй үйлээ ариун байлгахыг ямагт бодох хэрэгтэй. Биеэр үйлдэж буй үйлээ ариун байлгах нь амьтны амь үл таслах, хулгай үл хийх, буруу үл хурьцах гэсэн ёс юм. Хэлний үйлийг ариун байлгах нь худал үл хэлэх, үл хараах, хоёр нүүр үл гаргах, үл

чалчих хэмээсэн хэрэг.

Сэтгэлийн үйлийг ариун байлгах нь үл шунах, үл уурлах, эд юмсыг буруу үл харах хэрэг билээ.

Хэрэв сэтгэлд хир суувал ажил үйлс бузартаж, зовж зүдрэхээс зайлах аргагүй болно. Тиймээс санаа сэтгэлээ ариусгаж, аливаа үйлд биеэ барих нь чухал.

2. Эрт урьд цагт нэгэн баян бэлэвсэн эхнэр байжээ. Тэрбээр сайхан сэтгэлтэй, зөөлөн зан ааштай, төлөв даруу эмэгтэй тул, нэр хүнд ч сайтай байжээ. Мөн өөртэй нь адил ухаалаг, хөдөлмөрч нэг эмэгтэй зарцтай байжээ.

Нэгэнтээ зарц эмэгтэй бодсон нь: “Миний эзэгтэй бүгдийн хайр хүндлэл хүлээсэн билээ. Тэрбээр үнэхээр сайн хүн үү, эсхүл орчныхоо ачаар ийм болсон уу? Ямар ч гэсэн нэг сорьж үзье”хэмээв.

Маргааш өглөө зарц эмэгтэй оройхон босч, үдийн хоолны үеэр үзэгдэв. Эзэгтэй уцаарлангуйхан: "Өнөөдөр чи яагаад ийм орой босов" гэж асуув.

Зарц эмэгтэй; "Ганц хоёр удаа орой бослоо гэж бүү уцаарла" хэмээсэн нь эзэгтэйг улам хилэгнүүлэв.

Дараагийн өдөр зарц нь мөн хожуу босчээ. Уур

нь дүрэлзсэн эзэгтэй мод шүүрч, зарц эмэгтэйг цохиод авчээ. Хүмүүс энэ тухай мэдмэгцээ эзэгтэйг хүндэлж хайрлахаа больжээ.

3. Бүх хүмүүс энэ эзэгтэйтэй адил бүлгээ. Хэрэв орчин тойрон нь сайн бол, хүн ариун сэтгэлтэй, төлөв даруу, амгалан тайван байж чаддаг. Гэвч орчин тойрон нь хувиран өөрчлөгдөж, өөрийнх нь эсрэг хандвал тийм хэвээр үлдэж чадах уу?

Хүн өөрийнхөө тухай аягүй үг сонсож, хүмүүс өөрт нь илэрхий дайсагнаж, олигтойхон хувцас хунар, олигтойхон хоол унд үл олдож, сайн, муу ч өөрийн орох оронтой болж чадаагүй байхдаа урьдын адил амгалан тайван сэтгэлтэй хэвээр буянт үйлээ тасралтгүй үргэлжлүүлж чадах уу?

Орчин тойрон өөрт нь аятайхан байгаа нөхцөлд амгалан байдлаа хадгалж, сайн үйл бүтээж чаддаг бол тэрбээр сайн хүн бишээ. Гагцхүү Бурхан багшийн сургаалд баярлан баясаж, бие махбод, санаа сэтгэлийн төгс төгөлдөр чанарыг олсон нэг нь сайн хүн байж чадна. Тэрбээр амгалан байдлаа ямагт хадгалж, төлөв даруу хэвээрээ үлддэг билээ.

4. Бүх үгийг эсрэг тэсрэг утга илэрхийлдгээр нь таван зүйлд хувааж болно. Үүнд: зохистой болон зохисгүй, бодит байдалд нийцэх ба үл нийцэх,

зөөлөн болон хатуу ашигтай ба хортой, мөн хайрлаж хэлэх болон үзэн ядаж хэлэх үгс ормой.

Танд хандаж эдгээр үгийн алий нь ч хэлсэн, сэтгэлийн тэнцвэрээ хадгалж бүдүүлэг үг үл хэрэглэж, хүмүүст санаа тавьж халамжлан, энэрлийг үзүүлж, уур уцаар, үзэн ядах сэтгэлийг огт мэддэггүй болох хэрэгтэй.

Хэн нэгэн нь хүрз зээтүү хоёроор ээлжлэн газар ухаж, шороогоо алга болгоно гэж эргэн тойрон тараан цацахдаа яаж ч хичээсэн, яаж ч хүссэн шороо алга болж устахгүй бүлгээ. Үүнтэй адил үгсийг устгаж, алга болгож болохгүй.

Иймээс танд хандаж ямар ч үг хэлсэн өөрийгөө төгс болгож, энэрэнгүй сэтгэлээ хөхүүлэн дэмжиж, хичнээн хичээгээд будгаар тэнгэр дээр юм зурж болдоггүйн адил, үгс санаа сэтгэлд чинь ямар нэгэн байдлаар нөлөөлөхгүйн тулд сэтгэлийнхээ тэнцвэрийг хадгалах хэрэгтэй. Хичнээн ч хичээгээд хуурай өвсөн бамбар асаан их устай голыг хатааж ширгээж болохгүй билээ. Хичнээн оролдоод сайн элдүүртэй арьсыг үрж шар шархийх чимээ гаргаж болохгүй билээ.

Хүн сэтгэлээ дэлхий ертөнц лүгээ адил уужимхан, тэнгэр лүгээ адил зах хязгааргүй, далай тэнгис лүгээ

адил гүн гүнзгий, сайн элдүүртэй арьс лүгээ адил зөөлөн байлгахыг эрмэлзэх хэрэгтэй.

Дайсны гарт орж, зэрлэгээр тамлуулсан ч санаа сэтгэлээр унаж болохгүй. Хэрэв санаа сэтгэлээр унавал, Бурхан багшийн сургаалыг үнэн зөв дагахгүй байна гэсэн үг юм. Ямар ч тохиолдолд сэтгэлээ амгалан хэвээр хадгалж, үзэн ядсан уур хилэнд автсан үг хэлэхийг цээрлэж, хүнд нинжин сэтгэл, хайр халамжаар хандах хэрэгтэй.

5. Нэг хүн үдэш болоход утаа суунагладаг, өдөр нь галд автдаг шоргоолжны үүрийг олж харжээ. Тэрбээр энэ тухайгаа номч мэргэнд хэлсэн аж. Цаадах нь түүнд "Илд авч шоргоолжны үүрийг ухахыг" тушаав. Хүн тушаасан ёсоор нь болгов.

Тэрбээр шоргоолжны үүрийг төнхөж эхлээд оньс, дараа нь хөөс, сэрээ, хайрцаг, яст мэлхий, хутга, хэрчим мах ухаж гаргаж ирэв. Хамгийн сүүлд луу гаргаж ирэв.

Хүн шоргоолжны үүрээс юу олсноо мэргэн хүнд хэлбэл цаадах нь: "Луунаас бусдыг хаях хэрэгтэй. Луунд саад болох хэрэггүй, орхи" хэмээв.

Энэхүү домог үлгэрт "Шоргоолжны үүр" нь хүний биеийг төлөөлнө. "Үдэш болоход утаа

суунагладаг" хэмээх нь хүн үдэш болоход өдрийн хэрэг явдлаа дурсаж, сайныг хийсэн байвал баярлан баясч, мууг хийсэн бол харамсан гунихыг хэлж буй юм. "Өдөр галд автдаг" хэмээх нь хүн үдэш бодсоноо өдөр үг, үйлээрээ хэрэгжүүлэхийг хэлж байгаа юм.

Энэхүү домог үлгэрийн “хүн” нь Бурхан багшийн сургаалыг дагаж байгаа юм. "Номч мэргэн хүн" нь Бурхан багш билээ. "Илд" нь ариун тунгалаг оюун ухаан, "гүнзгий ухах" гэдэг нь төгс төгөлдөр болохыг хичээх гэсэн үг билээ.

"Оньс" нь мунхагийн харанхуй, "Хөөс" нь уур уцаар болоод зовлон зүдүүр, "Сэрээ" нь эргэлзэх, түгших, "Хайрцаг" нь шунал хүсэл, үзэн ядах, залхуурах, санаа сэтгэл түгших, харамсах, тээнэгэлзэхийг тус тус хэлнэ. "Яст мэлхий" бол бие, сэтгэл юм. "Хутга" бол таван хүсэл билээ. "Хэрчим мах" нь зугаа цэнгэлд автахын хүслэн юм, эдгээр нь хүний биеийг хордуулах учир энэ бүхнээс ангижрах хэрэгтэй.

Шоргоолжны үүрнээс хамгийн сүүлд гарч ирсэн "Луу" бол хорвоо ертөнцийн шунал тачаалаас салж чадсан санаа сэтгэл юм. Хэрэв хөл доорхи газраа сайн ухвал эцсийн эцэст лууг гаргаж ирнэ гэсэн үг.

"Луунд саад болох хэрэггүй, орхи" гэдэг нь

хорвоогийн шунал тачаалаас ангижирсан сэтгэлийг амгалан байлгаж эхэлсэн хэргээ дуусгах бололцоо олгохыг хэлж байгаа юм.

6. Бүхнийг айлдагч багшийн шавь Пиндола гэгээрснийхээ дараа төрсөн балгас Каусамбидаа эргэж очоод, халуун дотно хандсан оршин суугчдад талархсанаа илэрхийлэхийг хүсчээ. Тэрбээр Бурханы үрийг суулгах газар олохоор шийджээ. Хотын захад цаад зах нь харагдахгүй, цувуулан тарьсан дал модны гудам бүхий цэцэрлэг байв. Хоёр эрэг дээгүүрээ халин урсаж буй Ганга мөрнөөс сэрүүн салхи сэвэлзэнэ.

Нэг удаа зуны халуунд Пиндола шатаам хурц нарны туяанаас заилсхий, дал модны сүүдэрт бясалгал үйлджээ. Яг энэ өдөр Удаяна хаан хатадтайгаа хамт цэцэрлэгт цэнгэхээр ирэв. Тэрбээр хөгжмийн ая, наргиан наадмын шуугианаас цуцаж, модны сүүдэрт зүүрмэглэжээ.

Хааныг унтаж байх хооронд хатад нь цэцэрлэгээр зугаалж байгаад дал модны сүүдэрт бясалгал үйлдэж байсан Пиндолаг олж харжээ. Пиндолаг харж гайхаж биширсэн эмэгтэйчүүд Бурхан багшийн сургаалыг сонирхож, түүнээс ном номлохыг хүсчээ.

Хаан сэрээд гав ганцаар хоцорсноо мэдэв. Тэрбээр хатадаа хайж, дал модны сүүдэрт ариун явдалтай даянч хатдынх нь дунд сууж буйг олж харав. Санаа сэтгэл нь мэдрэхийн зугаа цэнгэлд эвдэрсэн хааны зүрхэнд хардахын гал дүрэлзэн бадарч, уур уцаартаа шатаж, ариун явдалтай даянч руу дайран давшилж хэлсэн нь: "Чи миний хатдыг уруу татаж байгаадаа ичихгүй байна уу?" Пиндола нүдээ аньж, нэг хэсэг дуугүй суув. Тэрбээр хариуд нь юу ч хэлсэнгүй.

Ариун явдалтны ийм амгалан тайван, хэнэггүй байдлыг харж галзууртлаа уурласан хаан илдээ хуйнаас нь суга татаж, Пиндолагийн нүүрэнд тулгахад цаадах нь үг эс дуугаран, чулуу лугаа адил үл хөдлөн суусаар байлаа.

Уур уцаартаа үнэхээр галзуурсан хаан шоргоолжны үүрийг ухаж, үл хөдлөн сууж байсан хуврагыг улаан шоргоолжоор цацав. Гэвч Пиндола урьдын адил хөдлөлгүй суусан хэвээр.

Тэгтэл гэнэт хаан гэмшин ичиж, ариун явдалт мэргэн хүнээс уучилж өршөөхийг хүсчээ. Тэр цагаас хойш Бурхан багшийн сургаал хааны ордонд түгэн дэлгэрч, удалгүй улс даяар таржээ.

7. Хэд хоногийн дараа Удаяна хаан ойд байсан

Пиндолаг эргэн очиж өөрийнх нь амгалан тайван байдлыг алдуулсан олон асуултын хариуг сонсохыг хүсэв.

"Ариун багштан минь, Бурхан багшийн шавь нар залуухан мөртлөө яагаад уруу татагддаггүй цэвэр ариун хэвээр үлдэж чаддаг юм бэ?" гэв.

Пиндола: "Хаан минь, Бурхан багш бидэнд хүүхнүүдэд хэрхэн хандахыг зааж сургасан юм. Хижээл насны эмэгтэйчүүдийг ээжийгээ, дунд насныхыг дүү нараа, залуухныг нь охидоо хэмээн бодох хэрэгтэй. Бурхан багшийн энэхүү сургаалын ачаар Түүний шавь нар залуу ч гэсэн элдвээр уруу татагддаггүй, цэвэр ариун хэвээр үлддэг билээ" гэв.

"Гэтэл хүмүүс эх шигээ хижээл насны, дүү нар шигээ дунд насны, охид шигээ залуухан эмэгтэйг харж дур хүсэлдээ автан уруу татагддаг шүү дээ. Ариун явдалтай багш минь, Бурхан багшийн шавь нар яаж ийм хүслээ дарж чаддагийг хэлээд өгөөч?" гэж Удаяна хүсэв.

"Хаан минь, Чадагчийн эрхт багш бидэнд хүний биеийг бузартуулдаг цус, идээ, хөлс, тос зэргийг олж харахыг зааж сургасан юм. Хүнд буй энэ бүхнийг олж харснаар бид залуу ч гэсэн сэтгэлээ цэвэр ариун хэвээр хадгалж чаддаг юм" гэж Пиндола өчив.

"Ариун багштан минь. Бие бялдар, санаа сэтгэлийн зовлонг давж туулсан, ухаант шавь нарт энэ нь амархан буйзаа. Харин Бурхан багшийн туршлага муутай шавь нарт энэ нь хэцүү биз ээ. Тэд бузартсаныг олж харахыг хүсч тэмүүлэхдээ өөрсдөө мэдэлгүй цэвэр ариунд хэт дурлан шунадаг бий. Бузар булайг олж харахыг тэмүүлэхдээ өөрсдөө мэдэлгүй гоо сайханд дурлан шунах бий. Бурхан багшийн шавь нар гоо сайхан, цэвэр ариун үйл хэргээ үргэлжлүүлэн бүтээхийн бололцоогоо хадгалах өөр янз бүрийн нууц байдаг уу?" гэж Удаяна асуув.

"Хаан минь, Бурхан багш бидэнд таван мэдрэхүйн үүд хаалгыг сайтар хамгаалахыг зааж сургадаг. Нүд өнгө, хэлбэрийг харж, чих хоолойноос гарах дуу авиаг сонсч, хамар анхилууныг үнэртэж, хэл бал бурмыг амталж, бие аятай таатайг мэдэрч байхад Бурхан багш ачтай таатайд уруу эс татагдаж, аягүй таагүй юманд эс уурлахыг зааж сургадаг. Таван мэдрэхүйн цонх хаалгыг сайтар харуулдаж хамгаалж байх хэрэгтэй. Бурхан багшийн энэхүү сургаалын ачаар залуухан шавь нар нь хүртэл санаа сэтгэлээ цэвэр ариун хадгалж чаддаг юм" гэж Пиндола мэргэн айлдав.

"Ариун багштан минь, Бурхан багшийн сургаал номлол үнэн зөв билээ. Би үүнийг өөрийн туршлагаас мэднэ. Хэрэв таван мэдрэхүйн үүд

хаалгыг эс хамгаалвал хүн дорхноо доод хүслийн эрхэнд орно. Бидний үйл хэрэг ариун нандин байхын тулд таван мэдрэхүйн үүд хаалгыг сайтар хамгаалах ёстой" гэж Удаяна өчив.

8. Хүн санаа бодлоо, үйл хэрэг болгож эхлэхэд зайлшгүй сөргөлдөөн буй болно. Хэрэв харааж загнавал хариуд мөн тэгэхийг эрмэлзэнэ. Хүн ийнхүү сөргөлдөхөөс бүхий л аргаар түдгэлзэх хэрэгтэй. Сөргөлдөх нь салхины өөдөөс нулимахтай адил. Энэ нь өрөөлд бус өөрт хор хүргэнэ. Энэ нь салхины эсрэг хог шүүрдэх лүгээ адил. Ингэснээр өөрийгөө л тоос шороогоор булна. Эсрэг үйлдэл зайлшгүй гай гамшиг авчирна.

9. Хүн ховдог харамч сэтгэлээсээ салж өглөгч болох нь тун сайн. Түүнээс гадна бас гэгээрэхийг эрмэлзэж, Бурхан багшийн сургаалыг хүндэтгэн биширвэл бүр сайн.

Хүн хувийн ашиг сонирхолыг үл дээдлэн, бусдад эрвийх дэрвийхээрээ туслахыг хичээх ёстой. Хэрэв өрөөлд тусалвал бусад хүн энэ үлгэрийг дагах билээ. Ингэж зол жаргал бүтэж буй болно.

Дүрэлзэж буй бамбарын галаас хэдэн мянган хүн бамбараа асаасан ч тэр нь үл дуусна. Зол жаргал үүнтэй адил билээ. Бусдад яаж ч харамгүй тараасан

тэр нь ширгэж үл дуусна.

Гэгээрэх зам мөрийг дагасан хүн алхам бүртээ туйлын сонор соргог байх ёстой. Зорилго хичнээн өндөр байлаа ч, түүнд алхам алхмаар л ойртоно. Энэ зам мөр өдөр тутмын амьдрал дундуур дайран өнгөрөхийг мартаж үл болно.

10. Гэгээрэх зам мөрийг дагасан хүнд биелүүлэхэд бэрх 20 зүйл буй. Үүнд:

1. Ядуу хүн өглөгч болох бэрх. 2. Бардам хүн гэгээрэхийн зам мөрийг хөөх бэрх. 3. Өөрийгөө умартаж гэгээрэх бэрх. 4. Бурхан багш энэ ертөнцөд байгаа цагт мэндлэх бэрх. 5. Бурхан багшийн сургаалыг сонсох бэрх. 6. Сэтгэлээ ариусгаж доорд хүсэл шуналаас салах бэрх. 7. Гоё сайхан, аятай таатай юмыг үл хүсэх бэрх. 8. Эрх дархтан хүсэл юугаа хангахын тулд эрх дархаа үл хэрэглэх бэрх. 9. Доромжилж байхад тэвчиж, уурлахгүй байх бэрх. 10. Юу ч болсон амар тайван байх бэрх. 11. Аливаа юмыг өргөн цар хүрээтэй, гүн гүнзгий судлах бэрх. 12. Ямар нэгэн юмыг шинээр эхэлж буй хүнийг дооглохгүй байх бэрх. 13. Бардам зангаа барьж дийлэх бэрх. 14. Сайн найзтай болох бэрх. 15. Бурхан багшийн сургаалыг дагаж гэгээрэх бэрх. 16. Гадаад нөхцөл байдлын нөлөөнд орохгүй байх бэрх. 17. Бусдын авьяас чадварыг тааж зааж сургах бэрх. 18.

Санаа сэтгэлээ ямагт амгалан байлгах бэрх. 19. Зөв, буруугийн тухай маргахгүй байх бэрх. 20 Зөв арга барилыг сурах бэрх.

11. Муу, сайн хүмүүс зан чанараараа ялгарна. Муу хүн нүгэлийг эс ухаарч, түүнийг үйлдэхээ зогсоож эс чадна Тэрбээр нүглийнх нь тухай хэлэхэд дургүйцэнэ. Сайн хүн буян, нүглийн тухай ойлголттой болой. Тэрбээр нүглийг танимагц, үйлдэхээ зогсоож, нүдийг нь нээж өгсөн хүнд талархан баярладаг. Ийнхүү сайн хүн муугаасаа ялгарна.

Найр тавьж тусалсан хүндээ талархаж эс чадах хүнийг мунхаг гэнэ Ухаантай хүн ямагт баярлаж талархахдаа бэлэн байдаг. Тэрбээр өөрт нь найр тавьж тусалсанд төдийгүй, хүний төлөө халамж анхаарал тавьсан бусад хүмүүст ч ямагт талархан баярлахад бэлэн байдаг.

III
БУРХАН БАГШИЙН СУРГААЛЫГ ЭРТНИЙ ДОМОГТ ӨГҮҮЛСЭН НЬ

1. Эрт урьд цагт хөгшчүүлээсээ салахын түүс болсон улс байжээ. Тэр улсад насан өндөр хэнийг ч алс холын ууланд аваачиж орхидог аж. Гэвч нэг сайд

хөгшин эцгээсээ салж чадахгүй байжээ. Тэрбээр гүнзгий том нүх ухаж, доторхийг нь янзлан тохижуулж тэнд эцгээ нуусан аж.

Нэг удаа бурхан, тэнгэрээс морилон заларч, эзэн хаанд хүнд хэцүү асуулт тавьжээ: "Энэ хоёр могойг хараад аль нь эр, аль нь эм болохыг ялгаж хэл. Эс таавал улс гүрнийг чинь хүйс тэмтрэнэ" гэхэд хаан эр, эм могойг ялгаж чадсангүй. Ордныхон дотроос ч ялгаж хэлэх хүн олдсонгүй. Эзэн хаан, улс гүрэн даяараа зарлиг буулгаж, эр, эм могойг ялгаж хэлсэн хүнд их шан амлав.

Хаанд бурханы хэлсэн оньсогын тухай сайд эцэгтээ хэлжээ. "Энэ амархан шүү дээ. Хоёр могойг зөөлөн олбог дээр тавибал мушгиралдан цагираглах нь эр могой, үл хөдлөн хэвтэх нь эм могой" хэмээн эцэг нь заажээ.

Сайд нь эр, эм могойг хэрхэн ялгах тухай хаандаа хэлсэн аж. Ийнхүү тэр оньсогыг тайлжээ. Бурхан урьд өмнөхөөсөө улам ээдрээтэй хэцүү оньсого таалгаж эхлэв. Хаан болоод ордныхон нь тэдгээр оньсогыг тааж чадахгүй байлаа. Харин мэргэн эцгийнхээ ачаар өнөөх сайд, оньсого бүгдийг тайлжээ.

Асуусан асуулт, хариулсан хариуг доор

сийрүүлэв.

"Унтаж байхад нь сэрүүн, сэрүүн байхад нь унтаж байна хэмээн хэний тухай ярьдаг вэ?"

"Гэгээрэх зам мөрийг даган явж буй хүний тухай ингэж ярьдаг. Энэхүү зам мөрийн тухай мэдэхгүй учир нойрсож буй хүнийг сэрүүн байна гэдэг. Харин энэ зам мөрийг мэддэг учир сэрүүн байгаа хүнийг нойрсож байна гэдэг". "Аварга том зааны жинг яаж мэдвэл зохих вэ?". "Зааныг завинд суулгаж, завь усанд хэр зэрэг суусныг тэмдэглэж, дараа нь завинаас буулгаж, оронд нь ус тавьсан тэмдэгт хүртэл завинд чулуу ачвал зохино. Эцэст нь ачсан чулуугаа жигнэвэл зааны жинг мэдэж болно".

"Нэг аяга ус их тэнгисээс илүү гэдэг чухамхүү юу гэсэн үг вэ?", "Хэрэв ариун цагаан сэтгэлд хөтлөгдөн аягаар ус хутгаж буурал эцэг, эхдээ юм уу, эсвэл өвдөж зовсон хүмүүст уулгавал энэ сайн үйл хэзээ ч үл мартагдана. Өргөн их тэнгист хичнээн их ус байлаа ч нэгэн өдөр ширгэж болно. Харин буян хэзээ ч ширгэж алга болдоггүй. Тиймээс аяга ус их тэнгисээс илүү гэж ярьдаг юм".

Бурхан яс арьс болсон туранхай хүнийг дуудан ирүүлжээ. Туранхай хүн асуусан нь: "Энэ ертөнцөд надаас илүү өлсч буй хүн бий юу?" "Бий. Хэрэв хүн

зүрх сэтгэл цэвдэг, санаа бодол ядуу, лам, бурхан ном хэмээх гурван эрдэнэд үл итгэдэг бол сэтгэл нь өлсөж цангахаас гадна, хойт ертөнцөд шийтгэл хүлээж бирд буюу өлсгөлөн сүнс болж урт удаан хугацаанд дааж давшгүй тамын зовлон амсана".

"Энэ зандан модоор хийсэн дөрвөлжин хэлбэртэй самбар байна. Энэ самбарын аль хэсэг нь уг модныхоо үндсэнд ойр вэ?" "Энэ самбарыг усанд талбихад арай гүн живж буй тал нь үндсэндээ ойр нь юм".

"Хоорондоо яг адилхан хоёр хүлэг байна. Нэг нь эх, нөгөө нь унага юм. Яаж ялгах вэ?" "Хоёуланд нь өвс тавьж өг! Эх нь үрдээ өвсний сайныг өгдөг юм. Ингэж тэр хоёрыг амархан ялгаж болно".

Эдгээр асуултын хариуг сонссон бурхан магнай тэнийн баярлав. Хааны магнай мөн адил тэнийжээ. Хаан, сайдынх нь нүхэнд нуугдсан эцэг ийнхүү цэцэн мэргэн хариулсныг мэдээд зарлиг буулгаж, өвгөдөө тээршаан зайлуулахыг хориглож, харин хүндэлж дээдлэхийг тушаав.

2. Энэтхэгийн Видеха хэмээх улсад хатан хаан зүүдэндээ зургаан соёотой цагаан заан үзжээ. Тэрбээр хаанаас цагаан зааны зургаан соёог олж бэлэглэхийг гуйжээ. Хатандаа ухаангүй хайртай хаан, энэхүү хүсэлтийг зөвшөөрөхөөс өөр аргагүй болов.

Тэрбээр мөнөөх заан хаана нутагладгийг мэдэх хүнд үлэмж их шагнал, бэлэг сэлт өгөхийг амлаж, улс даяар зар түгээв.

Тэр цагаан заан алс хол, Хималайн уулсад амьдардаг байжээ. Тэрбээр Бурхан багшийн хутгийг олохоор бэлдэж байлаа. Нэг удаа тэрбээр анчин эрийн амийг аварчээ. Эх нутагтаа эргэж ирсэн мөнөөх анчин хааны зарлигийг сонсч зааны нутагладаг газрыг мэддэг хүнд ихээхэн шагнал хүртээхийг дуулаад өөрийнхөө амийг аварсан зааныг алж, соёог нь авахаар явжээ. Мөнөөх заан Бурхан багшийн хутгийг олох гэж бэлдэж байсныг нүгэлт гөрөөчин мэдэх тул зааныг хуурахаар орхимж нөмөрч ламын дүрээр очжээ. Тэгээд заан өчүүхэн бээр сэжиглэлгүй амарч байхад нь хортой сумаар харважээ.

Шархадсан заан үхэл нь ирснийг мэдэрчээ. Гэвч өөрөөс нь урваж тэрсэлсэн анчинд уурлаж унтууцсангүй. Харин хорвоогийн шунал тачаалын эрхэнд орсон түүнийг өрөвдөж, муу зальтай анчныг хэдэн хэсэг болгон урж тасдахыг завдан, уурлаж хилэгнэсэн нөхдөөс нь хамгаалж, өөрийнхөө доор оруулан нууж, хөлөөрөө хамгаалсан аж. Заан анчнаас юуны учир амийг нь хөнөөж буйг асууж, соёо нь хэрэг болсныг мэдмэгц соёогоо том модонд цохиж хугалаад анчинд өгчээ. "Ингээд миний зовлон зүдүүр

дуусав. Одоо би бээр Бурхан багшийн ертөнцөд мэндэлнэ. Би Бурхан багш болмогцоо юуны түрүүн чиний зүрхнээс шунал хүсэл, уур хилэн, харанхуй мунхаг хэмээх хорт гурван сумыг суга татан хаяна" хэмээн цагаан заан тангараг тавьжээ.

3. Хималайн уулын бэлд, хулсны ширэнгэнд бусад шувууд, амьтантай хамт нэгэн тоть амьдарч байжээ. Нэгэнтээ хүчтэй салхи босч хулс моддын гол хоорондоо хавиралдсанаас болж гал гарчээ. Салхи хүчтэй үлээж, ширэнгэ тэр аяараа галд автаж, түймэр дүрэлзэв. Их галд шахагдаж түрэгдсэн ан амьтан, жигүүртэн шувууд чарлах нь чарлаж, хашгирах нь хашгирна. Тоть шувуу урт удаан хугацааны турш өөрийг нь орогнуулсан хулсан ширэнгэнд баярлан талархсанаа илэрхийлж шувууд амьтдыг аврахын тулд холгүй бус цөөрөм рүү нисч усанд нь умбаж, жигүүрээ норгон, буцаад агаарт хөөрч түймэрт автсан ширэнгэний дээрээс далавчаа сэгсэрч ус цацав. Хулсан ширэнгэд баярлаж талархсан, мөн шувууд, амьтдыг өрөвдөн хайрласан тоть ядарч цуцахыг үл мэдэн нуур, ширэнгэ хоёрын хооронд ниссээр байлаа.

Тоть шувууны бусдын тусын тулд өөрийгөө умартах сэтгэлийн тэнхээ, нигүүлсэнгүй сэтгэл нь тэнгэрт буй Бурханы гайхал бишрэлийг төрүүлжээ. Тэрбээр тэнгэрээс залран ирж, тоть шувуунаас

асуусан нь: "Би чиний халуун сэтгэлийн хүсэл тэмүүллийг ойлгож байна Гэхдээ чи яаж хэдхэн дусал усаар түймэр унтраана гэж бодно вэ?" Тоть хариулсан нь:

"Би талархаж баярласан, нигүүлсэнгүй сэтгэлдээ хөтлөгдсөн юм. Тиймээс надад бүтэхгүй чадахгүй юм байхгүй. Би энэ түймрийг унтраах ёстой. Үхсэн ч хамаагүй энэ галыг л унтраана" гэв.

Ийм хариу сонссон Бурхан хайлж тоть шувуунд туслан хамтын хүчээр түймрийг даржээ.

4. Хималайн ууланд хоёр толгойтой шувуу амьдарч байжээ.

Нэг толгой нь нөгөө толгойгоо амтат жимс зооглож буйг үзээд атаархахдаа хортой жимс идэхээр шийдэв. Чингээд хортой жимсээ ч идэв, хоёулаа ч үхэв.

5. Нэг могойн сүүл нь толгойтойгоо маргалджээ.

"Толгой, чи дандаа түрүүлж явдаг. Ингэх нь шударга бус. Би ч гэсэн түрүүлж явж байя".

Толгой хариулсан нь: "Би үргэлж түрүүлж явдаг нь үнэн. Анхнаасаа ингээд бүтчихсэн болохоор яая

гэхэв дээ. Би чамайг урдаа оруулж чадахгүй".

Тэр хоёр удтал маргалдаж, хичнээн сөргөлдсөн ч толгой ямагт түрүүлэн явдаг байлаа. Чингээд уурласан сүүл нь толгойгоо явуулахгүйн тулд модны голыг ороожээ. Толгой гайхаш алдран зогсоход сүүл нь амжиж ороосон модноосоо салж урагшаа мөлхөөд удалгүй галтай нүх рүү унаж шатаж үхэв.

Юм бүхэн өөрийн гэсэн байртай, бас тусдаа үүрэгтэй билээ. Хэрэв байр сууриа голж, ногдсон үүргээсээ татгалзвал өөрийгөө ч, бусдыг ч хөнөөнө.

6. Дүрсхийдэг зантай нэгэн эр байжээ. Нэг удаа байшингийн нь дэргэд хоёр хүн ярилцаж байв.

"Уг нь энэ байшингийн эзэн сайн хүн байгаа юм. Ганц гэм нь дүрсхийдэг зантай" гэлцэв.

Үүнийг сонссон нөгөө эр дүрсхийн уурлаж, гэрээсээ харайн гарч ирээд ярилцаж байсан хоёрыг дайрч цус нөжийг нь гартал зоджээ.

Ухаантай хүний гэм бурууг хэлэхэд түүнийгээ засахыг эрмэлзэнэ. Тэнэг хүнд алдааг нь хэлбэл засаж залахын оронд улам том алдаа гаргадаг.

7. Нэг их баян, тэнэг хүн байжээ. Тэрбээр өндөр шовх, гоё оройтой гурван давхар байшинг харчихаад түүнтэй ижил байшин барихаар шийджээ.

Тэрбээр мужаан дуудаж, өндөр оройтой байшин барихыг тушаав. Захиасыг биелүүлж ажлаа эхэлсэн мужаан байшингийн суурь тавьж, дараа нь хоёрдугаар давхрыг барьж дуусаад, гуравдугаар давхраа эхэлжээ. Мужааны ажиллахыг харсан баян тэвчээр алдан:

"Надад байшингийн суурь, хоёрдугаар давхарын аль нь ч хэрэггүй. Гуравдугаар давхрын өндөр орой л хэрэгтэй. Түүнийг л шалавхан бариад өг" гэв.

Тэнэг хүн хөдөлмөр гэдгийг үл мэднэ, гагцхүү санаанд нь нийцэх бэлэн юм л шаардана. Гэтэл суурь тавилгүй гуравдугаар давхрыг барьж болохгүйтэй адил, сайн хөдөлмөрлөхгүй бол бэлэн юм хаанаас гарах вэ?

8. Нэг хүн зөгийн бал чанаж байхад найз нь иржээ. Тэрбээр анд нөхрөө амтат балаар дайлах гэж балаа гал дээрээсээ авалгүй дэвүүрээр сэвж хөргөж эхлэв. Үүнтэй адил ертөнцийн шунал тачаалын галыг унтраалгүйгээр сэрүүн тунгалаг гэгээрэлд хүрч үл болно.

9. Хоёр чөтгөр нэг хайрцаг, нэг таяг, хос шаахайг хувааж чадахгүй маргалдав. Тэд бүтэн өдрийн турш хэн нь юу авах тухай маргалдаад шийдэж чадсангүй.

Нэг хүн тэднийг харчихаад асуусан нь:

"Та нар юунд ингэж их маргалдана вэ? Энэ чинь ямар юм болоод та хоёр тэгтлээ маргалдаж хувааж чадахгүй байгаа юм бэ?" гэв.

Чөтгөрүүд хариулсан нь: "Энэ хайрцагаас хоол унд, үнэт эрдэнийн чулуу гээд юу хүссэнээ авч, энэ таягаар ямар ч дайсныг дарж, энэ гутлыг өмсвөл агаарт дүүлэн нисч болно" гэв.

Нөгөө хүн хэлсэн нь:

"Та хоёр маргалдах юм алга байна шүү дээ. Гэдрэгээ жаахан ухраад зогсч бай. Би та нарт тэнцүүхэн хуваагаад өгье" гэв.

Чөтгөрүүд өөрөөс нь холдмогц хайрцаг, таягийг авч, хоёр шаахайг нь хөлдөө угласан нөгөө хүн агаарт дүүлэн нисч бараа сураггүй болов.

Энэ домог үлгэрт чөтгөрүүд нь буруу шашинтан, хайрцаг бол өглөг гэсэн үг юм. Тэд өглөгөөс элдэв үнэт эрдэнэ бүй болдгийг үл мэднэ.

Таяг нь сэтгэлээ төвлөрүүлэхийг хэлж буй. Тэд сэтгэлээ төвлөрүүлж, ертөнцийн шунал тачаалын шулмыг дарж болохыг үл мэднэ.

Хос шаахай нь ариун ном сургаалыг хэлж буй юм. Энэхүү ариун номын ачаар аливаа маргааныг шийдэж болохыг тэд үл мэднэ. Иймээс хоорондоо маргалдаж, хайрцаг, таяг, хос шаахай гурвыг хувааж үл чаджээ.

10. Нэг үдэш аянчин эр эзгүй хоосон байшинд буудаллажээ. Гэнэт шөнө дунд чөтгөр хүрч ирэв. Тэрбээр үхсэн хүний хүүр авчраад шалан дээр чулуудджээ.

Удалгүй бас нэг чөтгөр ирж: "Энэ бол миний олсон хүүр" хэмээжээ. Хоёр чөтгөр хоорондоо маргалдаж эхлэв.

Тэгснээ эхний чөтгөр нөгөөдөө:

"Ингэвээс бидний хэн нь ч юм олж үл долооно. Ерөөсөө гэрч авчирч, хэний олсон хүүр болохыг хэлүүлье" гэв.

Нөгөө чөтгөр нь зөвшөөрчээ. Эхний чөтгөр нь энэ бүх хэрэг явдлыг харж, үнхэлцгээ хагартал айж байшингийн буланд шигдсэн нөгөө хүнийг гаргаж

ирээд "Хэн анх хүүр авчирсныг хэл" гэж тушаав.

Айж чичирсэн хүн өөрийгөө хаашаа ч гарах аргагүй болсныг ухаарчээ. Хэрэв тэрбээр хоёр чөтгөрийн нэгийг нь дэмжиж, нөгөөг нь гомдоовол зайлшгүй алуулна. Яасан ч үхлийн аюулаас мултрах аргагүйгээ ухаарч, зориг орсон эр санаа шулуудаж, яг харснаа хэлжээ.

Хоёр дахь чөтгөр яг л бодсоноор нь хилэгнэж, өрөөсөн гарыг нь тас татан хаяжээ. Эхний чөтгөр үхсэн хүний гарыг авч, тасарсан гарынх нь оронд тогтоов. Улам уурссан хоёр дахь чөтгөр нөгөө гар, хоёр хөлийг нь таслаж, түүгээр ч зогсохгүй бие, толгойг нь тасджээ. Эхний чөтгөр бүгдийг нь үхсэн хүний эрхтнээр сольж орлуулжээ.

Хоёр чөтгөр хоорондоо цуцаж ядартлаа маргаад тэр өрөөнд энд тэнд хэвтэж буй хүний гар, хөл, бусад эрхтнүүдийг идчихээд ам хамраа арчсаар арилаад өгчээ.

Аянчин ганцаархнаа хоосон байшинд үлдэв. Түүний хоёр гар, хөл, бие, толгой, ер нь эцэг эхээс заяасан бүх эрхтнийг хоёр чөтгөр идэж, оронд нь огт танихгүй хүний эрхтэнтэй болгожээ. Ингээд аянчин өөрийгөө би мөн үү, эсвэл би бус уу хэмээн ялгаж ухаарахаа больжээ. Үүрээр элий балай хүн лүгээ

адил аймшигт шөнийг өнгөрөөсөн байшингаасаа гарч явлаа. Замд нь сүм тааралдсанд баярлаж, тэнд ороод урьд шөнө өөртэй нь тохиолдсон явдлыг нэгд нэгэнгүй ярьж хэрхэхийг асуужээ. Хүмүүс аянчны ярьсныг сонсчихоод өөрийн "би" үл орших үнэнийг ухаарч баярлан баясчээ.

11. Гоё сайхан хувцастай, гоо үзэсгэлэнтэй хүүхэн нэг байшинд хүрэлцэн иржээ. Гайхаш алдсан эзэн асуусан нь: "Та хэн буй?" Хүүхэн хариулсан нь: "Би бээр хүмүүст зол жаргал авчирагч жаргалын бурхан". Эзэн баярлаж, зочныг гэртээ саатахыг урьж, хүндэтгэн дайлав.

Удалгүй өөр нэгэн эмэгтэй хүрч ирэв. Өмссөн хувцас нь ядуу зүдүү, өнгө зүс нь аймаар муухай аж. Хэн болохыг нь эзэн асуув. Цаадах нь, би бээр гачигдал зовлонгийн бурхан гэв. Мэл гайхсан эзэн түүнийг хөөн зайлуулах гэжээ. Гэтэл гачигдал зовлонгийн бурхан хэлсэн нь:

"Жаргалын бурхан бол миний эгч юм. Бид хоёр эвтэй найртай учраас үргэлж хамт амьдардаг. Хэрэв чи намайг хөөвөл, миний эгч ч гэсэн эндээс яваад өгнө шүү". Гачигдал зовлонгийн бурхан явсны дараа, аз жаргалын үзэсгэлэнт бурхан мөн адил явчив.

Амьдрал буй бол үхэл буй. Зол жаргал буй бол

гай зовлон буй. Сайн юм буй бол, муу юм бас буй. Хүмүүс үүнийг мэдэх ёстой. Мунхаг хүн гай зовлонгоос зугтаж, гагцхүү жаргалын хойноос хөөцөлдөнө. Гэгээрэх зам мөрийг дагаж буй хүн эдгээр ойлголтоос давж алинд нь ч гэсэн нэг их дасаж дадах хэрэггүй.

12. Эрт урьд цагт ядуухан зураач амьдарч байжээ. Тэрбээр эхнэрээ орхиж, хөрөнгө мөнгө хураахаар харийн орныг зорив. Гурван жилийн турш борви бохирохгүй хөдөлмөрлөж ихээхэн мөнгө хөрөнгө цуглуулав. Эх нутагтаа харьж явах замдаа бурханы шашны лам нарт өргөл барьц барьж буйтай таарсан зураач магнай тэнийн баярлажээ. "Би одоо болтол ганц ч удаа жаргалын үрийг суулгаж үзээгүй билээ. Харин одоо жаргалын үр суулгах талбайгаа оллоо. Ийм сайхан учралыг алдаж яаж болох вэ?" хэмээн дуу алдаж, хураасан хөрөнгө мөнгөө үл харамлан лам нарт өглөг барьц барихад зориулжээ. Тэрбээр гэртээ гар хоосон буцаж ирсэн аж.

Эр нөхөр нь гар хоосон эргэж ирсэнд эхнэр нь уурлаж, хураасан хөрөнгө мөнгөө хаашаа яаж үрснийг шалгаан байцаав. Нөхөр нь хураасан хөрөнгөө найдвартай агуулахад хадгалсан гэж хариулав. Юун агуулах вэ хэмээсэнд ариун шударга лам хувраг нар хэмээжээ.

Уурлаж уцаарласан эхнэр нь нөхрөө шүүхэд мэдүүлэн бариулж, нөхөр нь байцаагджээ. Тэрбээр хариулсан нь:

"Би борви бохисгүй хөдөлмөрлөөд олсон хөрөнгө мөнгөө дэмий юманд зарж үрээгүй. Би одоо болтол жаргалын үрийг суулгаагүй явсан. Харин түүнийг суулгах шимт хөрстэй талбай болсон буян үйлдэх ёслолтой таараад сүсэглэн итгэж, авч явсан хөрөнгө мөнгөө харамлаж нуулгүй өргөл болгосон бүлгээ. Би бээр жинхэнэ баялаг бол үнэтэй цэнэтэй зүйлс бус харин сэтгэл юм гэдгийг ухаарсан билээ" гэжээ.

Шүүгч зураачийн өчлийг сонсоод тэнд байсан хүмүүстэй нэгэн адил баярлан хөөрч, магтан сайшаажээ. түүнээс хойш зон олон түүнд нийтээрээ итгэдэг болж, тэрбээр баяжиж, эхнэртэйгээ цуг амар сайхандаа жаргажээ.

13. Эрт урьд цагт оршуулгын газраас холгүй нэг хүн амьдарч байлаа. Нэгэн шөнө түүнд өөрийг нь дуудах дуу хүүрийн нүхнээс дуулдахад үнхэлцгээ хагартал айж чичрэв. Үүр цайсан хойно, шөнө болсон явдлыг найз нөхөддөө хэлжээ. Нэг найз нь зоригтой эр байсан тул, дараачийн шөнө хүүрийн нүхнээс дуу гарвал юу байгааг очиж үзэхээр шийджээ.

Дараачийн шөнө түрүүчийнхтэй адил дуу гарч, мөнөөх оршуулгын газрын ойролцоо амьдардаг хүнийг дуудсан аж. Цаадах нь энэхүү дууг сонсч айн чичирчээ. Түүний зоригтой найз нь дуулдах дууг чиглэн оршуулгын газар очоод, чимээ гарах газрыг олж, хэн буйг асуужээ.

Газар дороос гарсан дуу хэлсэн нь:

"Би бол газар дор нуусан эрдэнэ юм. Би, нэрийг нь дуудсан тэр хүндээ очих гэсэн ч, тэрбээр айгаад ирээгүй юм. Чи зоригтой хүн тул миний буянд эн тэнцэнэ. Маргааш өглөө би долоон зарцаа дагуулаад танайд очно" гэв.

Зоригтой хүн хэлсэн нь: "За тэгээрэй, би чамайг хүлээж байя. Харин яаж угтвал зохих вэ?"

Нөгөө дуу хариулсан нь: "Танайд лам нарын дүрээр очно. Юуны түрүүн биеэ угааж ариутгаарай. Гэр орноо цэвэрлэж, ус бэлдчихсэн байгаарай. Тэгээд шингэвтэр будаатай найман аяга тавиад хүлээж бай.

Тэр хоолыг идэж дуусмагц биднийг нэг нэгээр нь тусгай өрөөнд оруулаарай. Бид алттай сав болон хувирна" гэв.

Маргааш өглөө нь хэлсэн ёсоор бүх юмыг засч бэлджээ. Зоригт эр угаал үйлдэж, гэр орноо янзалж, зочдоо ирэхийг хүлээжээ. Удалгүй бадар барьсан 8 лам залрав. Тэднийг гэртээ урьж, хоол ус өргөн барьж, дараа нь нэг нэгээр нь бэлдсэн өрөөндөө аваачив. Найман лам алтаар дүүрэн сав болон хувирчээ.

Атаа жөтөө ихтэй нэг хүн үүнийг дуулж мэдээд бас алттай болохыг хүсэв. Тэрбээр мөн адил гэр орноо цэвэрлэн янзалж, найман лам залж, хоол ундаар дайлж, дараа нь мухрынхаа нэг өрөөнд оруулаад түгжив. Гэвч найман лам нь алт болж хувирахыг хүссэнгүй, уурлан хашгиралдаж, атаа жөтөөтэй тэр эрийг шүүхэд мэдүүлэн баривчлуулжээ.

Оршуулгын газрын ойролцоо амьдардаг хулчгар эр бас үнэт эрдэнэс өөрийнх нь нэрийг дуудаж байсныг санав. Тэрбээр мөн адил шунаж, эрдэнэс өөрийнх нь мөн учраас нэрийг нь дуудсан хэмээн боджээ. Тэрбээр найзындаа очиж, алттай савыг авах гэтэл олон могой байжээ. Могой аймхай хүн рүү дайрсан аж.

Энэ явдлын тухай хаан мэджээ. Тэрбээр зоригт эрийг алтны эзэн мөн хэмээв. Ийнхүү зарлиг айлдахдаа хаан номлосон нь: "Ертөнцийн бүх юм

үүнтэй адил бүлгээ. Тэнэг хүн ямагт аз дайрахыг л хүлээнэ. Гэтэл аз ганцаараа тохионо гэж үгүй. Энэ нь ном сургаалыг ёс төдий дагадаг, сэтгэлдээ жинхэнэ сүсэг итгэлгүй хүнтэй ижил юм. Тийм хүн сэтгэлийн жинхэнэ амарлингуй байдлыг олохгүй".

II БӨЛӨГ

БОДЬ МӨРИЙН ЗЭРГИЙГ ОЛОХ АРГА ЗАМ

I

ҮНЭНИЙ ЭРЭЛ

1. Сансар огторгуй яаж бүтсэн, ямар бүтэцтэй вэ? Сансар огторгуй мөнх орших уу? Эсвэл хэзээ нэгэн цагт сөнөж мөхөх үү? Сансар огторгуй эцэс төгсгөлгүй юу? Эсвэл хаа нэгтээ зах хязгаар нь бий юу? Нийгэм яаж бүтсэн, ямар бүтэцтэй вэ? Нийгмийн төгс төгөлдөр ямар хэлбэр байдаг вэ? Эдгээр асуултад хариу авсныхаа дараа л гэгээрэх зам мөрийг дагана гэвэл бүгд түүнээсээ өмнө амьсгал хураана гэсэн үг.

Нэг хүн хорт суманд шархадсан гэж бодъё. Төрөл төрөгсөд, ойр дотны хүмүүс нь цугларч сумыг нь сугалж, шархадсан хүнд тус үзүүлэх хэрэгтэй хэмээн эмч дуудна.

Гэтэл шархадсан хүн ингэж хэлбэл юу болох вэ?

"Та нар азнаж бай, энэ сумыг битгий сугалж ав. Би над руу хэн харвасныг мэдмээр байна. Эрэгтэй хүн үү, эсвэл эмэгтэй хүн үү? Ер нь тэрбээр ямар хүн бэ? Ямар нумаар харвасан бэ? Том уу эсвэл жижигхэн нум уу? Модон уу эсвэл хулсан нум уу? Хөвчийг нь юугаар хийсэн бэ? Шөрмөсөөр үү, эсвэл

ороонго ургамлаар уу? Сумыг нь юугаар хийсэн бэ? Модоор уу, эсвэл хулсаар уу? Сумны өд нь ямар вэ? Энэ бүхнийг намайг мэдтэл хүлээж бай, сумыг битгий сугалаарай".

Тэрбээр энэ бүхнийг мэдэхээс өмнө хор бүх биеэр нь тарж, амьсгал хураах нь эргэлзээгүй. Иймд юуны түрүүн сумыг сугалан авч, хорыг биеэр нь тараахгүйн тулд боломцоотой бүхнийг хийх хэрэгтэй.

Сансар огторгуй ямар ч бүтэцтэй байсан, манай нийгмийн төгс төгөлдөр хэлбэр ямар ч байлаа гэсэн, юуны түрүүн бид нарт заналхийлж буй аюулыг зайлуулах хэрэгтэй.

Сансар огторгуй маань мөнх үү, удахгүй мөхөх үү гэдгээс үл шалтгаалан амьдрал, өвчин, үхэл, уй гашуу, уйтгар гуниг, зовлон зүдүүрийн галын аюул бидэнд ямагт заналхийлдэг. Энэ галд автахаас зайлсхийхийн тулд бид гэгээрэх зам мөрийг дагах хэрэгтэй юм.

Бурхан багш хэрэгтэй юмыг л зааж номлодог. Тэрбээр хэрэггүй юмыг зааж номлодоггүй. Тэрбээр хүмүүс мэдэх юмаа л мэдэх, татгалзах юмнаасаа татгалзах, сурах ёстойгоо сурах, гэгээрэх ёстойдоо л гэгээрэх хэрэгтэй хэмээн номлодог.

Тиймээс хүн сонголт хийх ёстой. Тэрбээр өөрт нь хамгийн чухал, хамгийн хэрэгтэй нь юу вэ? гэдгийг шийдэж, өөрийн хамгийн гол асуудлыг шийдвэрлэхэд сэтгэл юугаа бэлдэхээс эхлэх ёстой юм.

2. Модны гол олохоор ой руу явсан хүн навч, мөчир түүчихээд модны голтой боллоо гэж бодвол мунхаг хэрэг болно. Заримдаа модны голтой болохыг хүссэн мөртлөө холтос юм уу, эсвэл доторх хальс, нэг үеийг нь хуулчихаад модны голтой болсон гэж боддог.

Амьдрах, өтлөх, өвдөх, үхэхийн болон уй гашуу, уйтгар гуниг, зовлон зүдүүрийн айдсаас салахын тулд хүн гэгээрэх зам мөрийг хайдаг. Энэ нь тэрхүү модны гол юм. Гэвч зарим нь өчүүхэн нэр хүнд, алдар нэр олчихоод түүндээ сэтгэл ханаж ихэмсэг зан гаргаж, өөрийгөө өргөмжлөн магтаж, бусдыг доромжилж эхэлдэг. Ийм хүмүүс навч, мөчир цуглуулснаа модны голтой боллоо гэж эндүүрдэг.

Өчүүхэн хүч чадал зарцуулчихаад хүссэн бүхнээ биеллээ гэж боддог хүмүүс ч буй. Тэд энүүхэнд сэтгэл ханаж ихэмсэг зантай болж, өөрийгөө өргөмжлөн магтаж, бусдыг дайрч доромжилдог. Ийм хүмүүс гаднах хальсыг нь хуулж авчихаад модны голтой болсон гэж эндүүрдэг.

Аливаа үйл хэргийн үндэс язгуурыг дөнгөж хардаг болчихоод олсон амжилтандаа ханан ташуурч, ихэмсэглэн, өөрийгөө өргөмжлөн магтаж, бусдыг басан доромжилдог хүмүүс буй. Ийм хүмүүс гаднах нэг үеийг нь хуулж авчихаад модны голтой болсон гэж андуурдаг. Эдний аль аль нь хүч чадлаа дайчлахгүй, залхуу хойрго болдог. Тэд дахин дахин зовж зүдэрнэ.

Гэгээрэхийг зорьсон хэн нэгэнд нэр хүнд, алдар гавъяа, өргөл барьц аль нь ч зорилго болж чадахгүй. Өчүүхэн хичээл зүтгэл, санаа сэтгэлийн амгалан байдал, хэрэг явдлын уг үндсийг өнгөц хардаг болох нь зорилго бус юм.

Юуны түрүүн энэ ертөнцөд амьдрал, үхлийн үнэн мөн чанарыг тогтоох шаардлагатай юм.

3. Ертөнц энэ буйгаараа мөн чанаргүй билээ. Сэтгэлдээ элдэв санаархалыг арилгах замыг хайх хэрэгтэй. Төөрөгдөл гадаад нөхцөл байдалд бус харин сэтгэлд төрж буй болдог.

Сэтгэлийн хүсэл хүний зовж зүдэрдэг тэрхүү гай гамшгийн галыг асааж бадраана. Мунхагаас болж төөрөгдлийн харанхуй, сэтгэлийг хучиж хүн уй гашууд автаж, гуньж гутардаг. Чухамхүү энэ сэтгэл л төөрөгдлийн байшин савыг бүтээн буй болгодог.

Гэгээрэхийг хүсч буй хүн энэхүү сэтгэлтэй тэмцэх шаардлагатай.

4. "Сэтгэл минь, чи юунд дэмий юмны эрэлд ийш тийш үсчинэ вэ? Чи юунд түгшин бачимдаж, нэг ч хором амгалан тайван байж үл чадна вэ?

Чи юунд намайг төөрөгдүүлж, элдвийн эд юмс цуглуулахад хүргэнэ вэ?

Зээтүү газар хүрэхээс өмнө хугарвал, газар хагалж болохгүйтэй адил, хэдийгээр тоо томшгүй олон төрлийг дамжсан боловч би үргэлж төөрөгдлийн далайд хөвж явсан бөгөөд сэтгэлийнхээ атар газрыг хагалж чадаагүй юм.

Сэтгэл минь, чи надад хааны амьдралыг хүртэл заяаж, бас гуйлгачны амьдралыг ч үзүүлж, би гуйлга гуйж ч явлаа.

Чи надад бурхадын ертөнцөд элбэг дэлбэг амьдрах хувь тавилан заяаж, би тэнд цэнгэл жаргалд умбаж явлаа, тамд амьдрах тавилан оноож, би тэнд галд шатаж ч явлаа.

Тэнэг сэтгэл минь чи намайг янз бүрийн зам мөрд уруу татаж байлаа. Одоо болтол би бээр чамайг дуулгавартайяа дагаж, санаа бодлын чинь эсрэг

хэзээ ч зүтгэж байгаагүй билээ. Гэвч одоо би бурхан багшийн сургаалыг танин мэдлээ. Одоо чи намайг бүү түгшээж бачимдуул, надад бүү саад бол. Зовлон зүдүүрээс салах, түргэн гэгээрэх бололцоо олго.

Сэтгэл минь, хэрэв чи үнэнийг ухаарч, энэ ертөнцөд аливаа юм өөрийн мөн чанаргүй, бүх юм хувиран урсаж, өөрчлөгддөгийг ойлгож, дасаж дадсанаасаа ангижирч, эд юмсыг өөрийн хэмээн тооцохоо больж, шунал хүсэл, уур хилэн, тэнэг мунхгаасаа салвал амарлингуй байдлыг олно.

Хэрэв чи оюуны илдээр ховдог хомхой сэтгэлийн ургамлыг тас цавчвал, өөрийн хүсэл сонирхолд хөтлөгдөн ашиг хонжоо, нэр төр, алдар хүндийн хойноос хөөцөлдөхөө боливол амар амгаланг олно.

Сэтгэл минь, чи намайг гэгээрэх замд залж авчирсан хэрнээ, яагаад дахин түгшиж бачимдаж, хорвоогийн ашиг сонирхол, алдар нэрийг хөөцөлдөх болов?

Ямар ч барьцгүй, үргэлж яарч урагшаа тэмүүлж байдаг сэтгэл минь, гэтлэхэд бэрх төөрөгдлийн далайг гэтлэн давах бололцоо олгооч. Эдүгээ хүртэл би чамайг юм бүхэн дээр үг дуугүй дагасан бүлгээ.

Харин чи одоо надад захирагд. Бурхан багшийн сургаалыг хамт дагая.

Сэтгэл минь ээ, уул толгод, гол ус, далай тэнгис бүгдээрээ хувиран өөрчлөгдөж, юм бүхэн гай гамшгаар дүүрэн билээ. Энэ ертөнцийн хаана нь баясал цэнгэл олж болох вэ? Бурхан багшийн сургаалыг дагаж, гэгээрлийн эрэгт түргэн хүрье".

5. Хэрэв хүн гэгээрэхийг чин сэтгэлээсээ хүсэж, иймэрхүү аргаар сэтгэлтэйгээ тэмцвээс санаа шулуудан гуйвж дайвалгүй урагшилна. Хүмүүс түүнийг дооглон инээлдэж, зангидсан нударгаар зодож занчиж, чулуугаар шидэж, илд далайн халдсан ч огт үл хэрэгсэж, үл уурлан хилэгнэнэ.

Түүний толгойг хөрөөдсөн ч сэтгэл нь үл хямарч үймэрнэ. Хэрэв сэтгэл нь харанхуйлвал Бурхан багшийн сургаалд үнэнч бусаа харуулна.

Түүнийг дооглон хөхрөлдөж, доромжлон дээрэлхэж, зодож нүдэж, мод хийгээд илдээр занчсан ч эгдүүцэл зэвүүцэл үл төрнө. Харин ч энэ бүхнийг амссанаар Бурхан багшийн сургаалд улам баттай сүсэглэнэ.

Гэгээрэхийн тулд хүршгүйд хүрч, давшгүйг давж, юу байгаагаа бусдад өгөх хэрэгтэй.

Гэгээрэхийн тулд өдөрт ганцхан ширхэг будаагаар хооллож, асан дүрэлзэж буй гал руу явж ор гэсэн ч бэлэн байх хэрэгтэй.

Гэвч өгснөө өгсөн хэмээн бүү бод. Бардах буянаас, мартах буян нь илүү гэдгийг санаж, энэ нь ухаалаг, зөв зүйтэй үйл мөн хэмээн түүнийг дага. Энэ нь үрдээ сүүлчийн хувцсаа тайлж өгсөн ч өгчихлөө хэмээн үл бодох, өвчтэй хүүхдээ асарсан ч асарч байна гэж үл санах эх лүгээ адил юм.

6. Эрт урьд цагт хаан амьдарч байв. Тэрбээр ухаантай, нигүүлсэнгүй сэтгэлтэй ард түмэндээ хайртай хүн байжээ. Хаант улс нь баян, ард иргэд нь амар амгалан, эв найртай амьдарч байлаа. Бурхан багшийн сургаалыг эзэн хаан хүндэтгэх учир улс даяар зарлиг буулгаж, ариун буянт сургаалыг зааж өгсөн хүнд үнэт эрдэнэс бэлэглэнэ гэв.

Үнэнийг ухаарахыг эрмэлзсэн хааны энэ хүсэл нь бурхдын ертөнцийнхнийг хүртэл баясгаж байв. Нэг удаа бурхан энэхүү тэмүүлэл нь үнэн эсэхийг сорихоор шийдэж, чөтгөрийн дүрээр ирж, хааны ордны хаалгыг тогшив.

"Би ариун сургаалыг мэднэ. Эзэн хаандаа энэ тухай уламжилна уу" гэж харуулд нь хэлжээ.

Үүнийг сонсоод баярласан хаан ихээхэн хүндэтгэн ордондоо урьж оруулаад ариун сургаалаас номлохыг хүсчээ. Тэгтэл чөтгөр хурц илд лүгээ адил аймшигтай соёогоо ярзайлгаж: "Би маш их өлсөж байна Ходоод хоосон, ном зааж чадахгүй" гэв.

Хаан идээ будаа зооглохыг урьсанд: "Би амьд хүний цус ууж, мах иднэ" гэв. Хааны хүү, охин хоёр нь өлссөн чөтгөрт өөрийгөө хоол болгоё гэлцэв. Чөтгөр хоёуланг идээд цадсангүй, хааныг идэхийг хүсчээ.

Хаан намуухан хариулсан нь: "Миний амь бол юу ч биш ээ. Гэвч чи намайг идчихвэл би яаж сургаалыг чинь сонсох билээ?" гэв.

Чөтгөр номлож эхэлсэн нь: Ховдог хомхой сэтгэлээс түгшүүр бухимдал үүсдэг, ховдог хомхой сэтгэлээс айдас төрдөг. Ховдог хомхой сэтгэлээс салж ангижирсан хүн түгшүүр бухимдлыг үл мэднэ. Тийм хүн юунаас ч үл айна". Энэ бүхнийг айлдчихаад нөгөөх чөтгөр бурхан болон хувирмагц хааны хүү, охин хоёр нь амилав.

7. Эрт урьд цагт үнэнийг эрсэн, хатуу зоригт, даяан хийдэг даянч Хималайн ууланд сууж, төөрөгдлөөс ангижруулах сургаалыг эрж хайж байв. Түүнд өөр

юу ч хэрэггүй, энэ ертөнцийн эрдэнэсийг ч, бурхдын ертөнцөд мэндлэхийг ч үл хүсч байв.

Даянчийн энэхүү эрмэлзэл тэмүүлэлд бурхан уярч, түүнийг сорихоор шийдэж, чөтгөрийн дүрээр Himалайн ууланд заларчээ.

"Энэ ертөнцөд юм бүхэн өөрчлөгдөн хувирч, буй болж, алга болдог" хэмээн дуулав.

Даянч энэ дууг сонсож магнай нь тэнийв. Ангаж цангасан хүн горхины ус хоржигнон шоржигнохыг сонсох шиг, олзлогдсон хүн эрх чөлөөгөө олох шиг аятай таатай санагджээ.

"Энэ жинхэнэ үнэн, жинхэнэ сургаал мөн байна". Би үүнийг л эрж хайсан хэмээн бодож, дуулж буй хүнийг л олж харжээ. Тэрбээр гайхан тээнэгэлзэж, түүнд дөхөөд:

"Саяын дууг чи дуулсан уу? Хэрэв үнэхээр дуулсан бол цааш нь үргэлжлүүлнэ үү " гэв.

Чөтгөр: "Тийм ээ, би дуу дуулсан. Гэхдээ одоо өлсөж байгаа тул үргэлжлүүлж чадахгүй" гэв.

Даянч дахин: "Би чамаас гуйж байна, дуугаа үргэлжлүүлэн дуулж өгөөч. Миний хайж буй гэгээн

үнэн энэ дуунд оршиж байна. Дуу дуусаагүйг ч ойлгож байна. Чи гүйцэд дуулахгүй юу" гэв.

Чөтгөр үгүй хэмээн толгой сэгсэрч:

"Би турж үхлээ. Хэрэв амьд хүний мах идэж, цус уувал энэ дуугаа үргэлжлүүлнэ" гэв.

Даянч хэрэв дуугаа цааш нь үргэлжлүүлбэл сонссоныхоо эцэст өөрөө чөтгөрийн хоол болно хэмээн амлажээ.

Чөтгөр дуугаа дуустал нь дуулжээ. Дууг нь сийрүүлбэл:

"Хорвоо ертөнцөд бүх юм хувиран өөрчлөгдөж, буй болж, алга болдог. Төрж мэндлэх, үхэж үрэгдэхэд дадаж дассанаасаа салж чадвал мөнхийн амгаланг олж болно".

Даянч дууны үгийг мод, чулуун дээр сийлж, дараа нь модон дээр гарч чөтгөрийн сарвайсан гар руу хоол нь болохоор үсрэв. Яг энэ мөчид чөтгөр бурхан болон хувирч даянчийг газар унагалгүй барьж авав.

8. Эрт урьд цагт гэгээрэхийг хүссэн Садапрарудита хэмээх хүн амьдарч байжээ. Сэтгэл

юугаан гагцхүү гэгээрэхэд л зориулж алдар нэр, ашиг хонжоог үл эрнэ. Нэг удаа тэнгэрээс дуудаж хэлсэн нь:

"Садапрарудита, зүүн зүг рүү яв. Хаашаа ч эргэж хазайлгүй шулуун явна шүү. Халуун хүйтнийг мартаж, алдар чинь мандах, нэр чинь хугарахыг үл хэрэгсэж, буян нүглийн алиныг нь ч орхиж, зүүн зүг рүү яв. Тэгвэл чи жинхэнэ багшаа олж гэгээрнэ".

Садапрарудита баясан хөөрч тэнгэрээс айлдсан ёсоор гэгээрэхийг хүсч зүүн зүгт оджээ. Тэрбээр тэнгэрээр хөнжил, уул толгодоор дэр хийж явж байлаа. Харийн нутагт хавчин хяхах, дайран доромжлохыг ч түүхгүй байлаа. Заримдаа хоол хүнсээ залгуулахын тулд хөлсөөр ажиллаж, эцэж цуцахыг үл мэдэн зүтгэнэ. Эцэст нь тэрбээр жинхэнэ багшаа олж золгож, түүндээ шавь орохыг хүсчээ.

Хүн буян үйлдэхийг хүсвэл, элдвийн саад бэрхшээл тохиолдоно гэж ярьдаг. Гэгээрэхийг хүсч зорьсон Садапрарудитагийн замд бэрхшээл олон тохиолдсон билээ.

Тэрбээр багшдаа халуун ногоо, цэцэг бэлэглэхийн тулд хөлсөөр ажиллахаар шийдтэл хэн ч хүлээж авсангүй. Очсон газарт нь түүнийг шулмын зардас нар салахгүй дагаж байв. Гэгээрэх зам нь

үнэхээр хүнд хэцүү, саад бартаатай байлаа.

Түүнд багшийнхаа ариун сургаалыг тэмдэглэх үзэг, цаас үгүй байсан тул хутга авч гараа зүсээд, багшийнхаа зааж сургасныг цусаараа тэмдэглэн бичжээ. Ингэж тэрбээр ариун үнэнийг ухаарчээ.

9. Эрт урьд цагт Судхана нэртэй жаал хүү амьдарч байжээ. Тэрбээр мөн адил үнэнийг эрж, гэгээрэхийг ХҮСЧ байлаа. Тэрбээр загасчидтай уулзан учирч тэнгис далайн хуулийг мэджээ. Тэрбээр эмчтэй уулзан учирч хүмүүсийг өрөвдөн хайрлаж, нигүүлсэнгүй хандахын ухааныг сурч, баян хүнтэй учирч аливаа юм өөрийн үнэ цэнэтэй байдгийг ойлгожээ.

Бясалгал хийж буй ламтай учирч, амгалан тайван сэтгэл нь нүүр царайнд нь хүртэл ул мөрөө үлдээж, бусдын сэтгэлийг ариусгаж, хүмүүст гайхалтай сайхан нөлөөлдөгийг мэджээ. Уужим сэтгэлтэй эмэгтэйтэй учирч, бусдын тусын тулд цаг үргэлж бэлэн байдгийг нь гайхан бишрэв. Гэгээрэхийн төлөө өөрийгөө хайрлахыг мартан, зүйл бүрээр сорин зовоож буй даяанчтай учраад, номын ёсоор гэгээрэхийн тулд өндөр хурц ирмэгтэй хад асганд авирч, гал дундуур туулах хэрэгтэй юм гэдгийг ухаарав. Хэрэв хүсвэл нүдээр харж, чихээр сонсч буй бүхэн үнэн зөв сургаал болно гэдгийг жаал хүү

ойлгожээ.

Тэрбээр хүч чадал сул дорой эмэгтэй хүн хүртэл гэгээрч болох сэтгэлтэй, гудамжинд тоглож буй хүүхэд ч бүхэл бүтэн өөрсдийн ертөнцтэй гэдгийг ухаарчээ. Байгалийн хуулиудад дуулгавартайяа захирагддаг сэтгэл нь оюун ухаантай гэдгийг дуу шуу цөөнтэй, бодь сэтгэлтэй хүнээс олж мэджээ.

Хүж уугиулахад ч Бурхан багшийн сургаал оршино. Цэцгээр чимэх урлагт хүртэл гэгээрэх зам мөр оршино. Нэг удаа ойд амарч байхдаа өмхөрсөн модны голоос шинэхэн мод ургаж буйг хараад газар дээр оршихын мөнх бусын үнэнийг ухаарчээ.

Үнэнийг эрэн тэмүүлсэн Судхана хүүгийн сэтгэлийг өдөр мандах нарны гэрэл, шөнө анивчих оддын туяа ариусгаж байлаа.

Жаал хүү хаана ч гэсэн гэгээрэх замыг хайж, зөв зүйтэй ном заалгаж, үнэнийг таних олон арга хэлбэрийг олж мэджээ.

Үнэхээр гэгээрэхийн тулд сэтгэлийн цайзны бөх батыг хамгаалж, түүнийг чимж байх хэрэгтэй аж. Сэтгэлийнхээ цайзны үүд хаалгыг нээн дэлгэж, сүсэг бишрэлийг үзүүлэн, ариун шүтээнээ хэмээн Бурхан

багшаа тахиж, итгэл бишрэлийн цэцгийг дэлгэрүүлж, баяр баясгалангийн хүжийг уугиулан асаах хэрэгтэй.асаах хэрэгтэй.

II
ГЭГЭЭРЭХ ЯНЗ ЯНЗЫН ЗАМ МӨР

1. Гэгээрэхийг тэмүүлсэн хүн сургаал зарлиг, сэтгэл төвлөрүүлэх ёс, оюун ухаан хэмээсэн гурван эрдмийг өөрийн болгох хэрэгтэй.

Сургаал зарлиг гэж юу вэ? Гэгээрэхийн зам мөрийг хөөсөн хүн төдийгүй ер нь хэн бүхэн эдгээр сургаал зарлигийг нарийн чанд сахиж мөрдөн бие, сэтгэл юүгээн анхааралтайяа ажиглаж, таван мэдрэхүйн үүд хаалгыг сонор соргог хамгаалж, хамгийн бага нүглийг хүртэл тэвчиж, буяныг бүтээж сэтгэлээ төгс төгөлдөр болгох шаардлагатай.

Санаа сэтгэлээ төвлөрүүлэх гэж юуг хэлнэ вэ? Энэ нь шунал хүслээсээ салж, муу үйлээс холдож, аажим аажмаар сэтгэлийн амгалан тайван байдлыг олохыг хэлнэ.

Оюун ухаан гэж юуг хэлнэ вэ? Энэ нь дөрвөн үнэнийг мэднэ гэсэн үг буюу тэдгээрийг өгүүлбээс, зовлонгийн үнэн, зовлонгийн шалтгааны үнэн, зовлонгоос салж болохын үнэн, зовлонг таслан зогсоох зам мөрийн үнэн эдгээр болой.

Энэ гурван эрдмийг узэж судалдаг хүнийг Бурхан багшийн шавь гэдэг.

Дүр төрх, дуу хоолойгоороо огт төсгүй , эвэр ч үгүй илжиг нь үхрийн араас дагаж, би үхэр мөн хэмээн хичнээн ориловч түүнийг үхэр гэж хэн ч бодохгүй. Үүнтэй адил дээрх гурван эрдмийг үзэж судлаагүй мөртлөө өөрийгөө гэгээрэхийг хүсч тэмүүлэгч, Бурханы шавь хэмээн ярьж буй хүн үлэмж тэнэг билээ.

Тариачин, намар арвин ургац авахын тулд, юуны өмнө хавар цагаар газраа хагалж, үр цацаж, талбайгаа усалж, хортой ургамлыг түүж устгана. Үүнтэй адил гэгээрэхийг хүссэн хүн заавал гурван эрдмийг сурч судлах ёстой. Тариачин, өнөөдөр суулгасан үр нь өдөртөө соёолж, маргааш тариан түрүү найгаж, нөгөөдөр ургацаа хурааж авахсан гэж хичнээн хүсэвч, тийм ёсон үгүй. Үүнтэй адил гэгээрэхийг хүссэн хүн өнөөдөр хорвоогийн шунал тачаалаас салж, маргааш дадал заншлаасаа ангижирч, нөгөөдөр гэгээрч үл чадна.

Газарт унасан үр нь тариачны нөр их хөдөлмөрийн ачаар, жилийн нэг улирлыг нөгөө нь сольсны дараа соёолж, тариан түрүү найгана. Үүнтэй адил гэгээрэхийг хүссэн хүн, бурханы сургаал зарлиг болон санаа сэтгэлээ төвлөрүүлэх эрдэм, оюун ухаан

зэрэг гурван эрдмийг судлан, аажим аажмаар хорвоогийн шунал тачаал, дадал заншлаас ангижирч, эцэст нь гэгээрдэг.

2. Энэ ертөнцийн нэр алдар, эд баялгийг хүсэн мөрөөдөж, ховдог хомхой сэтгэлдээ автсан хүн гэгээрэх зам мөрийг олох нэн бэрх. Учир нь энэ ертөнцийн зугаа цэнгэл болон гэгээрэх зам мөрийн цэнгэлийг эрж хайх нь хоёр өөр зүйл юм.

Бидний зааснаар юм бүхний учир шалтгаан нь сэтгэл билээ. Хэрэв сэтгэл энэ ертөнцийн зугаа цэнгэлд автвал төөрөгдөл, зовлон зүдүүр л буй болно. Харин гэгээрэхийг хүсвэл гэгээрэл болон цэнгэл жаргал буй болно.

Тиймээс гэгээрэхийг хүсэгч нь сэтгэлээ ариусгаад Бурхан багшийн сургаалыг хазайлгүй дагаж, номлол бүхнийг мөрдөх учиртай. Хэрэв номлолыг мөрдвөл сэтгэлээ төвлөрүүлж чадна. Сэтгэлээ төвлөрүүлж чадвал, оюун ухаан нь саруул болно. Саруул оюун ухаан түүнийг гэгээрүүлнэ.

Чухамхүү эдгээр гурван эрдэм гэгээрэх зам мөр мөн билээ. Хүмүүс эдгээр гурван ухааныг эс судлах тул, урт хугацааны турш төөрч будилсан юм. Тэд гэгээрэх зам мөрийг олж, бусадтай хэрэлдэхийг цээрлэж, нам гүм бодол эрэгцүүлэлд автан, сэтгэлээ

ариусган түргэн гэгээрэхийг хичээх хэрэгтэй.

3. Хэрэв эл гурван эрдмийг дэлгэрэнгүй тайлбарлаваас энэ нь найман зам мөр, дөрвөн үзэл санаа, биеэ зөв авч явах дөрвөн хэм хэмжээ, таван хүч, зургаан заншил эдгээр болно.

Найман зөв зам мөр нь зөв үзэл, зөв сэтгэхүй, зөв үгс, зөв үйлс, зөв амьдрах арга, зөв тэмүүлэл, зөв дурсан санахуй, зөв бясалгал эдгээр юм.

Зөв үзэл нь дөрвөн үнэнийг танин мэдэж, учир шалтгааны үнэнд итгэж, эд юмсыг зөв үзэхийг хэлнэ.

Зөв сэтгэхүй нь хүслийн эрхэнд үл автах, шуналын эрхэнд үл орох, үл уурлах, бусдад хор үл хүргэх зэрэг юм.

Зөв үгс нь худал үл хэлэх, үл чалчих, үл хараах, хоёр нүүр үл гаргах юм.

Зөв үйл нь амьтны аминд үл халдах, хулгай үл хийх, буруу үл хурьцах юм.

Зөв амьдрах арга нь хүн ичмээр арчаагүй амьдрах аргаас зайлсхийхийг хэлнэ.

Зөв тэмүүлэл нь хэзээ ч үл залхуурах, зөв зорилгод

хүрэхийн тулд хүч чармайлт гаргахыг хэлнэ.

Зөв дурсах нь аливаа үйлийг бодолтойгоор үйлдэхийн нэр юм.

Зөв бясалгал нь өмнөө зөв зүйтэй зорилго тавих болон оюун ухаанаа гэгээрүүлэхийн тулд дотроо бясалгал үйлдэхийг хэлнэ.

4. Дөрвөн үзэл бодлыг тодруулбал:
Хүний бие бузартсан тул, түүнд дасахыг цээрлэ.

Аливаа мэдрэхүй зовлонг буй болгоно.

Хүний сэтгэл цаг үргэлж хөдөлгөөнд оршиж, байнга өөрчлөгдөн хувирч буй.

Энэ ертөнцөд бүх юм учир шалтгаан, нөхцөл байдлаас үүдэх тул мөнхийн чанартай юм нэгээхэн бээр ч үгүй бүлгээ.

5. Биеэ зөв авч явах дөрвөн хэм хэмжээг сийрүүлбэл:

Одоохондоо үүсээгүй нүглийг сэрэмжлэн зайлуулах.

Нэгэнт үүсч буй болсон нүглийг таслан зогсоох.

Буян буй болоход тус нэмэр үзүүлэх.

Буян улам арвижуулах эдгээр болой.

Хүн бүр биеэ зөв зүйтэй авч явахын дөрвөн хэм хэмжээг дагаж мөрдөх ёстой.

6. Таван хүчийг тодруулбал:
Сүсэглэн итгэх.

Хичээн зүтгэх.

Үйл хэргээ бодож эргэцүүлэх.

Бясалгах.

Оюун ухаанаа гэгээрүүлэх эдгээр болно.

Эдгээр таван хүч хүнийг гэгээрүүлнэ.

7. Зургаан дадал заншил бол өглөгч зан, сургаал зарлигийг мөрдөн сахих, тэвчээр хатуужил үзүүлэх, уйгагүй зүтгэх чадвар, бясалгал, оюун ухаан эдгээр юм. Хэрэв эл зургаан дадал заншлыг эзэмшиж чадвал төөрөгдлийн энэ эргээс гэгээрлийн цаад эрэгт хүрч

болно.

Өглөгч зан нь хомхой сэтгэлээ номхотгох, сургаалыг дагаж мөрдөх нь зөв зүйтэй үйл бүтээх, тэвчээр хатуужил нь үл уцаарлах, уйгагүй зүтгэх нь залхуу хойрго занг устгах, бясалгал нь сэтгэлээ амар тайван болгох, оюун ухаан нь ухаангүй мунхаг сэтгэлийг гэгээрүүлэхийг хэлнэ.

Цайзны суурь лугаа үлгэрлэж болох өглөгч зан, сургаал зарлигийг дагаж баримтлах нь Бурхан багшийг дагах нэгэн ёсны үндэс суурь болно. Тэвчээр, уйгагүй зүтгэл хоёр нь цайзны хана лугаа адил гадаад гай гамшгаас хамгаална. Бясалгал болоод оюун ухаан нь амьдрал, үхэлд хэт дасахаас зайлсхийж, өөрийгөө хамгаалах зэвсэг юм. Тэд тулалдаанд орж буй цэрэг эрийг хамгаалах дуулга юм.

Гуйсанд өгөх нь өглөг боловч, жинхэнэ өглөг биш ээ. Үнэн өглөг нь хэн ч, юу ч гуйхгүй байхад нигүүлсэнгүй сэтгэлийг үзүүлэн өгөхийг хэлнэ. Хааяа өгөх нь жинхэнэ өглөг биш ээ. Жинхэнэ өглөг нь үргэлж өгөхийг хэлнэ.

Хэрэв өглөгийнхөө дараа харамсах юм уу, өгсөндөө бардаж биеэ тоох зан гаргавал энэ нь жинхэнэ өглөг биш ээ. Сайн үйл бүтээсэндээ баярлан

хөөрч, өглөгийн эзэн өөрийгөө, юу өгснөө, хэнд өгснөө мартаж чадвал сая жинхэнэ өглөг.

Зөв өргөл барьцыг хожим нь шан харамж горьдож эс өргөнө. Тэр нь нигүүлсэнгүй ариун сэтгэлээс үүдсэн, өөрт болон өрөөлд гэгээрэхийн ерөөл билээ.

Энэхүү ертөнцөд ямар ч хөрөнгөгүй ядуу хүн хүртэл өргөж чадах долоон янзын өргөл барьц буй. Нэгдүгээрт, бие юугаан өргөл болгох. Энэ нь хүч хөдөлмөрөө зориулан зүтгэхийн нэр, түүний дээд хэлбэр нь өөрийн амь биеийг үл хайрлан зүтгэх явдал болой. Үүний тухай дараачийн хэсэгт өгүүлнэ. Хоёрдугаарт, сэтгэл юүгээн өргөл болгох. Энэ нь эргэн тойрон буй хүмүүс, эд юмст анхаарал халамжтай хандахыг хэлнэ. Гуравдугаарт, мэлмий юугаан өргөх. Энэ нь дэргэдэх хүмүүсээ амирлангуй болгох төлөв даруу, намуухан харц юм. Дөрөвдүгээрт, булбарай зөөлөн нүүр царайгаа өргөл болгох. Энэ нь үргэлж халуун дотно мишээхийн нэр билээ. Тавдугаарт, үг яриагаа өргөл болгох. Энэ бол анхаарал халамж, хайр ивээлийн үгс юм. Зургадугаарт, байр суудлаа өргөл болгох. Энэ бол байр сууриа бусдад тавьж өгөхийн нэр бүлгээ. Долдугаарт, орон байраа өргөл барьц болгох. Энэ нь гэр орондоо бусдыг хонуулахын нэр билээ. Эдгээрийг аливаа хүн өдөр тутмын амьдралдаа үйлдэж чадна.

8. Эрт урьд цагт Саттва хэмээх хунтайж байжээ. Нэгэнтээ хоёр ахтайгаа цуг ойд тоглож наадахаар очтол, долоон зулзага төрүүлсэн эм бартай таарчээ. Бар өлсгөлөн байсан учраас зулзагуудаа идэхийг завдаж байв.

Хоёр ах нь айн сандарч, зайлан зугтав. Гагцхүү Саттва хунтайж биеэ өргөл болгож, өлсгөлөн барыг хооллохоор шийджээ. Тэрбээр өндөр, эгц хад асга оөд мацан авирч, өөрийн биеэр эм барыг хооллов. Бар цадаж, зулзагаа оролдсонгүй.

Саттва хунтайжийн сэтгэл гагцхүү гэгээрэхийг л хүсчээ.

"Миний бие хэврэг, хувирамтгай. Одоо болтол би бээр хэнд ч өглөг өгсөнгүй, гагцхүү өөрийн биеийг бодож, тордож байжээ. Эдүгээ эм бард биеэрээ өргөл барьж гэгээрэе". Хунтайж ингэж шийдээд ёсоор болгож эм бард биеэрээ өргөл барьжээ.

9. Бурхан багшийн үнэнч шавь бол энэрэнгүй, нигүүлсэнгүй, баясгалантай, амарлингуй сэтгэлийн дөрвөн байдлыг ухааран мэдвээс зохилтой.

Энэрэхийг ухаарвал, хүсэл шуналаасаа сална. Нигүүлсэнгүйг ойлговол уур хилэнгээсээ ангижирна. Баяр баясгаланг танин мэдвэл зовлонг таслан

зогсооно. Амарлингуйг ухаарвал өөрт чинь туслах хийгээд гомдоохын алинд ч амгалан тайван хандана.

Хүмүүст жаргал цэнгэл эдлүүлэх нь их энэрэнгүй сэтгэл, тэднийг шаналал зовлонгоос ангижруулах нь их нигүүлсэнгүй сэтгэл юм. Хүмүүст баяр баясгалантай.

хандах нь их баяр жаргал юм. Бүх юманд, бүгдэд тэгш хандаж дээр доор хэмээн үл ялгах нь их амарлингуй сэтгэл юм.

Иймээс сэтгэлээ төгс засаж, шунал хүсэл, уур хилэн, зовлон зүдүүр, хайрлах, үзэн ядахаас салгах их энэрэнгүй, их нигүүлсэнгүй, их баясгалантай, их амарлингуй сэтгэлийг ухаарах хэрэгтэй бүлгээ. Гэхдээ дассан нохойгоо хөөж туухад хэцүү байдагтай адил муу санаа бодлыг хөөн туухад бэрх билээ. Айсан согоо хэдхэн дэгдээд алга болдогтой адил сайхан санаа амархан арилна. Тэгээд ч муу санаа бодлоосоо салах нь чулуун дээр сийлсэн үгийг арилгахаас хэцүү бүлгээ. Харин сайн санаа бол усан дээр бичсэн лүгээ адил агшнаа замхарна. Тиймээс гэгээрэхэд бэрх юм.

10. Ялж төгс нөгчсөн багшийн шавь Срона нь баян тансаг айлд төржээ. Тэрбээр төрөлхийн сул дорой, өвчин эмгэгтэй хүү байжээ. Амарлингуй оршигч багштай учирсан тэрбээр Түүнд шавь орж, номыг дагаж, өөрийгөө зүйл бүрээр сорьж, хөлөө цус гартал

шархтуулж байсан болович нэг л гэгээрэхгүй байлаа.

Бүхнийг айлдагч багш Сронаг өрөвдөж хэлсэн нь:

"Срона, чи гэртээ байхдаа босоо ятга тоглож сурсан биздээ. Чавхдасыг хэтэрхий хүчтэй, эсвэл хэтэрхий сул татвал уянгалаг сайхан дуу гарахгүй гэдгийг чи мэднэ. Чавхдасыг хэтэрхий чанга бус, хэтэрхий сул бус, яг тааруулан татвал уянгалаг дуу гарна.

Гэгээрэх зам мөр үүнтэй адил билээ. Хэрэв залхуурвал үл гэгээрнэ, мөн хэтэрхий хичээж, хэтрүүлж хийвэл үл гэгээрнэ, хэмжээгээ мэдэж, тааруулах хэрэгтэй".

Срона энэхүү зөвлөгөөг сонсоод удалгүй гэгээрэв.

11. Эрт урьд цагт таван янзын зэвсэг гарамгай эзэмшсэн хунтайж байжээ. Тэрбээр сургууль номоо өндөрлөөд гэрийн зүг эргэв. Замдаа хээр талд үс ноос нь тэр аяараа өөх тос болсон аймшигт амьтантай таарчээ.

Тэр амьтан хунтайж руу дайрав. Хунтайж нум сумаар харватал сум нь аймшигт амьтны өөх тостой үсэнд наалдаж ямар ч гэм хор учруулсангүй. Илд, ойл, мод, жадны аль нь ч өөх тостой үс ноосонд нь наалдсан аж. Ямар ч зэвсэггүй үлдсэн хунтайж зангидсан нударгаараа цохиж, хөлөөрөө өшиглөтөл, гар хөл нь бас наалдаж, хунтайж өөрөө агаарт дүүжлэгджээ. Тэрбээр толгойгоороо мөнөөхөн гайхлын цээж рүү цохитол толгой нь бас наалдчихав.

Аймшигт амьтан хэлсэн нь: "Одоо чи миний гарт орлоо. Би чамайг иднэ" гэв.

Хунтайж инээд алдан: "Чи намайг ямар ч зэвсэггүй болсон гэж бодов уу? Үгүй шүү, би алтан зэвсэгтэйгээ үлдсэн. Хэрэв чи намайг залгивал миний зэвсэг чамайг дотроос чинь хүү татна" гэв.

Айж сандарсан гайхал амьтан "Яаж тэр вэ?" гэж асуухад, "Яахав, үнэний хүчээр" гэж хунтайж өгүүлжээ.

Чингээд аймшигт амьтан хунтайжийг чөлөөлж, түүгээр сургаал номлол заалган хойшид мууг үйлдэхээ больсон ажээ.

12. Үйлдсэн үйлээсээ болон бусдаас ичих зовохыг мэдэхээ боливол нийгмийн хэв журам зөрчигдөнө.

Хэрэв өөрөөсөө болон бусдаас ичиж зовбол хэв журам сахихад тустай. Чухамхүү ичиж зовох сэтгэлийн ачаар хүмүүс эцэг эх, багш нар, ахмадуудаа дээдлэн хүндэлж, ах, эгч, дүү нарын харьцаанд ёс журам сахина. Өөрийн үйлийг эргэн тунгааж, өөрөөсөө ичиж, бусдын үйлийг харж ичиж зовох нь чухал юм.

Хэрэв хүн наманчилж чадвал, нүгэл нь нүгэл бус болж арилна. Эс чадвал мөнхийн нүгэл болж, сэтгэл зүрхийг нь зовоож шаналгана.

Зөв сургаал сонсоод байн байн эргэцүүлэн бодож, сурч судалж, дагаж мөрдвөл түүнийг ухаарна. Бодож эргэцүүлэхгүй, дагаж мөрдөхгүй бол сонссон ч эс ухаарна.

Итгэл бишрэл, ичих нүүр, төлөв даруу зан, хичээл зүтгэл болон оюун ухаан нь энэ ертөнцийн агуу их хүч юм. Эдгээрээс хамгийн чухал нь оюун ухааны хүч бөгөөд бусад дөрөв нь түүний хүчийг нөхөн гүйцээдэг юм.

Гэгээрэхийг зорихдоо аар саар юм хөөцөлдөж, дэмий чалчин цаг алдаж, их унтаж болохгүй. Энэ бүхэн зөв зам мөрөөс хазайлгадаг.

13. Хүмүүс гэгээрэхийн төлөө адилхан зүтгэвч нэг

хэсэг нь эрт, нөгөө нь нэлээд хожуу гэгээрдэг. Тиймээс бусад хүмүүс түрүүлж гэгээрснийг хараад гуньж гутрах хэрэггүй.

Нум сум харваж сурч эхлэхэд сум нь байгаа онох нь ховор. Гэвч суралцахаа эс зогсвол сум байндаа тусах нь олширно. Гол мөрөн ямагт мушгиран урсах боловч эцсийн эцэст далайд цутгадаг. Гэгээрэх нь үүнтэй адил юм. Хэрэв тасралтгүй эрж хайвал зайлшгүй гэгээрнэ.

Бидний нэг бус удаа тэмдэглэснээр нүдэнд харагдах юм бүхэнд сургаал нуугдаж буй. Үүнтэй адил аливаа юманд гэгээрэх учир шалтгаан буй.

Хүж уугиулаад анхилуун сайхан нь агаарт түгэн тархаж буйг ажигладаг хүн байжээ. Тансаг анхилуун утаа нь байна, мөн байхгүй, энэ анхилуун нь явдаг ч үгүй, ирдэг ч үгүй гэж хэлж болно. Үүнийг таньж мэдмэгцээ тэр хүн гэгээрчээ.

Нэг хүн замаар явж байгаад хөлөндөө өргөс оруулжээ. Өргөс нь хатгаж өвтгөхөд байнгын нэгэн сэтгэл үгүй, зүйл бүрийн хүчний нөлөөн дор сэтгэл өөрчлөгдөн хувирдгийг ухаарчээ. Үлгэрлэвэл, түгшиж бачимдсан сэтгэл нь шунал тачаал болон хувирч, амарлингуй тайван сэтгэл нь гоо сайхан болжээ. Үүнийг ухаармагцаа хүн гэгээрчээ.

Нэгэн харамч хүн байжээ. Тэрбээр ховдог хомхой сэтгэлийн тухай эргэцүүлэн бодоод ийм сэтгэлийн түлээ түлш нь эцсийн эцэст оюун ухааны гал түймэр болж дүрэлзэж болох юм хэмээн дүгнэжээ. Үүнийг ухаармагцаа тэрбээр гэгээрчээ.

"Сэтгэлээ тэгшил. Хэрэв сэтгэл тэгширвэл энэ ертөнцийн газар шороо мөн адил тэгширнэ". Энэхүү сургаалыг сонссон нэг хүн ертөнцийн бүх ялгаа нь тэдгээрийг сэтгэл хэрхэн үздэгээс шалтгаална гэсэн дүгнэлтэд хүрчээ. Үүнийг ухаармагцаа тэрбээр гэгээрчээ. Иймэрхүү маягаар гэгээрэх учир шалтгаан эцэс төгсгөлгүй бүлгээ.

III
СҮСЭГ БИШРЭЛИЙН ЗАМ

1. Бурхан багш, түүний ном болон лам хувраг хэмээх гурван эрдэнэд шүтсэн хүнийг Бурхан багшийн шавь гэж нэрлэнэ. Харин Бурхан багшийн шавь нь сахил хийгээд бишрэл, өгөөмөр сэтгэл, оюун ухааныг эрхэмлэн дагана.

Шавь нь амьтны амь үл таслах, үл хулгайлах, буруу үл хурьцах, худал үл хэлэх, дарс үл уух ээрэг таван сахилыг мөрдлөг болгоно.

Бурхан багшийн оюун ухаанд сүсэглэн итгэх нь

шавийн итгэл бишрэл юм. Ховдог хомхой, харамч сэтгэлээсээ салж, өргөл барьц өргөх нь шавийн өглөгч сэтгэл билээ. Учир шалтгааны шүтэн барилдах үнэнийг ухаараад хорвоо дээр бүх юм урсаж, хувиран өөрчлөгдөж буйг ухаарах нь шавийн оюун ухаан бүлгээ.

Зүүн зүг рүү налж ургасан мод унахдаа зайлшгүй зүүн зүгтээ унадагтай адил Бурхан багшид гүнээ итгэж сургаалыг нь дагасан хүн Бурхан багшийн ертөнцөд заавал мэндэлнэ.

2. Бурхан багшийн шавь бол Бурхан багш, Түүний сургаал болон лам хуврагт итгэн биширдэг хүн юм.

Бурхан багш бол өөрөө гэгээрч, хүмүүсийг аварч буй хүн юм. Бурхан багшийн заасныг Сургаал хэмээн нэрлэнэ. Лам хуврагууд нь сургаалыг дагаж, зөв замаар явж буй хүмүүсийн ах дүүгийн холбоо бүхий нийгэмлэг болно.

Хэдийгээр Бурхан багш, сургаал, лам хувраг гурав тус тусдаа оршдог боловч нэгэн нэгдмэл цул чанарыг бүрдүүлдэг. Бурхан багш сургаалдаа биелж, сургаал нь лам хуврагуудад биеллээ олдог тул энэ гурав нэгдмэл болой.

Сургаал болон лам хуврагт итгэж сүсэглэх нь

Бурхан багшид итгэж сүсэглэнэ гэсэн үг. Бурхан багшид итгэх нь сургаал болон лам хуврагт итгэнэ гэсэн хэрэг.

Тиймээс хүмүүс ганц Бурхан багшид итгэж сүсэглэснээр аврагдаж болно. Бурхан багш хүн бүрийг Өөрийн хүүхэд лүгээ адил хайрлах тул хүүхдүүд ээждээ итгэхтэй адил Бурхан багшид хүмүүс итгэж чадвал Бурхан багшийг ямар ч гэсэн амилуулан үзэж, цугаараа аврагдана.

Бурхан багшид итгэдэг хүн ямагт Түүний гэгээн гэрлээр гийж, Түүний анхилуун үнэрт ариусна.

3. Энэ ертөнцөд Бурхан багшид итгэхээс илүү ариун сайхан юм байхгүй. Хэрэв хүн амьдралдаа ганц удаа ч болов Бурхан багшийн нэр алдрыг сонсч, Түүнд итгэж баясвал хамгийн их зол жаргалтай учирсан гэж хэлэх хэрэгтэй.

Тиймээс Бурхан багшид итгэсний баяр баясгаланг амсахын тулд энэ ертөнцийг бүхлээр нь залгисан галд ч орох хэрэгтэй юм.

Үнэнийг хэлэхэд Бурхан багштай учрах нэн бэрх, сургаалыг нь түгээн сурталчилж байгаа хүнийг олох бэрх, энэ сургаалд итгэх нь бүр бэрх билээ.

Та одоо уулзахад амаргүй номлогчтой учирч, тэр болгон аз тохиож сонсоход бэрх сургаал сонслоо. Амьдралын ийм ховорхон тохиолдлыг алдалгүй Бурхан багшид итгэж сүсэглэх хэрэгтэй.

4. Итгэл бишрэл бол хүний хамгийн сайн хань, энэ ертөнцийн аян замынх нь хүнс, хамгийн үнэтэй эрдэнэ нь юм.

Итгэл бишрэл бол Бурханы шашныг, мөн буян бүхнийг хүлээн авч буй цагаан мутар юм. Итгэл бишрэл бол бузрыг шатаагч, хүний сэтгэлийг ариусгагч, зөв зам мөрт залагч, Бурхан багшийн зам мөрийг дагах хүслийг бадраагч гал бүлгээ.

Итгэл бишрэл сэтгэлийг баян болгож, ховдог шунахай болон бардам занг үндсээр нь устгаж, төлөв даруу байхыг хүнд зааж сургана. Түүний ачаар хүний оюун ухаан гялалзаж, үйлс нь гэгээн болмуй. Итгэл бишрэл нь саад бэрхшээлээс үл шантарч, гадаад нөхцөл байдлын боол үл болох, элдвийн юманд уруу эс татагдах хүч өгдөг юм.

Итгэл бишрэл нь урт удаан, уйтгартай замд хүний сэтгэлийг засч, гэгээрэхэд хөтлөдөг.

Итгэл бишрэлийн ачаар хүн өөрийгөө үргэлж Бурхан багшийн дэргэд Бурхан багшийн ивээлд буй

хэмээн санадаг. Итгэл бишрэл хүний бүдүүн хадуун, амиа хичээсэн сэтгэлийг зөөлрүүлж, хүнийг найрсаг, нүдэнд дулаахан болгодог.

5. Сэтгэлдээ сүсэг итгэлийг агуулсан хүн сонорт нь хүрсэн аливаа дуу хоолойноос Бурхан багшийн сургаалыг ялгаж, түүнд баярлан баясах оюун ухаантай болно. Цаг нь болж, нөхцөл бүрэлдэхэд бүх юм үүсч буй болохыг ойлгож, үүнийг ингэх л ёстой хэмээн хүлээн авах чадвартай оюун ухааныг түүнд хайрладаг.

Тэрбээр энэ ертөнцийн хувирч буй бүх зүйлд нэгэн өөрчлөгдөшгүй үнэн буйг ойлгож, амьдрал өөдлөж доройтоход үл гайхаж, үл харамсах чадвар бүхий оюун ухаантай болмуй.

Итгэл бишрэл нь нүглээ наманчлах, уяран хайлах, мөргөж залбирах гурван хэлбэрээр илэрдэг.

Сэтгэлдээ итгэл бишрэлтэй хүн бол үйл ажлаа гүн гүнзгий задлан шинжилж, нүгэл, бузар булайг үйлдсэндээ харамсан гуньдаг. Өөр хүн сайныг бүтээхийг хараад өөрөө үйлдсэнтэй адил баярлаж, түүнд сайн сайхан бүхнийг хүсч ерөөдөг. Тэрбээр үргэлж Бурхан багштай хамт байж, Бурхан багштай хамт үйлс бүтээж, Бурхан багштай хамт амьдрахыг хүсдэг.

Сүсэгтэй сэтгэл нь бурхан багш түүнийг Өөрийн ертөнцөд залан аваачиж буйд баярлан баяссан чин сэтгэл, гүн гүнзгий сэтгэл юм.

Хаа сайгүй Бурхан багшийг өргөмжлөн дээдлэх магтаалд итгэн сүсэглэж, баясагч хүнд Бурхан багш зүрх сэтгэлийнхээ хүчийг хайрлан, Өөрийн ертөнцөд аваачиж, дахин төөрөлдөхөөс хамгаална.

6. Бурхан багшид итгэн сүсэглэх нь хүн бүрийн сэтгэлийн гүнд буй Бурхан багшийн мөн чанарын илрэл юм. Учир нь Бурхан багшийг танин мэдсэн хүн бол өөрөө Бурхан багш юм. Бурхан багшид итгэсэн хүн бол өөрөө Бурхан багш бүлгээ.

Хэдийгээр Бурхан багшийн мөн чанар хүн бүрт буй боловч, тэр нь хорвоогийн шунал тачаалын хир буртагт гүн гүнзгий нуугдмал учраас бүрэн илэрч хөгждөггүй. Ховдог хомхой сэтгэл, уур уцаарын эргүүлэгт Бурхан багш руу тэмүүлсэн цэвэр ариун сэтгэл буй болно гэж үү?

Хорт мод ургадаг төгөлд анхилуун сайхан үнэрт мод ургадаггүй. Хэрэв хорт модны дунд анхилуун үнэрт мод ургавал гайхамшигт явдал болно. Түүнчлэн хүмүүсийн сэтгэлд Бурхан руу тэмүүлсэн, Бурханд итгэж сүсэглэсэн сэтгэл сэрвэл энэ нь гайхамшиг мөн билээ.

Тиймээс Бурхан багшид итгэж сүсэглэсэн хүмүүсийн сэтгэлийг үндэсгүй итгэл хэмээнэ. Ингэхийн учир гэвэл итгэлийн үндэс нь хүмүүсийн сэтгэлд бус, Бурхан багшийн нигүүлсэнгүй, энэрэнгүй сэтгэлд оршдогт билээ.

7. Эл учир итгэл бишрэл нь ариун чанартай юм. Тэр нь зөв зам руу залан чиглүүлж, буянт үйлийн эх булаг болмуй. Гэвч энэхүү итгэл бишрэл нь зөв замыг эрж хайж буй хүмүүсийн сэтгэлд ч тийм амархан буй болохгүй. Учир юун гэвэл таван эргэлзэл саад болмой.

Нэгдүгээрт, Бурхан багшийн оюун ухаанд эргэлзэх.

Хоёрдугаарт, сургаал үнэн гэдэгт эргэлзэх.

Гуравдугаарт, Бурхан багшийн сургаалыг номлогч хүнд эргэлзэх.

Дөрөвдүгээрт, зөв зам мөрийг эрж хайхдаа төөрч будилах.

Тавдугаарт, биеэ дэндүү тоож, Бурхан багшийн сургаалд итгэж сүсэглэн дагасан хүмүүст үл итгэсэннээс тэвчээр алдах эдгээр болно.

Эргэлзэхээс илүү аймшигтай юм хорвоо дээр үгүй. Эргэлзэл хүмүүсийг бие биенээс нь хөндийрүүлж, найз нөхрийн холбоог тасалдаг хор билээ. Энэ бол хамтран зүтгэгчдийн амь насанд аюултай чинжаал хутга, найз нөхдийн сэтгэл рүү шигдэн орох өргөс билээ.

Тиймээс итгэл бишрэлийг олсон хүмүүс аль дивангарт энэрэнгүй сэтгэлт Бурхан багш, итгэлийг сэтгэлд нь суулгасныг мэдэх ёстой.

Бурхан багшийн мутар хүний сэтгэлд итгэлийн гэрлийг асааж, эргэлзлийн харанхуйг арилгасан бүлгээ.

Аль дивангарт хүмүүсийн сэтгэлд итгэл бишрэлийг суулгасан Бурхан багшид баярлаж, Бурхан багшийн хэмжээлшгүй энэрэнгүй сэтгэлд баясан хөөрч, итгэл сүсгийг олсон хүн энэ хорвоод амьдарч байхдаа ч Бурхан багшийн ертөнцөд мэндэлж чадмой.

Энэхүү ертөнцөд хүн болж төрөх үнэхээр хэцүү. Бурхан багшийн сургаалыг олж сонсох ч хэцүү. ИТГЭЛ бишрэлийг олох бүр хэцүү. Тиймээс хэн хүн энэхүү сургаалыг олж сонсохын төлөө бололцоотой бүхнийг хийх хэрэгтэй.

IV

АРИУН ШУДАРГА ҮГ

1. Өөрийг нь хараалаа, доромжиллоо, зодож занчлаа хэмээн бодож буй хүний гомдол тайлагддаггүй.

Гомдсон тухайгаа цаг үргэлж бодвол гомдол үл тайлагдана. Гомдлоо мартсанаар тайлж болно.

Муу дээвэрлэсэн байшинд дусаал гоождогтой адил өөрийгөө үл хянах хүний сэтгэлд хүсэл шунал дүүрнэ.

Залхуу хойрго зан бол үхэлд хүргэх хамгийн дөт зам, хөдөлмөрч зан бол амьдралын зам мөн билээ. Мунхаг хүн залхуурч, ухаантай хүн хөдөлмөрлөнө.

Нум сум хийж буй уран хүн сумаа харуулдан засч, тэгш болгохтой адил ухаант хүн сэтгэлээ засч тэгш шулуун болгоно.

Хөдөлж хөөрөх нь амархан, тайвширч номхрох нь амаргүй, сэтгэлээ барих хэцүү. Түүнийг тайвшруулснаар хүн амарлингуй болно.

Хүнд өс хонзонт этгээд, эсвэл дайснаас нь илүү хор хөнөөлийг сэтгэл нь хүргэдэг.

Хүсэл, шунал, уур хилэн, муу юмнаас сэтгэлээ хол байлгаж чадсан хүн л жинхэнэ амарлингуйг хүртэнэ.

2. Ажил үйлсээрээ батлахгүй сайхан үг урсгах нь үнэр танаргүй гоё цэцэг лүгээ адил бүлгээ.

Цэцэгсийн үнэр салхины эсрэг үл анхилна. Сайн хүний тухай цуу салхины эсрэг ч даян дэлхийгээр тарж түгнэ.

Нойр үл хүрэх хүнд шөнө урт, ядарч цуцсан аянчинд зам урт, зөв сургаал үл мэдэх хүнд төөрөгдөл удаан санагдана.

Аян замд гарахдаа өөртэйгээ эн тэнцүү, эсвэл илүү хүнтэй цуг яваарай. Мунхаг хүн дагуулснаас ганцаар явах нь дээр.

Зэрлэг араатнаас бүү ай, муу нөхрөөс ай. Зэрлэг араатан зөвхөн биеийг гэмтээнэ, муу нөхөр сэтгэлийг гэмтээж шархлуулна.

Үр хүүхэд, эд баялгийнхаа төлөө сэтгэл зовсоор хүн шаналж гүйцдэг. Хүн өөрөө өөртөө ч үл харьяалагдах атлаа, үр хүүхэд, эд баялгаа яагаад өөрийн хэмээн тооцно вэ?

Тэнэгээ мэддэг тэнэг хүн өөрийгөө ухаантай гэж бодох тэнэгээс дээр бүлгээ.

Хоолны амтыг халбага мэддэггүйтэй адил, тэнэг хүн ухаантай хүнтэй ярилцаж суухдаа сургаалыг нь ойлгодоггүй.

Шинэ сүү үл гашлахтай адил муу үйлийн хариу тэр дороо үл ирнэ. Гэвч тэр нь үндсэн доор унтралгүй уугих гал адил эцэстээ дүрэлзэн асч түймэр гарна.

Ухаан муутай хүн нэр алдар, ашиг хонжооны хойноос хөөцөлдөж цаг үргэлж зовж зүдэрнэ. Тэрбээр үргэлж албан тушаал ахих, илүү эрх дархтай болох, илүү ашиг хонжоо олохыг хүсэх тул байнга зовж шаналдаг.

Алдааг хэлж, нүглийг зааж, дутагдлыг илчилсэн хүнийг нуучихсан эрдэнийг олж өгсөн хүнтэй адил үзэж, хүндэтгэх хэрэгтэй.

3. Бурхан багшийн сургаалд баярлагч хүн цэвэр ариун сэтгэлтэй, тэр нь сургаалаар ариусч байдаг тул шөнө нойр бөхтэй байдаг.

Мужаан мод харуулдах, гарын дүйтэй хүн сумаа тэгшлэх, газар малтагч суваг ухаж ус урсгахтай адил ухаант хүн сэтгэлээ засч янзалж байдаг.

Салхи үлээхэд хад асга үл доргих лугаа адил, ухаант хүнийг яаж ч загнаж зандачсан, яаж ч магтаж өргөмжилсөн сэтгэл нь үл донсолж, амгалан байдлаа үл алдана.

Өөрийгөө ялах нь дайны талбарт тоо томшгүй олон цэргийг дарж ялалт байгуулснаас илүү юм.

Зөв сургаалыг мэдэлгүй зуун жил амьдарснаас, мэдээд ганцхан хоног амьдарсан нь дээр.

Аливаа хүн үнэхээр өөртөө хайртай юм бол өөрийгөө нүглээс ангид байлгах ёстой. Залуу зандан нас, эр бие гүйцэх цаг, өтөлж хөгшрөх үеийнхээ аль нэгэнд хүн, амьдралдаа нэг удаа ч болов сэрж сэхээрэх ёстой.

Энэ ертөнц мөнхийн гал дунд орших бүлгээ. Энэ ертөнцөд хүсэл шунал, уур хилэн, мунхагийн гал дүрэлзэн амой. Эл шатаж буй байшингаас шалавхан зайлах хэрэгтэй.

Энэхүү ертөнц, үнэхээр хөөс, аалзны шүлс, хир буртаг дүүрэн сав лугаа адил бүлгээ. Тиймээс хүн бүр ариун сэтгэлээ ариг гамтай хадгалах хэрэгтэй.

4. Бурхан багшийн сургаал.нүгэл үл үйлдэж, сайн үйлс бүтээн сэтгэлээ ариусгахыг заадаг юм.

Хатуужил тэвчээртэй байхыг сурах хэцүү ч, эцсийн эцэст алдрын титмийг тэвчээртэй хүн л хүртдэг.

Хүн цэвэр ариун амьдрах ёстой. Гомдооход гомдох хэрэггүй. Уйтгар гунигийн цаг ирэхэд уйдаж гуних хэрэггүй. Ховдог хомхой сэтгэлтний дунд байхдаа ховдог хомхой сэтгэлтэй бүү бол. Аливаа юмны тухай бол миний юм гэж бүү бод.

Эрүүл мэнд бол хамгийн сайн давуу тал. Сэтгэл хангалуун байх нь хамгийн их баялаг, итгэл найдвар бол хамгийн ойр дотнын байдал, гэгээрэх нь хамгийн аятай таатай байдал юм.

Нүглээс холдсондоо баярлаж, анир чимээгүйд баясч, Бурхан багшийн сургаалд хөөрч буй хүн юунаас ч үл айна.

Сайн, мууг ялгахдаа сайнд нь дасаж дадаж үл болно. Сайн, мууг хооронд нь ялгаснаар уйтгар гуниг, айх эмээх сэтгэл буй болж, бачимдах давчдах эхэлнэ.

5. Зэв төмрөөс үүсэж эргээд төмрөө иддэгтэй адил, нүгэл нь хүнээс буй болж, эргээд хүнээ иддэг.

Уншлага залбирал байсаар байтал тэдгээрийг

уншихгүй нь уншлага залбиралын бузар юм. Байшин барилга буй атал, түүнийгээ засч янзлахгүй нь байшингийн бузар юм. Бие махбод байсаар байтал түүнийгээ хэрэгсэхгүй нь биеийн бузар болой.

Буян эс үйлдэх нь хүний бузар мөн. Мөнгө харамлах нь өглөгийн бузар.Нүгэл бол энэ хийгээд хойт ертөнцийн бузар юм.

Гэвч хамгийн адгийнх нь мунхагийн бузар бүлгээ. Үүнийг эс арилгаваас хүн ариусч үл чадна.

Өөрийнхөө шившгээс ичдэггүй хүн болох амархан, хэрээ лүгээ адил эрээ цээргүй болох ч амархан, цэвдэг сэтгэлтэй, бусдыг гомдоодог, түүнийгээ анзаарахгүй байх амархан.

Төлөв даруу зантай, бусдыг хүндэтгэх, дасаж дадсанаасаа салж ангижрах сэтгэлтэй хийгээд буян үйлдэж, ухаантай болох хэцүү.

Бусдын алдаа мадаг нүдэнд шууд тусдаг, харин өөрийнхийг олж харах хэцүү. Бусдын нүглийн тухай цууг дэвэн дэлхийгээр дорхноо тараачихдаг мөртлөө, бид өөрсдийнхөө нүглийг гартаа буй даалууг нуух мэт хав дардаг.

Тэнгэрт шувууд, утаа манан, салхи шуурганы

мөр үгүйтэй адил, буруу номонд гэгээрэх нь ер үгүй. Юунд ч байнгын тогтсон чанар үгүй бүлгээ. Харин гэгээрсэн хүнд хямрах бачимдах сэтгэл үгүй.

6. Цайзыг дотроос нь ч, гаднаас нь ч найдвартай хамгаалах адил биеийг тэгэж хамгаалах хэрэгтэй. Үүний тулд сонор сэрэмжээ нэг ч хором алдаж болохгүй.

Хүн болгон өөртөө эзэн болж, өөртөө найдна. Тиймээс юуны түрүүн өөрийгөө хянан удирдах хэрэгтэй.

Өөрийгөө удирдаж, хоосон чалчихыг цээрлэж, гүн гүнзгий бодож бясалгавал энэ нь аливаа бачимдлаас ангижрахын эхлэл болно.

Нар өдөр мандаж, сар шөнө гийдэг. Цэрэг эр хувцас дуулгаараа гялалзаж байдаг бол зөв замыг хөөж буй хүн бясалгалаар гялалзаж байдаг.

Нүд, чих, хамар, хэл, бие зэрэг таван мэдрэхүйнхээ үүд хаалгыг хамгаалж үл чадах, гадаад ертөнцийн өнгөнд уруу татагдах хүн бол зөв замаар явж буй бусаа. Таван мэдрэхүйнхээ үүд хаалгыг баттай хамгаалж чаддаг, амгалан тайван хүн бол зөв замаар явж буй юм.

7. Ямар нэг юманд дасаж дадсан бол, тэдгээрийн нөлөөн дор хүн эд юмсыг үнэн мөнөөр нь харж чадахгүй. Хэрэв хүн дадаж дассаныхаа хүлээснээс ангижирч чадвал, эд юмсын мөн чанарыг зөв харж чадна. Тиймээс эл хүлээснээс чөлөөтэй болсон сэтгэлд эд юмс шинэ утга чанартай болмой.

Уйтгар гуниг байвал, баяр баясгалан байна. Баяр баясгалан буй цагт уйтгар гуниг ч буй. Тэдгээрээс болон нүгэл, буяны дээр нь байвал дадаж дасахын хүлээс алдарна.

Ирээдүйг мөрөөдөж цаг нь болоогүй юмны төлөө зовж шаналвал, эсвэл зөвхөн өнгөрсний хойноос харамсвaaс хүн тайрсан хулс лугаа адил хатна.

Хэрэв улирч өнгөрсний хойноос харамсаж гашуудалгүй, ирээдүйн тухай мөрөөдөлгүй, хараахан болж өнгөрөөгүй юмны төлөө санаа зоволгүй, одоо буйг үнэлж сурвал хүний бие, сэтгэлиин аль аль нь эрүүл саруул байна.

Өнгөрснийг харамсан гашуудах, ирээдүйг тэсгэлгүй хүлээх хэрэггүй, харин одоогийн хормыг үнэлээн амьдрах хэрэгтэй.

Өнөөдөр хийх юмыг маргааш болъё хэмээн

хойшлуулах хэрэггүй. Өнөөдөр бүтээж болохыгоо найдвартай сайн хийснээр тэр өдрийг үр ашигтай өнгөрүүлнэ.

Итгэл бишрэл нь хүний эрхэм нөхөр, оюун ухаан нь хамгийн сайн газарч бүлгээ. Гэгээрэхийн гэрлийг эрж хайхдаа зовлонгийн харанхуйг тойрч явах хэрэгтэй.

Итгэл бишрэл бол дээд баялаг, чин сэтгэл бол хамгийн сайн мэдрэхүй бүлгээ. Буян үйлдэх нь энэ ертөнцийн хамгийн ариун ажил юм. Бурхан багшийн сургаалын дагуу бие сэтгэлээ засан залж, амар амгаланг олох хэрэгтэй.

Итгэл бишрэл бол энэ хорвоогийн аян замын хоол хтнс юм. Буян бол хүний ариун сайхан орон гэр юм. Оюун ухаан бол энэ ертөнцийн гэрэл гэгээ юм. Зөв санаа бодол нь шөнийн харуул хамгаалалт гэсэн үг. Цэвэр ариун хүн мөнх амьдарна. Хүн ховдог шунахай сэтгэлээ дарснаар эрх чөлөөтэй болно.

Гэр орныхоо төлөө бие юугаан, хот тосгоныхоо төлөө гэр орноо, эх орныхоо төлөө хот тосгоноо мартаарай. Гэгээрэхийн төлөө бол бүгдийг мартаарай.

Бүх юмс хувиран өөрчлөгдөж, буй болж, алга

болдог. Хүн төрөх, үхэхийн тухай санаа зовж, шаналахаа болимогц нам гүм, энх амгалан байдлыг олдог.

АХАН ДҮҮСИЙН ХОЛБОО

I БӨЛӨГ

АХАН ДҮҮСИЙН ХОЛБООНЫ ҮҮРЭГ

I

ХУВРАГИЙН АМЬДРАЛ

1. Миний шавь болохыг хүсэж буй хүн орон гэр, нийгэм, эд хөрөнгөө орхих хэрэгтэй. Миний сургаалын төлөө энэ бүхнийг орхисон хүн бол Миний өв залгамжлагч юм. Ийм хүнийг л лам хувраг гэдэг.

Хүн хэдийгээр Миний хувцаснаас зуурч, Миний мөрийг дагалаа ч гэсэн сэтгэл нь шуналд автсан байвал Надаас асар хол байна гэсэн үг. Хэдийгээр лам хувцас өмссөн ч Миний сургаалыг олж харахгүй байна гэсэн үг. Миний сургаалыг эс харсан хүн, Намайг олж үзэхгүй.

Надаас зуу зуун мянган бээр хол байсан ч, сэтгэл нь зөв болоод амгалан тайван, ховдоглож шунахыг үл мэдэх хүн, Миний дэргэд байгаатай адил. Учир нь тэрбээр Миний сургаалыг харж буй юм. Сургаалыг минь олж харсан бол Намайг олж үзэх нь тэр ээ.

2. Миний шавь хуврагууд дараах дөрвөн болзлыг үргэлж дагаж мөрдөх ёстой.

Нэгдүгээрт, хувцас хунараа хуучин даавуугаар

оёх, хоёрдугаарт, бусдын өглөгөөр амьдрах, гуравдугаарт, модон доор, эсвэл хад чулуун дээр амьдрах, дөрөвдүгээрт хувраг хүн гагцхүү бусад лам нарын шингэнээр бэлдсэн эм тан уух ёстой.

Бадар барьж айл айлын үүд тогшиж өглөг гуйх нь гуйланчлал мөн бөгөөд аюул заналхийллээс болоогүй, нэг ёсны хуурамч гуйланчлал юм. Энэ бол ертөнцийн бүх зовлон зүдүүрээс хэрхэн салж, төөрөгдлөөс ангижрах замыг хэрхэн олохыг өөрт нь зааж өгнө хэмээн итгэж найдсан хүний гуйланчлал юм.

Хэрэв хүн сахил хүртчихээд ховдог шунахай сэтгэлээсээ салж чадахгүй, уур хилэнгээсээ болж амар амгалан байж чадахгүй, таван мэдрэхүйнхээ үүд хаалгыг хамгаалж чадахгүй бол сахил хүртэх эрх гавьяагүй бүлгээ.

3. Өөрийгөө лам гэдэгт итгэдэг, бусдын асуухад лам мөн хэмээн хариулдаг хүн өөрийхөө тухай дараахийг итгэлтэй хэлж лав чадна.

"Би хувраг хүний сахиж мөрдөх ёстой болгоныг чанд сахидаг. Хувраг хүний чин сэтгэлээр би бээр надад өглөг өгч буй бүгдэд аз жаргалыг хүсэн ерөөж, сахил хүртсэн зорилгодоо хүрэх ерөөлийг дэвшүүлж байна"

Ер нь хувраг хүн яах ёстой вэ? Тэрбээр өөрийн алдаа мадаг, шившигт явдлаас ичин зовж, бие, хэл, сэтгэлийн үйл хийгээд амьдралаа ариусгаж, таван мэдрэхүйнхээ үүд хаалгыг найдвартай сахин хамгаалж, зугаа цэнгэлд үл автах ёстой. Тэрбээр өөрийгөө магтаж, бусдыг муулах, залхуурах, их унтахыг цээрлэх ёстой.

Үдэш тэрбээр бясалгал хийж, чимээ аниргүй сууж, унтахынхаа өмнө салхинд түр гарах хэрэгтэй. Шөнө болоход хоёр хөлөө давхарлан баруун талаараа хэвтэж, маргаашийг бодсоор аажимхан нойрсож, үүрээр чимээ шуугиан гаргалгүй дахин бясалгал хийж, эрүүл агаарт түр гарвал зохино.

Өдөр тутмын амьдрал дунд хувраг хүний сэтгэл ямагт ариун байх ёстой. Чимээ аниргүй газрыг сонгоод бие сэтгэлээ цэх шулуун болгон сууж, шунахай сэтгэл, уур хилэн, мунхаг ухаан, нойр, сэтгэлийн тээнэгэлзэл, харамсал, эргэлзлээс салан ангижирч, сэтгэлээ ариусгах ёстой. Ийнхүү сэтгэлээ төвлөрүүлснээр оюун ухаанаа нэмж, хорвоогийн шунал тачаалаас салж, гэгээрэхийн төлөө эрмэлзэн тэмүүлэх хэрэгтэй

4. Хэрэв хүн сахил хүртсэн мөртлөө ховдог шунахай сэтгэл, уур хилэнгээс салж чадахгүй, гомдож атаархах, биеэ тоох, хуурч мэхлэх зэрэг

дутагдлаа нууж далдалвал энэ нь хоёр талдаа иртэй илдийг хувцсан дотроо нуусантай адил бүлгээ.

Ийм хүн хэдийгээр орхимж нөмөрсөн ч лам биш, хэдийгээр бадар барьсан ч лам биш, хэдийгээр маань мэгзэм уншивч лам биш. Тэрбээр гагцхүү хуврагийн гадаад дүрийг үзүүлэгч мөн.

Хуврагийн дүрийг үзүүлснээр хорвоогийн шунал тачаалаас салж үл болмой. Нялх хүүхдийг орхимжонд ороосон ч түүнийг лам гэж хэлэхгүй бүлгээ.

Сэтгэлээ зөв төвлөрүүлж, оюун ухаанаараа гэгээрч, хорвоогийн бүх шуналаас ангижирч, үнэний замаар урагшилсан хүнийг л жинхэнэ лам хэмээнэ.

Хэрэв хүн цус нь хатаж, яс нь үйрсэн ч шаардагдах бүхнийг хийхээр шулуудвал, үүнийхээ тулд өөрийгөө үл хайрлавал, сахил хүртсэн зорилгодоо заавал хүрч, ариун үйлс бүтээнэ.

5. Хувраг хүн нь Бурхан багшийн сургаалыг түгээн дэлгэрүүлэх үүрэгтэй. Тэрбээр хүмүүст зааж сургаж, нойрсож буйг нь сэрээж, хүмүүсийн буруутсан сэтгэлийг засч, өөрийгөө үл хайрлан сургаалыг өргөн дэлгэр сурталчлах ёстой.

Гэвч номлож сургах нь амаргүй бөгөөд номлохыг хүсэгч хэн бүхэн Бурхан багшийн хувцсыг өмсөж, Түүний суудал дээр заларч, Түүний өрөө тасалгаанд орох ёстой.

Бурхан багшийн хувцсыг өмсөх нь намуун зөөлөн, хатуужил тэвчээртэй болно гэсэн үг. Бурхан багшийн суудал дээр заларна гэдэг нь бүх юмс мөн чанаргүй гэдгийг ойлгох, аливаад үл дасахын нэр юм. Бурхан багшийн өрөө тасалгаанд орох нь бүх хүнд үлэмж нигүүлсэнгүй, энэрэнгүй сэтгэлээр хандахын нэр юм.

6. Энэхүү сургаалыг номлохыг хүссэн бүхэн дараах дөрвөн зүйлд онцгой анхаарах ёстой. Үүнд: өөрийн бие, өөрийн үгс, өөрийн хүсэл, их нигүүлсэнгүй сэтгэл энэ дөрөв орно.

Нэгдүгээрт, номлож буй хүн ер бусын хатуужил тэвчээрийн орчлонд амьдарч, ширүүн бүдүүлэг зан авиргүй, зөөлөн намуун байх ёстой. Тэрбээр юунд ч мөн чанар үгүй хэмээн ойлгож, муу, сайны алиныг ч бүтээхийг үл санаархаж, юунд ч үл дасаж занших ёстой. Эдгээрийг бодож тэрбээр өөрийнх нь бие, махбодын бүх үйл хэрэг хатуу бус зөөлөн байхын төлөө хичээвээс зохино.

Хоёрдугаарт, тэрбээр өөр рүү нь дөхөн ойртож

буй хүн үхэнд анхаарал халамжтай хандаж, эрхтэн дархтан хийгээд муу аргаар амьдарч буй хүмүүсийн алинтай нь ч дотносохоос болгоомжлох ёстой. Мөн хүйс өөр хүмүүсээс холхон явбал зохино. Анир чимээгүй газар сэтгэлээ төгс төгөлдөр болгож, энэ ертөнцөд бүх юм учир шалтгааны хуулийн дагуу болж, тохиолдож буйг ойлгож, бусдыг дооглон шоглох, үл тоомсорлохыг цээрлэж, тэдний алдаа дутагдлыг ярихгүй байвал зохино.

Гуравдугаарт, тэрбээр сэтгэлийнхээ амгалан тайвныг хадгалахдаа Бурхан багшид, хайртай аавдаа хандаж буй шигээ хандаж, зөв замаар явж буй хүмүүст багшийн ёсоор туслах хэрэгтэй. Тэрбээр бүх хүнд асар нигүүлсэнгүй хандаж, бүгдэд ном сургаалыг ижил тэгш номлох хэрэгтэй.

Дөрөвдүгээрт, Бурхан багш лугаа адил тэрбээр энэрэнгүй, нигүүлсэнгүйг үргэлж үзүүлж, Бурхан багшийн сургаалыг үл мэдэх хүмүүс номлохыг нь заавал сонсоосой хэмээн хүсэж, энэхүү хүсэл нь сэтгэлчлэн бүтэхийн тулд бүхнийг хийх ёстой.

II
СҮСЭГТНИЙ ЗАМ МӨР

1. Дээр хэлсэнчлэн, бурханы шашинд итгэж

биширдэг хүн, Бурхан багш, Түүний сургаал, Бурсан хувраг хэмээх гурван эрдэнэд итгэж биширдэг билээ.

Тиймээс Бурханы шашинд итгэж буй хүн Бурхан багш, Түүний сургаал, Бурсан хуврагт баттайяа итгэн сүсэглэж, номлолын дагуу сүсэгтний дагах ёс дэгийг чанд баримтлах ёстой.

Энгийн сүсэгтэн хүний баримтлах дэг ёсыг тодруулбал: амьтны амийг үл таслах, хулгай үл хийх, буруу үл хурьцах, үл хуурч мэхлэх, дарс үл уух эдгээр болой.

Гурван эрдэнэд баттайяа сүсэглэж, дээрх сахилыг чанд мөрдсөнөөр энгийн сүсэгтэн хүн бусад хүмүүсийг ухуулан ятгаж, тэдгээрийг гурван эрдэнэд мөн адил итгэн сүсэглэдэг, ёс горимыг дагаж мөрддөг болгох хэрэгтэй юм. Тэрбээр сүсэг бишрэл нэгтэй хүмүүсийн тоог төрөл төрөгсөд, анд найз нар, танил хүмүүсийнхээ дундаас олшруулахыг хичээвээс Бурхан багшийн энэрэнгүй нигүүлсэнгүй сэтгэл тэдэнд бас хүрнэ.

Энгийн сүсэгтэн хүн гэгээрэхийн тулд гурван эрдэнэд бишрэн итгэж, дэг ёсыг нь сахин мөрдөж буйгаа үргэлж санаж байх ёстой. Тиймээс энгийн хүн хүсэл шуналын ертөнцөд амьдарч байхдаа хүсэл шуналаас салахыг хичээх хэрэгтэй.

Эрт орой хэзээ нэгэн цагт хүн эцэг эхээсээ сална. Гэр бүлээсээ ч салж хагацна. Энэ ертөнцийг ч орхих цаг ирнэ. Тэртээ тэргүй салж хагацах ёстой хүмүүст, тэртээ тэргүй орхиж явах юмсад дасаж дадаж болохгүй, харин салж хагацахыг үл үзэх нирваныг хүсэж мөрөөдөх хэрэгтэй.

2. Хэрэв сүсэгтэн Бурхан багшийн сургаалыг сонсоод итгэл бишрэл нь улам баттай болвол тэрбээр сэтгэлд нь баяр баясгалан өөрөө үүсэж буйг мэдэрнэ. Тэрбээр ийм байдалд ормогц бүх юм гэрэл гэгээтэй, бүх юманд баяр баясгалан буйг олж харна.

Түүний сэтгэл зөөлөн, цэвэр ариун болно. Тэрбээр тэвчээртэй, амарлингуй болж, хүмүүсийг түгшээхээ болино. Тэрбээр Бурхан багш, Түүний сургаал, Бурсан хуврагын тухай бодох тул сэтгэлд нь баяр баясгалан өөрөө буй болж, тэрбээр бүх юм гэрэл гэгээтэйг олж харна.

Итгэл бишрэлийн ачаар тэрбээр Бурхан багштай нэг болно. Тэрбээр өөрийгөө бодохоо больж, өөрөө юуг ч үл хүснэ. Ингээд амьдралдаа юунаас ч айж эмээхийг больж, гүжирдлэг гүтгэлгийг ч тоохгүй болно.

Тэрбээр Бурхан багшийн ертөнцөд мэндэлнэ гэдэгтээ итгэж, үхлээм үл айна. Тэрбээр сургаалын

үнэн шударгад, түүний үнэ цэнэд итгэх тул хүмүүст сүсэг бишрэлийнхээ тухай хэнээс ч айхгүй ярьдаг болно.

Тэрбээр бүгдэд энэрэнгүй, нигүүлсэнгүй сэтгэлийг үзүүлэхийг хичээх тул хүмүүстэй ижил тэгш харьцана. Тэрбээр цэвэр ариун, зөв сэтгэлтэй болох тул буяныг дуртайяа үйлдэнэ.

Сайн сайхан, хүнд хэцүү аль ч цагт тэрбээр улам гүн бишрэлтэй болж, алдаа дутагдлаасаа ичиж, сургаалыг хүндлэн, хэлснээрээ хийж, хийснээрээ хэлдэг болно. Түүний үг, үйл хоёр хэзээ ч үл зөрнө. Тэрбээр эд юмсыг саруул ухаанаар харж, сэтгэл нь уул лугаа адил бат бэх болж, гэгээрэх замаар улам урагшлахыг хүснэ.

Ямар ч тохиолдолд тэрбээр Бурхан багшийн сэтгэлийг даган олон түмнээ залж чиглүүлэх билээ. Энэхүү манан будант ертөнцөд бузартсан хүмүүстэй харьцахдаа тэрбээр тэднийг буяны талд татаж оруулахыг хичээнэ.

3. Тиймээс юуны өмнө Бурхан багшийн сургаалыг сонсохыг хүн бүр өөрөө хүсэх хэрэгтэй.

Дүрэлзэж буй гал руу орвол сургаалыг олно хэмээн сонсоод хүн гал руу ороход бэлэн байх ёстой.

Учир нь энэхүү ертөнцийг тэр аяар нь залгисан галд явж ормогцоо тэрбээр Бурхан багшийн нэр алдрыг сонсч өөрийн авралыг олно.

Ингэж сургаалыг олмогцоо хүмүүст өргөл барьц өргөж, хүндэлж болохыг нь хүндэлж, зүтгэж болоход нь зүтгэж, их нигүүлсэнгүй, энэрэнгүй сэтгэлээр бусдад хандах хэрэгтэй юм.

Хувиа бодсон үйлдэл, элдвийн ааш зан нь гэгээрэхийг хүсэн тэмүүлэх хүнд үл зохино.

Тиймээс сургаалыг сонсож байхдаа түүнд итгэх хэрэгтэй. Бусдад атаархаж, бусдын үгэнд хууртан төөрөлдөж болохгүй, гол нь өөрийн үйлийг сайтар ажиглаж, бусдын үйлийг бүү бод. Юуны өмнө сэтгэлээ төгс төгөлдөр болговоос зохино.

Бурхан багшид үл итгэдэг хүн гагцхүү өөрийгөө л бодно. Тиймээс сэтгэл нь давчхан бөгөөд цаг үргэлж амгалан тайван бус байдаг. Харин Бурхан багшид итгэдэг хүн өөрийнхөө ард буй хүч хийгээд дээд зэргийн нигүүлсэнгүй сэтгэлд итгэдэг юм. Тиймээс сэтгэл нь уужим бөгөөд үргэлж амарлингуй байдаг.

4. Бурхан багшийн сургаалыг сонсон дагагч хүн өөрийн биеийг мөнх бус чанартай, зовлон зүдүүрийн сав бөгөөд нүглийн эх булаг гэдгийг мэднэ. Тиймээс тэрбээр өөрийнхөө биед дасаж даддаггүй юм.

Гэвч өөрийн биед хайр гамтай хандахаа бас мартдаггүй юм. Тэрбээр зугаа цэнгэл эрж хайснаас бус, харин билгийн нүдээ нээж, ном сургаал номлож бусдад түгээхийг хүссэнээс ингэнэ.

Хэрэв өөрийн биеийг эс хайрлаж, халамжилваас урт удаан наслаж чадахгүй. Урт удаан наслаж эс чадваас сургаалыг эзэмшиж, бусдад түгээж чадахгүй.

Мөрөн голыг гатлах гэсэн хүн салаа, аялж буй нь морио гамнадаг. Үүнтэй адил Бурхан багшийн сургаалыг анхааралтайяа сонсдог хүн биеэ гамнаж хайрлах ёстой.

Бурхан багшид итгэдэг хүн гоё сайхан харагдахын тулд бус, харин нүцгэн биений шившгээ нуун далдлах, даарч хөрөх болон халууцахаас хамгаалахын тулд хувцас хунар өмсөх ёстой.

Жаргаж цэнгэхийн тулд бус, амьд биеэ тэтгэх, Бурхан багшийн сургаалыг дагах, түүнийг түгээн дэлгэрүүлэхийн тулд хүн хоол унд ууж идэх бүлгээ.

Тэрбээр зугаа цэнгэлийн төлөө, баян чинээлгээ харуулахын тулд байшинд амьдардаг бус аа. Харин гэгээрлийн байшинд амьдарч, хана нь түүнийг хорвоогийн шунал тачаалаас зааглаж, буруу номын бороо шороо, салхи шуурганаас хамгаалдаг гэж бодож болно.

Иймд алив юмыг өөрийн зугаа цэнгэл, эсвэл өөрөө хүмүүсээс илүү гэдгээ харуулахын тулд бус, харин гэгээрч Бурхан багшийн сургаалыг өөрийн болгож, түүнийг бусдад сургахын тулд хийх хэрэгтэй.

Тиймээс хүн гэр орондоо ойр дотныхонтойгоо хамт байхдаа сургаалаа үргэлж санаж байх ёстой. Тэрбээр энэрэх, нигүүлсэхийг үзүүлэн гэр бүлийнхээ сайн сайхны төлөө зүтгэж, тэднийгээ авралын замд бүхий л аргаар оруулах хэрэгтэй.

5. Эгэл жирийн хүн эцэг, эх, гэр бүл, өөрийнхөө болон Бурхан багшийн төлөө ямагт зүтгэх ёстой.

Эцэг эхийнхээ төлөө зүтгэхдээ тэдэндээ үргэлж санаа зовж, амар амгалан, аз жаргалыг ерөөж байх хэрэгтэй. Тэрбээр эхнэр хүүхэдтэйгээ цуг байхдаа хэт дадаж дасахын хүлээснээс ангижрахыг хичээвэл зохино.

Тэрбээр хөгжим сонсохдоо ч Бурханы сургаалаас сэтгэлийн цэнгэл эрэх хэрэгтэй. Тэрбээр өрөөндөө ч ухаант хүн шиг байж, бузар булайгаас үүрд салахыг эрмэлзэх ёстой. Хэн нэгэн хүнд өглөг өгөхдөө бүх юмнаас татгалзаж, хармын сэтгэлээс ангижрах нь зүйтэй. Тэрбээр хурал цуглаанд оролцохдоо Бурхан багш нарын хуралд буй хэмээн бодвол зохино. Хэрэв гай зовлон тохиолдвол юу ч тохиолдсон сэтгэлээ тайван байлгахыг л хүсэж залбирах ёстой.

Бурхан багшийн авралд багтахаар тэмүүлэхдээ буяны их замыг бусдын хамт хүсэх хэрэгтэй.

Бурхан багшийн номлолын авралд багтахыг хичээхдээ сургаалын эрдэнийн сан руу орох, далай их оюун ухаантай болохыг бусдын хамт хүсэх хэрэгтэй.

Лам хуврагуудын авралыг хүсэхдээ бусдын хамт олон түмнээ зөв чиглүүлж, тэднийхээ замаас элдэв гай барцадыг зайлуулах хэрэгтэй.

Хувцас хунар өмсөхдөө сайн санаа, номхон хүлцэнгүйн өмсгөл өмсөхөө мартахгүй байвал зохино.

Тэрбээр хүндээр, хөнгөнөөр морь харахдаа хомхой сэтгэл, уур хилэн, мунхгийн бузраас мөн

адил ангижрахыг хүсвэл зохино.

Өгсүүр замыг харсан хүн дээд буяны мөрөөр дээшээ гарч, төөрөгдлийн ертөнцөөс ангижрахыг хүсэж, доошоо уруудсан зам харахдаа Бурхан багшийн сургаалын гүн рүү бууж орохыг хүсэх нь зүйтэй.

Гүүр харсан хүн Бурхан багшийн сургаалын гүүрийг барьж, түүн дээгүүрээ хүмүүсийг гаргахыг хүсэх ёстой.

Тэрбээр уй гашууд автсан хүнийг харахдаа үргэлж хувирч байдаг ертөнцийн мөнх бусыг ухааран өрөвдөх хэрэгтэй.

Тэрбээр хүсэл шуналдаа автсан хүнийг харахдаа зүүд зэрэглээ мэт хуурамч амьдралаас ангижирч, үнэнхүү гэгээрэхийг хүсэх ёстой.

Тэрбээр амттай хоол олдоход хэмжээндээ тохируулан идэж хүслээ нимгэлж, зуршил заншлаасаа салахыг хүсэх нь зүйтэй.

Тэрбээр амтгүй хоол олдоход ертөнцийн хүслээсээ үүрд салахыг хичээвэл зохино.

Зуны аагим халуунд тэрбээр ертөнцийн шунал

тачаалын халуунаас ангижирч, гэгээрэхийн сэрүүн агаар сэвэлзэхийг хүсэх ёстой.

Өвлийн тэсгим хүйтэнд тэрбээр Бурхан багшийн агуу их нигүүлсэнгүй сэтгэлийн илчийг хүсэх нь зүйтэй.

Тэрбээр мөргөж залбирч байхдаа Бурхан багшийн ямар ч сургаалыг үл мартаж, амьдралд биелүүлэхийг эрмэлзвэл зохино.

Тэрбээр Бурхан багшийн тухай бодохдоо Түүний мэлмий лүгээ адил хурц, гярхай харцтай байхыг хүсвэл зохино.

Тэрбээр шөнө унтахдаа бие, хэл, санаа бодол тайвшран амар болох хийгээд сэтгэлээ ариусгах ба сэрэхдээ эргэн тойрон буй бүхнийг анзаарч ажихын тулд билгийн хараа бүрэн нээгдэхийг хүсэх ёстой.

6. Бурхан багшийн сургаалд итгэж буй хүн юмсыг байгаагаар нь олж харах, эд юмс мөн чанаргүй хэмээх сургаалыг мэдэж байх, ажил хөдөлмөр болон хүний хийдэг бусад үйлийг үл тоомсорлох ааш зан гаргахгүй, харин ч тэдгээрийг буйгаар нь хүлээн авч, өөрийгөө гэгээрүүлэхэд ашиглахыг хичээдэг.

Хүний хорвоо тэр аяараа төөрөгдлөөр дүүрэн

учир бүх юм утгагүй хэмээн үл бодно. Мөн гэгээрлийн ертөнцөд бүх юм сайн сайхан хэмээн үл бодно. Тэрбээр энэ ертөнцөд буй бүхнээс гэгээрэх зам мөрийг л эрж хайх бүлгээ.

Хэрэв харанхуй мунхагаас болж сохорсон нүдээр харвал, хорвоо утга учиргүй, буруу ташаа юм шиг санагдана. Хэрэв оюун ухааны ариун тунгалаг нүдээр харвал хорвоо тэр аяараа гэгээрлийн ертөнц болно.

Ертөнцөд утга учиргүй эд юмс, утга учиртай эд юмс аль нь ч үгүй. Ертөнцөд сайн, муу юм гэж үгүй. Хүний санаа бодолд л ингэж хоёр хуваагддаг юм.

Эдгээр санаа бодлоос ангижираад бүхнийг оюуны гэрлээр гийгүүлбэл алив юмс ариун утгатай болно.

7. Бурхан багшийн сургаалд итгэснээр хүн Бурхан багшид итгэж буй юм. Улмаар итгэж биширсэн сэтгэлээрээ хорвоогийн бүх юмыг ариун хэмээн хүлээн авч, өөрийнхөө төлөө үл зовнин, бусдын тусад зүтгэх бүлгээ.

Тиймээс Бурхан багшийн сургаалд итгэсэн хүн биеэ үл тоож, бусдын төлөө төлөв даруу зүтгэж, бүхнийг тээж даадаг газар лугаа адил уужим

сэтгэлтэйгээр бүгдийн төлөө ямагт зүтгэж, ямар ч зовлон зүдүүрийг туулан давахад бэлэн байдаг. Тэрбээр залхуурахыг үл мэдэж, ядуу хүмүүст буян үйлдэхэд бэлэн байх бүлгээ.

Сэтгэлээр дорой хүмүүст нигүүлсэнгүйг үзүүлж, хүмүүсийн санаа сэтгэлийг зөв залж хүмүүжүүлэхийн тулд энэрэнгүй сэтгэлт эх болох гэсэн түүний тэмүүлэл бол бүх хүнийг эцэг эх лүгээ адил хүндэлж тэдний өмнө аугаа их багшийнхаа өмнө сөгдөх адил сөхөрч хүндэтгэх гэсэн хүсэл мөн.

Тиймээс хүмүүс Бурхан багшийн сургаалд итгэсэн хүнийг үзэн ядаж, зовоож тамлахыг хүсвэл ямар ч хүчтэй хор их далайг хордуулж чадахгүйтэй адил тэдний хүсэл эс бүтнэ.

8. Бурхан багшийн сургаалд өөрийн зол жаргалын тухай бодож итгэсэн хүн Бурхан багшид итгэх итгэл нь Бурхан багшийн хүч чадал, Түүний зөөлөн өрөвч сэтгэл мөн хэмээн ухаарч Бурхан багшид талархан баярлах бүлгээ.

Ертөнцийн шунал тачаалын шавар шавхай дунд Бурхан багшийн номлолд итгэх итгэлийн үр үгүй ч, Бурхан багшийн энэрэнгүй сэтгэлийн ачаар энэхүү шавхай дунд итгэлийн үр суулгаж болно, улмаар түүнээс Бурхан багшид итгэх сэтгэл урган гарах

бүлгээ.

Бидний заасанчлан, хорт мод ургадаг төгөлд анхилуун сайхан үнэртэй зандан мод үл ургана. Үүнтэй адил хорвоогийн шунал тачаалд уруулж, тасдуулж буй цээжинд Бурхан багшид итгэх бишрэлийн үр соёолохгүй.

Гэлээ ч хорвоогийн шунал тачаал бүхий цээжинд баяр баясгалангийн цэцэг урган цэцэглэх амой. Энэхүү цэцгийн үндэс нь тэр хүний хэнхдэгт бус, өөр газар буй буюу. Тэр нь Бурхан багшийн цээж бүлгээ.

Бурхан багшид итгэдэг хүн өөрийнхөө л тухай бодож эхэлбэл, сэтгэлд нь шунал, уур хилэн, мунхаг ухаан оволзон бусдад атаархаж, бусдыг үзэн ядаж, зовоож шаналаахыг хичээж эхлэх болно. Гэвч Бурхан багшийн авралыг эрж буй хэн хүн Бурхан багшийн дээр дурьдсан агуу их үйл хэргийг бүтээж эхэлдэг. Энэ бол үнэхээр гайхамшиг мөн амой.

III
АМЬДРАЛЫН ЧИГ БАРИМТЛАЛ

1. Гай зовлон дороос үүдэн гардагийг үл мэдэж, дорно эсвэл өрнө зүгээс ирдэг хэмээн бодох нь тэнэг явдал бүлгээ. Дотоод сэтгэлээ янзалж цэгцлээгүй байж, гадна талаа хамгаалах нь буруу.

Өглөө эрт босоод шүдээ сойздож, гар нүүрээ угааж, баруун, зүүн, урд, хойд, дээд, доод зургаан зүгт мөргөж, аюул ирж болох замыг хааж, аз жаргалтай сайхан өдөр болоосой хэмээн хүсэх нь хүн бүхний хийх ёстой зүйл билээ.

Гэвч Бурхан багшийн сургаалын хувьд өөр бөгөөд үнэний зургаан зүгийг хүндэлж, ухаантай байж, буян бүтээснээр гай зовлонгоос өөрийгөө хамгаалж чадна.

Эдгээр зургаан зүгийг мөрдөж баримтлахын тулд юуны өмнө дөрвөн зүйлийн бузраас салж, сэтгэлийн дөрвөн муу илрэлийг тасалж, гэр орон болон эд хөрөнгийг сүйтгэх зургаан үүдийг хаах хэрэгтэй бүлгээ.

Энэхүү дөрвөн үйлийн бузар гэдэг нь амьтны амь таслах, хулгай хийх, буруу хурьцах, худал хэлэх эдгээр болой. Сэтгэлийн дөрвөн муу илрэл нь ховдог шунахай сэтгэл, уур хилэн, мунхаг ухаан, айж эмээх болой. Гэр орон болоод эд хөрөнгийг сүйтгэх зургаан үүд гэдэг нь ууж согтуурах, үдэш орой болтол

найрлах, мөрийтэй тоглох, хөгжим, театр зэрэгт ухаанаа өгч хөөцөлдөх, мөрийтэй тоглох, муу хүнтэй нөхөрлөх, ажилд залхуурах эдгээр болой.

Энэхүү дөрвөн буруу үйлийн бузраас салж, сэтгэлийн дөрвөн муу илрэлийг таслан, орон гэр, эд хөрөнгийг сүйтгэх зургаан үүдийг хамгаалж, үнэний зургаан зүгт мөргөх ёстой.

Үнэний зургаан зүг гэдэг нь эцэг эх, үр хүүхдийн зүүн зүгийн зам, багш, шавь нарын өмнө зүгийн зам, хань ижлийн баруун зүгийн зам, анд найзуудын хойд зүгийн зам, эзэн, зарцын доод зүгийн зам, Бурхан багшийн сургаалд итгэсэн хүний дээд зүгийн зам юм.

Эцэг эх, үр хүүхдийн зүүн зүгийн зам гэдэг нь үр хүүхэд нь эцэг эхдээ үйлдэх таван үйл юм. Үүнд: эцэг эхдээ туслах, аав ээжийнхээ төлөө хөдөлмөрлөх, удам угсаагаа хамгаалах, өв залгамжлалаа үргэлжлүүлэх, өвөг дээдэсдээ өргөл барьж байх эдгээр багтана.

Эцэг эх ч мөн ялгаагүй хүүхдийнхээ өмнө таван үүрэг хүлээн мөрдөх ёстой. Үүнд: муу зүйлээс хол байлгах, буяныг зааж сургах, мэдлэг, чадварыг суулгаж өгөх, сайн хань олж өгөх, цаг нь болохоор эд хөрөнгөө өвлүүлэх эдгээр болой. Эцэг эх, үр хүүхэд харилцан өөрсдийн үүргээ дагаж мөрдвөл эцэг эх, үр хүүхдийн зүүн зүгийн зам энх амгалан болж, эв үл эвдэрнэ.

Багш, шавийн өмнө зүгийн зам гэдэг нь шавь нар багшаа угтан тосч мэндлэх, түүнд хүчин зүтгэх, дуулгавартай сонсох, өглөг барьц өргөх, номлолыг нь анхааралтай сонсох эдгээр болой.

Харин багш бол шавь нартаа үлгэр жишээ үзүүлэх, өөрийнхөө сурч мэдсэнийг шавь нартаа үнэн зөв заах, сайн ойлгосон зүйлийг нь мартуулахгүй байх, тэднийгээ нэр хүндтэй болгоход санаа тавьж, хаана ч байсан хүндлүүлэх хүн болгоно. Ингэснээр багш, шавийн өмнө зүгийн зам энх амгалан болж, эв үл эвдэрнэ.

Хань ижлийн баруун зүгийн зам бол нөхөр нь эхнэрээ хүндэтгэх, эелдэг зөөлөн харьцах, үнэнч байж, эрх мэдлийг олгож, хааяа түүнд гоёл чимэглэлийн зүйл бэлэглэх ёстой. Харин эхнэр нь нөхрийнхөө өмнө бүх зүйлийг эмх цэгцтэй байлгаж, хамаатнуудаа зохицуулж, үнэнч байж, гэрийнхээ эд хөрөнгийг гамнаж, ар гэрийнхээ ажлыг сайн гүйцэтгэх үүргийг хүлээнэ. Ингэвэл хань ижлийн зүүн зүгийн зам энх амгалан байж, эв үл эвдэрнэ.

Анд нөхдийн хойд зүгийн зам гэдэг нь найз нар нэг нэгийгээ нөхөх, бие биедээ найрсаг дотно хандах, харилцан ашигтай байхыг хичээх, нэгэндээ үргэлж анхаарал халамж тавьж, шударга байх.

Мөн найзыгаа буруу замд орохоос сэргийлэх, хэрэв тийм байдалд орвол түүний эд баялгийг

хамгаалж, сэтгэл санаа нь тавгүй үед түүнд зөвөлгөө өгөх, гай гамшиг тохиолдвол гар сунган туслах, хэрэгцээ шаардлага гарвал эхнэр, үр хүүхдийг нь ч асарч туслахын нэр юм. Ингэвэл анд нөхдийн хойд зүгийн зам энх амгалан байж, эв үл эвдэрнэ.

Эзэн, зарцын доод зүгийн замын хувьд эзэн нь зарцынхаа өмнө дараах таван үүргийг хүлээнэ. Үүнд: зарцынхаа хүч чадалд тохирсон ажлыг өгөх, чанартай хүнсээр хангах, өвдвөл асарч хамгаалах, амттан өгч байх, үе үе амрааж байх.

Зарц мөн адил таван үүрэг хүлээнэ. Өглөө эзнээсээ эрт босч, орой эзнээсээ орой унтаж, ямар ч зүйлд үнэнч шударга байж, ажлаа сайн мэддэг байх ёстой. Мөн эзнийхээ нэрийг хөөдөхгүйг цаг ямагт хичээх хэрэгтэй. Ингэвэл эзэн, зарцын доод зүгийн зам энх амгалан байж, эв үл эвдэрнэ.

Бурхан багшийн сургаалд итгэсэн хүний дээд зүгийн зам гэдэг нь ном заалган сурч буй хүний хувьд багшаа хүндлэн биширч, энэхүү бишрэл түүний бие, хэл, сэтгэлд шингэсэн байх ёстой. Тэрбээр багшаа хүндлэн угтаж, сургаалыг нь үнэнчээр даган мөрдөж, өргөл барьц өгч байх нь зүйтэй.

Харин Бурхан багшийн сургаалыг номлон дэлгэрүүлж буй багш нь нүглээс зайлсхийж, буяныг номлож, чин сэтгэлээсээ хайрлаж, зөв замыг зааж, номоо сайн ойлгож, шавь нар нь сэтгэлийн амар

амгаланг олтол тэднийг араасаа дагуулах үүрэгтэй. Ингэснээр Бурхан багшийн сургаалд итгэсэн хүний дээд зүгийн зам нь энх амгалан байж, эв үл эвдэрнэ.

Зургаан зүгт мөргөх гэдэг нь ийнхүү зургаан зүгийн гай гамшгаас зайлахыг хүсч мөргөж залбирахыг хэлж байгаа хэрэг биш. Энэ нь үнэний зургаан зүгийг дагаж, гай гамшиг хүний дотор буй болохооос сэргийлнэ гэсэн үг юм.

2. Хүн нөхөрлөж болох хийгээд үл болох хүмүүсийг ялгаж сурах хэрэгтэй.

Нялуун үгтэй, бялдууч зантай, шунахай хүн болон үрлэгэн этгээдтэй нөхөрлөж болохгүй.

Хүнд хэцүү цагт чинь туслаж, баяр баясгалан, уй гунигийн алийг ч хуваалцахад бэлэн, зөв зүйтэй үгээ харамгүй хэлдэг, нигүүлсэнгүй сэтгэлтэй хүнтэй нөхөрлөж болно.

Чамайг буяны замаас хазайлгахгүйн тулд нүд эс салгаж, сэтгэлдээ чиний төлөө зовж, гай зовлон тохиолдоход тайтгаруулдаг, хэрэгтэй үед чамд туслахын тулд өөрийгөө ч үл хайрлаж, нууцыг чинь хадгалж чадах, үргэлж зөв зүйтэй зөвлөгөө өгдөг тийм хүнтэй үерхэж, түүний төлөө зүтгэх ёстой.

Ийм найзтай болох амаргүй тул, хүн өөрөө

бусдад иймэрхүү анд болохыг хичээвэл зохино. Сайн хүн өөрийн зөв үйлийн ачаар бусдын хувьд наран болдог билээ.

3. Хүн эцэг эхдээ юугаар ч төлж баршгүй өртэй юм. Эцгээ баруун, эхээ зүүн мөрөн дээрээ зуун жилийн турш үүрч яваад ч төлж чадахгүй.

Эцэг эхээ анхилуун сайхан үнэр бүхий усанд зуун жилийн турш өдөр шөнөгүй оруулсан ч энэ их өрийг төлж дийлэхгүй. Арван хуруу тэгш хүү болж, тэднийхээ төлөө эрвийх дэрвийхээрээ зүтгэж, тэднийгээ хаан ширээнд суулган, хамгийн элбэг дэлбэг, баян тансаг амьдралд умбуулсан ч ачийг нь хариулж чадахгүй юм.

Харин тэднийг Бурхан багшийн сургаалд итгүүлж чадвал, буруу замыг орхиж, зөв мөрийг хөөдөг болговол, шунахай сэтгэлээсээ татгалзаж өглөг барьц баясгалантайгаар өргөдөг болговол тэдний ачийг хариулж болно. Энэ нь тэр их ачийг хариулахаас ч илүү тус дэм болж магадгүй юм.

4. Нэгэн гэр бүлд олон сэтгэлийн харилцаа байдаг тул, хэрэв гэр орноороо эвтэй бол цэцэглэж буй цэцэрлэг лүгээ адил үзэсгэлэн төгс бүлгээ. Хэрэв сэтгэл санааны найрсал эвдэрвэл хэрүүл маргаан дэгдэж, гэр бүл салж сарнина. Ийм тохиолдолд

бусдыг бус, өөрийнхөө сэтгэлийг буруушаан гэмшиж, зөв мөрийг хөөх нь зүйтэй.

5. Эрт урьд цагт үлэмж сүсэг бишрэлтэй нэгэн залуу эр байжээ. Эцэг нь талийгаач болоход тэрбээр эхтэйгээ хамт хоёулхнаа үлдэв. Ээж, хүү хоёр бие биеэ хайрлан халамжилж, сайхан амьдарч байлаа. Удалгүй хүү нь гэрлэж, гурвуулаа амьдрах болов.

Эхлээд юм бүхэн сайн сайхан, цугаараа жаргалтай байлаа. Нэгэнтээ шалихгүй юмнаас болж хадам эх, бэр хоёрын хооронд зөрчил үүдэн, хэрүүл маргаан тасрахгүй болов. Хөгшин эх тэвчиж ядаад, сүүлдээ хос залууг орхиж, гэрээсээ явав.

Эхийгээ явсны дараа бэр нь хүү төрүүлжээ. Хадам эх нь цуг амьдарч байхдаа бэрээ үргэлж гомдоодог байсан тул хүүхэд төрүүлж чадаагүй, харин түүнийг явсны дараа бурхан үр хүүхэд хайрласан тухай цуу яриа орь ганцаар амьдарч буй хөгшний чих дэлсчээ.

Хадам эх уурлан хилэгнэж дуу алдсан нь: "Энэ хорвоод шударга үнэн юм алга. Эхийгээ хөөсөн бэрд бурхан хүүхэд хайрлах нь хөлөөрөө толгой хийсэн шударга үйл юм" гэв.

Тэрбээр элий балай болж: "Ийм шударга явдлыг

болиулах хэрэгтэй" хэмээн хашгирсаар оршуулгын газар руу гүйжээ.

Индра бурхан энэ бүхнийг мэдэж, хадам эхийн зам дээр гарч ирэв. Тэрбээр түүнийг асуун шалгааж, ятган сэнхрүүлэхэд хөгшин эх үл сонсов.

Чингээд Индра бурхан хэлсэн нь: "За, тэгвэл би чиний үзэн яддаг бэр, ачийг чинь амьдаар нь шатаачихъя. Тэгвэл чи баярлах уу?"

Индра бурханаас үүнийг сонссон хадам эх сая ухаан орж, буруугаа ойлгон, нүглээ наманчилж, бэр, ач хоёроо өршөөхийг учирлан гуйжээ. Хүү, бэр хоёр нь ч эдүгээ хүртэл төөрөлдөж байснаа ухаарав. Тэд ээж рүүгээ очих гэж яваад оршуулгын газраас буцаж байхад нь замд нь таарчээ. Индра бурхан, хадам эхийг бэртэй нь эвлэрүүлж, тэдний гэр бүлд эв найр эргэж ирэв.

Шударга ёсыг үл гээх аваас сургаал номлол хэзээ ч үл мөхнө. Сургаал нь өөрөө оршин тогтнохоо больдог бус, харин хүн шударга ёсыг мартдагаас л болдог юм.

Сэтгэл сэтгэлтэйгээ зөрөлдөхөд үнэхээр аймшигт гай гамшиг ниргэнэ. Ялигүй үл ойлголцол ч их аюулыг авчирна. Гэр бүлийн амьдралд үүнээс л хамгийн их айж эмээвэл зохино.

6. Хүн гэр бүлээ тэжээн тэтгэхийн тулд шоргоолж юм уу, эсвэл зөгий лүгээ адил ажиллах ёстой. Тэрбээр бусдад найдах, өргөл барьц өгөхийг хүлээх ёсгүй.

Хөлсөө асгаруулж олсон баялгаа гагцхүү өөрийн хэмээн үзэж, зөвхөн өөртөө зарцуулж болохгүй. Нэг хэсгийг нь хүмүүст өгч, нөгөө хэсгийг нь хожим хэрэг болно хэмээн хадгалах ёстой. Хэрэв хөрөнгө нь нийгэм, эсвэл Бурхан багшийн сургаалын тусад үйлчилвээс баярлан баясах ёстой.

Энэ хорвоод "Өөрийн" гэсэн юу ч байхгүй. Бүх юм цаг нь болж, нөхцөл бүрэлдэхэд хүнд олдож, хүн түүнийг түр хугацаагаар л хэрэглэнэ. Тиймээс аливаад дээд зэргийн ариг гамтай хандах ёстой.

7. Удаяна хааны хатан Сямавати, Анандад 500 хувцсаар өргөл барихад цаадах нь дуртайяа хүлээн авчээ.

Хаан үүнийг мэдмэгцээ Ананда шунахай сэтгэлд хөтлөгдөн тэр их өргөлийг авсан гэж бодоод түүнээс очиж асуусан нь:

"Ариунаас ариун анд минь, чи нэгэн зэрэг бүхэл бүтэн 500 хувцас аваад яах гэсэн юм бэ?"

Ананда хариулсан нь: "Хаан минь, олон лам хувраг ноорхой цоорхой хувцастай явдаг. Би тэдэнд шинийг өгөх гэсэн юм" "Тэгвэл чи хуучин хувцсыг нь яах вэ?" "Бид хуучин хувцсаар орны даавуу хийнэ". "Хуучин дэрний уутыг яах вэ?" "Шалан дээр дэвсэх олбог хийнэ". "Хуучин олбогоо яах вэ?" "Хөлний арчуур хийнэ". "Хөлний арчуураар яах вэ?" "Хаан минь, хуучин хөлний арчуураар шалны арчуур хийнэ". "Хуучин шалны арчуурыг яах вэ?" "Хуучин шалны арчуурыг тууз туузаар нь урж, зуурч буй шавартай холиод, зуурсан шавраараа байшин барихдаа ханыг нь шавж өрнө".

Эд юмсад ариг гамтай хандаж, зөв хэрэглэх хэрэгтэй. Ийнхүү "Өөрсдийн" бус, харин бидэнд түр олдсон юмсыг ашиглаж хэрэглэх ёстой.

8. Нөхөр, эхнэрийн харилцааг тав тухыг бодож тогтоогоогүй, мөн нэг гэрт амьдарч буй учраас ч тэгсэн юм бус. Ариун сургаалын дагуу тэд сэтгэлээ төгс төгөлдөр болгохыг хичээвэл зохино.

Цагтаа эвтэй найртай гэр бүлийн үлгэр жишээ болж байсан амраг хоёр нэгэнтээ Эрхэм дээд ариун явдалт багш дээр очиж, Түүнд хандаж хэлсэн нь: "Эрхэм дээд ариун явдалт багш аа, бид багаасаа бие биеэ мэддэг байсан юм. Дараа нь насанд хүрээд гэр бүл болсон. Одоо болтол бид хоёрын толгойд нэгийгээ хуурах бодол ганц ч удаа орж ирээгүй юм.

Бид, энэ ертөнцөд амьдарч буй шигээ хойт насандаа ч биесээ хайрлан халамжилж амьдармаар байна. Бидний энэхүү хүсэл биелж бүтэхэд юу хийх хэрэгтэйг хэлж өгнө үү?" Эрхэм дээд ариун явдалт багш хариулсан нь: "Тийм бол та хоёр нэг шашинд сүсэглэх хэрэгтэй.

Сургаалыг хоёулаа дагаж, хамтдаа сэтгэлээ төгс төгөлдөр болгож, хамтдаа өргөл барьц өргөж, хамтдаа оюун ухааныг олвол, та хоёр хойт насандаа ч нэгэн сэтгэлээр амьдарч чадна".

9. Гэгээрэх замд эрэгтэй, эмэгтэй хүний хооронд ялгаа үгүй. Эмэгтэй хүн гэгээрэхийг мөн адил хүсвэл тэрбээр гэгээрэх замыг дагаж мөрддөг болно.

Прасенажит буюу Гэгээнээ ялгуугч хааны охин, Айодхи хааны хатан Маллика гэгээрэх замыг дагаж Чадагчийн эрхт багшийн сургаалд мөргөн залбирч, Түүний өмнө дараах арван тангараг өргөсөн юм.

"Бүхнийг айлдагч багш минь, өнөөдрөөс эхлээд гэгээртлээ би нэгдүгээрт, ариун сургаал зарлигийг зөрчихгүй. Хоёрдугаарт, би өөрөөсөө эх хүмүүст ихэмсэг зан гаргахгүй. Гуравдугаарт, хэнд ч уурлаж уцаарлахгүй. Дөрөвдүгээрт, бусдын зүс царай, эд юмсад атаархахгүй. Тавдугаарт, би бээр өөрийн

сэтгэл, эд юмсыг хайрлан харамсахгүй. Зургадугаарт, би бээр өөртөө зориулж эд юмс хадгалахгүй, ядуу хүмүүсийг жаргалтай болгохын тулд юу байгаагаа тэдэнтэй хуваалцана. Долдугаарт, би бээр өргөл барьц өргөж, бүх хүмүүстэй найрсаг харьцаж, бусдад тустай бүхнийг хийж, бусдын оронд өөрийгөө тавьж үзээд тэдний тухай бодох болно. Би бээр энэ бүхнийг өөрийн төлөө бус, харин бусдын төлөө, ямар ч ашиг хонжоо бодолгүй, далдын муу санааг агуулалгүй хийнэ.

Наймдугаарт, хэрэв ганц бие хүн, шоронгийн хоригдол, өвчин эмгэгт нэрвэгдсэн, өөр өөр зовж зүдэрсэн хүмүүстэй учирвал тэдний зовлонг нимгэлэхийн тулд тэднийг аврана гэдэгтээ итгэн найдаж, үнэнийг хэлж сургана. Есдүгээрт, хэрэв амьд амьтныг барьсан хийгээд хорьсон хүнтэй таарвал, хууль журмыг зөрчиж буй хүнтэй учирвал, тэдний муу үйлийг таслахын тулд бүх хүчээ дайчилж залхаах ёстойг нь залхааж, зааж сургах ёстойд нь зааж сургана. Аравдугаарт, зөв сургаалыг мартсан хүн аливаа юманд нуугдмал буй үнэн зөв сургаалаас холдон хөндийрч, гэгээрлийн эрэгт хүрэхгүйг мэдэх учраас би бээр зөв сургаалыг сонсохоо хэзээ ч үл мартана.

Түүгээр ч барахгүй, эдгээр зовж зүдэрсэн хүмүүсийг аврахын тулд би гурван зүйлийг хүснэм. Нэгдүгээрт, бүх хүмүүс амар амгаланг олохыг би хүсч байна. Энэхүү ариун хүслийн ачаар би, дараагийн төрөлдөө ямар ч маягаар амьдарсан, зөв сургаалын оюун ухаантай болно гэдэгт итгэнэ. Хоёрдугаарт, зөв сургаалын оюун ухаантай болмогц хүч чадлаа дайчлан бусад хүмүүст зааж сургана. Гуравдугаарт, зөв сургаалыг хамгаалахын тулд бие хийгээд амьдрал, бүх эд хөрөнгөө өгөхөд бэлэн байна". Гэр бүлийн жинхэнэ утга учир нь хамтдаа гэгээрэх замд ороход оршино. Хэрэв энэхүү зам мөрийг дагаж, Малликатай адил их эрмэлзэлтэй байвал Бурхан багшийн агуу их шавь болж чадна.

II БӨЛӨГ

БУРХАН БАГШИЙН ЖАРГАЛЫН ОРНЫГ БҮТЭЭХ НЬ

I

ЭВТЭЙ ХУВРАГУУД

1. Харанхуй нөмөрсөн уужим хээр тал байжээ. Хаана ч гэрэл гэгээ байсангүй. Тоо томшгүй олон амьд амьтан тэр талд амьдарч байв.

Түнэр харанхуйгаас болоод амьтад нэг нэгийгээ үл мэдэх бөгөөд амьтан бүр ганцаардах аж. Тэд ганцаардан зовж тарчлан амь зууж байв. Амьдрал нь уйтгар гунигаар дүүрэн байлаа.

Гэтэл гэнэт гэрэл гэгээ гийжээ. Асар том асаасан бамбар тэргүүн дээрээ өргөсөн агуу их хүн санамсаргүй байтал гарч ирэв. Хав харанхуй байсан тал нүд ирмэх зуур гэрэлтсэн аж.

Одоо болтол харанхуйд мөлхөж байсан амьтад хөл дээрээ босч эргэн тойрноо харжээ. Тэд орчин тойронд өөрсөдтэй нь адил амьд амьтан амьдарч буйг олж хараад баярлан баясч дуу алдан нэг нэг рүүгээ тэмүүлүж, тэврэлдэж, баярлаж, тас тас хөхөрч, хоорондоо ярьж эхлэв.

Энэ домог үлгэрт хээр тал нь амьдралыг

төлөөлнө. Харанхуй нь зөв оюун ухааны гэрэл гэгээ байхгүйг хэлнэ. Сэтгэлд нь оюуны гэгээ үгүй тул хүмүүс бие биетэйгээ уулзан учрахдаа ч танилцаж, үерхэн нөхөрлөж үл чадна. Тэд хорвоод ирэхдээ ганцаараа, хорвоогоос буцахдаа ч ганцаараа бүлгээ. Тэд үргэлж ганцаардаж дэмий л ийш тийш сандчин үсчиж, ганцаардлаас зовж шаналдаг юм.

Тэргүүн дээрээ бамбар асааж барьсан агуу их хүн гарч ирсэн нь Бурхан багш оюун ухааны гэрлийг амьдралд авчирсныг өгүүлнэ.

Энэхүү гэрэл тусахад гэгээрсэн хүмүүс анх удаа өөрсдийгөө болоод бусдыг танин мэдэх боломжтой болно. Гайхан баярласан тэд нэг нэг рүүгээ тэмүүлж, тэдний хооронд эв найрамдал буй болно.

Хэдэн сая хүн ч байсан хэрэв бие биеэ л мэдэхгүй бол тэр нь нийгэм бус юм.

Нийгэм хэмээх нь оюун ухааны жинхэнэ гэрэл байнга тусч гийсэн, хүмүүс нь бие биетэйгээ танил дотно, нэг нэгэндээ итгэдэг, энх амгалан байдалд эвтэй найртай амьдардаг хамт олныг хэлнэ.

Энх амгалан болон эв найр хэмээх нь нийгэм, хамт олны амьдрал, тэдгээрийн жинхэнэ утга учир нь болой.

2. Энэ хорвоод гурван янзын хамт олон буй.

Нэгдүгээрт, удирдагч нь эрх дархтай эсвэл эд хөрөнгөтэй учир оршин тогтнодог хамт олон буй.

Хоёрдугаарт, өөр өөрийн тооцоотойгоор цугласан хүмүүсээс бүрдсэн хамт олон буй. Тэдний тооцоо хэвээрээ ахуйд энэхүү хамт олон орших болно.

Гуравдугаарт, ариун сургаалыг дагасан хүмүүсээс бүрдсэн хамт олон буй. Тэдний амьдралд энх амгалан хийгээд эв найр л ноёрхоно.

Эдгээр гурван янзын хамт олноос жинхэнэ нь гуравдугаар болой. Энэ хамт олон нэгэн сэтгэлээр амьдарч, янз бүрийн сайн үйлс бүтээх тул, энх амгалан, баяр баясгалан дүүрэн сэтгэл хангалуун зол жаргалтай амьдардаг.

Ууланд орсон борооны ус нь эхлээд уулын горхи, дараа нь томоохон гол мөрөн, эцэст нь тэнгис далайд цутгахтай адил өөр, өөр байдалтай, нас сүүдэртэй хүмүүс сургаалын бороон дор цангаагаа тайлан, олон бяцхан хамт олноос нийгмийг бүрэлдүүлж, эцэст нь гэгээрэхийн нэгэн далайд цутган нийлмүү.

Бүхний сэтгэл сүү, ус лугаа адил сүлэлдэн нэгдэхэд үнэнхүү найртай хамт олон буй больюу.

Эл хорвоод жинхэнэ эв найртай хамт олныг буй болгох гол хүч нь зөв сургаал юм. Энэ бол нэг нэгийгээ олж харахад туслах гэрэл гэгээ, сэтгэл эвдрэх үймэхээс аварч, энх амгалан, эв найрыг буй болгох хүч юм. Бурхан багшийн сургаалд тулгуурлан буй болсон энэхүү хамт олныг бурханы шавь нарын хамт олон гэж хэлж болно.

Бүх гишүүд нь энэхүү сургаалын дагуу сэтгэлээ төгс төгөлдөр болгох ёстой тул, хэдийгээр бурханы олон шавь нар өөр, өөр хүмүүс боловч, хэрэг дээрээ нэг сүсэг бишрэлтэй хамт олныг бүрдүүлнэ.

3. Сүсэг бишрэл нэгтэй хамт олон хоёр янзын гишүүдээс бүрдэнэ. Нэг хэсэг нь жирийн сүсэгтнүүдийн дунд бурхан багшийн сургаалыг түгээн дэлгэрүүлж, нөгөө хэсэг нь тэднийхээ амьдралыг тэтгэж, хоол хүнсийг бэлдэж, хувцас хунарыг нь оёх бүлгээ. Эдний аль нь ч гэсэн хамт олноо дэмжин өргөжүүлж, сургаал үүрд түгэн дэлгэрч байх байдлыг буй болгохын төлөө хүч чадлаа дайчлах ёстой юм.

Хамт олны гишүүд цаг үргэлж энх амгалан, эв найрыг хүсэн тэмүүлж, хамт олныхоо эрхэм

зорилтыг биелүүлэхэд бүхий л хүч чадлаа дайчлах ёстой. Лам хуврагууд жирийн сүсэгтэн олонд ном сургаал айлдаж, жирийн сүсэгтнэ олон нь тэдний номлож буйд итгэн сүсэглэх ёстой тул, лам хувраг болон жирийн сүсэгтэн олны хооронд энх амгалан, эв найр тогтоно.

Тэд хоорондоо хэрүүл маргаангүй, энх амгалан, эв найртай амьдрахын тулд хүч чадлаа дайчилж, нэг сүсэгтэй хамт олонтойгоо амьдрах завшаан тохиолдсонд баярлаж, бие биенээ хайрлаж, санаа сэтгэлээрээ нэгдэн нийлэхийг эрмэлзэх ёстой.

4. Бурсан хуврагийн дунд энх амгалан, эв найрыг буй болгох зургаан дүрэм журам байна. Үүнд: Нэгдүгээрт, чин сэтгэлийн үгс. Хоёрдугаарт, чин сэтгэлийн үйл хэрэг. Гуравдугаарт, чин сэтгэл. Дөрөвдүгээрт, бусдаас авсан эд юмыг хоорондоо тэнцүүлэн хуваах. Тавдугаарт, цугаараа нийтлэг зөв сахилтай байх. Зургадугаарт, цугаараа зөв үзэл бодолтой байх эдгээр болно.

Эдгээрийн дотроос зөв үзэл санааны тухай зургадугаар хууль хамгийн чухал бөгөөд бусад таван хуулийнхаа цөм нь билээ.

Мөн нийт хамт олонд зориулсан долоо, түүний гишүүн бүрд зориулсан долоон хууль тус тус буй.

Хэрэв эдгээр хуулийг дагавал хамт олон цэцэглэн хөгжинө. Эхлээд нийт хамт олны хуулийг толилуулвал:

Нэгдүгээрт, цугаараа байн байн цугларч, ном сургаалыг хэлэлцэх.

Хоёрдугаарт, ахмад хийгээд залуус нь хоорондоо эв найртай амьдарч, нэг нэгийгээ хүндэтгэх.

Гуравдугаарт, ном сургаалыг хүндэтгэж, тэдгээрийг хувцас хунар лугаа адил солихгүй байх.

Дөрөвдүгээрт, ахмад нь залуустай харьцахдаа ах захын ёсыг сахих.

Тавдугаарт, үнэнч шударга байх, нэг нэгийгээ хүндэтгэх нь хэнбугайн ч биеэ авч явахын үндэс болох.

Зургадугаарт, нам гүм байдалд сэтгэл юугаан ариусгах хэрэгтэй. Гэхдээ нам гүм газарт бусдыгаа урьдаа оруулж өөрөө хамгийн сүүлд очвол зохино.

Долдугаарт, хүмүүсийг хайрлаж, зочин гийчнээ найрсаг хүлээн авч, өвчтэй хүмүүсийг халамжлан асарвал таарна. Энэ долоон хуулийг дагавал хамт олонд хагарч бутрах аюул заналхийхгүй.

Хамт олны гишүүн бүрд зориулсан долоон хууль юу юу вэ? хэмээвээс: Нэгдүгээрт, сэтгэл юүгээн ариун тунгалаг байлгаж, юм юманд үл шунах. Хоёрдугаарт, ховдог шунахайгаас ангижирч, энэхүү байдлаа хадгалах. Гуравдугаарт, тэвчээртэй байж, үл маргах. Дөрөвдүгээрт, үг дуу цөөнтэй байхыг эрхэмлэж, илүү дутууг үл ярих. Тавдугаарт, сургаалыг даган мөрдөж, даруу байх. Зургадугаарт, бурханы сургаалаа дагах шиг дагах, бусад сургаалыг үл тоох. Долдугаарт, эгэл жирийн байдалд дуртай байх, элдвийн чамин хоол унд, хувцас хунарт үл шунах. Эдгээр долоон хуулийг дагавал хамт олон хагарч бутрах аюул үгүй амой.

5. Дээр өгүүлсэнчлэн бурханы олон шавь бурсан хуврагийн амьдрал нь энх амгалан, эв найраас бүрдэнэ. Энэ ёсыг эс сахивал бурханы шавь нарын хамт олон хэмээн үл тооцно. Тиймээс хагарал бутралаас сэргийлбэл зохино. Хэрэв хагарал бутрал үүсч болбол тэр дор нь арилгахыг хичээх хэрэгтэй.

Цусыг цусаар үл цэвэрлэж, гомдлыг гомдлоор үл цайруулна. Гомдол хорслыг гагцхүү мартсанаар цайруулна.

6. Эрт урьд цагт Каламити хэмээх хааны улс гүрнийг Брахмадатта хэмээх дайнч, хөрш хаан

дайран довтолж эзлэн авчээ. Каламити хаан хэсэг хугацаанд эхнэр хүүхэдтэйгээ хамт нуугдсан боловч удалгүй баригдав. Харин хүү нь зугтаж амжсан аж.

Хааныг цаазлах өдөр хүү нь эцгийгээ аврахыг бодож аз таарч аятай таатай нөхцөл боломж гарахыг хүлээж байв. Гэтэл боломж гарсангүй, хан хүү яаж ч чадсангүй, аавынхаа цаазлуулахыг л харсан аж.

Хаан цугларсан олны дундаас хүүгээ олж хараад өөрөө өөртөө хандаж буй мэт амандаа бувтнасан нь: "Удаан эрж хайх хэрэггүй яаран бүү үйлд, гомдол хорслыг мартсанаар л цайруулна".

Хан хүү эцгийнхээ өшөөг авахаа андгайлжээ. Тэрбээр аятай таатай бололцоо гармагц Брахмадатта хааныд алба хашиж, удалгүй түүнд шадарлаж, бүрэн итгэл найдварыг нь хүлээжээ.

Нэг удаа хаан ан авд морджээ. Хан хүү энэхүү бололцоог ашиглаж, эцгийнхээ өшөөг авахаар шийдэв. Тэрбээр сэжиг авахуулалгүй хааныг цэргүүдээс нь салгаж, хоёулаа уул толгодоор гөрөөлж явав. Удалгүй хаан ядарч, газарт хэвтээд, өөртөө хязгааргүй үнэнч хэмээн эргэлзээгүй итгэсэн зарцынхаа өвдөг дээр тэргүүнээ тавьж зүүрмэглэв.

Хан хүү: "Өшөө авах цаг ирлээ" хэмээн бодож,

илдээ хуйнаас нь сугалаад, эзнийхээ хүзүүнд тулгажээ. Энэ мөчид тэрбээр аав нь үхэхийнхээ өмнө хэлсэн гэрээсийг санав. Тэрбээр хааны хүзүү рүү илдээ дүрэх гэж хэдэнтээ завдсан боловч нэг л чадахгүй байлаа. Ийнхүү шийдэж ядах хооронд хаан сэрчихэв. Тэрбээр Каламити хааны хүү хоолойг нь огтлох гэж оролдсон тухай аймшигт зүүд зүүдэлснээ ярив. Хан хүү хааныг барьж аваад, урт удаан хугацааны турш хүсэн хүлээсэн өшөөгөө авах мөч ирлээ хэмээн илдээ далайж, нэрээ хэлжээ. Тэгснээ тэр дорхноо илдээ хаяж, хааны өмнө сөхрөв.

Каламити хаан үхэхийнхээ өмнө хэлсэн үгс Брахмадатта хааны сэтгэл зүрхэнд хүчтэй туссан тул, тэрбээр хүүг нь өршөөжөө. Хан хүү ч гэсэн аавыгаа алсан хааныг өршөөжээ. Тэд эвлэрч, Брахмадатта хаан, хан хүүд улс гүрнийг нь эргүүлж өгөв. Түүнээс хойш тэд он удаан жил эв найртай амьдарчээ.

Каламити хаан үхэйинхээ өмнө хэлсэн үгийг тайлбарлавал: "Удаан эрж хайх хэрэггүй" гэдэг нь "Сэтгэл зүрхэндээ үзэн ядахыг удтал бүү тээ" гэсэн утгатай юм. "Яаран бүү үйлд" гэдэг нь "Эв эвдэхийг бүү яар" гэсэн санаа аж.

Гомдлоор гомдлыг үл тайлна. Түүнийг гагцхүү мартан цайруулж болно.

Энх амгалан, эв найр бүхий бурханы шавь нар энэхүү домгийн сургаалыг хэзээ ч мартаж үл болно.

Зөвхөн бурханы шавь нар төдийгүй эгэл жирийн амьдралд ч гэсэн хүмүүс мартаж үл болно.

II
БУРХАН БАГШИЙН ЕРТӨНЦ

1. Дээр хэлсэнчлэн бурханы олон шавь бурсан хуврагийн дунд хамгийн чухал нь энх амгалан, эв найр бөгөөд, хэрэв тэд Бурхан багшийн сургаалыг дэлгэрүүлэх үүргээ эс мартвал хамт олон нь аажмаар өргөжин тэлж, сургаал дөрвөн зүг найман зовхист түгэн дэлгэрнэ.

Номлол тарж дэлгэрэх нь гэгээрэхийг эрж хүсэгчдийн тоо олширч буйг харуулахаас гадна, одоо болтол энэхүү ертөнцөд ноёрхсоор ирсэн шунал тачаалын чөтгөр шулмаар толгойлуулсан ховдог хомхой сэтгэл, уур хилэн, харанхуй мунхагийн арми ухарч, оюун ухаан, гэрэл гэгээ, итгэл бишрэл, баяр баясгалангийн ноёрхол тогтож буйг илтгэнэ.

Чөтгөр шулмын эзэмшил нутаг нь шунал тачаал, харанхуй мунхаг, хэрүүл маргаан, илд зэвсэг, цус нөж, дайн дажингаар дүүрэн билээ. Түүний эзэмшилд атаа жөтөө, үзэн ядах сэтгэл, Бурхан

хууран мэхлэх, бялдуучлах, нууж далдлах явдал хийгээд элдэв доромжлол ноёрхох бүлгээ.

Гэтэл энэхүү эзэмшилд оюун ухаан гэрэлтэж, энэрэнгүй нигүүлсэнгүйн хур бороо шаагиж, итгэл бишрэл үндэслэн, баяр баясгалангийн цэцэг навч дэлгэрч, чөтгөрийн эзэмшил нь нүд ирмэх зуур Бурхан багшийн ертөнц болон хувирах ажаамуу.

Бүлээхэн салхи, нялх цэцэг навч хавар цаг ирснийг илтгэхтэй адил хүн гэгээрэхдээ өвс ногоо, уул, ус, мод, ер нь юм бүхнийг Бурхан багшийн ертөнц болгон хувиргана.

Учир нь сэтгэл зүрх ариусвал, эргэн тойрны бүх юм ариун нандин болдог.

2. Зөв зүйтэй сургаалыг хүндлэн дээдэлдэг ертөнцөд хүний сэтгэл гэгээн тунгалаг, амгалан тайван болно. Учир нь Бурхан багш хүмүүст үлэмжийн нигүүлсэнгүйг үзүүлж тэднийг ямагт гийгүүлэн хамгаалж, ингэснээр тэдний сэтгэлийн бузар нь арилдаг.

Цаг хугацаа улирахад ариун амгалан сэтгэл нь гүн гүнзгий чанартай, зөв зам мөрийг хөөсөн, өглөг барьж өргөсөн, хууль зарлигийг сахисан, тэвчээр хатуужилтай, хичээнгүй, намуухан, ухаалаг

энэрэнгүй, нигүүлсэнгүй, бололцоотой бүхнийг ашиглан хүмүүсийг зөв зам мөрд хөтөлж оруулсан сэтгэл болдог юм. Тиймээс ч Бурхан багшийн ертөнц бүтэж буй болох юм.

Эхнэр хүүхэдтэй гэр бүл ч гэсэн Бурхан багшийн оршиж буй айл болно. Нийгмийн зайлшгүй ялгаатай улс гүрэн ч гэсэн Бурхан багшийн удирдан чиглүүлсэн ахан дүүгийн сэтгэлийн холбоо барилдлагаатай болно.

Ховдог хомхой сэтгэлдээ баригдаж харанхуй мунхаг болсон хүмүүсийн барьж босгосон ордонд Бурхан багш үл заларна. Шөнийн цагаар дээврийнх нь цоорхойгоор сар гэрэлтдэг эгэл жирийн овоохойд тунгалаг ариун, амгалан сэтгэлтэй хүн сууж байвал тэнд Бурхан багш заларч саатна.

Хэрэв Бурхан багшийн ертөнц нэг ч гэсэн хүний сэтгэлд бүтэж буй болсон байвал тэр хүн нь сүсэг бишрэл нэгтэй хүмүүсийг өөртөө татаж, ахан дүүгийн холбоо тогтооно. Бурхан багшид нэг ч гэсэн хүн итгэвэл тэрхүү итгэл нь гэр бүлд, гэр бүлээс тосгонд, хот суурин газарт, улс оронд, эцэст нь бүх дэлхийд түгэж дэлгэрнэ.

Бурхан багшид итгэх итгэл түгэн дэлгэрэх нь Бурхан багшийн ертөнцийн хил хязгаар өргөжин

тэлнэ гэсэн үг.

3. Энэхүү ертөнц нэг талаас нь харвал чөтгөрийн эрхшээлд орсон бөгөөд энэ бол шунал тачаалын ертөнц, цус урсгасан дайн тулалдааны талбар юм. Энэ хорвоод гэгээрнэ гэж итгэдэг хүн хорвоо ертөнцийг бузартуулж буй цусыг сүү, шунал тачаалыг энэрэнгүй сэтгэл болгоно. Тэрбээр энэхүү ертөнцийг чөтгөрөөс булааж, түүнийг Бурхан багшийн ертөнц болгохоор тэмцдэг.

Их далайн усыг буй чигээр нь шанагаар утган авна гэвээс үлэмж хэцүү бүлгээ. Гэвч Бурхан багшид нэгэнт итгэсэн хүн дахин хэдэнтээ төрсөн ч энэхүү эрхэм ажлыг дуусгах хүсэл эрмэлзэл дүүрэн буй.

Бурхан багш цаад талын эрэг дээр зогсоод хүлээж буй. Цаад талын эрэг нь ховдог хомхой сэтгэл, үзэн ядах явдал, мунхаг ухаан, зовлон зүдүүр зэрэг үгүй гэгээрлийн ертөнц юм. Тэнд л оюуны гэрэл гэгээ тусч, энэрэнгүй, нигүүлсэнгүйн хур бороо орох бүлгээ

Энэ бол зовж зүдэрч, уйдаж гашуудсан, эсвэл энэ хорвоод, Бурхан багшийн сургаалыг номлосоор ядарч сульдсан хүмүүс алжаалаа тайлж, амардаг ертөнц юм.

Энэ бол мөнхийн гэрэл гэгээтэй, мөнхийн амьдрал бүхий, эргээд төөрөлдөж будилдаггүй Бурхан багшийн ертөнц амой.

Бурхан багшийн энэхүү ертөнц, үнэнхүү гэгээрэхийн баяр баясгалангаар дүүрэн, тэнд цэцэгсийн гэрэл нь оюун ухааныг магтан дуулж, жигүүртэн шувууд нь ном сургаалыг сурталчилж байдаг юм. Энэ бол хүний хамгийн сүүлчийн орон гэрээ олох газар бүлгээ.

4. Хэдийгээр энэ нь алжаал тайлах орон боловч, залхуурахад зориулагдаагүй юм. Цэцэгсээр бүтсэн ор дэр нь мөнхийн амгалан нойронд автан унтахад зориулсан бус аа. Энэ бол өөрийн ариун зорилгыг хэрэгжүүлэхийн тулд хүчээ сэлбэхэд зориулагдсан газар юм.

Бурхан багшийн үйл хэзээ ч үл дуусна. Энэ үйл нь хүн, амьтан буй цагт, амьд бүхнии сэтгэл өөрийн ертөнцийг бүтээж буй цагт үл дуусна.

Бурхан багшийн ачаар цаад талын эрэг дээрх ариун ертөнцөд хүрсэн Бурхан багшийн үр хүүхэд энэ ертөнцөд буцан ирж Бурхан багшийн үйлсэд хамтран зүтгэх ёстой.

Нэг галаас тоолж баршгүй олон гал асахтай адил

Бурхан багшийн сэтгэлийн гал хүмүүсийн зүрхэнд үргэлж гал асаан бадраах бөгөөд энэ нь үүрд үргэлжилнэ.

Бурхан багшийн үр хүүхэд энэхүү үйл ажлыг өвлөн авч, хүмүүсийг гэгээрүүлэн Бурхан багшийн ертөнцийг чимэхийн тулд сэтгэлд нь үргэлж гал асаана.

III
БУРХАН БАГШИЙН ЕРТӨНЦИЙН ҮНДЭС СУУРЬ

1. Удаяна хааны хатан Сямавати Бурхан багшид хязгааргүй итгэдэг байлаа. Тэрбээр хааны ордны арын өрөөнүүдэд амьдарч, орндоос хаашаа ч гардаггүй байжээ. Түүний зарц бөгтөр эмэгтэй ер бусын ойтой байсан бөгөөд Бурхан багш сургаалаа номлохыг үргэлж сонсож, дараа нь юу сонссоноо үг алдалгүй эзэгтэйдээ дамжуулдаг байв. Түүнтиы ачаар хааны хатны сүсэг бишрэл улам бэхжиж байлаа.

Эзэн хааны бага хатан атаа жөтөө ихтэй бүлгээ. Тэрбээр их хатныг энэ ертөнцөөс тонилгохыг хүсэж, Удаяна хаанд гүтгэн ховложээ. Уурлаж хилэгнэсэн хаан Сямаватийг хороохоор шийдэв.

Сямавати, хааны өмнө үхэхэд бэлэн дуулгавартайяа зогсчээ. Гэвч хаан энэрэнгүй,

нигүүлсэнгүй сэтгэлтэй хатныг хараад нумаа өргөж, сумаа харваж чадсангүй. Түүний уур хилэн арилж, түүнээс ийнхүү бүдүүлэг загнасныг нь уучлахыг хүсчээ.

Атаа жөтөөнд баригдсан бага хатан уурандаа дэлбэрэх шахаж хааны эзгүй хойгуур, хорон санаатныг илгээж, Сямаватигийн амьдардаг ордны арын өрөөнүүдийг шатаалгажээ. Зарц эмэгтэйчүүд сандран бужигналдсан ч их хатан тэднийг тайвшруулж, Бурхан багшийн зааж номлосны дагуу үл гайхаж, үл айж, үхлийг тайван хүлцэнгүй угтав. Бөгтөр зарц эмэгтэй ч мөн адил галд өртөж амь насаа алджээ.

Бурхан багшийн сургаалыг дагасан хорвоогийн эмэгтэйчүүдээс энэ хоёрт хамгийн дээд зэргийн сайшаал магтаал оногдсон юм. Сямавати хатныг хамгийн энэрэнгүй, бөгтөр зарц эмэгтэйг хамгийн дуулгавартай хэмээмүй.

2. Шагжа омгийн хаан Маханама, Бурхан багшийн үеэл дүү бөгөөд Түүний сургаалд гүнээ итгэсэн хамгийн үнэнч шавь нарын нэг байлаа.

Косалагийн муу санаат хаан Вирудака Шагжа омгийнхон руу дайран довтолж, дайн өдөөж ялжээ. Маханама цайзнаасаа гарч Вирудака хаанаас цайзанд амьдарч буй ард түмнийг нь өршөөхийг гуйжээ. Муу

санаат хаан татгалзахад тэрбээр ядахнаа өөрийг нь цөөрөмд орж, усан доор байх хугацаанд цайзын хаалгыг нээлттэй байлгахыг хүсчээ.

Вирудака хаан, түүнийг усан доор удаж чадахгүй хэмээн бодож, зөвшөөрчээ.

Маханама усан доор оров. Цайзын хаалга нээгдэхэд дотор нь байсан хүмүүс бөөн баяр хөөр болж эрх чөлөө рүү тэмүүлсэн гүйлдэв. Харин Маханама усан доороос гарч ирэхгүй л байлаа. Тэрбээр усан доор үсээ задалж цөөрмийн ёроолд ургасан уд модны үндсэнд зангиджээ. Ийнхүү амь насаа золиосонд гаргаж, ард түмнээ аварчээ.

3. Гэлэнмаа нарын дундаас Утпалаварна хамгийн саруул ухаантай, ухаанаараа Модгальяанатай ч эн зэрэгцдэг байжээ. Тэрбээр олон гэлэнмааг дагуулан номлох бөгөөд тэдний хамгийн сайн удирдагчдын нэг байв.

Дэватта хэмээх нэгэн хорон санаатай, харгис хэрцгий хүн Ажатасатра хааныг ятгаж, Бурхан багшийн сургаалыг эсэргүүцэхийг уриалжээ. Гэвч хаан удалгүй Бурхан багшийн шашинд сүсэглэж, Дэваттагын ятгалгыг хэрэгсэхээ больжээ. Нэг удаа хааны ордонд очтол Дэваттаг оруулсангүй. Тэрбээр яахаа мэдэхгүй ордны гадаа зогстол дотроос нь

Утпалаварна гарч ирэв. Тэрбээр Утпалаварнаг үзмэгцээ уурлан догширч гараа зангидан байдаг хүчээрээ толгой дундуур нь дэлсээд авчээ.

Утпалаварна толгой тархи нь өвдөхийг тэвчиж, хийддээ буцаж очив. Тэрбээр гайхаж, гуньсан шавь гэлэнмаа нарыг тайвшруулж хэлсэн нь: "Эгч дүү нар минь ээ! Хүний амьдралыг урьдаас таахын аргагүй. Хорвоогийн бүх юм хувирч өөрчлөгдөх тул өөрийн мөн чанаргүй. Гагцхүү гэгээрэхийн ертөнц амгалан болоод нам гүм буй. Та нар сэтгэлээ төгс төгөлдөр болгож, гэгээрвээс зохино". Ингэж хэлээд тэрбээр чимээгүй амьсгал хураажээ.

4. Урьд олон хүний амь насыг хөнөөсөн, харгис хэрцгий дээрэмчин Ангулималья хэмээх хүн Бурхан багшийн ачаар аврагдаж, түүний шавь болжээ. Тэрбээр гуйлга гуйхаар хот суурин газар очиход хүмүүс хөөн тууж, урьдын нүглийнх нь төлөө зодож занчдаг байжээ.

Нэг удаа хотод гуйлга гуйж явахад нь урьд өмнө түүнд хорсож гомдсон хүмүүс сайтар занчжээ. Тэрбээр цус нөжөө урсгасаар арайчүү хийддээ хүрч, Бурхан багшийн өлмийд мөргөн, урьд өмнө хийсэн нүглийнх нь хариуд зовж зүдрэх боломж олгосон Бурхан багшид талархаж хэлсэн нь:

Бүхнийг айлдагч багш аа! Намайг төрөхөд "Гэмгүй" гэдэг нэр өгсөн ч би мунхгаасаа болж олон хүний амь хохироосон бүлгээ. Тэгээд хүн бүрийн аль нэг цустай хурууг тасдаж авдаг байсан учир хүмүүс намайг Ангулималья буюу хуруу цуглуулагч гэж нэрлэсэн юм.

Харин одоо Таны нигүүлсэнгүй сэтгэлийн ачаар би гурван эрдэнийн төлөө зүтгэж, гэгээрэх оюун ухааныг оллоо. Морь юм уу, үхрийг зөв тийш залахын тулд ташуур, сур хэрэглэдэг атал Ялж төгс нөгчсөн багш Та бээр ташуур, сур, дэгээний алийг ч хэрэглэлгүй миний сэтгэлийг зассан билээ.

Өнөөдөр би үйлийнхээ үрийг л амслаа. Би бээр нас уртасгах, эсвэл түргэтгэхийн алийг ч үл гуйж, харин миний цаг хэзээ ирэхийг чимээгүй хүлээнэ".

5. Модгальяана, Шарибудари нар Бурхан багшийн шилдэг хоёр шавь бүлгээ. Бурхан багшийн сургаал хүмүүсийн сэтгэлд гол ус лугаа адил урсан орж буйг хараад бурхангүй бөө нар атаархаж, элдвийн саад бэрхшээл учруулахыг оролдож байв.

Тэд ямар ч хэцүү хориг тавьсан, зөв сургаал ямагт түгэн дэлгэрч байсан учраас бөө шүтэгчид Модгальяанаг алж, улмаар Бурхан багшийг гар хөлгүй болгохоор шийджээ.

Модгальяана бээр, бөө нарын нэг, хоёр дайралтаас амь мултарсан ч тэд гуравдах удаа дайрахдаа түүнийг бүслэн барьж аваад хэрцгий зодож занчжээ.

Гэгээрсэн Модгальяана өөрийг нь зодож цохиход амгалан тайван байлаа. Түүний ясыг хугалж, арьс махыг нь хуулан тасдаж, зэрлэгээр тамлан зовоосон боловч, тэрбээр амирлангуй номхон хэвээр амьсгал хураажээ.

АНГУТТАРА НИКАЯ

Хуврагууд аа, энэ ертөнцөд олны тусын тулд, олныг жаргаахын тулд нэгэн хүн мэндэлжээ. Тэрбээр дэлхий ертөнцөд нигүүлсэнгүй сэтгэлийг үзүүлэх, тэнгэрийн амьтад, хүн төрөлхтөнд тусалж, жаргаахын тулд мэндэлсэн юм. Тэр хэн бэ? Энэ бол Тагхагата буюу Түүнчлэн ирсэн, Архат буюу Дайныг дарагч, Ялж төгс нөгчсөн бээр билээ. Хуврагууд аа, энэ бол Тэрбээр юм.

Хуврагууд аа, энэхүү ертөнцөд тэр нэгэн хүн залрах нь хэцүү. Тэр хэн бэ? Энэ бол Татхагата, Архат, Ялж төгс нөгчсөн билээ. Энэ бол Тэрбээр юм.

Хуврагууд аа, энэхүү ертөнцөд ховорхон тохиолдогч хүн бол ер бусын хүн мөн. Тэр хэн бэ? Энэ бол Татхагата, Архат, Ялж төгс нөгчсөн юм.

Хуврагууд аа, нэгэн хүн амьсгаа хураахад цугаараа гуньж гутрав. Тэр хэн бэ? Энэ бол Татхагата, Архат, Ялж төгс нөгчсөн юм. Энэ бол Тэрбээр юм.

Хуврагууд аа, энэхүү ертөнцөд хосгүй хүн мэндэлжээ. Тэр хэн бэ? Энэ бол Татхагата, Архат, Ялж төгс нөгчсөн юм. Энэ бол Тэрбээр юм.

Хуврагууд аа, эл ертөнцөд нэгэн хүн төрөх нь дээд язгуурын мэлмий, дээд язгуурын гэрэл, дээд язгуурын туяа мөн билээ. Тэр хэн бэ? Энэ бол Татхагата Архат, Ялж төгс нөгчсөн юм. Энэ бол Тэрбээр юм. (АНГУТТАРА НИКАЯ 1-13)

"БУРХАН БАГШИЙН СУРГААЛ"-ЫН НОМ ЗҮЙ

Товчлолууд: ДН - Дигха Никая
МН - Маджхима Никая
СН - Самютта Никая
АН - Ангуттара Никая

БУРХАН БАГШ

Хэсэг	*хууд.*	*мөр*	*Эх зохиол*
I бөлөг.			
1	2	1	Элдэв судар
	5	1	АН 3-38, Сукхумала судар
	5	12	МН 3-26, Арияпариесана судар
	5	22	Элдэв судар
	6	20	МН 9-85, Бодихиражакумара
	7	4	Элдэв судар
	7	14	Нипата судар 3-2, Падхана судар
	7	20	Элдэв судар
	8	15	Виная, Махавагга 1
	9	9	ДН 16, Махапариниббана судар
2	10	13	ДН 16, Махапариниббана судар
	11	9	Париниббана судар
	13	11	Париниббана судар
	13	20	ДН 16 Махапариниббана судар

Хэсэг	*хууд.*	*мөр*	*Эх зохиол*
II бөлөг.			
1	15	1	Амитаюр-дхьяна Вмалакирти-нирдеша судрууд
	15	8	Шурамгама судар
	15	14	Вималакирти-нирдеша болон Махапаринирвана судрууд
	16	7	Саддхармапундарика судар 16
	17	4	Махаяна-жатака-читтабхуми-парикша судар
	17	15	Махапаринирвана судар
2	19	8	Саддхармапундарика судар 3
	20	12	Саддхармапундарика судар 4
	22	7	Саддхармапундарика судар 5
3	23	14	Саддхармапундарика судар 16
III бөлөг.			
1	26	1	Аватамсака судар 5
	27	1	Махапаринирвана судар
	27	9	Аватамсака судар
	27	19	Суварнапрабхасоттамаража ар 3
2	30	11	Аватамсака судар
	30	20	Аватамсака судар 34, Гандавьюха
	31	2	Бага Сукхавативьюха судар
	31	9	Аватамска судар
	31	17	CH35-5
	31	21	Махапаринирвана судар

Хэсэг	*хууд.*	*мөр*	*Эх зохиол*
3	33	21	МН 8-77, Махасакулудайн судар
	34	25	Махапаринирвана судар
	35	12	Ланкаватара судар
	35	23	Аватамсака судар
	36	19	Саддхармапундарика судар 25
	36	24	Махапаринирвана судар
	37	17	Саддхармапундарика судар 2
	37	24	Саддхармапундарика судар 3

ДХАРМА БУЮУ НОМ

I бөлөг.			
1	42	1	Виная, Махавагга 1-6 болонөсн 5611-12 Дхаммачакраправартана судар
	43	11	Итивуттака судар 103
	43	20	МН 2, Саббасава судар
	44	3	42 бөлөг бүхий судар 18
	44	17	Шрималадэвисимханада судар
3	46	16	Аватамсака судар 22, Дашабхумика
II бөлөг.			
1	50	1	МН 4-35, Чуласаччака судар
	52	13	АН 5-49, Ража-мунда судар
	53	1	АН 4-185, Самана судар
	53	9	АН 3-134, Уппада судар

Хэсэг	*хууд.*	*мөр*	*Эх зохиол*
2	53	15	Ланкаватара судар
	53	20	Аватамсака судар 2
	54	9	Аватамсака судар 16
	55	1	Аватамсака судар 22, Дашабхумика
	55	5	Ланкаватара судар
	55	14	АН 4-186, Уммага судар
	55	18	Дхаммапада 1, 2, 17, 18
	56	6	СН 2-1-6, Камада судар
3	56	18	Аватамсака судар 16
	57	4	Ланкаватара судар
	57	21	МН 3-22, Алагаддупама судар
	58	15	Ланкаватара судар
	58	19	Ланкаватара судар
4	61	19	Виная, Махавагга 1-6
	62	11	Ланкаватара судар
	62	19	СН 35-200, Дарукхандха судар
	63	2	Ланкаватара болон бусад судар
	63	17	МН 2-18, Мадхупиндика судар
	63	11	Ланкаватара судар
	65	1	Ланкаватара судар
	65	20	Вималакирти-нирдеша судар
	67	23	Аватамсака судар 34, Гандавьюха
	68	7	Ланкаватара болон бусад судар

Хэсэг	*хууд.*	*мөр*	*Эх зохиол*
III бөлөг.			
1	70	1	Виная, Махавагга 1-5
	71	1	Виная, Чулавагга 5-21
	71	8	Шурамгама судар
2	76	13	Шурамгама судар
	78	14	Махапаринирвана судар
	78	23	Саддхармапундарика судар 7 болон Шурамгама судар
	79	13	Аватамсака судар 32
	79	18	Махапаринирвана судар
	79	24	Брахмажала судар
	80	12	Махапаринирвана судар
3	81	12	Махапаринирвана судар
IV бөлөг.			
1	87	1	Шрималадевисимханада судар
	88	3	АН 2-11
	88	11	Итивуттака 93
	88	19	Виная, Махавагга
	89	5	АН 3-68, Аннатиттхика судар
	89	19	АН 3-34, Алавака судар
	90	12	Вайпилья судар
	90	19	Виная, Махавагга 1-6, Дхаммачакраправартана судар
	90	22	МН 2-14, Чуладукхандха судар
	91	13	Махапаринирвана судар
	92	16	Итивуттака 24
2	94	13	МН 6-51, Кандарака суттанта

Хэсэг	*хууд.*	*мөр*	*Эх зохиол*
	95	9	АН 3-130
	96	4	АН 3113
3	96	17	Итивуттака 100
	97	10	парабль судар
	98	11	Махапаринирвана судар
	99	23	АН 3-62
	100	15	АН 3-35, Девадута судар
	101	16	Тхеригатха Аттхакатха
4	102	22	Сукхавативьюха судар, II боть
V бөлөг.			
1	110	1	Сукхавативьюха судар, I боть
	113	19	Сукхавативьюха судар, II боть
	115	7	Амитаюр-дхьяна судар
2	118	13	Бага Сукхавативьюха судар

ТӨГС ТӨГӨЛДӨР ЧАНАРЫГ ЗОРИМУЙ

I бөлөг.			
1	124	1	МН 2, Саббасава судар
	125	20	МН 3-26, Арияпариесана судар
	126	9	СН 35-206, Чхапана судар
	127	10	42 бөлөг бүхий судар 41-2
	129	22	МН 2-19, Дведхавитакка судар
	130	18	Дхаммапада Аттхакатха
2	131	19	АН 3-117
	132	8	МН 3-21, Какачупама судар

Хэсэг	*хууд.*	*мөр*	*Эх зохиол*
	135	10	МН 3-23, Ваммика судар
	137	4	Жатака 1У-497, Матанга-жатака
	141	5	42 бөлөг бүхий судар 9
	141	14	42 бөлөг бүхий судар 11
	142	7	42 бөлөг бүхий судар 13
	143	4	АН 2-4, Самачитта судар
3	143	21	Самьюктаратнапитака судар
	149	17	хандред фабль судар
	153	9	пражнапарамита судрын дуртгал
	155	7	Махапаринирвана судар
	156	7	Самьюктаратнапитака судар

II бөлөг.

1	161	1	МН 7-63, Чуламалункья-суттанта
	163	6	МН 3-29, Махасаропама судар
	164	16	Махамая судар
	165	3	Тхерагатха Аттхакатха
	167	8	МН 3-28, Махахаттхипадопамасудар
	168	1	Махапаринирвана судар
	168	10	Аваданашатака судар
	169	21	Махапаринирвана судар
	172	9	Панчавимшати-сахасрикапраж-няпарамита судар

Хэсэг	*хууд.*	*мөр*	*Эх зохиол*
	173	6	Аватамсака судар 34, Гандавьюха
2	175	4	АН 3-88
	176	3	АН 3-81
	176	10	АН 3-82
	177	4	Париниббана судар, II боть
	178	2	МН 14-141, Саччавибханга судар
	179	7	Париниббана судар, II боть
	180	6	АН 5-16, Вала судар
	180	13	Аватамсака судар 6
	181	22	Махапаринирвана судар
	182	7	Самьюктаратнапитака судар
	183	1	Суварнапрабхаса судар 26
	183	20	Махапаринирвана судар
	184	22	Тхерагатха Аттхакатха
	185	16	Жатака 55, Панчавудха-жатака
	186	22	Итивуттака 39, 40
	187	11	Махапаринирвана судар
	187	15	Махапаринирвана судар
	187	20	АН 5-12
	187	23	Париниббана судар
	188	13	Шурамгама судар
3	189	15	СН 55-21, 22 болон Маханама судар
	190	11	АН 5-32, Чунди судар
	190	18	Вималакирти-нирдеша судар
	191	10	Шурамгама судар

Хэсэг	*хууд.*	*мөр*	*Эх зохиол*
	191	18	Сукхавативьюха судар, II боть
	192	5	СН 1-4-6
	192	8	Аватамсака судар 33
	193	4	Аватамсака судар 24
	193	15	Суварнапрабхаса судар 4
	194	1	Амитаюр-дхьяна судар
	194	4	Сукхавативьюха судар
	194	8	Махапаринирвана судар
	195	6	МН 2-16, Четохила судар
	196	7	Сукхаватиьюха судар, II боть 4
4	197	1	Дхаммапада
	205	4	СН 1-4-6
	205	19	АН
	205	23	Махапаринирвана судар

АХАН ДҮҮСИЙН БАРИЛДЛАГА

I бөлөг.

1	208	1	Итивуттака 100 болон МН 1-3, Дхаммадаяда судар
	208	5	Итивуттака 92
	208	16	Виная, Махавагга 1-30
	209	17	М 4-39, Маха-асапура судар
	210	23	МН 4-40 Чула-ассапура судар
	211	18	Саддхармапундарика судар 19
	212	1	Саддхармапундарика судар 19
	212	12	Саддхармапундарика судар 14

Хэсэг	*хууд.*	*мөр*	*Эх зохиол*
2	213	23	СН 55-37, Маханама судар
	214	11	АН 3-75
	214	20	СН 55-37, Маханама судар
	215	1	СН 55-54, Гилаянам судар
	215	7	Аватамсака судар 22
	216	20	Махапаринирвана судар
	219	17	Аватамсака судар 7
	222	16	Махамая судар
	223	16	Аватамсака судар 21
	224	15	Махапаринирвана судар
3	226	1	ДН 31, Сингаловада судар
	231	4	АН 2-4, Самачитта судар
	231	20	АН 3-31
	232	3	Жатака 417, Каччани-жатака
	234	1	ДН 31, Сингаловада судар
	234	11	Дхаммапада Аттхакатха 1
2	235	16	АН 4-197
	236	11	АН 5-333, Уггаха судар
II бөлөг.			
1	239	1	Махапаринирвана судар
	241	1	АН 3-118, Сочейан судар
	242	14	СН
	243	12	Виная, Махавагга 10-1 болон 2
	243	23	ДН 16, Махапариниббана судар
	245	14	Виная, Махавагга 10 1 болон 2
2	248	8	СН
	249	8	Чуинкио судар

Хэсэг	*хууд.*	*мөр*	*Эх зохиол*
	249	14	Вималакирти-нирдеша судар
	251	2	Махапаринирвана судар
	252	1	Бага сукхавативьюха судар
	252	10	Сукхавативьюпха судар
	252	23	Вималакирти-Нирдеша судар
3	253	11	Дхаммапада Аттхакатха 1
	253	20	АН 34-2
	254	19	Дхаммапада Аттхакатха
	255	13	АН 5-1
	255	18	Сарвастивада-сангхаведакавасту10
	256	13	МН 9-86, Ангулимала судар
	256	16	АН 26

ХАВСРАЛТ

БУРХАНЫ ШАШНЫ ТОВЧ ТҮҮХ

- Энэтхэгээс Япондуламжласан нь -

1. ЭНЭТХЭГ

Төв Энэтхэгт "Азийн гэрэл гэгээ" гийж бадарсан нь хүн төрөлхтний оюуны амьдралд тохиолдсон нэгэн агуу бөгөөд эрин үеийн ач холбогдол бүхий үйл явдал болсон юм. Өөрөөр хэлбэл, олон зууны турш эдүгээ хүртэл азийнхны сэтгэлийг тэтгэсээр буй Агуу их оюун ухаан, Энэрэнгүй, Нигүүлсэнгүй сэтгэлийн булаг ундарсан нь тэр бүлгээ.

Хожим нь Бурхан багшийн сургаалыг дагагчдын Шагжамуни буюу "Шагжа омгийн Чадагчийн эрхт" хэмээн өргөмжилсөн Бурхан Гаутама, гэр орноо орхин явж, бадар барьж, лам болж, өмнө зүгийн Магадха хэмээх газар бодь модны дор гэгээрсэн юм. Энэ их ёслол манай эриний өмнөх тавдугаар зууны дунд орчим болсон хэмээн үздэг билээ. Түүнээс янагш тэрбээр "Агуу их Үхэл" хүртлээ буюу Нирванд ортлоо 45 жилийн турш Оюун ухаан, Энэрэнгүй, Нигүүлсэнгүй сэтгэлийн тухай сургаалаа уйгагүй номлосон юм. Улмаар Төв Энэтхэгийн янз бүрийн улс гүрэн, овог аймагт энэхүү шашин шүтлэгийн их үндэс суурь тавигдсан бүлгээ.

Маурья удмын гуравдахь хаан Ашока буюу Гаслангүй хааны үед (МЭӨ 268-232 онуудад захирч байжээ) Бурхан Гаутамагийн сургаал зарлиг түгэн дэлгэрч, тэр ч байтугай хилийн чанадад тархаж эхэлсэн аж.

Маурьягийнхан нь Энэтхэг орныг нэгтгэсэн анхны удам бүлгээ. Энэ удмын анхны хаан Чандрагуптын үед (МЭӨ 317-293 онуудад захирч байсан аж) Маурья удмын эзэмшил нутаг хойгуураа Хималайн уулс, зүүн талдаа Бенгалийн булан,

баруугаараа Гинду Кушийн уулс, урдуураа Виндхьягийн уулстай хил залгаж байлаа. Ашока хаан Калинга хэмээх өмнөд зүгийн орныг улс гүрэндээ нийлүүлж, улс нь Декканы уулс хүртэл тэлсэн аж.

Энэ хаан харгис хатуугаараа алдаршиж хүмүүс түүнийг Чандашока буюу "Аймшигт Ашока" хэмээн нэрлэжээ. Гэвч Калинга улсыг байлдан дагуулж байхдаа цэргүүдийнхээ устгаж эвдсэн бүхнийг хараад зан ааш нь эрс өөрчлөгдөж, тэрбээр Оюун ухаан, Энэрэнгүй, Нигүүлсэнгүй сэтгэлийн сургаалыг үнэн сэтгэлээсээ шүтэн биширдэг болжээ. Түүнээс хойш Бурхан багшийн сургаалыг даган мөрддөг хүний хувьд олон сайн үйлийг бүтээснээс, хамгийн томоохон нь дараах хоёр үйл байлаа.

Эхнийх нь, "Ашокийн бичээс" юм. Тэрбээр эзэмшил нутагтаа газар сайгүй чулуун хөшөө босгож, түүн дээр энэхүү улс орны хаан Бурхан багшийн сургаалын дагуу улсаа захирч буйг сийлжээ. Ийм утгатай үгсийг өнгөлсөн хад асган дээр мөн адил сийлсэн байв. Хоёрдахь нь, тэрбээр Энэтхэг орон даяар Бурхан багшийн Оюун ухаан, Энэрэнгүй, Нигүүлсэнгүй сэтгэлийн сургаалыг түгээн дэлгэрүүлсэнд оршино. Түүнээс гадна тэрбээр энэхүү сургаалыг түгээн дэлгэрүүлэхээр элч нараа гадаадын олон оронд илгээжээ. Элч нараа Сири, Египет, Кирен, Македон, Эпир зэрэг алс холын орнуудад явуулсныг онцгой анхаарвал зохино. Тэд Бурхан багшийн сургаалыг алс холын баруун зүгт түгээн дэлгэрүүлжээ. Түүгээр ч зогсохгүй Тамрапарни буюу Шри-Ланкад очсон Махендра элч" үзэсгэлэнтэй сайхан сургаалыг үзэсгэлэнтэй сайхан Ланкадвипа арал дээр сайтар үндэслүүлсэн" байна. Ийнхүү урд зүгийн улс орнуудад ариун сургаалыг сурталчлах үндэс тавигджээ.

2. МАХАЯНА БУЮУ ИХ ХӨЛӨГНИЙ ШАШИН ҮҮССЭН НЬ

Арай сүүлийн үеийн бурханы шашинтнууд "Бурханы сургаал дорнод зүг рүү түгсэн" гэж өгүүлэх нь олонтаа. Гэвч манай эриний өмнө бурханы сургаал өрнө зүг рүү хандаж байсан нь тодорхой. Энэхүү сургаал дорно зүг рүү манай эриний эхэнд хандаж эхэлсэн юм. Гэвч эхлээд бурханы шашинд гарсан нэгэн томоохон өөрчлөлтийн тухай хэлэх хэрэгтэй. Энэ нь "Махаяна" буюу "Их хөлөгний шашин" хэмээх "шинэ давалгаа" үүсэнд оршино. Улмаар "Махаяна" бурханы шашинд улам хүчтэй тодорч, улам хүчтэй байр суурьтай болсон юм.

Энэхүү "шинэ давалгаа" хэзээ буй болов? Хэрхэн бий болов? Хэн түүнийг үүсгэв? Энэ тухай хэн ч тодорхой хэлж чадахгүй билээ. Бидний баттай өгүүлж чадах нь: нэгдүгээрт, түүнийг тухайн үеийн тэргүүний лам хувраг нар бурханы сургаалын эхний үеийн Махасамгхикийн дэгийн үндсэн дээр бүтээсэн юм. Хоёрдугаарт, манай эриний өмнөх хоёр, нэгдүгээр зуун, мөн манай эриний нэгдүгээр зуун гэхэд Махаянагийн хамгийн чухал судар ном буй болсон байлаа. Нагаржуна эдгээр ном судрын үндсэн дээр гүн ухааны идэвхтэй үйл ажиллагаагаа явуулж эхлэхэд Махаяна нь бурханы шашны түүхийн тавцан дээр тодрон гарч ирсэн билээ.

Бурханы шашны түүхийн урт хугацаанд Махаяна ихээхэн чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Хятад, Японд бурханы шашин түүхийнхээ бүхий л хугацааны турш энэхүү чиглэлийн нөлөөн дор хөгжсөөр ирсэн билээ. Үүнд Ч гайхах юм үгүй. Учир нь Махаяна ард түмний хэрхэн аврагдахын шинэ зам

зорилтыг дэвшүүлсэн юм. Үүнийг хэрэгжүүлэхээр бодьсад нар хэмээх ариун явдалт шинэ хүмүүсийг дэвшүүлж гаргасан билээ. Түүгээр ч зогсохгүй тэднийг дэмжихийн тулд Махаянагийн сэтгэгчид метафизик, сэтгэл зүйн салбарт оюун ухааны томоохон ололт амжилт гаргасан юм. Үүний үр дүнд бурхан Гаутамагийн залгамж халааг үргэлжлүүлсэн Махаяна нь Оюун ухаан, Нигүүлсэнгүй сэтгэлийн сургаалд олон шинэ шинж чанарыг оруулжээ. Махаянагийн ачаар бурханы шашин илүү дайчин, илүү чин сэтгэлийн болжээ. Их устай мөрөн лүгээ адил энэхүү сургаал дорнын улс орныг тэтгэж эхлэв.

3. ТӨВ АЗИ

Хятадууд анх Төв Азиар дамжин бурханы шашинтай танилцжээ. Тиймээс бурханы шашны Энэтхэгээс Хятадад ирсэн зам мөрийн тухай ярихдаа юуны өмнө торгон замыг дурьдах ёстой. Анх манай эриний өмнөх II зууны эцэст, Хятадын Хан улсын эзэн хаан У-дигийн хаанчлалын үед (МЭӨ 140-87 онуудад захирч байв) эл замыг Төв Азийн говь цөлийг дамжин Өрнө, Дорныг холбосон худалдааны зам гэж нээжээ. Тэр үед Хятадын нутаг дэвсгэр баруун зүгт нилээн сунасан байлаа. Хятадын хөрш зэргэлдээ оршиж байсан Фергана, Согд, Тохара, Парфи зэрэг оронд бүр Македоны Александрын үед үүсч тогтсон арилжаа наймааны уур амьсгал хэвээр байжээ. Эдгээр орны нутаг дэвсгэрийг дайрч өнгөрөх худалдааны замд хамгийн чухал бараа таваар бол хятадын торго хэмээн тооцдог байжээ. Тиймээс ч Торгон зам хэмээн нэрлэсэн аж. Энэтхэг, Хятадын хооронд голдуу бурханы шашны салбарт эхэлсэн соёлын харилцаа мөн адил энэхүү худалдааны замын ачаар тодорхой үйл хэрэг болж

байлаа. Тийм учраас бурханы шашны ирсэн зам нь Торгон зам юм.

4. ХЯТАД

Хятадад бурханы шашны түүх, бурханы шашны ном судартай болж, тэдгээрийг орчуулснаар эхэлнэ. Эрт дээр үеэс эхлэн, анх сүүлийн Хан улсын эзэн хаан Мин-дигийн үед буюу Юнпины үед (МЭ 58-76 онууд) Касяпаматанга болон бусад лам хувраг "Ссу-ших-ер-чан-чин" (42 бөлөгтэй судар) судрыг авчран орчуулснаар эхэлсэн гэж үздэг билээ. Гэвч орчин үеийн эрдэмтдийн үзэж байгаагаар энэ нь эргэлзээтэй домог аж. Тэд анх Ань Ши-Гао, Лоянд байхдаа (МЭ 148-171 онуудад) энэ судрыг авчирч орчуулсан гэдгийг баталжээ. Түүнээс хойш Хойд Сүн улсын эзэн хаадын үе хүртэл <МЭ 960-1129 онууд) нэг мянган жилийн турш бурханы шашны ном судрыг орчуулах ажил үргэлжилжээ.

Эхний үед голдуу Төв Азийн лам хуврагууд Хятадад ном судар авчирч, тэдгээрийг хятад хэлээр орчуулахад голлох үүрэг гүйцэтгэж байв. Тухайлбал, Ань Ши-Гао Хятадад Парфи улсаас ирсэн байна. Ш зуунд Лоянд ирж, "Сукхавативьюха" нэрт судрыг орчуулсан Кан Сэн-Кай Самаркандаас ирсэн байв "Богдсын ном цагаан лянхуа" судрын орчуулагч хэмээн алдаршсан Чу Фа-Ху буюу Дармарагша нь Тохараас ирж, Лоян, Чанъаньд Ш зууны СҮҮЛ, IҮ зууны эхэнд амьдарч байв. Ү зууны эхэнд Кумаражива Кучээс залран ирсний дараа бурханы шашны ном судрыг орчуулах ажил Хятадад оргилдоо хүрчээ.

Ойролцоогоор чухамхүү энэ үеэс эхлэн Хятадын лам хуврагууд самгарьд хэл сурахаар Энэтхэгт очих болов. Анх Энэтхэгт хүрсэн лам гэвэл Фа-сянь хуушаан (339-420?)

байлаа. Тэрбээр 399 онд Чанъаниас Энэтхэг рүү явж, 15 жилийн дараа буцаж иржээ. Тэдний дундаас хамгийн их алдаршсан нь Сюань-зуан (602-664) байсан юм. Тэрбээр 627 онд Энэтхэгт очиж, 645 онд буюу 19 жилийн дараа Хятадад буцаж ирсэн аж. И-уин (635-713) 671 онд Энэтхэг рүү далайгаар явж, 25 жилийн дараа Хятадад мөн адил далайгаар буцаж ирсэн аж.

Тэд, Энэтхэгт самгарьд хэл сурч, шилж сонгосон ном судраа аваад Хятадад буцаж ирдэг байсан бөгөөд тэдгээрийг хятад хэлээр орчуулахад өөрсдөө гол үүрэг гүйцэтгэдэг байв. Сюань-зуан хэлний онцгой авъяастайгаа харуулсан юм. Түүний уйгагүй үйл ажиллагааны ачаар бурханы шашны ном судрыг орчуулах ажил Хятадад бас нэг оргилдоо хүрчээ. Эрдэмтэд, Сюань-зуанаас өмнө Кумаражива болон бусад лам нарын хийсэн орчуулгыг "Хуучин орчуулга", харин Сюань-зуанаас хойш хийсэн орчуулгыг "Шинэ орчуулга" хэмээн тус тус ялгаж нэрлэдэг бүлгээ.

Энэхүү бурханы шашны баялаг орчуулгын ном судар дээр тулгуурласан хятадын лам хувраг нарын гүн ухаан, шашны үйл ажиллагаанд аажим аажмаар хятаджих чиг хандлага тодорч эхэлсэн юм. Энэ нь Хятадын үндэсний зан чанар, хятад үндэстний хэрэгцээ шаардлага болон түүний өөртөө итгэх итгэл бат бэх байсны тод илрэл юм. Үүнийг эхний үед хятадын лам хувраг нар Пражнягийн сударт өгүүлдэг "Хоосон чанар"-ын онолын метафизикийг ихэд анхааран сонирхож байсан тухай баримт гэрчилнэ. Удалгүй тэд, Хинаяна буюу Бага хөлөгний шашнаас татгалзаж гагцхүү Махаяна буюу Их хөлөгний шашныг сонирхож эхэлсэн баримт ч гэрчилнэ. Энэхүү чиг хандлага Тяньтай дэгт (Япон нэр нь Тэндай) тод томруун илэрч, Чань дэгт (Япон нэр нь Зэн) цэцэглэн хөгжсөн юм.

Хятадад Тяньтай дэг VI зууны хоёрдугаар хагаст, Агуу их Тяньтай багш (Япон нэр нь Тэндай Дайси) хэмээн алдаршсан Ш тэргүүн хамба Жи-и (538-597)-гийн үед бүрэлдэн тогтсон юм. Тэрбээр, Хятадын бурханы шашны гүн ухааны хамгийн гарамгай зүтгэлтний нэг байсан юм. Бурхан багшийн сургаалыг таван үе, найман номлолд хуваасан түүний ангилал урт удаан хугацааны турш Хятадаар зогсохгүй Японд ч гэсэн бурханы шашин хөгжихөд хүчтэй нөлөөлж байлаа.

Чухамхүү хэзээ үүссэнээс нь үл хамааран ном судрыг Хятадад авчирмагцаа шууд хятад хэлээр орчуулж байв. Бурханы шашны ном судрын баялаг нөөц хуримталсны дараа эдгээр судрын үүсэл, гарал, үнэ цэнийг шинээр ухааран тогтоох шаардлага урган гарсан юм. Бурханы шашныг бүхэлд нь ухаарсан өөрсдийн үзлийг тусгаж, тэдгээрийг боловсруулан гаргах, эдгээр үзлийн үндэслэл бүхий тайлбар сэлтийг тодорхойлох шаардлага гарч ирэв. Ийнхүү Жи-и болон бурханы шашны бусад сэтгэгчдийн ангилал буй болж, эдгээр нь юуны түрүүн хятадын гүн ухааны үзэл бодлын хөгжлийн үр дүн болсон юм. Тэдгээрээс Жи-и-гийн ангилал хамгийн эмх цэгцтэй, хамгийн итгэл үнэмшилтэй нь болсон аж. Гэвч бурханы шашны орчин үеийн судалгаа эхлэхэд энэхүү ангилал нь ноёлох нөлөөгөө алджээ.

Хятадын бурханы шашны түүхэнд Чань дэг нь (Япон нэр нь Зэн)"сүүлчийн ололт амжилт" болсон юм. Түүнийг хилийн чанадаас ирсэн номч мэргэн Бодидарма (-528) үүсгэсэн билээ. Бодидармагийн суулгасан үр гагцхүү зургадугаар тэргүүн хамба Хуэй-нэн (638-713) -ий дараа үзэсгэлэнт сайхан цэцэг лүгээ адил дэлгэрсэн юм. VIII зууны дараа энэхүү дэгээс дэлхийд гайхуулсан суут зүтгэлтнүүд тэд нарын үйл ажиллагааны ачаар эл дэг хэдэн зууны турш цэцэглэж байлаа.

Бурханы шашны үзэл бодол шинээр хегжсөн нь хятадын

ард түмний үндэсний зан чанартай гүн гүнзгий холбоотой гэж болно. Энэ нь үнэн хэрэгтээ хятадын гүн ухааны санаа бодлоор тодотгосон бурханы шашин байлаа. Бурхан Гаутамагийн сургаалын гол мөрөнд шинэ урсгал цутгахад улам их устай болж, Хятадаас дорно зүгт байсан улс орныг шимт урсгалаараа тэтгэж эхэлсэн юм.

5. ЯПОН

Японы бурханы шашны түүх VI зуунаас эхэлдэг. 538 онд Пэкчэ улсын хаан, японы эзэн хаан Киммэйд элчээ Бурхан багшийн цутгамал баримал, бурханы шашны ном судар зэрэг бэлэгтэйгээр илгээжээ. Ингэж бурханы шашин Японд залран иржээ. Түүнээс хойш бурханы шашин Япон улсад даруй 1400 гаруй жил хөгжиж байна.

Бурханы шашны энэхүү урт удаан хугацааны түүхэнд хамгийн чухал гурван үеийг тэмдэглүүштэй.

Эхний үе нь VII, VIII зуун буюу Хоорю-жи сүм(607) барихаас эхлэн Тодай-жи сүм(752) барих хүртэл үеийг хамарна. Энэ үеийг тодорхойлохдоо Азийг тэр аяар нь хамарсан соёлын ер бусын хөгжил дэвшлийн давалгааг анзаарахгүй байж болохгүй. Тэр цагт өрнийн соёл иргэншил харанхуй бүдүүлэг, харин дорнынх нь идэвхтэй хөгжин өргөжиж байлаа. Хятад, Төв Ази,Энэтхэг болон бусад урд зүгийн орнуудад оюун ухаан, шашин шүтлэг, урлаг уран сайхны үйл ажиллагаа идэвхтэй өрнөж байсан юм. Бурханы шашин, хүний үйл ажиллагааны энэхүү олон төрлийг нэгтгэж, хүмүүнлэг үзлийн хүчит давалгаа болон Дорнын ертөнцийг ариун усаараа угааж эхэлсэн юм. Тэр үеийн Японы соёлын хөгжил нь үзэсгэлэн төгөлдөр Хоорю-жи сүм, сүрлэг агуу

Тодай-жи сүмийг барьж бүтээснээр болон энэ хоёр сүмийг тойрон өрнөсөн олон талт шашны болон урлаг, уран сайхны үйл ажиллагаагаар илэрсэн юм. Эл хөгжил дэвшил бүх Азийг хамарч эцэст нь түүний хамгийн зүүн хязгаарт хүрсэн соёлын агуу их давалгааны нөлөөн дор өрнөснийг хэлэх нь зүйтэй.

Эдүгээ хүртэл соёл иргэншлээс хол хөндий явсан Японд соёл нүд ирмэх зуур дэлгэрэн цэцэглэв. Чухамхүү бурханы шашин тэр үед олон улсын соёл түгээгч болж байлаа. Улмаар бурханы шашны сүм хийд олон улсын соёл иргэншлийн төв, лам хувраг нь шинэ, дэвшилт үзэл бодлыг дамжуулан түгээгч наран болж байлаа. Үзэл бодлыг хамгийн сайн агуулах зүйл нь ном судар байжээ. Тэд гагцхүү шашнаар зогсохгүй илүү өргөн цар хүрээтэй агуу чанартай соёлыг багтааж байв. Бурханы шашин Японд дэлгэрч эхэлмэгц гүйцэтгэсэн үүргийн үнэн зөв түүх ийм юм.

Удалгүй IX зуунд Сайчо (767-822), Кукай (774-835) хэмээх бурханы шашны хоёр томоохон зүтгэлтэн гарч иржээ. Тэд, Японы бурханы шашны анхны хоёр дэгийн суурийг тавьсан юм. Тэр үеийн бурханы шашныг Хэйаны дэгийн бурханы шашин хэмээнэ. Тэр үед бурханы шашныг юу ч хийдэггүй язгуууртнууд сонирхдог зүйл хэмээн үзэх чиг хандлага байв. Гэвч энэ хоёр зүтгэлтэн, бурханы шашны мөн чанар, сэтгэлээ төгс төгөлдөр болгоход оршино хэмээн үзэж байсан учир үйл ажиллагаагаа хот суурин газраас уул хаданд шилжүүлж, тэнд сэтгэлээ төгс төгөлдөр болгох тусгай ариун шүтээн босгосон аж. Түүнээс хойш 300 гаруй жилийн турш тэд нарын Тэндай, Шингон дэгүүд голдуу эзэн хааны ордонд, язгууртнуудын дунд цэцэглэн дэлгэрч байлаа.

Хоёрдахь үе XII, XIII зууныг хамарна. Энэ үед Хоонэн (1133-1212), Шинран (1173-1262), Догэн (1200-1253),

Ничирэн (1222-1282) зэрэг японы бурханы шашны гарамгай зүтгэлтнүүд идэвхтэй үйл ажиллагаа өрнүүлсэн юм. Өнөөдөр Японд бурханы шашин дэлгэрсэн түүхийг өгүүлэхдээ бид эдгээр хүмүүсийн нэрийг дурьдахгүй өнгөрч хэрхэвч болохгүй. Гэвч ямар учраас чухамхүү энэ үе бурханы шашны олон гарамгай зүтгэлтнийг Япон улсад төрүүлсэн бэ? гэвэл энэ нь нэгдүгээрт, тэдний өмнө нэгдсэн зорилт байснаар тайлбарлагдана. Ямар зорилт вэ? гэвэл бурханы шашныг япон маягаар ухааран эзэмших явдал байлаа.

Бурханы шашин Японд бүр эрт нэвтэрсэн юм шүү ГЭЖ бидний хэлснийг эсэргүүцэж болох юм. Түүхэн баримтын хувьд энэ нь үнэн билээ. Гэвч аливаа улсын ард түмэн нэгэн соёлыг хүлээн авч, түүнийг боловсруулж, түүнд дасч, өөрийн болгоход хэд хэдэн зуун шаардагдана. Өөрөөр хэлбэл 7-8 дугаар зуунд Японы хүлээн авсан шашин 12, 13 дугаар зуунд сая цэцэглэсэн билээ. Энэ нь бурханы шашны зүтгэлтнүүдийн нөр их хөдөлмөрийн үр дүн юм.

Түүнээс хойш Японы бурханы шашин эдгээр гарамгай зүтгэлтний тавьсан суурин дээр хөгжсөн билээ. Улмаар тэр чигээрээ бидэнтэй учран золгож байгаа юм. Өөрөөр хэлбэл, түүнээс хойш Японы бурханы шашны түүхэнд үүнтэй адил дэвшил хөгжил өрнөөгүй билээ. Гэвч бидний бодож байгаагаар дараа нь японы бурханы шашны түүхэнд анхаарал татсан үйл явдал тохиолдсон юм. Энэ бол эртний бурханы шашны судлалд орчин үеийн эрдэмтдийн гаргасан ололтууд юм.

Японд бурханы шашин анх нэвтрэн орж ирснээсээ эхлэн хятадын бурханы шашны нөлөөн дор байсан юм. Энэ нь дан ганц Их хөлөгний сургаал байсан гэсэн үг. Ялангуяа 12, 13 дугаар зууны суут зүтгэлтнүүдийн дараа бүх дэг Махаяна буюу Их хөлөгний шашныг өвлөсөн юм. Ийм нөхцөлд

эртний бурханы шашны судалгаа Мэйжигийн эрин үеийн дундаас хойш буюу өнгөрсөн зууны эцэст эхэлсэн юм. Эдгээр судалгааны ачаар янз янзын дэгийг үүсгэгчдээс гадна юуны түрүүн бурханы шашны үндэслэгч буйг мартсан хүмүүсийн өмнө Бурхан Гаутамагийн яруу тод гэрэлт дүр тодорсон билээ. Махаянагаас өөр юу ч мэддэггүй байсан хүмүүсийн өмнө Бурхан багшийн эмх цэгцтэй сургаал тэр чигээрээ тодорсон юм. Эдгээр судалгаа одоохондоо цэвэр эрдэм шинжилгээний шинж чанартай, бурханы шашныг цоо шинээр өрнүүлэн хөгжүүлээгүй боловч бурханы шашны тухай японюудын мэдлэгийг шинэчлэн баяжуулахад томоохон үүрэг гүйцэтгэж байгаа бүлгээ. Бидний үзэж байгаагаагаар энэ нь Японы бурханы шашны хөгжлийн түүхэнд гуравдахь чухал үе нь юм.

БУРХАН БАГШИЙН СУРГААЛ УЛАМЖИЛЖ ИРСЭН ТҮҮХ

Бурханы шашин нь Шагжамунийн 45 жилийн турш номлосон сургаал зарлигийн үндсэн дээр бүтсэн шашин юм. Тиймээс Шагжамунийн айлдварууд бурханы шашинд маргашгүй нэр хүндтэй байдаг бүлгээ. Хэдийгээр бурханы шашинд 84 мянган сургаал номлол, олон янзын дэг буй боловч, нэг нь ч гэсэн Шагжамунийн номлолоос үл зөрнө. Сургаалыг олон боть ном сударт бичиж, тэмдэглэж үлдээжээ. Тэдгээр номын аймгийг "Ицезин", "Дацанзин" (японоор "Иссайкё", "Дайзокё" гэнэ) гэдэг юм.

Шагжамуни номлол сургаалдаа бүх хүмүүс эрх тэгш байх ёстойг айлдсан билээ. Тэрбээр энгийн, хүн бүрт ойлгомжтой хэлээр ярьдаг байжээ. Амьсгаа хураатлаа буюу 80 нас хүртлээ тэрбээр аль болох олон хүнийг аврахын тулд тасралтгүй номлосоор байжээ.

Шагжамуни таалал төгссөний дараа шавь нар нь сургаалыг яг багшаасаа сонссоноороо залгуулан номлож байв. Гэвч айлдсан сургаалыг нь амаар дамжуулахдаа буруу зөрүү сонсох, багшийнхаа айлдсаныг буруу тогтоох зэрэг тохиолдол гарч болзошгүй байжээ. Гэтэл Шагжамунийн айлдваруудыг яг тэр чигээр нь уламжлан дамжуулах ёстой байсан юм.

Бурхан багшийн сургаалыг хэн байхаас үл шалтгаалан хүн бүрт хүргэх шаардлагатай байлаа. Эдгээр сургаалыг огтхон ч гуйвуулалгүй хойч үедээ дамжуулахын тулд мэргэн буурлууд хуран чуулж бүх сургаалыг эмх цэгцтэй болгож эхэлсэн юм. Энэхүү чуулган "Кэцузю" хэмээн алдаршсан билээ. Тус чуулганд олон арван өвгөн буурал лам цугларсан аж. Лам бүр багшаасаа сонссоноор сургаалуудыг дэлгэрэнгүй айлдаж

гарчээ. Эдгээр сургаалыг дэлгэрэнгүй задлан шинжилж, алдаа мадагтай эсэхийг шалгаж байлаа. Эл их ажил хэдэн сарын турш үргэлжилжээ. Энэ нь мэргэн буурлууд Шагжамунийн сургаалыг хойч үедээ үнэн зөв өвлүүлэхийн тулд юутай ухамсартай хандсаныг гэрчилнэ Эмхэлж цэгцэлсэн айлдваруудыг ном сударт тэмдэглэж, түүн дээрээ хожим нь бурханы шашны зүтгэлтнүүдийн тайлбаруудыг нэмсэн аж. Эдгээр тайлбарыг утгачилвал "Эрэгцүүлэл" гэж нэрлэнэ. Бурхан багшийн айлдварууд, эрэгцүүлэлүүд, бурханы шашны лам хуврагуудын дэг жаягийг Типитака буюу "Гурван аймаг сав" хэмээдэг. "Гурван аймаг сав" нь Сутта-питака буюу "Судрын аймаг сав", Виная-питака буюу "Винайн аймаг сав", Абхидхарма-питака буюу "Авидармын аймаг сав" юм.

Одоо бүрэн бүтнээр уламжлагдан ирсэн пари хэлээр бичигдсэн судар болно. Пари хэлнээ гурван сан хэмээн алдаршсан судар уламжлагдан, бурхан шашинт эл улсын хамтын шүтээн судар болж чухал үүрэг хариуцлагаа гүйцэтгэж байгаа юм.

Домгийн дагуу бурханы шашин Хятадад манай эриний 67 онд буюу сүүлийн Хан улсын эзэн хаан Мин-дигийн ноёрхлын үед дэлгэрч эхэлсэн гэх боловч үнэн хэрэгтээ түүнээс хойш бүхэл бүтэн 84 жилийн дараа, өөрөөр хэлбэл 151 онд мөн улсын Хуан-ди эзэн хааны үед анх удаа бурханы шашны судрыг хятадаар орчуулсан юм. Тухайн үед энэтхэгт их хөлгөний бүлэг нэгэнтээ бий болсон ч хятад улсад эхэн үеийн бурханы судар болон их хөлгөний судар ялгаагүй уламжлагдан ирсэн байна. Түүнээс янагш бурханы шашны ном судрыг орчуулах ажил 1700 гаруй жилийн турш үргэлжилсэн юм. Орчуулсан судрын тоо 5586 боть бүхий 1440 ном болсон юм. Вэй улсын үеэс эхлэн бурханы шашны ном судрыг нэг газар хадгалж хамгаалахыг оролдож байсан аж. Гэвч

тэдгээрийг хэвлэх ажил Хойт Сүн улсын үеэс эхэлсэн билээ. Түүнээс хойш бурханы шашны номын тоонд хятадын бурханы шашны зүтгэлтнүүдийн бүтээлийг оруулдаг болсон юм. "Типитака" хэмээх нэр бурханы шашны ном судрын чуулганы агуулгад нийцэхээ больж Суй улсын үед бурханы шашны судрын чуулганыг "Ицезин" (япон нэр нь "Иссайкё"), Тан улсын үед "Дацанэин" (япон нэр нь Дайзокё) хэмээн тус тус нэрлэдэг болсон билээ.

VII зуунд бурханы шашин Төвдөд нэвтэрчээ. IX-XI зуунд ойролцоогоор 150 жилийн турш бурханы шашны ном судрыг төвд хэлээр орчуулжээ. Энэ хугацаанд бараг бүх ном судрыг орчуулсан юм.

Түүнээс гадна Бурхан багшийн айлдвар, номлолыг солонгос, япон, шри-ланка, монгол, камбожи, турк зэрэг дорнодын хэлээр очуулаад зогсохгүй латин, франц, англи, герман, итали зэрэг Европын олон хэлээр орчуулжээ. Тиймээс одоо Бурхан багшийн сургаал даян дэлхийд түгэж дэлгэрсэн гэж хэлэхэд хэтрүүлсэн болохгүй юм. Харин түүний агуулгын тухайд гэвэл бурханы шашин хоёр мянга гаруй жилийн түүхтэй, тэгээд ч түүний ном судар нэг түм гаруй боть учир, "Дайзокё"-гийн бүрэн орчуулга байдаг ч гэсэн бурхан багшийн айлдваруудын жинхэнэ утга учрыг ухаарч ойлгоход хэцүү билээ. Тиймээс бид бүхний шашин шүтлэгт түшиг тулгуур болж чадахуйц "Дайзокё"-гийн хамгийн чухал чухал хэсгийг шилж сонгох шаардлага урган гарсан юм.

Бурханы шашинд Шагжамунийн айлдварууд өчүүхэн ч гуйвашгүй нэр хүндтэй билээ. Тиймээс түүний сургаал бид бүхний амьдралтай аль болохоор нарийн нягт холбоотой, аль болохоор ойр дотно байх ёстой юм. Эс тэгвээс нэг түм гаруй боть бүхий ном судар бидний сэтгэлийг үл хөдөлгөнө. Тиймээс түүний сургаалыг ямагт бидний гар дор байдаг номын

хэлбэртэй болгон ерөнхийлөн товчлох шаардлага гарсан юм. Хэдийгээр энэ ном хэлбэрийн хувьд авсаархан боловч өрөөсгөл утгатай байх ёсгүй бөгөөд бурханы шашны бүх баялаг ном судрыг хамарсан байх шаардлагатай. Энэ номын үг бүрийг хүн бүхэнд ойлгомжтой, оновчтой, жирийн ярианы хэлээр бичсэн байвал зохино.

Энэ номыг чухамхүү ийнхүү буяныг санаж, зүрх сэтгэлийн угаас урган гарсан хүсэл эрмэлзэлд хөтлөгдөн бүтээсэн юм. 2000 гаруй жилийн турш үл ширгэн урсаж буй Шагжамунийн сургаалын их далайгаас эх авсан "Дацанзин" хэмээх их мөрний хүчит урсгалаас эл ном утга санаагаа уудлан авсан юм. Энэ бол төгс төгөлдөр болж бүтсэн ном гэж хэлж болохгүй нь тодорхой. Шагжамунийн айлдваруудын утга санаа хэмжихийн аргагүй гүн гүнзгий, түүний буян хязгааргүй учир хэнбугай ч тэдгээрийг хэмжиж үнэлэн цэгнэж чадахгүй. Бид, энэ номыг хэвлэх бүрдээ засан залруулж, эцсийн эцэст урьд урьдахаасаа илүү бүрэн дүүрэн, үнэнд улам ойр болно гэдэгт найдаж байна. Тийм ч ном байх ёстой юм.

"БУРХАН БАГШИЙН СУРГААЛ" ХЭМЭЭХ ЭЛ НОМ БҮТСЭН ТҮҮХ

Энэхүү "Бурхан багшийн сургаал" нь 1925 онд Муан Кизугийн толгойлж байсан "Бурхан багшийн сургаалын шинэ түүх"ийг түгээн дэлгэрүүлэх Нийгэмлэгээс эрхлэн хэвлэсэн "Бурхан багшийн сургаалын шинэ түүх"-ийг засан залруулж, шинээр эмхэтгэсэн хэвлэл юм.

"Бурхан багшийн сургаалын шинэ түүх"-ийн анхны хэвлэлийг Шүүгакү Ямабэ, Чизэн Аканума зэрэг профессорууд таван жилийн турш бурханы шашны олон эрдэмтэн мэргэдтэй хамтран ажилласны үр дүнд эмхэтгэсэн байна.

Бурханы шашныг сурталчлах нийгэмлэг, юуны түрүүн Муан Кизу болон энэхүү анхны хэвлэлийг эмхэтгэхэд оролцсон бүх эрдэмтэн мэргэдэд гүн гүнзгий талархал дэвшүүлж байна.

1926 оноос эхлэн Шовагийн эрин үед "Бурхан багшийн сургаалын шинэ түүх"-ийг сурталчлан дэлгэрүүлэх Нийгэмлэг "Бурхан багшийн сургаалын хялбаршуулсан хэвлэл" номыг хэвлэж, Япон орон даяар түгээн тараасан юм. 1934 оны зуны эхэн сард Номхон далайн орнуудын бурханы шашинт залуусын их хурал Япон улсад хуралдахад энэ их хуралд зориулсан нэгэн арга хэмжээ болгож бүх Японы бурханы шашинт залуусын холбооноос "Бурхан багшийн сургаалын хялбаршуулсан хэвлэл"-ийг Д. Годдардын тус дэмжлэгээр "Бурхан багшийн сургаал" нэртэйгээр англи хэлээр хэвлэсэн юм.

1962 онд Америк тивд бурханы шашин дэлгэрч эхэлсний 70 жилийн ойд зориулж Мицутоё пүүсийг үндэслэгч Эхан

Нумата "Бурхан багшийн сургаал"-ыг англи хэлээр хэвлэжээ. 1965 онд Нуматагийн хөрөнгөөр бурханы шашны Нийгэмлэг үүсч, "Бурхан багшийн сургаал"-ыг даян дэлхийд түгээн дэлгэрүүлэхээр шийдсэн юм.

Энэхүү шийдвэрийн дагуу 1966 онд "Бурхан багшийн сургаал"-ыг дахин хянах, шинээр эмхэтгэх тусгай хэсэг байгуулсан байна. Энэ хэсгийн бүрэлдэхүүнд Казүёши Кино, Шүүюү Канаока, Зэнно Ишигами, Шинко Саэки, Кодо Мацунами, Шуузюн Бандо, Такэми Такасэ нар орсон юм. Фумио Масутани, Н.А Уодделл, Тошисүкэ Шимизү болон бусад эрдэмтэн мэргэд тэд нарт тусалжээ. Ийнхүү бүхэлд нь шинэчлэн хянаж зассан "Бурхан багшийн сургаал"-ыг япон хэлээр зэрэгцүүлсэн англи орчуулгын хамт хэвлэжээ.

1972 онд тус "Сургаал"-ын буруу ташаа зүйлийг нөхөн залруулахын тулд Шүүюү Канаока, Зэнно Ишигами, Шууюү Ханаяма, Кансэй Тамура, Такэми Такасэ нар түүнийг дахин хянаж "Бурхан багшийн сургаал"-ыг англи хэлээр хэвлэжээ.

1973 онд "Бурхан багшийн сургаал"-ын япон хэл дээрх хэвлэлийг бүхэлд нь дахин хянаж, үсгийн алдаа мадагийг засч, нэмэлт оруулж, "Бурхан багшийн сургаал-ыг япон хэлээр шинээр хэвлэсэн аж.

1974 онд буруу оножорчуулсан үгс, хэллэгийг засч залруулахын тулд Кодо Мацунами, Шуузюн Бандо, Шинко Саэки, Доюу Токунага, Кансэй Тамура, Шууюү Ханаяма нар, Р.Стейнер нарын туслалцаатайгаар "Бурхан багшийн сургаал"-ын англи эхийг бүхэлд нь дахин хянан засч, япон хэлээр хэвлэсэн "Бурхан багшийн сургаал"-тай хамт хэвлэжээ. Ийнхүү "Бурхан багшийн сургаал"-ын япон эхийг тулган хянасан англи орчуулгын хамт хэвлэсэн байна. 1978, 1980 онуудад дээр нэрийг нь дурьдсан хянан тохиолдуулагчид

болон Шигэо Камата, Ясуаки Нара нарын оролцоотойгоор хянан тохиолдуулж, 2001 онд Кэнэс Танака, Ёнэзава Ёшиясу, Ватанабэ Шоко, Маэда Сэнгаку(Ахлах редактор) нар нэмэгдэж хянан тохиолдуулсан. 2013 онд Бурханы шашныг сурталчлах нийгэмлэг нь хувь нийлүүлсэн байгууллагаасаа буяны байгууллага болсонтой болсонтой холбоотойгоор Маэда Сэнгакү(Ахлах редактор), Ишигами Зэно, Кимура Киётака, Кэнэс Танака, Такэмура Макио, Ясуаки Нара, Ёшимизу Чизуко, Ёнэзава Ёшиясу, Ватанабэ Шоко гэсэн гишүүдтэйгээр "Бурхан багшийн сургаал"ыг хянан тохиолдуулах албыг байгуулж, улам сайжруулахын тулд жил бүр уулзалт зохион байгуулдаг. Энэхүү идэвхи зүтгэл цаашид ч үргэлжлэх болно.

"Бурхан багшийн сургаал" номыг монгол хэлээр Намбарын Энхбаяр орчуулав. Очирбатын Дашбалбар, Жамбалын Хатанбаатар нар хянан тохиолдуулав. Дожоогийн Цэдэв, Канаока Хидэро нар тулгуур хийж нягтлан уншив.

1991 оны хавар.

2017он, Такэмүра Макио багш ерөнхий редактор ажиллав.

СЭДВИЙН ЗААЛТ

Амьдрал	Хуу -дас	мөр
Амьдралын утга учир	5	12
Бодит ертөнц	104	1
Зөв тэгш амьдрал	249	14
Амьдралыг буруу үзэх үзэл	48	17
Амьдралын тухай зөв төсөөлөл	45	1
Өрөөсгөл амьдрал	61	20
Төөрөлдөгсдөд зориулах нь	135	10
Хүний амьдрал (сургаал домог)	97	10
Хэрэв амьдралын зугаа цэнгэлийг үтэр тонилгон хөөвөл (сургаал домог)	96	18
Өвгөн, өвчтөн, талийгаач гурав юуг зааж сургана вэ (түүх)	100	16
Үхлээс зайлж үл болно (түүх)................	101	16
Энэ хорвоо ертөнцөд үл биелж бүтэх Таван зүйл	52	12
Энэ ертөнцийн дөрвөн үнэн....................	53	1
Төөрөгдөл, гэгээрлийн аль аль нь сэтгэлээс үүднэ	53	16
Жирийн хүний бүтээхэд бэрх хэцүү боловч ихээхэн үнэ цэнэ бүхий 20 зүйл	142	7

Итгэл		
Итгэл бишрэл бол гал мөн	192	5
Итгэл бишрэлийн гурван тал	193	15
Итгэл нь гайхамшиг.................................	194	19

	Сэдвийн Хуу -дас	Заалт мөр
Итгэл нь чин сэтгэлийн илрэл мөн.........	194	1
Сохор хүмүүс зааныг таньж мэдэхэд хэцүү байдагтай адил үнэнийг олоход бэрх (сургаал домог)..................	80	12
Бурхан багшийн зөв сургаал нь Бурхан багшийн мөн чанарыг харуулна (сургаал домог)	83	7
Бухан багшийн мөн чанар хорвоогийн шунал тачаалын дор нуугдмал буй	78	23
Эгэлзэл нь итгэл бишрэлд саад бэхшээл болно...	95	9
Бурхан багш- эцэг, хүмүүс- Түүний үр хүүхэд мөн...	37	24
Бухан багшийн оюун ухаан далай лугаа адил өргөн дэлгэр, гүн гүнзгий юм	36	7
Бурхан багшийн сэтгэл агуу их нигүүлсэнгүй, энэрэнгүй үзлээр дүүрэн	15	1
Бурхан багшийн энэрэнгүй нигүүлсэнгүй сэтгэл мөнх оршино................................	16	8
Бухан багш бие махбодгүй.....................	14	1
Бурхан багш бүхий л амьдралынхаа турш номлож байсан	24	15
Бурхан багш хүмүүсийг аврахын тулд үхлийг үзүүлсэн	24	15
Бурхан багш сургаал домгийг ашиглаж.	19	15
Хүмүүсийг төөрөгдлөөс ангижруулсан .	20	13
Гэгээрлийн ертөнц..................................	267	14

Сэдвийн Заалт

	Хуу -дас	мөр
Бурхан багш, Ном, Лам хуврагуудын өлмийд мөргөмүй	190	18
Сахилаа мөрдөх, сэтгэлээ төвлөрүүлэх, Ухаантай үйл бүтээхийг хэрхэн сурах тухай..	175	6
Найман зөв зам мөр	178	2
Гэгээрэх зургаан зам мөр	180	13
Дөрвөн янзаар биеэ зөв авч явах нь........	179	15
Дөрвөн зөв үзэл..	179	7
Гэгээрүүлэх таван хүч	180	6
Сэтгэлийн дөрвөн хязгааргүй байдал.....	183	20
Амьдралын утга учрыг ухаарсан хүмүүс..	43	11
Хүний үхэл, түүний оршихын мөнх бус чанар	12	23
Бурхан багшийн нэр алдрыг давтсан хүмүүс Түүний жаргалтай оронд мэндэлдэг	121	4
Өөрөө гал шиг дүрэлзэж бай, өөрөө өөртөө л найдаж яв	10	16
Сэтгэл санаагаа төгөлдөржүүлэх нь		
Хүн бүр өөрт нь чухамхүү юу чухлыг ойлгох хэрэгтэй (сургаал домог)	161	10
Анхны алхам хийхээсээ эхлээд хянуур болгоомжтой бай	142	2
Юу эрж хайж байгаагаа бүү март (сургаал домог)	163	6

	Сэдвийн Хуу -дас	Заалт мөр
Аливаа юманд амжилт олохын тулд ихээхэн зовж зүдэрдэг (түүх)..................	169	22
Хичнээн олон ойчсон ч, дахин босч, хөл дээрээ зогс (түүх).............................	185	16
Нөхцөл байдалд сэтгэлийнхээ амар Амгаланг бүү эвдүүл (түүх)....................	132	7
Үнэнийг эрэн хайж буй хүн харанхуй өрөөнд гэрэлтэй орж буй хүн лүгээ адил..	44	3
Хүн амьдралын бүх юмнаас сургаалыг олж хардаг (түүх)....................................	173	6
Хүний үйлдлийг сэтгэл удирдана...........	129	22
Сургаалын гол нь сэтгэлээ төгөлдөр-жүүлэхэд оршино....................................	11	14
Юуны түрүүн сэтгэлээ хянаж удирдах Хэрэгтэй	226	1
Хэрэв сэтгэлээ хянан удирдаж чадвал ...	130	4
Сэтгэлийн янз янзын байдал (домог үлгэр)...	126	9
Сэтгэл бол өөрийн "би" бус	50	15
Сэтгэлийн хөдөлгөөнд бүү автаж захирагд...	10	21
Сэтгэлийн хөдөлгөнөө дийлж бай..........	165	3
Сэтгэлийнхээ эзэн бол............................	11	22
Бүх нүглийн эх булаг нь бие, хэл, сэтгэл гурав юм...	93	3
Сэтгэл, үгсийн хоорондын холбоо	133	22
Энэхүү бие цаг зуурын чанартай (түүх).	153	9
Энэхүү бие бузраар дүүрэн.....................	139	20

Сэдвийн Заалт

	Хуу -дас	мөр
Юуг ч хүчтэй үл хүс	10	21
Бие, хэл, сэтгэлээ цэвэр ариун байлга....	131	20
Сэтгэлээ төгөлдөржүүлж, аливаа юманд хэм хэмжээг баримталж бай (түүх)	184	22
Зовлон зүдүүр		
Ямар нэгэн юманд дадаж дассан сэтгэл зовлон зүдүүрийг буй болгоно	46	17
Зовлон зүдүүрийг хэрхэн зайлуулах нь .	13	11
Төөрөлдөх нь гэгээрэхэд хүрэх үүд хаалга юм	64	7
Төөрөгдлөөс хэрхэн салж ангижрах вэ ..	124	1
Орчлонгийн шунал тачаалын голыг унтраавaac сэрүүн тунгалаг гэгээрлийг олно..	151	19
Хүсэл шунал бол төөрөгдлийн учир шалтгаан мөн	91	13
Шунал хүсэл нь цэцэгсийн сүүдэрт нуугдаж буй хорт могой лугаа адил хэмээн бодож яв......................................	91	22
Галд автсан байшинд бүү дас (сургаал домог)	20	5
Хүсэл нь алдаа мадагийн учир шалтгаан юм..	126	1
Эл орчлон тэр аяараа галд автжээ	88	19
Хүн нэр алдар, эд баялгийн хойноос хөөцөлдвөөс өөрийгөө л шатаана...........	127	10

Сэдвийн Заалт
Хуу -дас мөр

Хүн нэр алдар, хайр дурлалын хойноос хөөцөлдвөөс өөрийгөө үхдийн зам руу хөтлөнө 127 17
Ухаантай, мунхаг хоёр хүний мөн Чанар.......... 143 4
Мунхаг хүн, үйлдсэн нүглээ анзаар-даггүй (сургаал домог) 150 15
Мунхаг хүмүүс гагцхүү үр дүнгээр нь тооцож бусдад атаархана (сургаал домог) 151 1
Мунхаг хүмүүсийн тухай (сургаал домог) 157 18

Өдөр тутмын амьдрал

Өглөг өргөмөгцөө өргөснөө март.......... 182 3
Эд өмчгүй хүний өргөх долоон өргөл Барьц.......... 182 6
Хэрхэн яаж баяжих вэ? (түүх) 156 7
Хэрхэн яаж жаргах вэ? 141 18
Тусыг хэзээ ч бүү мартаж бай (түүх) 148 6
Хүний янз янзын зан араншин.......... 95 9
Өш хонзон санасан хүн азгүй явдалтай Учирна.......... 141 5
Хэрхэн яаж гомдлыг цайруулах вэ? (түүх) 245 23
Бусдын шүүмжлэлийг зүрх сэтгэлдээ хэтэрхий ойрхон бүү тусга (түүх).......... 130 18
Хүн гагцхүү хувцас хунар, хоол хүнс, орон гэрийн төлөө амьдардаггүй.......... 218 20

Сэдвийн Заалт

Хуу -дас мөр

Хувцас хунар, хоол хүнс бол
зугаа цэнгэлийн тулд бус 125 1
Хоол ундад хандах нь.............................. 221 16
Хувцас хунарт хандах нь.......................... 220 19
Унтаж нойрсоход хандах нь 222 12
Халуун дулаан, хүйтэн нойтонд хандах
Нь 221 21
Өдөр тутмын амьдралд хандах нь 220 1

Аж ахуй

Эд агуурсыг ёс зүйнх нь дагуу
ашиглах хэрэгтэй (түүх).......................... 234 15
Өмч хөрөнгө хүнд мөнх үл ноогдоно..... 234 5
Гагцхүү өөрийнхөө төлөө өмч
Хөрөнгөө бүү хадгал 236 22
Хэрхэн яаж баяжих вэ (түүх) 156 7

Гэр бүл

Гэр бүл бол түүний бүх гишүүдийн
сэтгэлээрээ харилцдаг орон газар мөн ... 231 20
Гэр бүлийг эвдэн сарниулдаг
Үйлдлүүд... 226 21
Эх эцгийнхээ агуу их ачийг хэрхэн яаж
хариулах вэ.. 231 14
Эцэг эх, үр хүүхдийн хоорондын
Харилцаа 227 20
Эр нөхөр, эхнэр хоёрын хоорондын
Харилцаа 228 12
Эр нөхөр, эхнэр хоёр нэг л сүсэг

	Сэдвийн Хуу -дас	Заалт мөр
бишрэлтэй байх ёстой (түүх)	235	16
Хуврагийн зам мөр		
Ламын хувцас өмсөж, маань уншсанаар лам болохгүй	211	3
Лам хувраг нь сүм хийд болон сүм Хийдийн бүх бурхан шүтээн, эд агуурсыг өвлөн авагч бус	208	1
Ховдог хомхой сэтгэлтэй хүн жинхэнэ лам болж үл чадна	208	5
Жинхэнэ лам хуврагийн амьдрал	210	1
Нийгэм		
Нийгмийн ач холбогдол	240	17
Нийгмийн бодит байдал..........................	104	1
Олон төрлийн байгууллага	241	1
Жинхэнэ нөхрийн холбоо	241	11
Харанхуйг арилгагч гэрэл.......................	239	8
Энх амгалан, эв найрын харилцаа холбоо..	242	1
Аливаа хамт олны дотор энх амгалан, эв найрыг тогтоох арга	243	12
Лам хуврагуудын үлгэр жишээ холбоо..	242	7
Бурхан багшийг дагагчдын нийгмийн туйлын зорилт	251	2
Хэв журам эвдэгчид өөрсдөө үхэж үрэгдэнэ (сургаал домог)........................	149	17

Сэдвийн Заалт

	Хуу -дас	мөр
Бусдад атаархаж, хэрэлдэж маргагсад Өөрсдөө үхэж үрэгдэнэ (сургаал домог)	149	17
Ахмад буурлуудыг хүндэтгэж яв (түүх)	143	21
Багш, шавь нарын барилдлагаа	228	1
Нөхөрлөл найрамдлын дүрэм журам	228	21
Эзэн хөлсний ажилчдын хоорондын харилцаа	230	9
Найз нөхөр сонгох зам мөр	229	6
Гэмт хэрэгтнүүдэд хандах нь	237	11
Багш нарт хандмуй	212	12

САМГАРЬД ҮГСИЙН ТАЙЛБАР

АНАТМАН **(“Би” бээр байхгүй)**

Энэ нь бурханы шашны хамгийн чухал ухагдахууны нэг юм. Бурханы шашны дагуу гэрэлт ертөнцөд мөнх орших юм байхгүй учир хорвоод аливаа юм өөрийн мөн чанаргүй юм.

АНИТЬЯ **(аливаа юм хувиран өөрчлөгддөг чанартай)**

Энэ нь Бурханы шашны хамгийн чухал ухагдахууны нэг юм. Энэ ухагдахууны дагуу хорвоо ертөнцөд бүх юм хувиран өөрчлөгдөх бөгөөд байнга, тогтмол орших юм байхгүй аж. Аливаа амьд амьтан эрт орой хэзээ нэгэн цагт үхэх ёстой, энэ нь зовлонгийн учир шалтгаан болж байдаг юм. Гэвч хөгжил дэвшил, нөхөн төрөх нь мөн адил байнгын өөрчлөлт хувиралтын үр дагавар мөн учир эл олон үзэлд гутрангуй хандах хэрэггүй.

БОДХИСАТВА **(гэгээрэхийг ХҮСЭН ТЭМҮҮЛСЭН ХҮН)**

Анх Гаутама Сиддарта гэгээрэхээсээ өмнө ийм нэртэй байжээ. Махаяна буюу Их хөлөгний шашин үүссэний дараа гэгээрэхийг хүсэн тэмүүлсэн болгоныг ийнхүү бодхисатва буюу бодьсад гэж нэрлэх болсон аж. Сүүлдээ амьд амьтан бүрт дээд язгуурын нигүүлсэнгүй сэтгэлд хөтлөгдөн хандаж, гэгээрүүлэхийг оролдож буй хүмүүсийг ч ингэж нэрлэдэг болжээ. Хамгийн их алдаршсан бодьсад нарыг дурьдвал: Авалокитешвара буюу Хонсим бодьсад, Кшитигарбха, Ман жушри нар юм.

БУДДА **(Гэгээрч төгс нөгчсөн)**

Анх бурханы шашныг үндэслэгч Гаутама Сиддарта (Шагжамуни)-г ингэж нэрлэдэг байжээ. Учир нь тэрбээр 35 насандаа буюу одоогоос 2500 орчим жилийн өмнө Энэтхэгт гэгээрсэн аж. Өөрсдийн хамаардаг дэг, чиглэлээс үл шалтгаалан бурханы шашинтан бүрийн эцсийн зорилго нь Бурхан болоход оршино. Бурхан болох аргууд нь хоорондоо

ялгаатай.

учир бурханы шашин янз янзын дэг, сургуульд хуваагдсан байдаг. Махаяна буюу Их хөлөгний шашинд түүхэн хувь хүн болох Бурхан багшаас гадна Амитабха буюу Аминдава Махавайрочана буюу Махабярзана, Вайсажагуру нарын зэрэг бэлгэдэл бүхий олон Буддаг хүлээн зөвшөөрч, тахин шүтдэг. Амар жаргалтай оронд мэндэлсэн хүн бүр бурхан болдог гэсэн "Зол жаргалтай орны онол"-ын нөлөөн дор Япон улсад талийгаач болгоныг Бурхан буюу японоор "Хотоке хэмээн нэрлэдэг.

ДХАРМА (Зөв ном сургаал)

Энэ нь Ялж төгс нөгчсөнийг номлодог сургаал юм. Бурхан багшийн сургаалд гурван аймаг сав буй. Үүнд: Сударын аймаг сав (Бурхан багшийн айлдвар, яриа), Винайн аймаг сав (Бурхан багшийн тогтоосон дэг сахилга), Авидармын аймаг сав (Сударын болон Винайн аймаг савын ном судрт хожмын бурханы шашныг судлагчдын туурвисан тайлбар эргэцүүлэлүүд) эдгээр багтана. Энэ гурван аймаг савыг нийтэд ньТиптака хэмээнэ. Дхарма буюу Дарма нь бурханы шашны гурван эрдэнийн нэг нь юм.

КАРМА (Үйл)

Хэдийгээр анх энэ үг " үйл " гэсэн жирийн утгатай байсан боловч учир шалтгааны онолтой холбоотойгоор урьд өмнө үйлдсэн янз бүлийн үйлийн үр дүнд хуран хуримтлагдсан нэг ёсны нөөц хүч хэмээн тооцогдох болсон юм. Тодруулвал, хүний үйл бүр сайн, муугаасаа шалтгаалан ирээдүйд сайн эсвэл муу үр дүнд хүргэнэ. Улмаар хүний ирээдүйд нөлөөлөх энэхүү хүчийг карма (үйлийн үр) хэмээн нэрлэдэг болжээ. Хэрэв сайн үйл бүтээвэл буян хурж, түүний нөөц хүч, тэр үйлийг үйлдсэн хүний ирээдүйд сайнаар нөлөөлдөг гэж үзнэ. Хүний үйлс: бие, хэл болон сэтгэлийн гэж гурав хуваагддаг.

МАХАЯНА (Их хөлөг)

Бурханы шашны түүхэнд МахаянаХинаяна хэмээх хоёр том урсгалыг тэмдэглэсэн буй. Махаяна буюу Их хөлөгний сургаал Төвд, Хятад, Солонгос, Япон, Монгол болон бусад хойд зүгийн орнуудад, Хинаяны буюу Бага хөлөгний сургаал Бирм, Шри-Ланка (Цейлон), Тайланд болон урд зүгийн орнуудад түгэн дэлгэрчээ. Махаяна хэмээх нь энэхүү ертөнцөд төрж, үхэж буй бүх амьд амьтны зовлон зүдүүрийг багтааж, тэдгээрийг хооронд нь өчүүхэн бээр ялгалгүй цугааранг гэгээрүүлэхээр тээж чаддаг "Их хөлөг" гэсэн утгатай үг юм.

НИРВАНА (Бүрэн амарлингуй байдал, дээд зэргийн баяр цэнгэл)

Махчилвал "Унтраах, бөхөх" гэсэн үг. Энэ нь сэтгэл юүгээ төгс төгөлдөр болгож, зөв оюун ухааны үндсэн дээр дотоод бясалгал үйлдсэний ачаар хүний бүх бузар, шунал тачаал бүрмөсөн замхран арилсны дараах байдал юм. Ийм байдалд хүрсэн болгоныг бурхан гэнэ. Гаутама Сиддарта 35 настай байхдаа ийм нөхцөлд хүрч бурхан багш болжээ. Гэвч одоо Тэрбээр бүрэн амарлингуй байдалд гагцхүү амьсгаа хураасны дараа хүрсэн гэж үзэж байгаа юм. Учир нь хүний бие махбод амьдарч байгаа бол түүний бузар мөн адил оршсон хэвээр байдаг аж.

ПАЛИ (хэл)

Энэ нь Хинаяны буюу Бага хөлөгний сургаалын хэл юм. Бурханы шашны хамгийн эртний ном судрыг энэ хэлээр тэмдэглэн бичсэн гэж үздэг. Энэ бол самгарьд хэлний нэг аялгуу учраас энэ хоёр хэлний хооронд төдийлөн их ялгаа байхгүй. Үлгэрлэвэл, самгарьдаар Дхарма гэдэг бол палигаар Дхамма, самгарьдаар Нирвана бол, палигаар Ниббана юм.

ПАРАМИТА (цаад талын эрэгт хүргэдэг Хэрэгсэл)

"Цаад талын эрэгт хүргэдэг хэрэгсэл" нь Бурхан багшийн ертөнцөд хүрэхийн тулд хүний хэрэглэдэг арга хэрэгсэл билээ. Өглөгч зан, ёс суртахуун, тэвчээр хатуужил, зориг, бясалгах чадвар, оюун ухаан зэрэг хүнийг төрөх, үхэхийн ертөнцөөс гэгээрэхийн ертөнцөд авчирдаг 6 парамит буюу барамид буй гэж үздэг. Японы хавар, намрын Хиган хэмээх долоо хоногууд бурханы шашны энэхүү ухагдахуунаас үүдэн гарчээ.

ПРАЖНЯ (Оюун билиг)

Энэ нь 6 барамидын нэг нь билээ. Энэ бол хүний амьдралд зөв хандах, үнэнийг төөрөгдлөөс ялгах сэтгэлийн чадвар юм. Энэхүү чадварыг олсон хүнийг бурхан багш хэмээнэ. Тиймээс энэ бол ердийн хүний ухаанаас ялгаатай хамгийн ариун тунгалаг, гэгээрсэн оюун юм.

САНГХА (Бурханы олон шавь хуврагууд)

Бурханы шашны лам хуврагуудад гэлэн, гэлэнмаа тодохой сахил хүртэж тангараг өргөсөн хүмүүс тооцогдоно. Анх тэдгээрийн тоонд гагцхүү бадар барьдаг гэлэн, гэлэнмаа нар ордог байжээ. Хожим нь Махаяна буюу Их хөлөгний сургаал хөгжиж дэлгэрэхэд Сангха буюу Сангагийн тоонд гэлэнгүүдээс гадна бодьсадын зиндаанд хүрэхийг хүссэн бүх хүн тооцогдох болсон аж. Энэ нь бурханы шашны гурван эрдэнийн нэг юм.

САНСКРИТ (хэл)

Энэ бол Энэтхэг-Европын хэлний аймагт багтдаг эртний Энэтхэгийн сонгодог бичгийн хэл юм. Түүнийг ведийн болон сонгодог санскрит буюу самгарьд гэж хуваадаг. Махаяны буюу Их хөлөгний сургаалын ном судрыг энэ бичгээр тэмдэглэсэн бөгөөд түүний найруулгыг даган бурханы шашны холимог санскрит гэдэг билээ.

САНСАРА (Дахин дахин төрөхийн гинжин хэлхээс)

Энэ бол наракийн оршин суугч, бирд, амьтан, хүн, асур тэнгэр нар зэрэг зургаан ертөнцөд өнгөрснөөс өнөөдрийг дамжин ирээдүйд эцэс төгсгөлгүй үхэх төрөх давтагдахын нэр юм. Хүн гэгээрч эс чадваас энэхүү төрж үхэхийн тойрогт байнга эргэлдэхийн заяатай юм. Энэхүү тойргоос гарч чадсан хүнийг бурхан гэдэг.

ШУНЬЯТА (Хоосон чанар)

Энэ нь бурханы шашны хамгийн чухал ухагдахууны нэг юм. Энэхүү ухагдахууны дагуу гэрэлт ертөнцөд аливаа юм мөн чанаргүй бөгөөд мөнх оршихгүй юм. Эд юмс учир шалтгааны нарийн холбоотой тул өөрийн мөн чанар бүхий байнга тогтмол орших юм байхгүй. Тийм учраас юм бүхэн мөн чанартай эсвэл юу ч мөн чанаргүй хэмээн аль алинд нь хатуу итгэж үл болно. Энэ ертөнцөд аливаа юмны орших нь харьцангуй бөгөөд үнэмлэхүй чанартай юм байхгүй билээ. Энэ бол Махаяны гэх Их хөлөгний сургааль буюу Пражнягийн судрын гол ухагдахуун юм.

СУТРА (Ариун хөлгөн судар)

Бурхан багшийн номлолыг бичиж тэмдэглэснийг ингэж нэрлэдэг. Анх энэ үг эрдэм шинжилгээний ном, мэргэн үгсийн эмхэтгэлийн нэр байжээ. Сутра буюу судар нь Типитакийн нэг аймаг сав билээ.

ТХЕРАВАДА (Бага хөлөгний сургаал)

Энэ бол өмнө зүгийн уламжлалын бурханы шашинтан нарын гаргадаг нэгэн ердийн дуу авиа юм. "Тхера" нь ахмад гэсэн үг. Энэ бол түүхийн үүднээс үзэхэд бурхан багшийн сургаалыг хатуу чанд баримталдаг нэг хэсэг ахмад лам нарыг төлөөлсөн ахмадуудын дэг юм. Тэд нарын эсрэг арай дэвшилттэй сэтгэдэг өөр нэгэн хэсэг лам байсан билээ. Хожим нь тэдний үзэл бодол махаяны хүрээнд хөгжиж дэгжсэн. Энэ бол хойд зүгийн уламжлал билээ. Ийм хагарал бүр бурханы шашны эхний үед, Бурхан багшийн таалал төгссөнөөс хойш хэдхэн зуун өнгөрсний дараа, тэр үед дэвшилттэй хэмээн тооцогдож байсан. Махадэва лам, Бурхан багшийн сургаалын таван аймгийг урьд өмнөхөөс арай чөлөөтэй номлож болно хэмээн үзэж эхлэхэд тодорсон юм. Эцсийн эцэст энэ зөрчил хоёр дэг болж хуваагдсанаар шийдвэрлэгдсэн юм. Хожим нь Махасангхикийн дэг Махаяны сургаалыг боловсруулсан билээ.

Типитака (Гурван аймаг сав)

Энэ бол бурханы шашны ариун ном судрын гурван аймаг савын нэр Дармууд юм. Үүнд: Бурхан багшийн айлдвар, мэргэн сургаалыг эмхэтгэсэн Сударын аймаг сав, бурханы шашны лам хуврагуудын баримтлах ёстой эртний дэг сахилыг эмхэтгэсэн винайн аймаг сав, метафизикийн эрэгцүүлэлийг эмхэтгэсэн Авидармын аймаг сав эдгээр болно. Хожим нь Хятад, Японы бурханы шашны суут эрдэмтэн мэргэдийн бүтээлүүд бурханы шашны ном судард багтан ордог болсон байна. Дхарма-г үз.

БУРХАНЫ ШАШНЫГ СУРТАЛЧЛАХ **"БУРХАН БАГШИЙН СУРГААЛ"** НИЙГЭМЛЭГИЙН ТУХАЙ

Бурханы шашныг сурталчлах Нийгэмлэгийн тухай ярихдаа "Мицутоё" пүүсийг үндэслэгч Эхан Нуматагийн нэрийг дурьдахгүй өнгөрч болохгүй.

50 гаруй жилийн өмнө тэрбээр нарийн хэмжүүрийн багаж үйлдвэрлэдэг пүүс байгуулжээ. Эхэлсэн үйл хэрэг амжилттай байх эсэх нь тэнгэр, газар, хүн гурвын хоорондын зүй зохистой харилцаанаас, хүний төгс төгөлдөр чанар бол оюун ухаан, нигүүлсэнгүй сэтгэл, эр зориг гурвын хоорондын тэнцвэртэй зохицлоос шалтгаална гэдэгт хатуу итгэсэн тэрбээр шинэ технологийг боловсруулах, хүнийг төгс төгөлдөр болгох зорилт тавьжээ. Тэрбээр олон улсын энх амгалан байдал гагцхүү хүнийг төгс төгөлдөр болгосноор тогтоно, үүний тулд хамгийн сайн тохирох шашин нь бурханы шашин мөн хэмээн итгэдэг юм.

Тиймээс 50 жилийн турш пүүсээ удирдаж байхдаа тэрбээр бурханы шашныг сурталчлахын тулд бурханы шашны хөгжил, уран зураг, сургаалыг түгээн дэлгэрүүлэх, шинэчлэхэд ихээхэн хүч хөдөлмөр зарцуулж байжээ. 1965 оны 12 дугаар сард тэрбээр хөрөнгө гаргаж бурханы шашныг түгээн дэлгэрүүлэх бүх үйл ажиллагаагаа нэг байгууллагад төвлөрүүлж ингэснээр олон улсын энх амгалан байдлыг бэхжүүлэхэд өчүүхэн ч гэсэн өөрийн хувь нэмрийг оруулахыг эрмэлзжээ.

Ийнхүү Бурханы шашныг сурталчлах Нийгэмлэг хэмээх олон нийтийн байгууллага үүсчээ. Бурхан багшийн сургаалыг өргөн дэлгэр, гүн гүнзгий түгээн дэлгэрүүлж, газар дэлхий дээр бүх хүн дээд язгуурын оюун ухаан, дээд язгуурын нигүүлсэнгүй сэтгэлийн гэрэл гэгээгээр гийдэг байхын тулд яах ёстой вэ? Энэхүү асуултад хариулахад Бурханы шашныг сурталчлах Нийгэмлэгийн зорилт орших бөгөөд түүнийг

санаачлан үүсгэгч ч гэсэн үүнийг хүсч байгаа юм.

Өөрөөр хэлбэл, Бурханы шашныг сурталчлах Нийгэмлэг бурханы шашныг сурталчлахтай холбоотой бүх ажлыг хийдэг юм. Урт удаан түүхэндээ бурханы шашны соёлоороо бахархсаар ирсэн боловч өөрийн туурвин бүтээсэн шашны ариун номгүй Японы ард түмний хувьд "Бурхан багшийн сургаал" нь тэрхүү шашны ном болохыг тус Нийгэмлэг хүсэн ерөөж байгаа юм.

Тиймээс энэ номыг бүтээхдээ, түүнийг уншсан хүн бүр оюуны хэрэгцээ шаардлагаа хангадаг байхыг бодолцсон юм. Мөн хэнбугай ч гэсэн Бурхан багшийн агуу их дүртэй танилцах бололцоотой байх ёстой хэмээн үзэж энэ ном хүн болгоны ширээний ном, аяны үнэнч хань байхыг бодолцсон юм.

Нийгэмлэг нь эл ном болж л өгвөл айл болгонд байхыг, түүнтэй аль болохоор олон хүн танилцахыг хүсэн ерөөж байна. Нийгэмлэг, газар дэлхий дээр хүн бүр Бурхан багшийн сургаалтай танилцах тэр сайхан өдөр түргэн ирээсэй хэмээн хүсэн хүлээж байгаа юм.